

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР**

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ
ПОЛИТОЛОГИ
№ XX

МУИС-ийн ХЭВЛЭХ ҮЙЛДВЭР

2022 он

ПОЛИТОЛОГИ ХХ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№20 (570)

ХХ

ISSN 2227-6904

Key title: Политологи

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ:

Эрхлэгч:	профессор Ж.Төртогтох
Нарийн бичгийн дарга:	доктор Ц.Батболд
Гишүүд:	дэд профессор Я.Төгөлдөр
	доктор Г.Цэнд-Аюуш
	доктор Д.Ундрах
	доктор Д. Бумдарь
	доктор Д.Мягмарсүрэн
	доктор Б.Эрдэнэдалай
	доктор Г.Туяагэрэл

Техник редактор:	Г.Баярчимэг
------------------	-------------

Хаяг:

Улаанбаатар хот, Залуучуудын өргөн чөлөө, МУИС-ийн хичээлийн II байр
Шинжлэх Ухааны сургууль, Улс төр судлалын тэнхим

Утас: 976 - 75754400 (2317)

POLITOLOGY XX

SCIENTIFIC JOURNAL

№20 (570)

XX

ISSN 2227-6904

Key title: Politology

EDITORIAL BOARD

Editor in chief: Turtogtokh Janar, National University of Mongolia
Secretary: Batbold Tserendash, National University of Mongolia
Board members: Tuguldur Yanjiv, Mongolian University of Science and Technology
Tsend-Ayush Galsanpiljee, National University of Mongolia
Undrakh Davaadorj, National University of Mongolia
Bumdari Dagva-Ochir, National University of Mongolia
Myagmarsuren Dashzevge, Mongolian University of Science and Technology
Erdenedalai Bat-Ulzii, National University of Mongolia
Tuyagerel Ganbat, National University of Mongolia

Technical Editor: Bayarchimeg Ganbaatar

Address:

Department of Political Science, School of Arts and Sciences, National University of Mongolia, Zaluuchuud avenue, Ulaanbaatar, Mongolia

Phone: 976 – 75754400 (2317)

ПОЛИТОЛОГИ ХХ
Эрдэм шинжилгээний бичиг
№20 (570)

АГУУЛГА

Өмнөх үг

ОНОЛ, АРГА ЗҮЙ

Улс төрийн хүнийслийн онол, аргазүйн хандлагууд	
Ж.Төртогтох, Д.Уртнасан	7
Бодлогын шинжилгээний онолын загвар, хандлагууд	
Ц.Батболд	21
Хөгжлийн улс төр ба түүний арга зүй	
О.Мөнхжаргал, Ж.Төртогтох	49
Ерөнхийлөгчийн засаглалын талаарх онолын хандлага: Монгол улсын ерөнхийлөгчийн институт	
Я.Төгөлдөр, Д.Бумдарь	60
Үндэсний өөрийн ухамсрын төлөвшилтөнд улс төрийн ухамсрын нөлөө	
М.Мөнхзул, Г.Уянга	70
Улс төрийн бизнесийн мөчлөгийн онолын хандлага, үзэл баримтлал	
Д.Бумдарь, Б.Сарантуяа	75

ИНСТИТУТ, ҮЙЛ ЯВЦ

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулиудын статистиكت хийсэн улс төрийн шинжилгээ	
Б.Эрдэнэдалай	85
Монгол улсын 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд сонгогчдын улс төрийн оролцооны төлөв байдалд хийсэн шинжилгээ /2017, 2021 оны ерөнхийлөгчийн сонгуулийн жишээн дээр/	
Г.Цэнд-Аюуш, О.Мөнхжаргал.....	97
Монгол дахь улс төрийн намын сонгуулийн оролцоо, үр дүн	
Д.Түмэнжаргал, Г.Эрдэнэбаяр	108
Парламентын гишүүнээр сонгогдох шалгуурын асуудал	
Д.Сүхболд	126
Улс төрийн намын төлөвшлийн зарим асуудалд	
Б.Эрдэнэдалай, Н.Батжаргал	134
Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага иргэдийг төлөөлөх нь	
Д.Ундрах, Г.Ануцэцэн	142
Монгол улсын нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд зөвлөлдөх санал асуулгын хэрэгжилт, эрх зүйн орчин	
Г.Туяагэрэл, С.Мөнхбат, Ц.Бямбачулуун	156

Монгол улсын цахим засаглалын хөгжлийн үе шат, тойм судалгаа Д.Бумдарь, Б.Хишигням, Д.Бадамдаш	170
Улс төрийн социологид блокчэйн технологийг хэрэглэх боломж Т.Есүхэй, Б.Болор-Эрдэнэ	184
ГЛОБАЛ УЛС ТӨР	
Монгол дахь Европ судлалын өнөөгийн байдал ба тулгамдаж буй асуудлын судалгаа Г.Золзаяа, Б.Одгэрэл, Б.Галиндэв, С.Одхүү, Н.Хосбаяр	190
Соёл иргэншлийн мөргөлдөөн: Европыг чиглэсэн Исламын урсгал дахь Афганистан Д.Түмэнжаргал, Б.Эрдэнэбат	202
Монгол улс Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүнээр элсэх эсэх асуудлыг эдийн засгийн хамтын ажиллагааны аспектаар шинжлэх нь Д.Ундрах, Д.Ууганжаргал	209
Японы өсөлтийг дэмжсэн “Япон маягийн менежмент” – Монгол Улсын эдийн засгийг хөгжүүлэх мэдлэг Катанода Томоки	219
Зохиогчдын тухай товч	229

ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхимээс эрхлэн гаргадаг “Политологи” эрдэм шинжилгээний сэтгүүлийн ээлжит дугаар эрхэм уншигч та бүхний гар дээр очиж байна.

Улс төрийн үзэгдэл, үйл явц, харилцааны мөн чанар, шалтгааныг ойлгон таниулах, энэ талаарх зөв үнэлэлт дүгнэлтийг өгөх учир холбогдол бүхий улс төрийн мэдлэгийг бий болгоход улс төрийн шинжлэх ухааны гүйцэтгэх үүрэг их юм. Эдүгээ улс төрийн шинжлэх ухааны онол-арга зүй, судалгааны арга хэрэгсэл, улам нарийсан хөгжиж онолын болон эмпирик судалгаа шинжилгээний мэдлэгүүд даяаршиж байна. Улс төрийн мэдлэгийн даяарших үйл явц нь дэлхий дахин, бүс нутаг, улс орнуудад ардчилсан хөгжлийн ололт амжилтыг баталгаажуулах, түүнийг хөгжлийн шинэ шатанд гаргахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд цаашид ч гүйцэтгэсээр байх болно.

Монголд шинээр үүсэн төлөвшиж буй улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд энэ салбарын эрдэмтэн судлаачид ихээхэн хүчин чармайлт гаргаж байдгийн тодорхой нэг илрэл нь энэхүү сэтгүүл юм. Сэтгүүлийн эл дугаарт улс төрийн онол, арга зүй, улс төрийн институт ба үйл явц, глобал улс төр зэрэг улс төрийн шинжлэх ухааны хэд хэдэн чухал дэд хэсгүүдийн хүрээнд эрдэмтэн судлаачдын дангаар болон хамтран бичсэн нийт 19 өгүүлэл нийтлэгдэж байна.

Энэхүү дугаарт нийтлэгдсэн өгүүллэг тус бүр нь тухайн зохиогчийн үзэл санаа, байр суурь, судалгааны өгөгдөхүүнд тулгуурлаж байгаа бөгөөд МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхим, Политологи сэтгүүлийн редакцын байр суурь биш болохыг анхаарч хүлээн авна уу.

Уншигч та сэтгүүлийн талаарх санал, сэтгэгдлээ Улс төр судлалын тэнхимийн хаягаар ирүүлбэл бид гүнээ талархах болно.

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

УЛС ТӨРИЙН ХҮНИЙСЛИЙН ОНОЛ, АРГАЗҮЙН ХАНДЛАГУУД

Ж.Төртогтох

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, профессор,
Ардчилал судлалын төвийн захирал

Д.Уртнасан

МУИС, Улс төр судлалын тэнхимийн докторант,
Ардчилал судлалын төвийн судлаач

Хураангуй: Түүх, нийгэм, философи, нийгмийн сэтгэл судлал, улс төр судлал гээд нийгмийн ухааны салбарууд хүнийслийн талаар идэвхтэй судлах болсон нь 1980-аад оноос өрнөдийн орнуудад улс төрийн хүнийсэл хүчтэй ажиглагдаж эхэлсэнтэй холбоотой. Улс төр судлаачид уг асуудлын судалгааны ач холбогдол, энэ чиглэлээр дагнасан судалгаа хийх хэрэгцээ шаардлагын талаар ихээхэн анхаарал хандуулах болсон. Тус өгүүлэлд хүнийслийн ерөнхий ойлголт, нэр томъёоллууд, нийгмийн хөгжлийн явц дахь ойлголтын өөрчлөлтийг харуулах, улс төрийн хүнийслийн онол аргазүйн хандлага, судалгааны чиглэл, хэмжүүрүүдийн талаар тусгахыг зорьсон болно.

Түлхүүр үг: Хүнийсэл, улс төрийн хүнийсэл, төр иргэний харилцаа

Оршил

ХХ зууны эцэст улс орнуудад улс төрөөс хүнийсэх хандлага улам бүр автах болсныг улс төр судлаач Жиовани Сартори онцолсон¹ бөгөөд энэ үзэгдэл 1980-аад оноос өрнөдийн орнуудад ялангуяа АНУ, Дани зэрэг улсуудад хүчтэй ажиглагдаж эхэлсэн. Уг үзэгдэл газар авахын хэрээр төр ба иргэн хоорондын харилцаа улам бүр хөндийрч, үүнтэй холбоотой олон асуудлууд бодлого боловсруулагчид болон судлаачдын анхаарлыг татсаар байна. Ардчилалд шилжилт хийгээд 30 жил болж байгаа Монгол улсад ч мөн энэ асуудал ажиглагдсаар байгааг улс төр судлаач Ц.Мөнхцэцэг “Олон нийт улс төрийн үйл явц, намуудын тэмцэл, зөрчлөөс залхаж, сонгогчдын сонгуульд оролцох оролцоо буурч, улс төрөөс хүнийсч байна.” хэмээн дүгнэжээ. Төрийн бодлого олон нийтийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй байгаа учир иргэдийн төрд итгэх итгэл алдарч улмаар иргэд улс төрөөс хөндийрөх хандлага ихсэж байна.

Материал ба аргазүй

Тус өгүүлэлд хүнийслийн ерөнхий ойлголт, нэр томъёоллууд, нийгмийн хөгжлийн явц дахь ойлголтын өөрчлөлтийг харуулах, улс төрийн хүнийслийн онол аргазүйн хандлага, судалгааны чиглэл, хэмжүүрүүдийн талаар тусгахыг зорьсон болно. Учир нь дотоод, гадаадын судлаачдын судалгааны ажил, эрдэм шинжилгээний бүтээлүүдэд хүнийсэл, улс төрийн хүнийсэл, түүний илрэлийн талаар олонтаа дурдсан бөгөөд өнөөгийн нийгэмд тулгамдаад байгаа олон асуудлуудтай ямар нэгэн хэмжээгээр

¹ Berger, B. (2009) Political Theory, Political Science, and End of Civic Engagement, *Perspectives on Politics* Vol.7 No.2, 335-350

холбоотой, судалгаа шинжилгээний хэрэгцээ шаардлага байгааг илэрхийлсээр байна. Хэдийгээр нэршил, хэлбэрийн хувьд ялгаатай боловч мөн чанар агуулгын хувьд ижил байгаа нь уг асуудлын судалгааны ач холбогдол, энэ чиглэлээр дагнасан судалгаа хийх хэрэгцээ байна гэж таамаглаж болохоор байна.

Тухайлбал, 2019 онд хийгдсэн “Ардчиллын хөгжил, бэхжилтийн тулгамдсан асуудал, сорилтууд” судалгаанд 1990-2019 оны хооронд Монгол оронд ардчилал хэрхэн хөгжиж, ямар ямар саад бэрхшээлүүдийг даван туулж байгаа зэргийг нарийвчлан авч үзсэн бөгөөд иргэд улс төрөөс хүнийсч байгааг ардчиллын хөгжлийн явцад илэрч байгаа нэг сорилт болгон авч үзэж, энэхүү асуудлыг эмпирик байдлаар харах шаардлагатай хэмээгээд хамгийн бодит харах боломжтой тоон үзүүлэлт нь УИХ-ын сонгууль болон Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц гэж дүгнэсэн байна.²

Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичигт **alienation** хэмээх нэр томъёог “Орчин үед улс төрийн шинжлэх ухаанд хүнийслийг илүү нарийсган, улс төрийн буруу зан үйлд хөтөлдөг сөрөг, шүүмжилсэн хандлагад хэрэглэгдэж байна. Хүнийслийн талаарх улс төрийн шинжлэх ухааны эмпирик судалгааны чухал сэдвүүд бол үзэл баримтлалын олон талт дүн шинжилгээ, түүний хэмжилт, хувь хүний улс төрийн зөн үйлд мэдрэмжийн үзүүлж буй үр нөлөө, ялангуяа улс төрийн идэвхгүй байдал ба эсэргүүцлийн үйл ажиллагаанд оролцох тухай юм.”³ хэмээн тодорхойлжээ.

Улс төр судлаач Ц.Мөнхцэцэг 1990-2019 оны хооронд Монголд сонгууль, түүний үйл явц хэрхэн өрнөж байсныг нарийвчлан судлан гаргасан байна. 1990 онд ардчилсан Үндсэн хуулийг баталж, түүнд засгийн бүх эрх мэдэл ард түмний гарт байгааг, тэрхүү эрх мэдлээ өөрсдийн төлөөллөө сонгуулиар сонгож эдлэхийг тунхагласан. Тэрээр улс төрийн сонгуулийн үйл явцыг судлах нь ардчиллын гол үзүүлэлтүүдийг илрүүлэн гаргах боломжтой болгодог тул судалгааны болон практикийн ихээхэн ач холбогдолтой гэж үзсэн. Судлаач сонгуулийн үйл явцад хамгийн их нөлөөлдөг хүчин зүйл сонгогчдын зан үйл болдог бөгөөд Монголын сонгогчдын зан үйл онцлогийг улс төрөөс хүнийсэх үйл явц, улс төрийн тогтолцоонд итгэл алдрах байдал, нутгархах хандлага, хамаатан садны хэлхээ холбоо, үндсэрхэг үзэл гэсэн үзүүлэлтүүдээр илэрхийлсэн байна. Үүнээс иргэдийн улс төрөөс дайжих байдлыг улс төрөөс хүнийсэх үйл явц, улс төрийн тогтолцоонд итгэл алдрах байдал гэсэн хоёр үзүүлэлтээр авч үзсэн байна. “Олон нийт улс төрийн үйл явц, намуудын тэмцэл, зөрчлөөс залхаж, сонгогчдын сонгуульд оролцох оролцоо буурч, улс төрөөс хүнийсч байна. Тийм учраас улс төрийн намуудын хувьд мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчдээ сурталчлан таниулахаас гадна өөрийн дэмжигч сонгогчдоо сонгуульд оролцохыг уриалах давхар ажил нэмэгдэж байна.”⁴ Тэрээр үүнийг 2008 онд болсон орон нутгийн сонгуулийн ирц нийслэлийн хэмжээнд 44% байж сонгууль дахин явагдсан жишээгээр тайлбарлажээ. Олон нийтийн санаа бодлын цуврал судалгааны дүнг нэгтгэн үзээд улс төрийн институтууд болон оршин буй төрийн тогтолцоонд итгэл алдрах байдал нь өнөөгийн тогтолцоонд сэтгэл дундуур байх иргэд буюу пессимистүүдийн тоо, улс төрийг огт сонирхдоггүй идэвхгүй хүмүүсийн тоо тогтмол нэмэгдэж байна гэж дүгнэсэн. Энэ нь сонгууль болгоноор өөр өөр намуудад санал өгөх сонгогчдын тоог нэмэгдүүлж байгаа бөгөөд эдгээр хүмүүсийг “Хөвдөг сонгогчид” гэж томъёолоод нийт сонгогчдын 30 орчим хувийг эзэлж байна.

² Бумдарь, Д. (2019). Ардчиллын хөгжил, бэхжилтийн тулгамдсан асуудал, сорилтууд. In *Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт \1990-2019* (pp. 9-41). Улаанбаатар: "Адмон принт" ХХК ,

³ Төмөрбаатар, Я. (2020). Хүнийсэл. Т. Ж, & М. С-Д, *Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь* (хуудас. 747-750). Улаанбаатар: Адмон принт ХХК, хуудсд. 747-748)


⁴ Мөнхцэцэг, Ц. (2019). Сонгуулийн үйл явц: Сонгуулийн компани, сонгуулийн систем, тулгамдсан асуудал. In *Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт \1990-2019* (pp. 107-131). Улаанбаатар: "Адмон принт" ХХК, 126.

Төрийн бодлого мөн чанарынхаа хувьд зөв зохистой байхын тулд оролцож буй субъектүүдийн тэгш оролцоо чухал хэдий ч ардчилалд бэхжиж амжаагүй байгаа манайх шиг улсын хувьд улс төр эдийн засгийн явцуу бүлэг үүсэж, корпорацийн сонирхлоо хамгаалан тодорхой хүрээнд төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд үлэмж нөлөө үзүүлдэг. Энэ үзэгдлийг Чехийн улс төр судлаач Михал Клима клиентелизм гэж тодорхойлсон байна. Төрийн хууль тогтоох байгууллага нь иргэд төлөөллөөрөө дамжуулж байгуулдаг төлөөллийн байгууллага бөгөөд энэхүү үйл явц нь улс төрийн намаар дамжин хэрэгждэг. Өөрөөр хэлбэл улс төрийн нам бол төр болон иргэний нийгмийг холбогч гүүр байх учиртай. Харин намууд олгархи бүлгийн гарт орж клиентелист болох үед төрөөс гарах хууль тогтоомж, бодлого цөм тухайн бүлгийн эрх ашгийг хамгаалсан байдаг. Ийнхүү улс төрийн намууд клиентелист болж ирэхийн цагт олгархи бүлэглэлийн эрх ашгийг хамгаалахын тулд төрийн эрх мэдлийг авах гэж улайран сонгуулийн хэтийдсэн амлалт өгч сонгуульд оролцдог. Гэвч амлалтдаа хүрч чадаагүй учир иргэдийн үл итгэх байдал улам нэмэгддэг.

Үр дүн

Хүнийслийн онолыг түүх, нийгэм, философи, нийгмийн сэтгэл судлал, улс төр судлал гээд нийгмийн ухааны салбарууд сонирхон судалдаг. “Хүнийсэл буюу Alienation гэсэн нэр томъёо нь Англи хэл дээр XV зууны эхэн үед а/хувь хүний бурхнаас хөндийрөх тухай, б/өмчлөх эрхийг хуулийн дагуу шилжүүлэх тухай гэсэн үзэл санаанд хэрэглэгдэж эхэлсэн бөгөөд зарим судлаачид хууль эрхзүйн хэрэглээгээр дамжин Англи хэлнээс Герман хэлэнд орсон гэж үздэг.”⁵

Хүнийсэл / alienation/:



Оксфордын толь бичигт хүнийслийг дараах байдлаар тодорхойлсон⁶:

- 1/ нөхцөл байдал эсвэл ямар нэгэн туршлагаас холдож хөндийрсөн байдал,
- 2/ өөрийн өмчийн эрхийг шилжүүлэх



Кембрижийн толь бичигт хүнийслийг дараах байдлаар тодорхойлсон⁷:

- 1/ эргэн тойрныхоо хүмүүстэй ямар ч холбоогүй эсвэл бүлгийн гишүүн биш гэсэн мэдрэмж,
- 2/ хэн нэгнийг дэмжих, санал нийлэхээ болих үйлдэл



Мерриам вебстериин толь бичигт хүнийслийг дараах байдлаар тодорхойлсон⁸:


- 1/ өмнө нь холбоотой байсан зүйл, байр сууринаасаа хүн холдох эсвэл тухайн хүний сэтгэлийг татахаа болох
- 2/ эд хөрөнгийг бусдад шилжүүлэх

⁵ Alienation. (2018, Aug 30). Retrieved from Plato.stanford.edu: <https://plato.stanford.edu/entries/alienation/>

⁶ Оксфордын Англи-Монгол толь бичиг

⁷ <https://dictionary.cambridge.org/dictionary/english/alienation>

⁸ <https://www.merriam-webster.com/dictionary/alienation>



Коллинсийн толь бичигт хүнийслийг дараах байдлаар тодорхойлсон⁹:

- 1/ нүүр буруулах, гадуурхах
- 2/ гадны хүн байх эсвэл нийгмээс тусгаарлагдах мэдрэмж
- 3/ сэтгэцийн эмгэг: хүн өөрийгөө болон гадаад ертөнц хоёулаа бодит бус мэт санагдаж хүний сэтгэл санааг дарангуйлах
- 4/ хуулийн хүрээнд: а. эд хөрөнгийг шилжүүлэх буюу гэрээслэлээр бусдын өмчлөлд шилжүүлэх б. өмчлөгчийн эд хөрөнгөө захиран зарцуулах эрх



Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичигт хүнийслийг дараах байдлаар тодорхойлсон¹⁰:

- 1/ Иргэний ба капиталист нийгмийн дүн шинжилгээнд хүнийсэл нь хүмүүсийн холбоо тасрах процесс гэжээ.
- 2/ Тоглогч өөртөө болон нийгмийн харилцааны эсвэл бусад биеүдийн хооронд эерэг харилцан хамаарлыг ойлгож чадахгүй байх

“Хүнийсэл нь ямар нэг нийгмийн чухал объектоос холдож хөндийрөх хандлага бөгөөд нийгмийн чухал объект нь хувь хүнтэй шууд холбоотой нийгэм соёлын аливаа үзэгдэл байж болдог.”¹¹ “Хүрээлэн буй орчин, ажил, ажлын бүтээгдэхүүн, өөрөөсөө хөндийрсөн, тусгаарлагдсан мэдрэмжийг хэлнэ.”¹²

Мөн Философийн гарын авлагад “Хүнийсэх” гэдэг нь хөндийрөл, салалт гэсэн утга илэрхийлнэ”¹³ хэмээн авч үзсэн байна.

Хүнийслийг субъектив болон объектив гэж ангилдаг. Субъектив хүнийсэл нь субъект нь ямар нэг асуудалтай тулгарахад хэрхэн мэдэрч, бодох туршлагатай хамаарал бүхий харилцаа бол объектив хүнийсэл нь субъектийн асуудалтай тулгарахад мэдрэх мэдрэмж, бодол туршлагатай огт хамаардаггүй. Объектив, субъектив хүнийслийг нийгмийн нөхцөлд авч үзэн онол зүйн схемээр тайлбарлах боломжтой. Хүснэгт 1 . Объектив, субъектив хүнийсэл /Онол зүйн схем/¹⁴

Нийгмийн нөхцөл	Субъектив хүнийсэл	Объектив хүнийсэл
I	+	+
II		+
III	+	
IV		

Эх сурвалж: Stanford Encyclopedia of Philosophy: Alienation 2018

⁹ <https://www.collinsdictionary.com/dictionary/english/alienation>

¹⁰ Төмөрбаатар, Я. (2020). Хүнийсэл. Т. Ж, & М. С-Д, *Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь* (хуудсд. 747-750). Улаанбаатар: Адмон принт ХХК хууд. 747)

¹¹ E.Olsen, M. (1969). Two categories of political alienation. *Oxford Journals*, Vol 47, (Issue 3), 288-299.

¹² www.britanica.com

¹³ Хууль зүй, Дотоод хэргийн яам. (2007). Шүүх, эрх зүйн шинэчлэлт, Философи гарын авлага, Улаанбаатар, 71.

¹⁴ Alienation. (2018, Aug 30). Retrieved from Plato.stanford.edu: <https://plato.stanford.edu/entries/alienation/>

I нийгмийн нөхцөлийн талаар К.Маркс капиталист нийгмийн нөхцөл байдалд тохируулан оношилсон бөгөөд Марксын онол үйлдвэрлэл, эдийн засгийн харилцаанд үүсэх аливаа зөрчлийг шийдвэрлэж, үйлдвэрлэлийн хөгжлийг шинэ шатанд гаргахыг зорьж байсан. “Нийгмийн шударга бус байдлыг улам бүр гүнзгийрүүлж байдаг объектив хүчин зүйл нь нийгмийн олонхын хэт туйлширсан хандлага байдаг гэж үзээд зөвхөн дарлагдагч ангийн улс төрийн нэгдлээр дамжуулан улс төрийн системийг ойлгож тайлбарлах нь дарлагч болон дарлагдагч ангиудын хооронд үүсэх ялгарлыг улам бүр ихэсгэж байдаг гэсэн саналыг дэвшүүлсэн¹⁵ байдаг. Үйлдвэрлэлийн эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхийн тулд мөлжлөгийг арилгах гэж тодорхойлон “Нийгмийн хөгжлийн түлхүүр нь зөвхөн мөлжлөгөөс чөлөөлөгдөхийг зорьж буй ажилчин анги бус хүний хөгжлийн зорилгыг ухамсарласан анги”¹⁶ гэсэн санааг мөн дэвшүүлсэн байдаг.

II нийгмийн нөхцөлийн хувьд Франкфуртын сургуулийнхан* баримталдаг бөгөөд хувь хүмүүс хөгжингүй капиталист нийгэмд үйл ажиллагаандаа бус харилцаандаа сэтгэл хангалуун байдаг. Тэд хүнийссэн нөхцөл байдалдаа өөрсдийгөө таньж түүнээс сэтгэл ханамж авдаг. Үүнийгээ “Нийгэм бол үргэлж “бусад” байдаг бөгөөд хэзээ ч “гэр” байж чаддаггүй. Ийм нөхцөл байдал байнга оршин байх тул үүнтэй харилцах сайн муу арга замууд байх ёстой ба хувь хүмүүст зайлшгүй шаардагдах зүйл бол тэд өөрсдөө юу бүтээнэ түүгээрээ бусадтай харилцах арга замыг тодорхойлдог”¹⁷ хэмээн тайлбарлажээ.

III нийгмийн нөхцөлийн талаарх асуудал Гегелийн үзэл санаанд тусгагдсан байдаг бөгөөд нийгэм улс төрийн бүтэц дэх хувь хүмүүс нь гэр бүлийн гишүүд, эдийн засгийн төлөөллүүд зэрэг ямар нэг харилцаанд байна гэдгийг ойлгож үнэлдэггүй учраас институтээс хөндийрч ухамсартайгаар татгалздаг. “Нийгэм оршин тогтох хэлбэрүүд бүхий үе шатуудаар хөгждөг бөгөөд үе шат бүрийн нийгмийн хэлбэрийн цогцолбор нь тухайн үеийн хамгийн сайн нийгмийн амьдралыг ухамсарлаж, хувь хүний болон хамтын ухамсар, үйл ажиллагаатай уялдан хөгжсөөр байдаг. Энэ нь төр улсад, сүнслэг чанарын түгээмэл ойлголтод, хүн төрөлхтний туйлын зорилгод ч ялгаагүй ёс суртахууныг харгалзан үздэг.”¹⁸ Гегелийн энэхүү санааг улс төр судлаач Жорж К.Комнинел “сүнслэг чанарыг бурхан гэсэн ойлголтоор хялбаршуулан ойлгож болох бөгөөд дэлхий дээр өөрийгөө ухамсарлан ойлгох явдал нь нийгмийн харилцааны тогтвортой байдлыг хангадаг хэмээсэн нь теократ болон консерватив либерализмын үзлийн нийлбэр болжээ” гэж дүгнэсэн байна.

Хэдийгээр хүнийслийн талаар ийнхүү өөр өөр байр суурьтай байдаг хэдий ч улс төр, нийгмийн ухааны сэтгэгчид VI нийгмийн нөхцөл байдалд ойртуулахыг зорьдог байна. Үүний тулд Марксийн хувьд ертөнцийг эргүүлэх шаардлагатай буюу институт болон хандлага аль алинд нь хувьсал хийх хэрэгтэй гэж үзсэн бол Гегель хандлагаа л өөрчлөх ёстой буюу одоо байгаа ертөнц нэгэнт тогтсон учраас түүнд хандлагаа тохируулах нь чухал хэмээсэн байна.

Улс төрийн хүнийсэл

¹⁵ Базарпүрэв, С., & Туяагэрэл, Г. (2011). Улс төрийн сэтгэлгээний түүхэн дэх улс төрийн хямралын тухай үзэл санаа ба түүний хувьсан өөрчлөлт. *Политологи* №350 /62/, 34-51, 45.

¹⁶ Comninel, G. C. (2018). *Alienation and Emancipation in the Work of Karl Marx*. New York: Springer Nature America Inc

* 1923-1930 онд байгуулагдсан Нийгмийн судалгааны хүрээлэнтэй холбоотой барууны Марксист уламжлалыг баримтлагч философич, нийгмийн онолчдод өгсөн нэр.

¹⁷ *Alienation*. (2018, Aug 30). Retrieved from Plato.stanford.edu: <https://plato.stanford.edu/entries/alienation/>

¹⁸ Comninel, G. C. (2018). *Alienation and Emancipation in the Work of Karl Marx*. New York: Springer Nature America Inc

“Alienation-ямар нэг зүйлээс хөндийрөх холдох үйл явц”¹⁹ “Хүнийсэл нь либерал нийгэм, либерал улс төрийн гүн ухаанд ямар нэгэн зүйл буруу байгааг харуулж болох оношилгооны үүрэг гүйцэтгэдэг бөгөөд объект, субъект хоёрын хоорондын зохистой харилцаа алдагдаж, үүнд бухимдах, зөрчилдсөнөөс болж хоорондоо салан тусгаарлагдах үзэгдэл юм.”²⁰ “Конгресс, Сонгуулийн Хороо, сонгогддог байгууллага зэрэг нийгмийн төв байгууллагуудад үнэнч байдал сулрах иргэдийн хандлага”²¹, “Улс төрийн арга хэмжээнд сонирхолгүй болох болон төрийн албанд үл итгэх байдал хоёрын нийлэмж”²², “Иргэдийн улс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх мэдрэмж хамгийн бага байх нийгмийн нөхцөл үүсэхийг хэлнэ”²³, “Улс төрийн төв институт, лидер, нийгмийн улс төрийн үнэлэмж зэргээс хөндийрөх мэдрэмж”²⁴. Улс төрийн хүнийсэл гэсэн ойлголтын хүрээнд утга агуулгын хувьд зарим тохиолдолд төсөөтэй шинжийг агуулдаг, улс төрийн үзэгдэл, үйл явцын талаарх нэр томъёог тодорхойлох нь мөн чухал юм.

Улс төрийн идэвхгүй байдал /Political apathy/:

“apathy-үлбэгэр, номой, идэвхгүй”²⁵

Мерриам вебстерийн толь бичигт “сонирхолгүй байдал, санаа үл зовох байдал”²⁶

“Улс төрийн шинжлэх ухаанд улс төрд сонирхолгүй байх эсвэл хайхрамжгүй хандах мэдрэмжийг улс төрийн идэвхгүй байдал гэнэ.”²⁷

Улс төрийн абсентеизм /Political absenteeism/:

absenteeism гэдэг нэр томъёо нь Латин хэлний absens, absentis буюу алга болсон гэсэн үгнээс гаралтай бөгөөд “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр өөрийн ажил үүргээ биелүүлэхгүй байх үйл байдал юм.”²⁸ Харин улс төрийн абсентеизм нь “Сонгогчид сонгуульд санал өгөхөөс зайлсхийх эсвэл өргөн утгаараа идэвхгүй байдлаар тодорхойлогддог улс төрийн үйл байдал. Өөрөөр хэлбэл аливаа улс төрийн үйл ажиллагаанд оролцохоос зайлсхийх, ялангуяа сонгуулийн чиг үүргээс зайлсхийх үйл байдал юм.”²⁹

Санал хураалтад түдгэлзэх /abstention/:

“Санал хураалтыг ямар нэг зүйл эсвэл эсрэг талд ашиглахгүй байхыг сонгосон үйлдэл”³⁰ “Санал хураалтад түдгэлзэх нь оролцогч сонгуулийн өдөр санал хураалтад оролцохгүй байх, эсвэл санал өгөх үеэр байлцсан боловч санал өгөхгүй байх сонгуулийн журмын нэр”³¹.

Улс төрийн цинизм /Political cynicism/:

¹⁹ Оксфордын Англи-Монгол толь бичиг

²⁰ Alienation. (2018, Aug 30). Retrieved from Plato.stanford.edu: <https://plato.stanford.edu/entries/alienation/>

²¹ Weakliem, D.L., & Borch, C. Alienation in the United States: Uniform or group-Specific Change? Sociological Forum 21, 415-438.

²² Oskarsan, M. (2007). *Social Risk, policy Dissatisfaction and Political Alienation: A Comparison of Six European Countries*. Stanford University Press.

²³ Reef, M.J., & Knoke, D. Political Alienation and Efficacy, Measures of Political Attitudes.

²⁴ Wood, M. (2014). *Political alienation in American Society*. Retrieved from <https://scholarworks.uvm.edu/hcoltheses/38/>.

²⁵ Оксфордын Англи-Монгол толь бичиг

²⁶ <https://www.merriam-webster.com/dictionary/apathy>

²⁷ Dean, Dwight. (1965). Powerlessness and Political apathy, *Social Science* 40 (4), 208-213.

²⁸ www.oxfordlearnersdictionaries.com/us/definition/english/absenteeism?q=absenteeism

²⁹ www.ru.m.wikipedia.org


³⁰ www.oxfordlearnersdictionaries.com/us/definition/english/abstention?q=abstention

³¹ en.wikipedia.org/wiki/Abstention

“Цинизм бол бусдын сэдэлд үл итгэх байдлаар тодорхойлогддог хандлага юм. Цинизм нь нийгэм, байгууллага, эрх баригчдын талаар өндөр хүлээлт бий болсны улмаас ёс зүй, нийгмийн үнэт зүйлд үл итгэх байдал юм.”³²

Дээрх улс төрийн ойлголтууд нь улс төрийн итгэл буурах, улс төрийг сонирхохгүй байхаас үүдсэн улс төрийн хөндийрөх хандлага буюу улс төрийн хүнийслийн тодорхой илрэлүүд юм.

Зураг 1. Улс төрийн хүнийсэл /схем/



Хүнийслийн хандлагыг судлаач Марвин Олсин 4 хэлбэр болгон ангилсан байна.

1. Гажсан төрийн хэлбэрээс хувь хүн хүнийсэх хандлага бөгөөд Дюрге́м “уламжлалт ёс суртахууны хэм хэмжээ сулрах, нуран унасан нийгэмд илрэн гардаг нийгмийн хэвийн бус байдал”³³ хэмээн тодорхойлсон байна.
2. Судлаач Диан болон Мидлитон нарын боловсруулсан хүнийслийн хүчтэй хамаарлын ойлголт бөгөөд тэд хүчгүй байдал, утгагүй байдал, удирдамжгүй байдал зэргийг хүнийслийн хэмжигдэхүүн болгон дүн шинжилгээ хийхийг зорьсон.
3. Нийгэм, эдийн засгийн статустай холбоотой хүнийслийн хандлага
4. Соёл, нийгэм, үүрэг ролийн харьцаа алдагдсанаас үүсэх хүнийслийн хандлага

³² E.Olsen, M. (1969). Two categories of political alienation. *Oxford Journals*, Vol 47, (Issue 3), 288-299.

³³ E.Olsen, M. (1969). Two categories of political alienation. *Oxford Journals*, Vol 47, (Issue 3), 288-299.

Майкл Вүүд улс төрөөс хүнийсэх мэдрэмжийг дараах улс төрийн үзэгдэл, үйл явцтай холбох боломжтой гэж үзсэн.³⁴

- Санал өгөхөөс татгалзах
- Саналын дүнг эсэргүүцэх
- Улс төрийн дэглэмээ эсэргүүцэх
- Улс төрийн системийн оролтын дэмжлэг буурах
- Системийн тогтвортой байдалд аюул учрах

Үүнээс харахад улс төр судлаачдын нэг чухал анхаарлаа хандуулдаг судлагдахуун бол улс төрийн системд чиглэсэн хандлага юм. Учир нь улс төрийн системийн онолын гол ойлголт нь улс төрийн системийн бүтэц болон үйл явцыг тодорхойлоход иргэдийн дэмжлэг чухал үүрэгтэй байдагтай холбоотой.

Улс төр судлаач Дэвид Истон “Улс төрийн системийн тогтвортой байдалд чухал байр суурийг бие хүний хандлага эзэлдэг бөгөөд учир нь улс төрийн системийн дэмжлэгийн оролт хамгийн бага хэмжээнээс доогуур байвал ямар ч төрлийн системд аюул нүүрэлдэг.”³⁵ Уг тохиолдолд хүнийслийн ойлголт нь улс төрийн системийн дэмжлэг болон нэгтгэлийн тасралтгүй байдал алдагдсаныг илэрхийлж байна. Улс төрийн систем тасралтгүй эргэх холбоотой байх нь улс төрийн системийн тогтвортой байдлыг бий болгодог. Үүнийг судлаач Ю.Атар “улс төрийн системийн бүтэц хэдий чинээ уян хатан байна төдий чинээ орчноос ирсэн мэдээллийг зөв зохицуулна. Орчноос мэдээлэл бага ирэх тусам улс төрийн систем ба бүтцэд итгэх итгэл алдарна. Улс төрийн системийн бүтцэд итгэх итгэл алдагдсанаас улс төрийн системийн бүтэц өөрчлөгдөх үндэс болно.”³⁶ хэмээн тодорхойлжээ.

Улс төрийн хүнийслийн талаар улс төр судлаачдын дэвшүүлсэн хандлагуудаас Лассуэллийн хандлага түгээмэл ашиглагддаг. Тэрээр “улс төрийн үл тоомсорлол”³⁷ хэмээх нэршлээр үүний үндсэн гурван хэлбэрийн илэрхийллийг авч үзжээ. Үүнд:

1. Улс төрийн сонирхолгүй идэвхгүй байдал: Ажил болон бусад зүйлсийг илүүд үзэн улс төрийн сонирхолгүй байх
2. Улс төрийн эсрэг санаа бодол тээх: шашин зэрэг бусад хүчин зүйлсээс шалтгаалан, улс төртэй холбогдохгүйг зориудаар хичээх
3. Улс төрөөс ангид байх, зугтах: Өмнө нь улс төрд идэвхтэй оролцдог байсан ч илтгэл алдах зэргээс шалтгаалан улс төрөөс зугтах байдал гэжээ.

Улс төрийн хүнийслийн талаарх судалгаа 1960 оны сүүл, 1970-аад оны эхээр хүчээ авсан нь өрнөдийн орнуудад улс төрийн эсэргүүцлийн үйл ажиллагаа, хөдөлгөөнүүд идэвхэжсэн, энэ талаарх эмпирик болон онолын судлагаанууд хийгдэх хэрэгцээ шаардлагатай мөн холбоотой. Улс төр судлаач Марвин Олсэн “Хүн төрөлхтөн ерөнхийдөө хүнийсэх хандлага, хариу үйлдэл нь нэмэгдэж байгаа бөгөөд хоёр өөр чиглэлд хамаарах хүнийсэх үйл явц ажиглагдаж байна.”³⁸ гэж тодорхойлжээ.

1. Чадамжгүй байдлын хандлага /attitudes of incapability/

Хүний нийгмийн орчны байдлаас болоод нийгмийн дотоод үйл ажиллагаанд үр дүнтэйгээр оролцож чадахгүй гэж мэдрэх явдал. Энэ тохиолдолд хувь хүнийг

³⁴Wood, M. (2014). *Political alienation in American Society*. Retrieved from <https://scholarworks.uvm.edu/hcoltheses/38/>, 5-6.

³⁵ Finifter, W. (1970). Dimensions of Political Alienation. *The American Political Science Review*. Vol 64. No 2, 389-410.

³⁶ Атар, Ю. (2005). Улс төрийн системийн бүцийн өөрчилөлтөнд нөлөөлөх хүчин зүйлүүд. *Политологи №246 /28/*, 47-52, 49.

³⁷ Бумдарь, Д. (2019). Ардчиллын хөгжил, бэхжилтийн тулгамдсан асуудал, сорилтууд. In *Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт \1990-2019* (pp. 9-41). Улаанбаатар: "Адмон принт" ХХК, 23.

³⁸ E.Olsen, M. (1969). Two categories of political alienation. *Oxford Journals*, Vol 47, (Issue 3), 288-299.

нийгмийн амьдралд бие даасан байдлаа илэрхийлэх эсвэл өөрийн зорилгодоо хүрэхэд нийгмийн систем саад хориг болж байна гэсэн ойлголтоор илэрхийлэгддэг. Өөрөөр хэлбэл хувь хүн нийгмийн системээсээ хүнийсдэг ба уг хандлага нь гурван ойлголтоор илэрч болно.

- a) Удирдамжгүй байдал: Нийгмийн чухал объект руу чиглэсэн үйл ажиллагааг үл тоох байдлаар илэрдэг.
- b) Сул дорой байдал: Нийгмийн чухал объект руу чиглэсэн үйл ажиллагааны арга хэрэгслийг хангалттай ашиглахгүй байх. Энэ нь засгийн газрын бодлого шийдвэрт нөлөөлж чадгүй гэсэн мэдрэмжээс үүдэлтэй байдаг.
- c) Утгагүй байдал: Хувь хүн өөрийн зорилгодоо хүрэх болон үйл ажиллагааг гүйцэтгэх чадамжтай гэсэн итгэлтэй байх ёстой боловч үйл ажиллагааны мөн чанар болон үр дүн хоёрын харилцааны хооронд зөрчил үүсдэг. Улс төрийн үйл ажиллагаа, улс төрийн сонголт зэрэг нь нийгмийн нөхцөлийг өөрчлөх боломжгүй хий хоосон зүйл гэж мэдрэхээс үүсдэг.

2. Дургүйцэх хандлага /attitudes of discontentment/

Хувь хүн нийгмийн амьдрал дахь үйл ажиллагаа болон зорилго нь үнэ цэнтэй биш гэж мэдрэх явдал бөгөөд үүнийг “Улс төрийн цинизм” гэсэн нэр томъёогоор илэрхийлдэг. Уг хандлага дараах ойлголтоор илэрч болно.

- a) Ялгаатай байдал: Нийгмийн орчин дох нийгмийн ялгаатай байдалд дургүйцэх хандлага бөгөөд энэ нь нийгмийн орчинд харьяалагдах газаргүй гэж мэдрэгдэх мэдрэмжээс үүдэлтэй.
- b) Сэтгэл ханамжгүй байдал: Нийгмийн орчин, объектодоо сэтгэл ханамжгүй байх
- c) Урам хугарах байдал: Нийгмийн нь санаа бодолд нийцэхгүй болох.

Улс төр судлаач Ада В.Финифтэр “улс төрийн үйл явц болон засгийн газрын институтуудад олон нийтийн зүгээс хэрхэн хандаж буй хандлагыг судлахад улс төрийн хүнийслийн хэмжигдэхүүнүүд илрэн гардаг”. Түүнчлэн улс төрийн хүнийслийн судалгаанд чадамжгүй болон дургүйцэх хандлагуудыг тогтоохын тулд эдгээр үзэгдлүүдийг хэмжих нь чухал байдаг.

Улс төрийн хүнийслийн чадамжгүй байдлын хандлагыг улс төр судлаач Ангус Кампбэлл, Жэралд Гарин, Варрэн Миллэр нарын “Сонгогчдын шийдвэр” гэсэн бүтээл дэх улс төрийн үр нөлөөтэй байдлын хэмжүүрээр хэмжих боломжтой ба “улс төрийн үр нөлөө гэдэг нь хувь хүний улс төрийн үйл явцад нөлөөлөхүйц улс төрийн үйлдэл хийх эсвэл хийж чадна гэдгийг мэдрэх явдал”³⁹ юм. Ингээд дараах 4 ойлголтын хүрээнд хэмжилт явуулан зөвшөөрсөн тохиолдолд хүнийслийн чадамжгүй байдлын хандлагын индикаторт хамруулах боломжтой гэж үзсэн байна. Үүнд:

- Төрийн албан хаагчид над шиг хүмүүсийн юу гэж боддогийг нэг их тоодог гэдэгт итгэдэггүй.
- Над шиг хүмүүс засгийн газрын үйл ажиллагаанд нөлөөлөх санал өгөхөөс өөр арга байхгүй.
- Заримдаа улс төрчид болон засгийн газрыг хэрхэн үйл ажиллагаа явуулдгийг ойлгоход үнэхээр хэцүү.
- Над шиг хүмүүс засгийн газарт юу хийх талаар нь хэлэх боломжгүй.

Харин дургүйцэл болон улс төрийн цинизмийн хандлагыг дараах хэмжүүрээр хэмжээд ойлголт бүрийг зөвшөөрвөл улс төрийн хүнийслийн индикатор гэж үзэх боломжтой.

- Сүүлийн үед засгийн газар миний зөв зүйл гэж бодохгүй байгаа олон зүйлийг хийсэн.

³⁹ E.Olsen, M. (1969). Two categories of political alienation. *Oxford Journals*, Vol 47, (Issue 3), 288-299.

- Ихэнх тохиолдолд засгийн газар над шиг хүмүүст хамааралгүй бизнес болон цөөн бүлгүүдийн сонирхлыг илэрхийлсэн үйлчилгээ үзүүлж байгаа.
- Засгийн газар олонх хүмүүсийн хүсдэг гарцаагүй шаардлагатай үйл ажиллагааг явуулж чаддаггүй гэж надад санагддаг.
- Засгийн газрын одоогийн бүтэц болон үйл ажиллагаа нь улс орны өмнө тулгарч байгаа чухал асуудлуудыг шийдвэрлэж чадахгүй байна гэж үзэж байна.

Ийнхүү дээрх ойлголтуудтай ижил төстэй хэмжигдэхүүнээр улс төрийн хүнийслийн чадамжгүй байдал болон дургүйцлийн хандлагыг судалсан олон судалгаа шинжилгээ байдаг бөгөөд ихэнх нь улс төрчид болон төрийн албанд итгэх итгэл сулрах, үйл ажиллагаанд нь тааламжтай хандахгүй байх нь улс төрийн системдээ бүхэлд нь сөрөг үнэлэмжтэй болгож байгааг илэрхийлсэн байдаг.

Улс төрийн хүнийслийг судалдаг нэр хүнд бүхий санал асуулга бол “Харрис Полл”⁴⁰ олон нийтийн санаа бодлын тандалт судалгаа бөгөөд 1966 оноос хойш тасралтгүй хийгдэж байгаа АНУ-ын арван наймаас дээш насны иргэдийн улс төрийн хүнийслийн талаарх судалгаа юм. Тус судалгааны үр дүнгээр иргэдийн сонирхлыг эрх мэдэл, нөлөө бүхий хүмүүс сонсож, тэдэнд хэрхэн хандаж буйг хэмждэг ба индексийг 1/ улс орны удирдагч нарт танд юу тохиолдох нь хамаагүй гэж итгэдэг, 2/ баян хүмүүс улам баяжиж, ядуучууд ядуурч байна, 3/ эрх мэдэлтэй ихэнх хүмүүс бусад хүмүүсийн давуу талыг ашиглахыг хичээдэг, 4/ таны бодож байгаа зүйлс тийм ч чухалд тооцогдохгүй гэж итгэх, 5/ эргэн тойронд болж буй зүйлсээс гадуур үйлддэг гэж үздэг гэсэн таван асуултын дагуу боловсруулан хэмждэг. Түүнчлэн судалгаанд оролцогчдын улс төрийн үзэл санаа, нас, хүйс, боловсрол, орлого, үндэс угсаа гэсэн үзүүлэлтээр нь дээрх таван ойлголтод дүн шинжилгээ хийдэг.

⁴⁰ Harris Poll www.theharrispoll.com

Кейс 1: 2013 оны 10-р сарын 16-21-ний хооронд болон 2016 оны 5-р сарын 31-ны өдрөөс 6 дугаар сарын 2-ний хооронд Харрис Полл-ын онлайнаар хийсэн судалгаа үр дүнг тоймлон хүргэвэл:

Зураг 2. Харрис Полл санал асуулгын дүн



Эх сурвалж: www.theharrispoll.com⁴¹ болон www.prnewswire.com⁴²

Америкчуудын улс төрийн хүнийсэл өндөртэй бөгөөд 2016 онд хийгдсэн судалгааны тайланд “Барак Обама бүрэн эрхийн хугацаа дуусахад улс төрийн намын харьяаллаас болж улс төрөөс хөндийрөх хандлага ажиглагдаж байна. Бүгд Найрамдах үзэлтнүүд Ардчилсан болон бие даагчдаас /Independents/ илүү хүнийсэх хандлагатай байгаа бол коллеж төгссөн хүмүүс ахлах сургууль болон бага боловсролтой иргэдээс илүү хүнийсэх хандлагатай байна.” хэмээжээ.

Дээрх ойлголтуудыг нэгтгэн үзвэл улс төрийн хүнийслийн индикаторууд нь дараах нийтлэг хэмжүүрүүдийг тодорхойлдог.

- Хувь хүмүүс улс орон болон олон улсын асуудлыг ойлгох чадвар, асуудлуудыг хууль, дүрэм, журам, бодлого, шийдвэр шийдвэрлэж чадаж байгаа эсэхэд хандах хандлага
- Хувь хүмүүс улс төрийн үйл явцад нөлөөлж чаддаг талаарх хандлага

⁴¹ Allyssa, B., & Elise, S. (2016, Jun 28). *Americans' Sense of Alienation Remains at Record High*. Retrieved from www.theharrispoll.com:https://theharrispoll.com/in-the-midst-of-the-contentious-presidential-primary-elections-the-harris-poll-measured-how-alienated-americans-feel-as-part-of-a-long-term-trend-the-last-time-alienation-was-measured-was-in-novemb/

⁴² *Harris Poll Alienation Index Climbs Again as Two-Thirds of Americans Feel Alienated*. (2013, Nov 12). Retrieved from www.prnewswire.com:https://www.prnewswire.com/news-releases/harris-poll-alienation-index-climbs-again-as-two-thirds-of-americans-feel-alienated-231542101.html

- Төр иргэдийн амьдралд үзүүлэх олон янзын нөлөөг ухамсарлах хандлага
- Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн тэгш боломжийг төр хангаж байгаа эсэх талаарх хандлага
- Тодорхой хүмүүс болон бүлгүүд өөрсдийн эрх ашгийн үүднээс төрийн үйл ажиллагаанд нөлөөлдөг эсэх болон хувь хүний төрийн албанд итгэх эсэх талаарх хандлага

Кейс 2: 1965 онд АНУ-ын Мичиган мужийн Анн Арбор хотод улс төрийн хүнийслийн судалгаа⁴³ хийгдсэн бөгөөд түүврээ боловсрол, ажил мэргэжил, орлого, нас, хүйс гэсэн нийгэм эдийн засгийн хүчин зүйлсийн харилцан хамаарлаар улс төрийн хүнийслийн онцлогийг тодорхойлохоор зорьсон. Ингэхдээ хотын бүх хэсэг бүрээс 154-200 орчим оролцогчдыг “дундаас дээгүүр анги” болон “дундаас доогуур анги” гэсэн хоёр үзүүлэлтээр түүврэлэн авсан байна. Уг судалгааны үр дүнг дараах байдлаар тодорхойлох боломжтой.

- Хүнийслийн түвшнээр нь судалгаанд оролцогчдыг үнэлбэл “Өндөр хүнийсэл”-тэй 16,2 хувь, “дундаж хүнийсэл”-тэй 19,5 хувийг эзэлж байгаа бол хүнийслийн чадамжгүй байдлын хандлага нь 35,7 хувь, дургүйцлийн хандлага нь 35,3 хувийг эзэлж байна.
- Коллеж төсөгчдийн 50 хувь, бизнес болон мэргэжлийн өндөр статустай оролцогчдын 63 хувь, жилийн 10,000 доллараас дээш орлоготой хүмүүсийн 43 хувьд нь улс төрийн хүнийсэл идэвхтэй байна.
- Бага боловсролтой бичиг хэргийн ажилчид, өндөр настнууд, эмэгтэйчүүд америкийн нийгмийн амьдралд бага оролцдог ба үүнийхээ хэрээр улс төрийн хүнийслийн түвшин нэмэгдэж байна.
- Улс төрийн үзлийн хувьд ардчилсан үзэлтнүүд бүгд найрамдах үзэлтэй эсвэл бие даасан үзэлтэй хэсгээс илүү улс төрийн чадваргүй байгаагаа илэрхийлдэг.

Дээрх кейсээс харахад улс төрийн хүнийсэх хандлага ерөнхий хоёр шалтгаантай гэж судлаачид үздэг ба нэгд, иргэдийн амьдралын түвшин хангалуун, чадамжтай болох тусам улс төрийн сонирхол нь буурдаг, хоёрт, иргэдийн улс төрт итгэх итгэл буурч, улс төрийн нөлөөгүй гэж итгэх, нийгмийн амьдралд идэвхгүй байх зэрэг нь улс төрийг сонирхохгүй болгож улс төрөөс хүнийсдэг. Хувь хүн нийгэм, улс төрийн амьдралаас хөндийрөх нь нэг талаас бусадтай харилцах болон нийгмийн давуу талуудыг олж авахад саад болдог, нөгөө талаас төрөөс гаргаж буй бодлого, шийдвэрүүд тохирохгүй болж эхэлдэг.

Тиймд судлаачид улс төрийн хүнийслийг судалж хэмжүүрүүдийг нь тодорхойлон, байгаа эсэхийг тогтоон, шалтгааныг нь илрүүлэх, үр дүнг нь тооцоолох нь шийдвэр гаргагчдад улс орны улс төрийн соёлын хэм хэмжээг тодорхойлох, улс төрчдийн үйл байдалд дүн шинжилгээ хийх, улс төрийн хүнийслийн цаашдын ойлголтод тодруулга хийх, олон төрлийн нийгмийн гишүүд болон нийгмийн нөхцөл байдлын талаар хүнийсэлтэй хамаарал бүхий нарийвчилсан таамаглал дэвшүүлэх, нийгэм, сэтгэлзүйн янз бүрийн хувьсагчдын хоорондын харилцааны тааламжтай нөхцөл үүсэхэд олон талаас нь хэмжих зэрэг олон давуу талыг бий болгож улс төрийн системийн тогтвортой байдлыг хангах эрдэм шинжилгээний ач холбогдолтой юм.

⁴³ E.Olsen, M. (1969). Two categories of political alienation. *Oxford Journals*, Vol 47, (Issue 3), 288-299.

Хэлэлцүүлэг

Хүнийслийн тухай ойлголтын онолын боловсруулалт IX зуунд хийгдэж эхэлсэн боловч эрдэмтдийн дунд нэгдсэн байр сууринд хүрэлгүй 1930-аад онтой золгосон бөгөөд одоог хүртэл судалгааны хувьд маргаантай байдаг ч ерөнхийдөө зургаан гол чиглэлд судалгааны хүрээгээ тогтоосон байна. Анхлан ямар нэг хязгаарлалтаас чөлөөлөгдөх тухай ихэвчлэн яригддаг байсан бол орчин үеийн улс төрийн шинжлэх ухаанд төр, төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагаанд иргэдийн үнэлэмж буурч, итгэл алдсанаас үүдэн гарч буй иргэдийн үйл байдал нийгэм, улс төрийн үйл явцад хэрхэн нөлөөлж байгааг судлах болсон. Тийм ч учраас хөгжингүй орнууд улс төрийн хүнийслийг хэмжих нь төр, улс төрчдийн үйл ажиллагаанд дүгнэлт хийх чухал ач холбогдолтой хэмээн үзэж эрдэмтдийн боловсруулсан тодорхой ойлголтуудын хүрээнд индикаторуудаар хэмжих болжээ. Олон улсын туршлагад тухайлан улс төрийн хүнийслийн талаар хийгддэг олон нийтийн санаа бодлын судалгаанууд тогтмол явагддаг байна.

Иргэдийн улс төрөөс хүнийсэх хандлагыг учир шалтгаан болон түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг олон талаас нь судлан тогтоохгүйгээр олон асуудлын үндэс болж, эргэх холбоотойгоор шийдэгдэхгүй байгаа төр иргэн хоёрын хоорондын харилцааны зөрчилт байдлын асуудлуудыг шийдвэрлэхэд бэрхшээлтэй болов уу. Улс төрийн хүнийсэл нь нийгмийн зүгээс бодлого боловсруулах, шийдвэр гаргахад мэдээлэх, бодлогын үйл явцыг хянах, үнэлэх үнэлгээний үүрэг гүйцэтгэдэг тул энэ талаарх судалгаа шинжилгээ нь зөрчилтэй байгаа асуудлыг нөхцөл байдлыг сайжруулах, шийдвэрлэх боломжит хувилбарыг гаргахад чухал нөлөөтэй тул улс төрийн хүнийслийг хэмжих индикаторуудыг тодорхойлох нь чухал ач холбогдолтой юм.

Abstract

The social sciences, such as history, society, philosophy, social psychology, and political science, study the alienation. Since the 1980s, political alienation has been strongly observed in Western countries. Therefore, political scientists are paying more attention to the importance of research on this issue and the need for specialized research in this field. The purpose of this article is to show the general concept and terminology of alienation, the concept changes in the social development, and the theoretical and methodological approaches of political alienation, research directions and criteria.

Ашигласан зохиол

- Alienation*. (2018, Aug 30). Retrieved from Plato.stanford.edu: <https://plato.stanford.edu/entries/alienation/>
- Allyssa, B., & Elise, S. (2016, Jun 28). *Americans' Sense of Alienation Remains at Record High*. Retrieved from www.theharrispoll.com: <https://theharrispoll.com/in-the-midst-of-the-contentious-presidential-primary-elections-the-harris-poll-measured-how-alienated-americans-feel-as-part-of-a-long-term-trend-the-last-time-alienation-was-measured-was-in-novemb/>
- Amin, C. Z. (2016, 6 18). *Attitude: Adoption and Change*. Retrieved from slideshare.net: <https://www.slideshare.net/zulfiqur732/attitude-formation-and-change>
- Chuluunbaatar, G. (2018). Deliberative democracy as a possible solution to the challenges of Mongolian Democracy. *Proceedings of the International Conference on "Deliberative Democracy in Asia"*, (pp. 55-72). Ulaanbaatar.
- Comninel, G. C. (2018). *Alienation and Emancipation in the Work of Karl Marx*. New York: Springer Nature America Inc.

- E.Olsen, M. (1969). Two categories of political alienation. *Oxford Journals*, Vol 47, (Issue 3), 288-299.
- Easton, D. (1965). *A systems Analysis of Political Life*. New York: John Wiley & Sons.
- FindLaw's team. (2020 оны Mar 18). www.findlaw.com. What does Abstention from Voting Mean?: <https://www.findlaw.com/voting/my-voting-guide/what-does-abstention-from-voting-mean-.html>-ээс Гаграсан
- Finifter, W. (1970). Dimensions of Political Alienation. *The American Political Science Review*. Vol 64. No 2, 389-410.
- Harris Poll Alienation Index Climbs Again as Two-Thirds of Americans Feel Alienated*. (2013, Nov 12). Retrieved from www.prnewswire.com: <https://www.prnewswire.com/news-releases/harris-poll-alienation-index-climbs-again-as-two-thirds-of-americans-feel-alienated-231542101.html>
- Klima, M. (2017). *Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал руу*. Улаанбаатар: "Сэлэнгэпресс" ХХК.
- Oskarsan, M. (2007). *Social Risk, policy Dissatisfaction and Political Alienation: A Comparison of Six European Countries*. Stanford University Press.
- Patterson, T. E. (2008). *The American Democracy*. New York: McGraw-Hill Companies, Inc.
- Sidney, J. J. (1983). *The Alienation of the individual from society: A social-psychological theory and cross-cultural comparison*. <https://lib.dr.iastate.edu/rtd/8484/>.
- Social indicators*. (2016, May 16). Retrieved from www.progress.org: <http://wikiprogress.org/articles/archive/social-indicators/>
- Tomas, I. P. (2020). Alienation and fetishism in Karl Marx's Critique of Political Economy. *Nova Economia* Vol 30 No2.
- Viktor, D., Amna, E., & Banaji, S. (2018). Apathy or Alienation? Political passiving among youths across eight European Union Countries. *European Journal of Development Psychology* Volume 158, 284-301., 284-301.
- Wood, M. (2014). *Political alienation in American Society*. Retrieved from <https://scholarworks.uvm.edu/hcoltheses/38/>.
- Атар, Ю. (2005). Улс төрийн системийн бүцийн өөрчилөлтөнд нөлөөлөх хүчин зүйлүүд. *Политологи №246 /28/*, 47-52.
- Базарпүрэв, С., & Туяагэрэл, Г. (2011). Улс төрийн сэтгэлгээний түүхэн дэх улс төрийн хямралын тухай үзэл санаа ба түүний хувьсан өөрчлөлт. *Политологи №350 /62/*, 34-51.
- Бумдарь, Д. (2019). Ардчиллын хөгжил, бэхжилтийн тулгамдсан асуудал, сорилтууд. In *Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт \1990-2019* (pp. 9-41). Улаанбаатар: "Адмон принт" ХХК, 23.
- Хууль зүй, Дотоод хэргийн яам. (2007). Шүүх, эрх зүйн шинэчлэлт, Философи гарын авлага, Улаанбаатар, 71.
- Төмөрбаатар, Я. (2020). Хүнийсэл. Т. Ж, & М. С-Д, *Улс төрийн шинэслэх ухааны нэвтэрхий толь* (хуудсд. 747-750). Улаанбаатар: Адмон принт ХХК.

БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОЛЫН ЗАГВАР, ХАНДЛАГУУД

Ц.Батболд

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхимийн дэд профессор

Түлхүүр үг: Бодлого, бодлого боловсруулах, бодлого боловсруулах онолын загварууд,

Агуулга: Бодлогын судалгааны онолын загвар хандлагууд болох улс төрийн системийн хандлага, рационал хандлага, инкрементал хандлага, институциональ хандлага, хогийн сав загвар, социал конструктив хандлагыг оюутан судлаачдад товч танилцуулахад чиглэгдсэн бөгөөд энэ хүрээнд ерөнхий дүгнэлт гаргасан.

Хураангуй: Шинжлэх ухааны танин мэдэхүйн чиглэл бүхий уг өгүүлэлд бодлого боловсруулалтын онолын загвар, хамрах хүрээний талаар товч авч үзсэн. Уг өгүүлэлд бодлогын шинжилгээний улс төрийн системийн хандлага, түүний мөн чанар, системийн хандлагын хязгаарлагдмал шинж ба шүүмжлэл, бодлогын шинжилгээний рационал хандлага, түүний мөн чанар, рационал шийдвэр гаргах хандлага, рационал хандлагын хязгаарлалтууд, бодлогын шинжилгээний инкрементал хандлага, түүний мөн чанар, инкрементал шийдвэр гаргах боломжууд, стратегийн бодлого боловсруулах, бодлогын шинжилгээний институционал хандлага, түүний мөн чанар, бодлого ба институц зэргийг товч тайлбарласан. Мөн бодлогын шинжилгээний “хогийн сав” загвар, түүний мөн чанар, шийдвэр гаргах анархи загвар, бодлогын судалгааны социал конструктив хандлага, социал конструктивизмын төрлүүд, социал конструктивист судалгаа, социал конструктивизмын бодлого боловсруулах үйл явц зэргийг авч үзсэн.

Бодлого боловсруулалтын онолын загвар, хамрах хүрээ

Энгийн хэлээр бодлого гэдэг нь зорилго, санаа бодлын тунхаглал эсвэл жирийн байдлаар томъёолоход үйл хэрэг явуулах шийдвэр юм. Олон нийтийн бодлого боловсруулахад хэрэгтэй хэд хэдэн асуулт байдаг: (1) Хэн бодлого боловсруулдаг вэ, яагаад? Бодлогын процессын хүч чадал хаана нуугдаж байдаг вэ? Ямар ашиг сонирхол, шаардлагыг харгалзан үздэг вэ? Бодлогын шийдвэр, үр дүнгээс хэн илүү ашиг орлого олдог вэ? гэх мэт.

Өөр өөр бодлогын загварууд болон онол нь бодлого боловсруулалтыг бодит байдалд өөрөөр хийдгийг ойлгоход туслана. Бодлого аливаа үйлдлээс өмнө тохиолддогт зарим нь эргэлзэж байдаг. Зарим нь бодлого боловсруулах шинжлэх ухааны зүй зохистой байдлыг асуудаг. Аарон Вилдавски бодлогын шинжилгээг урлаг гэж үзсэн. Бодлогын шинжлэх ухаанд сахилга журмыг тодорхойлох явцад нийтийн бодлого нь бодлого боловсруулах хүмүүний шаардлагыг тусгасан байдаг. Практикт, бодлого боловсруулах үйл явц нь шинжлэх ухаан төдийгүй урлаг юм.

Бодлого боловсруулахад асуудал болон бэрхшээлийг тодорхойлох үйл явцад анхаарлаа хандуулахаас гадна үр ашигтай шийдлийг эрж хайх, хийж гүйцэтгэхэд шаардлагатай хэрэгжилтийн шалгуурыг бий болгох зэрэг цогц үйл ажиллагааг

шаарддаг. Улс төрийн тоглогчдын дундын харилцааны танин мэдэхүйн тодорхой цаг хугацааны үйл явцаар төрийн бодлогын зорилго тодорхойлогддог бөгөөд байгууллагын хүрээнд байгаа эх сурвалж, хүчин чадлын хэмжээнд тохируулан тэд зорилгоо биелүүлэхэд шаардлагатай боломжийг тогтооно. Бодлогын тоглогчид, байгууллага хоёр нь аливаа бэрхшээлийг шийдвэрлэх бодлогын агуулгыг тодорхойлох үйл явцад хамтран ажиллаж, шийдвэрийн дагуу хэрэгжилтийг зохион байгуулна.

Бодлогын шинжилгээний онолын загваруудыг 1970, 1980-аад оны үед төрийн бодлогод идэвхтэй ашиглах болсон байна. Энэ хүрээнд шинжээчид бодлогын шинжилгээний бүтэц, загваруудыг асуудал болон түүний нөхцөл байдалтай харилцан уялдаатайгаар зохион бүтээж ашиглаж иржээ. Бодлогын шинжилгээний загвар нь онолч эрдэмтдийн нийтлэлүүд болон шинжээчдийн бүлгийн эмпирик судалгааны үйл ажиллагааны үр дүнд шийдвэрлэх асуудлын бодит байдлын нийтлэг талуудын хил хязгаарыг тогтоох ойлголтын хүрээнд үүсжээ. Төрийн буюу нийтийн бодлогыг судлахад бодлогын шинжилгээний янз бүрийн загварыг хэрхэн тодорхойлж, асуудлын мөн чанартай хэрхэн холбогдохыг хэлэлцэж, түүнийг хэрхэн ашиглах ёстой талаар бодлогын үзэл баримтлалын хүрээнд шийдвэрлэдэг бөгөөд эдгээр нь янз бүрийн зөрчилдөөнт байр суурь, үзэл бодлын ялгаатай талууд нь хэрхэн өөрчлөгдөж, хамгийн боломжит хувилбар дээр хэрхэн санал нэгдэхийг шийдвэрлэдэг. Өөрөөр хэлбэл, бодлогын шинжилгээний загварууд нь асуудлыг шийдвэрлэх арга замуудыг тодорхойлох, бодлогын хамгийн оновчтой хувилбарыг сонгоход тусалдаг.

Бодлогын судалгаа нь бодлогын шинжилгээ (орчин, агуулга, хэрхэн хийгдсэн, хэрэгжсэн, улс төрийн процесс нь бодлого юм), бодлогод чиглэсэн шинжилгээ (бодлогын судалгаа, мэдээлэл) гэсэн хоёр үндсэн төрлүүдтэй. Бодлого боловсруулах явцад бэрхшээлтэй асуудлыг танин мэдэж, тодорхойлон бодлогын агуулгыг тогтоох, шийдвэр гаргагч нарын сонорт хүргэх байдлыг концепцийн хүрээнд шийднэ. Бодлого боловсруулалтыг бодлогын гүйцэтгэл эсвэл хэрэгжилтээс салангид үзэх хэрэгтэй ч сүүлийн хоёрыг нь хоорондоо харилцан хамааралтай болохыг судлаачид дүгнэн үзэж тэдгээрийг бодлогын залгамж холбооны хэсэг гэж харах болсон байна.

Рационал хандлага нь бодлогыг илүү ухаалаг шинжлэх ухаанч байдлаар техникийн, шийдвэр гаргах үйл явцын үр дүнд суурилсан, асуудлыг шийдэлд хүргэсэн, шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэгддэг. Бодлогын хэрэгжилт нь үзэл баримтлалын хувьд ямар нэг асуудал үгүй нэгэнт шийдэгдсэн, зөвхөн техник-эдийн засгийн үндэслэлээр тодорхойлогдож чиглэгдсэн төдийгүй эдгээр хүрээнд хянагдсан байдаг.

Улс төрийн тоглогч нарын институт хоорондын хэлэлцээрийн дүн бол бодлого гэж үзэх улс төрийн хандлага байдаг бөгөөд тэдний тэмцлийн үнэт зүйлс, ашиг сонирхол, агуулга, стратеги, эрх мэдлийн эрх сурвалж нь тодорхой бус, мөргөлдөөнт, зөрчилдөөнт орчинд үргэлжилдэг. Бодит ертөнцөд бодлого боловсруулах бодит процесс нь бодлогын институтууд, бодлого тодорхойлох орчин, дотоодын болон үндэсний, бүс нутгийн болон дэлхийн чиг хандлагатай уялдадаг.

Бодлого боловсруулах үйл явц нь шинэ бодлого боловсруулах эсвэл шинээр танигдсан, дахин тодорхойлсон бэрхшээлтэй уялдуулан одоо мөрдөж байгаа бодлогыг өөрчлөхийг шаарддаг. Иймийн учир бодлого нь инноваци, хэрэгжилт болон түдгэлзэх хүртэлх шатлалыг дамжина. Бодлогын шинжээч аль ч засгийн газар, олон нийтийн байгууллагын бодлогын чадавхийг судалж, стратегийн чиглэлийг сонгохын тулд мэдээлэл, шийдвэр гаргах хүч чадлыг хослуулан хэрэглэдэг.

Сонголт нь үнэт зүйлстэй холбоотой. Олон нийтийн бодлогыг боловсруулахад, асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай шийдлийг олохоос гадна зарим чухал үнэт

чанартай тухайлбал, таван Е-гийн зарчим нь эдийн засаг, үр ашиг, үр нөлөө, шударга байдал, тэгш байдал зэргийг уялдуулах нь чухал гэж үздэг бөгөөд зарим нь зургаа дахь Е-г (сонгогдох байдал/electability) нэмж өгсөн байна. Эдгээр үнэт зүйлсүүд өөр хоорондоо зөрчилдөж болох хэдий ч, улс төрийн ур чадварыг шалгасан байдлаар асуудал шийдэгддэг. Өргөн утгаар нь авч үзвэл бодлого боловсруулах, шинжилгээ хийх, шийдвэр гаргахтай холбоотой арга зүйн хоёр үндсэн хандлага байдаг:

1) Рационал хувилбар. Энэ хувилбар нь бодлогыг санаа зорилго гэж үзэж, бодлого боловсруулалтыг бодлогын сонголттой нэгтгэн асуудалд ханддаг бөгөөд бодлогыг шугаман процесс гэж үздэг байна.

2) Бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх бодит (реалист) ухагдахуун. Энэ хандлага бодлогыг үр дүн талаас нь хэлэлцдэг бөгөөд асуудлыг танин мэдэх, агуулгыг тодорхойлох болон хэрэгжилтийг нэгтгэж үзсэнээр бодлогын шийдвэр гаргах бодит нөлөөг үүсгэж байдаг харилцан хамаарлын процесс гэж дүгнэж байна.

Энэхүү хүрээлэлд бодлого боловсруулах болон бодлогын шинжилгээнд онолын дөрвөн үндсэн хандлага нь бодлого боловсруулах явцад хөгжиж ирсэн ажээ. Эдгээр нь 1) системийн хандлага, 2) рационал хандлага, 3) инкрементал хандлага, 4) институциональ хандлага юм. Бодлогын шинжилгээний хөгжлийн явцад дээрх хандлагууд нь бүрэн загварчлагдаж ирсэн бөгөөд эдгээрээс харьцангуй их шүүмжлэл дагуулсан системийн хандлага нь орхигдож, 1) институциональ загвар, 2) рационал загвар, 3) инкрементал загвар, 4) хогийн сав загварууд нь хөгжсөн байна.


Бодлогын шинжилгээний улс төрийн системийн хандлага

Бодлогын шинжилгээний системийн хандлага нь улс төрийн болон нийгмийн системийн тэнцвэрийг хангах гарц болох нийтийн буюу төрийн бодлогыг чухалчилдаг. Бодлогын асуудал нь хэн гэдэгт төвлөрч асуудлын хүрээнээс хамааран хувь хүн, бүлэг, улс орны нийгэм, улс төр, эдийн засаг, оюун санааны амьдралыг тэнцвэржүүлэхэд чиглэгддэг. Системийн субъектив үйлдлүүдийг яаж гэдэг асуудлаар шийдвэрлэдэг бөгөөд энэ нь хүрээлэн буй (байгаль, нийгэм, олон улсын гэх мэт) орчны орцыг улс төрийн тогтолцоонд түлхэц өгч, гарц, санал хүсэлтийг гаргаж ирдэг. Хэрэгжүүлэлт нь шинжлэх ухааны үндэслэлтэй урьдчилан тооцоолсон прогноз, таамаглалд тулгуурлах бөгөөд систем нь нийгэм дэх бүх нийтийн дэмжлэгийг шаарддаг, эрх мэдэл бүхий шийдвэрүүдэд хэрэгцээ шаардлагыг хувиргах чиг үүрэг бүхий институциуд, үйл ажиллагааны багцыг оруулан тооцно. Системийн элементүүд хоорондоо харилцан хамааралтай, систем нь хүрээлэн буй орчинд өөрийн хүч чадлаараа хариу үйлдэл үзүүлж болох бөгөөд өөрөө өөрийгөө хамгаалахын тулд үүнийг хийнэ гэсэн үг юм.

Улс төрийн бодлого боловсруулах үйл явцыг Дэвид Истон нийгмийн шаардлагыг бодлого болгон хувиргадаг “Хар хайрцаг” (black box) хэмээн тодорхойлсон байдаг. Улс төрийн системийг судалж үзсэнийхээ үр дүнд Дэвид Истон улс төрийн тогтолцоо нь эрх мэдлийг ашиглан баялаг, үнэт зүйлсийг хуваарилан байршуулах нийгмийн нэгэн хэсэг гэж үзсэн. Улс төрийн судалгааны системийн хандлагыг Загвар 1-д үзүүлэв.¹

Загвар 1. Д.Истоны "хар хайрцаг" загвар (Бодлогыг шинжлэх хүрээ; 1965)

¹ Easton, David, 1965, A Framework for Political Annlysis. N.J. Prentice Hall, Englewood Cliffs.



Эх сурвалж: Adapted from Easton's A Framework for Policy Analysis (1965)

Хүснэгт 1. Д.Истоны улс төрийн системийн тайлбар

Нийгмийн дотоод орчин:

- Экологийн систем
 - Биологийн систем
 - Хувь хүний систем
- Нийгмийн систем

Нийгмийн гадаад орчин:

- Олон улсын улс төрийн системүүд
- Олон улсын экологийн системүүд
- Олон улсын нийгмийн системүүд

Эх сурвалж: Зохиогч. Easton, David, 1965, A Framework for Political Annlysis. бүтээлээс товчлон зохиомжлов.

Дээрх загварт Д.Истон улс төрийн системийн шинжилгээний тухай ойлголтыг тайлбарласан. Оролт нь орчны физик, нийгэм, эдийн засаг, улс төрийн бүтээгдэхүүн юм. Эдгээрийг улс төрийн тогтолцоонд шаардлага ба дэмжлэг гэсэн хоёр хэлбэрээр авч үздэг. Шаардлага гэдэг нь орчиндоо өөрчлөлт авчрахын тулд хувь хүн болон бүлэг хүмүүсийн улс төрийн системд бий болгож буй тулгалт юм. Шаардлага нь орчиндоо шинэчлэл хийх хүсэлтэй хувь хүн эсвэл бүлгүүд төрийн бодлогод нөлөөлөх үед үүсдэг. Орчин гэдэг нь улс төрийн тогтолцооны хил хязгаараас гадуур өрнөх нөхцөл байдал, тэдгээрийн үйл ажиллагаа юм.

Оролтын хоёр дахь хувилбар болох дэмжлэг гэдэг нь улс төрөөс ангид нийгэм ба эрх мэдэлтнүүдийн оршин тогтнох үндэс суурийг тавьж өгдөг дүрэм, хууль, ёс заншлаас бүрддэг байна. Дэмжлэг нь хувь хүмүүс эсвэл бүлгүүд шийдвэр буюу хууль тогтоомжийг хүлээн зөвшөөрөхөд бий болдог. Дэмжлэг нь тогтолцоо дахь сэтгэл зүйн ба материаллаг нөөцийг бүрдүүлэх системийн бэлэг тэмдгийн болон бодитой оролтыг (тухайлбал, хуулиа дагаж мөрдөх, татвар төлөх эсвэл үндэсний далбааг хүндэтгэх зэрэг) хэлдэг байна.

Бодлого боловсруулах улс төрийн тогтолцооны гол цөм нь байгууллагууд ба хувь хүмүүс байдаг. Эдгээрт гүйцэтгэх захирал, хууль тогтоогч, шүүгч, төрийн өндөр дээд албан тушаалтнууд орно. Системийн хувилбарт тэд оролтыг гаралт болгон хувиргадаг. Үүний үр дүнд эрх мэдлийг ашиглан улс төрийн системийн үнэт зүйлсийг хуваарилах бөгөөд эдгээр хуваарилалт нь төрийн бодлогыг бий болгодог.

Системийн онолд төрийн бодлогыг улс төрийн тогтолцооны гаралт гэж үздэг. Эргэх холбоо гэсэн ойлголт нь төрийн бодлого орчны болон үүнтэй холбогдох

хэрэгцээ шаардлагыг өөрчлөхүйц нөлөө үзүүлж, улс төрийн тогтолцооны шинж чанарт нөлөөлж болно гэдгийг харуулж байдаг. Бодлогын гаралт нь системд шинэ шаардлага болон дэмжлэгийг бий болгож, эсвэл өмнөх дэмжлэгийг буцааж бий болгодог байна. Ирээдүйн бодлогод тохиромжтой орчинг бүрдүүлэхэд эргэх холбоо чухал үүрэг гүйцэтгэдэг.

Системийн хандлагын хязгаарлагдмал шинж ба шүүмжлэл

Системийн онол нь бодлого боловсруулах үйл явцыг ойлгоход чухал ач холбогдолтой. Томас Дая (Thomas Dye; 1980) бодлогод шинжилгээ хийх системийн загварын үнэт зүйлс нь тэдгээрийн асуултуудад оршдог² гэжээ. Тэдгээр асуултуудыг дор дурьдвал:

- Улс төрийн тогтолцоонд тавигддаг шаардлагыг бий болгодог хүрээлэн буй орчны чухал хэмжигдэхүүнүүд нь юу вэ?
- Тогтолцооны шаардлагыг төрийн бодлогод шилжүүлж, цаг хугацааны туршид үүнийгээ хадгалж үлдэх боломжийг олгох улс төрийн системийн чухал шинж чанарууд юу вэ?
- Хүрээлэн буй орчны оролт нь улс төрийн системийн шинж чанарт хэрхэн нөлөөлдөг вэ?
- Улс төрийн тогтолцооны шинж чанар нь төрийн бодлогын агуулгад хэрхэн нөлөөлдөг вэ?
- Хүрээлэн буй орчны оролт нь төрийн бодлогын агуулгад хэрхэн нөлөөлдөг вэ?
- Эргэх холбооны үр дүнд үүссэн төрийн бодлого нь улс төрийн системийн орчин болон шинж чанарт хэрхэн нөлөөлдөг вэ?

Төрийн бодлогыг судлахад системийн загварыг ашиглах нь хэд хэдэн хүчин зүйлсээс шалтгаалж хязгаарлагдмал байдаг. Энэ оролт-гаралтын загвар нь бодлого боловсруулах үйл явцыг ойлгоход үр дүнтэй туслалцаа үзүүлдэгч хэтэрхий хялбарчлагдсан гэж үздэг. Энэ загвар нь халамжийн эдийн засгийн ач холбогдол бүхий арга техникийг ашиглаж, “нийгмийн халамжийн функц”-ийг хамгийн ихээр тодорхойлдог. Уламжлалт оролт-гаралтын загваруудын бас нэгэн сул тал бол “хар хайрцаг”-ны хэсэгчлэгдсэн шинж чанарыг авч хэлэлцдэггүй явдал юм. Системийн хандлагын бодлого боловсруулалтын бүрэлдэхүүн хэсгүүдэд “эрх мэдэл, хувь хүн, захиргааны байгууллага” зэрэг нь дутуу байдаг. Роберт Лайнберри системийн хандлагын талаарх ажиглалтынхаа үр дүнд “Улс төрийн шийдвэр гаргагчид улс төрийн тогтолцоон дахь хүрээлэн буй орчинд эдийн засгийн хүчин зүйлс хүчтэй шахаж байдаг гэдгийг мартахгүй байх ёстой” гэдгийг онцолсон байна.³

Истоний загвар нь бодлого боловсруулагчид (үүнд байгууллагуудыг оролцуулаад) үйл ажиллагаа явагдаж байгаа орчинд нөлөө үзүүлэх хүчин чадал нь нэлээд их байдаг улс төрийн бодлогын үйл явцын чухал элементүүдийг гээгдүүлдэг. Уламжлалт оролт-гаралтын загвар нь шийдвэр гаргах системийг “хөнгөвчилсөн” ба “шалтгаант чанартай” гэхээсээ илүү үнэ цэнэ багатай бүхэлдээ тодорхой бус бүтэцтэй гэж үздэг. Өөрөөр хэлбэл, тогтолцооны бүтцийн өөрчлөлт нь төрийн бодлогод шууд нөлөө үзүүлдэггүй. Мөн улс төр болон бюрократ дахь ноёрхогч элитүүд нь олон нийтийн санал бодлоор манлайллын үзэл санааг илэрхийлдэг гэж үздэг. Үүний “дотоод агуулга”-д энэ санааг харуулсан оролттой өрсөлдөхүйц санаанууд байдаг.

² Dye, Thomas R., 1980, *Understanding Public Policy*, Prentice Hall, Englewood Cliffs.

³ Lineberry, Robert L., 1984, *American Public Policy: What Government does and What Difference it Makes*, Marcel Dekker, New York.

Тиймээс бодлогын өөрчлөгдөн дахин тодорхойлогдсон бүтээгдэхүүнд улс төр, засаг захиргааны элитүүдийн үзэл бодол хүрээлэн буй орчноос ирсэн шаардлага, дэмжлэгээс илүүтэй холбоотой байдаг. Ихэнх тохиолдолд ноёрхогч засаглалаас бодлогын санаачилга гардаг. Өөрөөр хэлбэл, засаглал нь бодлогыг боловсруулах, хууль ёсны болгох хүчирхэг институц юм.

Барууны ардчиллын хувьд бодлогын чиглэлийг тодорхойлоход ноёрхолын засаглалын үүрэг тун бага байдаг. Бодлогын чиглэл нь одоо ч гэсэн улс төрийн элитүүдийн давамгайлах уламжлалт хэлбэртэй хэвээр байна. Нөгөө талаас, улс орнуудын зорилт нь бүрэн холбогдсон, тодорхой биш байгаа Энэтхэг зэрэг хөгжиж буй оронд ноёрхолын засаглал нь альтернатив бодлогын төлөвлөгөөнүүдээс сонголт хийх үйл явцын үед хялбархнаар хөрөнгөждөг. Тэд төрийн бодлого боловсруулахад оролцохоос гадна цэвэр техникийн үүрэг даалгаврыг биелүүлдэг.

Эцэст нь, гадаад болон дотоод орчны цар хүрээнд систем дэх шийдвэр гаргагчдын үзэл санаа, үнэт зүйлд суурилдаг бодлого боловсруулах үйл явцын нөлөө оршдог гэж үздэг байна. Энэхүү санаа нь бодлого боловсруулалт нь бодлогын агуулгыг төдийгүй бодлого боловсруулагчийн үзэл хандлага, үнэт зүйлсийг хамардаг гэдгийг харуулж байна. Үндсэндээ бодлого боловсруулагчдын үнэт зүйлс нь бодлогын төрөл бүрийн хувилбаруудыг ойлгоход чухал ач холбогдолтой гэж үздэг.

Бодлогын шинжилгээний рационал хандлага

Рационал хандлага гэдэг үг нийгмийн шинжлэх ухааны зохиол бүтээлүүдэд маш их дурдагддаг боловч энэ хандлага нь бодлого боловсруулалтад илүү өргөнөөр хэрэглэгддэг. Гэхдээ рационал үзэл бодол нь зөвхөн бодлого боловсруулахад ашиглагддаггүй, түүнээс илүү өргөн цар хүрээтэй ойлголт юм. Бодлого боловсруулалтад рационал үзлийг “мэргэн ухааны хэмжүүр” гэж тооцдог. Энэ арга нь бодлого боловсруулахад бусад олон бодлогын хувилбараас “хамгийн сайныг сонгох” явдлыг онцолдог. Роберт Хэймэний ажигласнаар рационал бодлого нь “цэвэр ашиг”-ийг хамгийн их байлгах зорилготой ажээ.

Рационализмын цэвэр хэлбэр нь рационал цогц загвар бөгөөд энэ нь рационал бодлого боловсруулах “төгс” нөхцөл байдалд шинжлэх ухаанч байж эдийн засгийн онолын сонголт нь рационал байна гэж үздэг. Энэхүү нөхцөл байдал нь тодорхой логик, учир шалтгааны дараалалтай, нэрлэсэн үнэт зүйлсийг тодорхойлж, зорилго, зорилтуудыг тодорхойлж дэс дараалуулах, нөөц сонголтыг бий болгож асуудал шийдвэрлэх арга замыг сонгох, сонголт бүрт тохирсон үр дагаврыг тооцоолох, үнэт зүйлс ба зорилгод нийцсэн шинж чанарыг бий болгох, ашиг орлогыг нэмэгдүүлж, зардлыг бууруулах зэрэг байж болно.

Рационал загвар онолын цэвэр байдлыг хадгалж байдаг ч бодит байдал (реализм)-ын үйл байдлаар дутагддаг. Түүний цогц хэлбэр нь танин мэдэхүйн хязгаарлалт (мэдлэг, төсөөлөл, ур чадварын дутмаг), физиологийн хязгаарлалт (тодорхой бусаас айх, сонгох мэдрэхүй), байгууллагын хязгаарлалт (хэвшсэн ажиллагааны журам болон эрх зүйн чадамжаас хамаарсан зорилгын хязгаарлалт), эх сурвалжийн хязгаарлалт (эх үүсвэр, цагийн дутагдал, хязгаарлалт)-аас хамаарна.

Томас Дая рационал байдлыг үр ашигтай адилтгадаг. Түүний өгүүлснээр “Бодлого үр ашигтай байхдаа хамгийн рационал байдаг буюу олсон үнэ, зольсон үнэ хоёрын харьцаа эерэг бөгөөд бусад бодлогын хувилбараас хавьгүй илүү байх үед рационал гэгдэнэ. Цаашлаад тэрээр зольсон үнэнд мөнгөн хэмжүүр гэхээс илүү улс

төрийн бодлогын золиослосон нийгэм, улс төр, эдийн засгийн гэх зэрэг бүх золиос хамаарна”⁴ гэжээ.

Шийдвэр гаргагчдын тооцооллын боломжууд нь хязгаарлагдмал байдаг бөгөөд тэд өргөн хүрээнд сонголт хийх болон нөөцийн ашиглалт, хуваарилалт сонголт хийхэд хангалттай байж чаддаггүй. Ихэнх тохиолдолд янз бүрийн хязгаарлалтын дунд сонголт хийдэг. Тиймээс улс төрийн болон төрийн (нийтийн) бодлого нь рационал байх хэрэгтэй боловч энэ нь тийм ч амар биш юм.

Бодлогыг рационал байлгахын тулд:

1. Зорилгоо тодорхойлж тогтоох;
2. Ач холбогдлоор нь зорилгоо зэрэглэх;
3. Тэдгээр зорилгод хүрэхийн тулд хэрэгтэй улс төрийн бодлогын хувилбаруудыг тодорхойлох;
4. Бодлогын хувилбаруудад зардал-ашигын дүн шинжилгээ хийх;

Бодлого боловсруулагчид рационал бодлогыг төлөвлөхөд:

1. Нийгмийн үнэт зүйлс тэдний нийгэмд эзлэх жинг мэдэх;
2. Зорилго чиглэлээ тодорхойлж тодруулах;
3. Боломжит бодлогын хувилбаруудыг бүгдийг нь мэдэж байх;
4. Бүх хувилбаруудын үр дагаврыг харьцуулах;
5. Олж авсан болон золиослосон нийгмийн үнэт зүйлсийн харьцааг тооцоолох;
6. Зорилгод нийцсэн хамгийн ашигтай хувилбарыг сонгох чадвартай байх ёстой;

Рационал шийдвэр гаргах хандлага

Херберт Саймоны ажигласнаар бодлого боловсруулагчид рационал сонголт хийх үйл явцад хамгийн тохиромжтой сонголт хийхээс илүү ярвигтай асуудлуудыг олон ойлгомжтой хэсэгт хувааж ямар нэгэн эргэлзээ үүсэхээс сэргийлж хамгийн сэтгэлд хүрэхүйц, сайн сонголтыг хийдэг. Х.Саймон “хувь хүмүүс хэдийгээр рационал гэгддэг ч тэдний рационал байдал хязгаарлагдмал танин мэдэхүй, сэтгэл зүйн багтаамжаар хүлэгдсэн байдаг”⁵ гэжээ. Иймээс рационал бодлого боловсруулалт нь бусад бодлогуудаас илүү хэцүү сонголтыг шаарддаг. Энэ нь олон үе шаттай:

1. Эхлээд бодлого боловсруулагч суурь асуудлуудыг тодруулна. Дараа нь зорилгуудаа томъёолон зэрэглэдэг. Нэг зорилго нь нөгөөгөөсөө илүү чухал байж болох тул энэ нь шаардлагатай алхам юм.
2. Хоёрдугаар шатанд, бодлого боловсруулагчид зорилгодоо хүрэхэд туслах хувилбар сонголтын хүрээг тодорхойлох юм. Цогц бодлогын хувилбаруудыг бэлтгэж бүх хувилбарыг үнэлэн цэгнэнэ. Бусад бодлогын хувилбаруудыг тодорхойлох нь хувилбаруудын чанар ба хүрээ нь нөлөөлдөг учраас онц чухал юм.
3. Гуравдугаар шатанд улс төрийн бодлогуудын зардал ашигийг тооцоолж таамаглах шаардлагатай байдаг. Бодлого боловсруулагчид улс төрийн бодлогын хувилбар бүрийн олох ашиг болон гарах зардлыг таамаглан тооцоолох шаардлагатай.
4. Бүх хувилбар тус бүрийн нийт ашигийг тооцоолохын зэрэгцээ, бодлого боловсруулагч хамгийн их ашиг тустай хувилбарыг зохиох хэрэгтэй. Хоёр өөр хувилбарыг харьцуулснаар бага зардлаар илүү их ашиг олох арга олдох магадлалтай.


⁴ Dye, Thomas R., 1980, Understanding Public Policy, Prentice Hall, Englewood Cliffs.

⁵ Herbert A. Simon. 1982. Models of Bounded Rationality: Economic Analysis and Public Policy. MIT Press.

5. Эцэст нь бодлого боловсруулагч хамгийн ашиг тустай бодлогыг сонгоно.

Улс төрийн бодлогыг хэрэгжүүлж эхлэсэн бол рационал бодлого боловсруулагч түүнийхээ хэрэгжилтийг системчлэн хянаж тооцоо таамаглалтайгаа тулгах ёстой.

Загвар 2. Системийн шийдвэрийн рационал загвар



Эх сурвалж: Dye, Thomas R., 1980, Understanding Public Policy, Prentice Hall, Englewood Cliffs.

Хэрэв шаардлагатай гэж үзвэл тухайн бодлогыг боловсруулагч засвар хийж эсвэл бүрмөсөн хаяж ч болно. Үүнийг рационал бодлого боловсруулалтын “санал хүсэлтийн үе” гэж нэрлэдэг. Хэрвээ сонголт хийгч энэхүү санал хүсэлтийг хүлээн авч бодлогоо хянан, дасан зохицолд оруулбал бодлого маань өөрийгөө засдаг, эсвэл кибернетик болдог.

Системийн шийдвэрийн рационал загвар

Рационал үзэл баримтлал гэдэг ойлгол өргөн цар хүрээтэй тархаж нийгмийн шинжлэх ухааны утга зохиолд рационал загварууд олон олдож байна. 3.2 загварт үзүүлсэнчлэн Томас Дай рационал үзлийг бодлого боловсруулалтанд хэрхэн хэрэглэж болохыг буюу сонголтын системд рационал рационал хандлагыг ашиглах жишээ өгсөн байна.

Рационал хандлагын хязгаарлалтууд

Рационал шийдвэр гаргахад олон бэрхшээл байдаг. Рационал гэсэн утга нь төөрөлдсөөр өдгөө мөн чанараа алдах аюул нүүрлээд байна. Дадлагаас илүү өргөн хүрээтэй. Бодлого боловсруулалтанд тулгамддаг зарим чухал асуудлууд нь:

1. **Зорилгод хүрэх** Рационал бодлого боловсруулалт бол маш хэцүү. Рационал бодлого гарч ирнэ гэдэг магадлал бага. Бодлого боловсруулагчид оновчтой бодлогыг санал болгох үед шийдэх гээд байгаа асуудал маань бусад зорилгод тулгуурласан маш төвөгтэй болсон байдаг. Харин шийдвэр гаргагч маань эрх мэдэл, байр суурь, мөнгө болон дахин сонгуульд оролцох зэрэг өөрийн ашгаа ихэсгэх гэж оролдож байх магадлалтай. Тиймээс рационал бодлогыг боловсруулах

нь зорилгын бодит хэрэгжилтээс илүүтэй сорилт болдог. Гэсэн хэдий ч рационал бодлогыг бий болгох оролдлогуудад эерэг тал ч бий. Рационал үзэл нь ардчилалтай бага зэрэг төсөөтэй. "...ардчилал нь улс төрийн буяны хэмжүүр гэгддэг шиг рационал хандлага нь ч бас мэргэн ухааны хэмжүүр гэгддэг" гэж Лайнбэрри хэлжээ.

2. **Оновчтой байдлыг хамгаалах** Рационал бодлого оновчтой үр дүнд хүрэхийг эрмэлздэг. Гэвч бодит байдалд энэ нь үргэлж тохиолддоггүй. Олон нийтийн ашиг сонирхол бодлогод хувь хүмүүсийн ашиг сонирхлоос илүү чухал. Хэрэв агаарын бохирдлыг хянах нь бүгдээр ашиг тусыг нь хүртэх учраас олон нийтийн ашиг сонирхолд нийцэж байна гэж үзвэл бохирдлыг хянах стратегид зарагдаж байгаа бүх машиныг өртөг ихтэй агаарын бохирдлыг шүүх тоноглол тавих шаардлага тавигдана. Гэтэл цөөн иргэд автомашины хий ялгаруулалтанд өөрийн мөнгөө зарцуулах хүсэлтэй байдаг. Хэрвээ агаарын бохирдлын хяналт нийтийн ашиг тусын төлөө бол хувь хүмүүсийн өөрсдийн сонголт ч мөн түүний дагуу байх ёстой. Гэтэл эсрэгээр олонх хүмүүс өөрийнхөөрөө бодож "үүнийг бусад хүмүүс хийчихнэ дээ би хийхгүй байлаа гээд юу ч болохгүй" гэж боддог. Ийнхүү цэвэр зорилгодоо хүрэх гэтэл талуудын хүсэл тэмүүлэл байхгүйгээс үүдэн энэ нь дутагдалтай байдаг. Цаашлаад төр засгийн бодлого боловсруулагчид үйл явцын хэдэн хэрэгцээг хангахыг л хичээдэг. Тэд хамгийн сайн арга замыг олтлоо эрэлхийлдэггүй.
3. **Рационал сонголт ба хэрэгцээний хоорондох зөрчил** Зохих ёсоороо зан үйлд хайх, үйлдэл хийх хэрэгцээний хооронд зөрчил үүсдэг. Өмнө дурьдсанчлан, бодлого боловсруулагчид шийдвэр гаргахад түлхэц өгөх хүсэл эрмэлзэл төрдөггүй, харин статус, мөнгө, эрх мэдэл гэх мэт өөрийн шагналыг нэмэгдүүлэхийг тулд оролддог. Хоёрдугаарт, ирэх хууль тогтоомжийг нарийвчлан судлах цаг хугацаа богино байдаг. Яаралтай нөхцөл нь даруй үйлдэл хийхийг эрэлхийлнэ. Гэвч цаг хугацаа хэтэрхий богино байх нь түгээмэл. Бодлого боловсруулахад байнга боломжит асуудлуудын тоо нь олон байдаг нь тэдгээрийг анхааралтай судалж үзэх цагийг хязгаарладаг. Мөн нийгмийн үнэт зүйлсийн талаар мөн зөвшилцөлд хүрдэггүй байдал. Тодруулбал, тодорхой бүлгүүд болон хувь хүмүүсийн хоорондох зөрчилтэй үнэт зүйлсийн тархалт нь бодлого боловсруулагчдад түүнийг харьцуулж, жинлэхэд хүндрэл учруулдаг.
4. **Улс төрийн боломжийн дилемма** Улс төрийн боломж, түүний давуу талыг ашиглах асуудал бодлого боловсруулагч бүртэй тулгардаг. Улс төрийн боломжийн хувьд "улс төрийн тогтолцооноос бодлогын сонголтыг хэрэгжүүлэх нь оновчтой бөгөөд хүсч болох магадлал" гэсэн үг юм. Зөвлөгч нар улс төрийн боломжийг ашиглахдаа зөрчилдөөнөөс зайлсхийх нь олонтаа тохиолддог. Бодлогын янз бүрийн хувилбаруудын үр дагаврыг мэдэхгүй байх нь улс төрчдийг өмнөх бодлогод шилжүүлэхийг шаарддаг. Сонгуульд оролцдог албан тушаалтнуудын олонх нь бодлого боловсруулахад уян хатан байх зарчим баримтлахгүйгээр дахин сонгогдох боломжоо золиослохыг хүсэхгүй. Шийдвэрийг түдгэлзүүлэх, эсвэл бусад татан буулгах тактикууд нь улс төрийн зардлын хувьд оновчтой шийдвэр гаргахаас зайлсхийх нийтлэг арга зам юм. Тиймээс парламент болон гүйцэтгэх засаглалын улс төрийн албан тушаалтнууд оновчтой сонголт хийх нь олонтоо тохиолддог.
5. **Зардал-үр ашгийн дүн шинжилгээ хийх асуудал** Нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын олон янзын үнэт зүйлсийг гадуурхаж байхад бодлого боловсруулагчид зардал-үр ашгийн харьцааг тооцоолоход хэцүү байдаг. Үүнээс гадна бодлого боловсруулагчид нь хувийн хэрэгцээ болон бусад саад тотгорын дутагдал ихтэй байдаг тул зохих шийдвэр гаргахад хүрч болох рационал хувилбаруудыг үнэлэх чадваргүй болдог талтай. Зохистой бодлого боловсруулах нь бодлогын сонголтуудын дунд хатуу сонголт хийхийг шаарддаг. Гэхдээ боломжит бүх

боломжит бодлогын хувилбаруудыг мэдэж авахын тулд шаардлагатай мэдээллийг цуглуулах, мэдээлэл цуглуулахад оролцсон цаг хугацаа, зардлыг багтаасан хувилбар бүрийн үр дагаврыг цуглуулахад цөөнгүй саад бэрхшээлүүд тулгарч байдаг.

Рационал бодлого боловсруулахад өөр нэг ноцтой саад бол бюрократ орчин юм. Томас Дая: “Том бюрократ байгууллагуудын хийж буй бодлого боловсруулах ажлыг зохицуулах нь хэцүү байдаг, энэ нь хэсэгчилэгдсэн шинж чанартай янз бүрийн мэргэжилтнүүдийн орцыг шийдвэрийн цэг дээр авчрахад хүргэдэг. Томоохон бюрократ байгууллагууд рационал бодлого боловсруулахад эрх мэдлийн хуваарь, хувийн зорилгоо сэтгэл ханамжтай болгох, зөрчилтэй үнэт зүйлс, хязгаарлагдмал технологи зэрэг бусад хүчин зүйлс нь боломжит бодлогын хувилбарууд, тэдгээрийн үр дагаврын талаарх тодорхойгүй байдлыг бий болгож бюрократуудын чадавхийг хязгаарладаг”⁶ гэжээ.

Бодлогын шинжээчид рационал загварт хэт их найдвар тавихгүй байхыг К.Паттон, Д.Савики нар сануулсан байдаг. Тэд “Хэрэв рационал загварыг дагаж мөрдвөл олон улс үндэстнүүдийн хувьд боломжит сонголтууд нь учирч болзошгүй шийдвэр гаргах ёстой, олон тооны шийдвэрт саад учруулна. Учир нь улс төрийн системээс шалтгаалан оновчтой, логик гэж өөрсдөө үзсэн тоо баримтууд нь байнга тохирох албагүй, янз бүрийн сайн санаанууд ямагт ялахгүй, шинжээчид, шийдвэр гаргагч нар техникийн хувьд дээд зэргийн, улс төрийн хувьд боломжтой хувилбаруудын хоорондох зөрчилдөөнтэй тулгарч байдаг”⁷.

Рационал загварыг дагаж мөрдөн баримтуудад дүн шинжилгээ хийх замаар альтернатив хувилбарыг сонгох нь ихэвчлэн ардчилсан бус байдаг. Роберт Денхардт бодлогын шинжээчид тулгамдсан асуудлуудад техникийн шийдлийг ихэвчлэн ашигладаг гэж үзсэн бөгөөд “...ийм нөхцөл байдалд техникийн асуудлууд нь улс төрийн болон ёс зүйн асуудлуудыг олон нийтийн шийдвэр гаргах үндэс суурь болгож, норматив асуудлуудыг техникийн асуудалд шилжүүлэх болно”⁸ гэж үзсэн. Жишээлбэл, нийслэл хотоос жижиг хэмжээний үйлдвэрийн газрыг шилжүүлэхэд багагүй бэрхшээлтэй байдаг. Учир нь оролцож буй хүмүүс техникийн шийдлийг хүлээж авахгүй. Шүүгчид шийдвэр гаргахаас бусад тохиолдолд улс төрчид болон шахалтын бүлгүүд түүнийг эсэргүүцдэг.

Херберт Саймон бодлого боловсруулалтын рационал загварыг гэнэн, утопи үндэслэлтэй зорилго тавьсан процедур юм гэж шүүмжилсэн. Рационал бодлого боловсруулах нь маш хэцүү. Зарим шийдвэр гаргагчид, онолчид магадгүй ихэнх тохиолдолд рационал бодлого боловсруулах боломжгүй гэж үздэг. Гэсэн хэдий ч энэ загвар нь задлан шинжилгээ хийхэд чухал ач холбогдолтой хэвээр үлдсэн бөгөөд энэ нь асуудал, бэрхшээлүүдийг зохистой тодорхойлоход тусалдаг. Х.Саймон бодлого нь боловсруулагчдын хувьд үнэхээр “рационал” биш харин “сэтгэл ханамжтай” гэж байх ёстой үзсэн байна. Түүний хувьд “сайн” шийдвэр нь хамгийн сайн шийдвэр биш байсан ч түүнийг гүйцэтгэх л болно. Хувийн байгууллага бол хүрэх зорилготой ашгийн хамгийн дээд систем бөгөөд зорилго нь тодорхой байдаг. Харин төрийн байгууллагуудын зорилго нь тодорхойгүй байдаг. Шийдвэр нь тодорхой, сайн

⁶ Dye, Thomas R., 1980, Understanding Public Policy, Prentice Hall, Englewood Cliffs.

⁷ Patton, Carl V. and David S. Sawicki, 1986, Basic Methods of Policy Analysis and Planning, Prentice-Hall, Englewood Cliffs.

⁸ David F. Paulsen, Robert B. Denhardt. 1973. Pollution and public policy; a book of readings. New York, Dodd, Mead,

тодорхойлогдсон зорилго, үйл ажиллагааг зохицуулах хангалттай эрх мэдэлтэй байхаас рационал эсэх нь шалтгаална.⁹

Бодлогын шинжилгээний инкрементал хандлага

Бодлогын рационал загварын эсрэг хэлбэр нь инкрементал загвар бөгөөд Чарльз Линдбломын нээлт юм. Шийдвэр гаргах уламжлалт рационал загвартай зэрэгцүүлэн Ч.Линдблом бодлого боловсруулах үйл явцын “инкрементал загвар”-ыг дэвшүүлсэн. Түүний “Science of Muddling Through” гарчигтайгаар 1959 онд хэвлэгдсэн, бодлого боловсруулах “үйл явцтай холбоотой бодлогын нарийвчилсан дүн шинжилгээг хөгжүүлэх загвар нь өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн юм. Үүнээс хойш Ч.Линдбломийн гаргасан санаа цаашдаа улам хувьсан өөрчлөгдөж хөгжсөн байна. Инкременталь загвар бол шийдвэр гаргах үйл явц дахь тоглогчдын хоорондын харилцан ажиллагаа мөн бөгөөд энэ үйл явц рационал гэхээс илүүтэйгээр улс төрийн шинжийг агуулсан гэдэг нь нотлогдож байдаг.

Линдбломын үзэж байгаагаар практикт бид боломжит бүх сонголтод анализ хийдэггүй боловч өнөөгийн бодлого, нөхцөл байдалтай уялдуулан хязгаарлагдмал хэдий ч амжилт бүхий харьцуулалтыг хийж чаддаг. Бодлого боловсруулагчид туршлага дээрээ тулгуурлан шийдвэрлэж болох асуудлын зорилго ба үнэт зүйлсийг дахин дахин тодорхойлж байхын оронд гол шийдвэрт тохирох боломжит хувилбарыг сонгож, засварлах арга (өнөөгийн бодлогод юу болохгүй байгааг засах) хандлагыг хэрэгжүүлэх явдал чухал байна. Асуудал шийдвэрлэх нь олон дахин давтагддаг бөгөөд түүний прагматик зөвлөмж нь цогц байхаас зайлсхийж, өөрийн асуудлыг өөрөө шийдэж, бусдад ноогдсон асуудлаа тэд өөрсдөө шийдвэрлэх боломжийг олгох ёстой. Тэрээр инкрементализм бол бодлого боловсруулахын бодит байдлыг тодорхойлоод зогсохгүй, шинжлэх ухаантай дүйцэхүйц юм¹⁰ гэж үзжээ.

Инкрементализм нь консерватив үзлийн залгамж бөгөөд түүний байр суурь (статус кво)-ийг дэмждэг учраас бодлогын хувьд тогтвортой, өөрчлөлтгүй, шинэ танил бус асуудал, нийтлэг бус бэрхшээлийг орхигдуулдаг, хэрэв тэдгээрийг тодорхойлохыг оролдсон ихэнх тохиолдол нь бодлого тодорхойлогчдын хүрээллийн гадна байрладаг гэдэг шүүмжлэлд өртдөг байна.

Утопи болон бодит (реалист) туйлын хооронд зарим хүмүүс рационал загварын шинэлэг талыг, инкрементализмын прагматик талыг олж хардаг. Жишээ нь Амитай Этзиони холигдсон хайгуулын хэлбэрээс 3 дахь хандлагыг олж харсан байна. Хайгуул гэдэг нь эрэх хайх, цуглуулах, шинжлэх, үнэлэх, дүгнэлт гаргах үйл явцыг өөртөө багтаана. Холимог хайгуулын явцад бодлого боловсруулалт нь хоёр төвшинд хийгдэх ба дээд төвшинд асуудлыг тодорхойлж чиглэлийг тогтоож өгнө. Энэ хандлага нь өргөн хүрээний гүнд анализ хийх, цогц шийдэл гаргах ашигтай бөгөөд инкрементал алхамуудыг гүйцэтгэж доод төвшний зохицуулалтыг хийнэ.

Линдблом шийдвэр гаргах нь хялбар “нарийн төвөгтэй бодлогын асуултууд шиг их ажиллагаатай бус” гэдгийг л харуулахыг хүссэн юм. Линдбломд цаг хугацаа, оюуны чадамж, зардал, нийгмийн зорилгыг тодорхойлох улс төрийн бодлого боловсруулагчдын өөрсдийнх нь саад болон рационал байдал дахь тэдгээрийн үр дагавар гэх мэт нь хязгаарлалт болж байдаг¹¹ гэж үзсэн. Тэрээр Х.Саймоны үзэл санаанд тулгуурлан цогц үндэслэлтэй улс төрийн шийдвэр гаргах дараалсан

⁹ Herbert A. Simon. Rationality as Process and as Product of Thought. Richard T.Ely Lecture // American Economic Review, May 1978, v.68, no.2, p.1–16.

¹⁰ Lindblom, Charles, "Still Muddling Through. Not Yet There", Public Administration Review, Vol. 39, 1979.

¹¹ Lindblom, Charles, "The Science of Muddling Through" Public Administration Review, Vol. 19, 1959.

хязгаарлагдмал харьцуулалтыг онцлон гаргаж иржээ. Шийдвэр гаргагчийн инкрементал хандлага (улс төрийн засаглалын арга) нь өнөөгийн нөхцөл байдлыг байнга шинэчлэх үйл явцыг алхам алхмаар, жижиг шат шатаар оролцуулдаг байна. Энэ нь эсрэгээрээ үндсэн хандлага болон бодлогын дүн шинжилгээнд таатай нөхцлийг бий болгож, үндсэн нөхцөл нь дахин өөрчлөгдөх бүрт хуучин өмнөх онол дээр тулгуурласан туршлагыг бий болгож мөн дахин эхлэх бэлтгэлтэй байдаг ажээ.

Линдблумын үзсэнээр цаг, оюун ухааны хязгаарлалт түүнчлэн бодлого боловсруулагчдаас урьдчилан сэргийлэх зардал нь бодлогын янз бүрийн хувилбарууд, тэдгээрийн үр дагаврыг тодорхойлдог бөгөөд “дараалсан хязгаарлагдмал харьцуулалт”-ын зэргүүд нь рационал байдлыг хязгаарласан нөхцөл байдалд илүү оновчтой бөгөөд илүү бодитой байх нөхцлийг бүрдүүлдэг гэдэг саналыг дэвшүүлжээ.¹²

Инкрементал шийдвэр гаргах боломжууд

Инкрементал шийдвэр гаргах боломжууд нь эмх цэгцгүй байдлыг бууруулдаг онцлогтой:

1. Инкрементализм нь урт хугацааны өөрчлөлтийн дарааллыг бий болгодог. Бодлого боловсруулагчид шинэ эсвэл өөр бодлогын үр дагаврын тодорхой бус байдлын улмаас одоо байгаа бодлогын хууль ёсны байдлыг хүлээн зөвшөөрдөг.
2. Энэ нь харилцан тохиролцох, хэлэлцээр хийх үйл явц юм. Сайн шийдвэр гэж гэрчлэх зүйл нь түүний гол зорилго, амжилт гэхээсээ илүү гэрээ байдаг. Маргаантай зүйл нь одоо явагдаж байгаа хөтөлбөрүүдэд төсвийг нэмэгдүүлж, эсвэл багасгах үед гэрээ хэлэлцээр хийх нь илүү хялбар байдаг. Эдгээр нэмэгдэл өсөлт нь улс төрийн хурцадмал байдлыг багасгах, тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм.
3. Инкрементализм нь шүүх болон хүч түрсэн арга барицыг ашиглах хандлагатай байдаг. Энэ нь “супер хүн гэх хоосон ойлголт”-оос илүү юм.

Хүмүүнлэг үнэт зүйлсийг хамгийн их байлгадаг зүйл нь эсрэгээрээ тэдний тодорхой шаардлагыг хангахаар ажилладагт оршино. Тэд “хамгийн шилдэг арга зам”-ыг хайж олдоггүй бөгөөд харин оронд нь зүгээр л “ажиллах” арга замыг л олдог. Энэхүү судалгаа нь ихэвчлэн танил талаас эхэлдэг бөгөөд энэ нь орчин үеийн бодлогуудтай ойролцоо бодлогын сонголтуудтай байдаг. Иймд инкрементализм нь онолын хувьд илүү оновчтой, энгийн байдлын шалгуураар илүү өндөр оноо авдаг учраас илүү оновчтой байдаг.

Стратегийн бодлого боловсруулах

А.Этциони рационал болон инкрементал хандлагын талаар шүүмжлэлтэй хандаж байсан. Тэрээр “холимог-скан” хийх аргын гуравны нэгийг боловсруулсан. Этционигийн загвар нь хувь хүмүүс болон ашиг сонирхлын оролцогчдын эрх мэдлийн тэгш бус байдлын улмаас шийдвэр гаргах плюрализм нь алдаатай байдаг гэдэгт үндэслэдэг. Түүний ажилд улс төр ба зах зээлийн асуудлаар Линдблом олон ургальч үзлийн байр сууринаас маш их бууж өгсөн гэж түүний инкрементал плюрализмын онолыг шүүмжилдэг. Тэрээр олон ургальч үзлээр шийдвэр гаргаж байгаад нь талархал илэрхийлж байна. Гэхдээ бүх сонирхол оролцож чаддаггүй, улс төрд оролцож буй хүмүүс бүгд тэнцүү бус, зарим нь бусдаас илүү хүчтэй, эрх мэдэлтэй байдаг. Бизнес буюу том корпорациуд шийдвэр гаргах үйл явцад давамгайл байр суурь эзэлдэг¹³ гэжээ.

¹² Lindblom, Charles, "Still Muddling Through. Not Yet There", Public Administration Review, Vol. 39, 1979.

¹³ Etzioni, A. 1967. Mixed Scanning: A 'third' approach to Decision-Making, Public Administration Review, Vol. 27

Линдблом 1977 онд стратегийн бодлогыг боловсронгуй болгох талаар харилцан бие биенээ тохируулан сайжруулах хэрэгцээг санал болгосон байна.¹⁴ Тэр дараагийн “Still Muddling Through. Not Yet There” 1979 гэдэг өгүүлэлдээ илүү төвөгтэй асуудлыг шийдэх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн бөгөөд үндсэн санаа нь шинэчлэх болон сайжруулах зорилгыг авч үзсэн байна. Үүний тулд тэрээр:

1. Инкрементализм нь улс төрийн хэв маягаар алхам, алхамаар өөрчлөлтүүдийг хийдэг.
2. Инкрементализм нь бодлогын дүн шинжилгээ юм гэж үзсэн.

Энэ өгүүлэлд тэрээр инкрементал шинжилгээ гэдэг нь олон тооны корпорациуд бодлого боловсруулах үйл явцад хүчтэй нөлөө үзүүлдэг боловч тэдгээрийн эрх мэдлийн тэнцвэрийг хадгалах, аюулгүй байдлыг хангах арга зам болдог гэж үзсэн байна. Тэрээр инкрементал шинжилгээний гурван хэлбэр байдгийг дурьдсан:

1. Инкрементал шинжилгээ: Энгийн нэмэлт шинжилгээ. Энэ нь зөвхөн одоогийн бодлогоос арай өөр бодлого явуулж байгаа үед хэрэглэх шинжилгээний хэлбэр юм.
2. Стратегийн шинжилгээ: Ч.Линдблом олон тооны бэрхшээлүүдээс болж бүрэн дүн шинжилгээ хийх боломжгүй байдаг. шинжээч нь “мэдээлэлтэй, тунгаах бололцоотой” сайн орчинд байж байж илүү сайн сонголт хийх ёстой гэж үздэг. Эдгээр аргууд нь: туршилт ба алдаанаас суралцах, системийн шинжилгээ, үйл ажиллагааны судалгаа, зорилтыг удирдлагаар хангах, хөтлөх /удирдах/ үнэлгээ хийх болон техникийн хяналт.
3. Салангид инкрементализм: Салангид инкрементализм бол задлан шинжилгээний стратеги төдийгүй асуудлыг хялбаршуулж, анхаарлаа төвлөрүүлэхэд дараах зургаан аргуудыг ашигладаг: а) хязгаарлалт. Зарим нэг хуучин /танил/ хувилбаруудыг шинжлэх; б) Улс төрийн үнэт зүйлс, зорилтыг эмпирик асуудлын шинжилгээтэй уялдуулах; в) Дараагийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд анхаарах; г) Хязгаарлагдмал тооны сонголт, түүний үр дагаварт дүн шинжилгээ хийх, д) туршилт ба алдаанаас суралцах; е) Бодлого боловсруулагчдын дунд аналитик судалгааны ажлыг хэсэгчлэн хуваах;

Линдблом 1963 онд Дэвид Брайбкүгтэй хамт бичсэн “Шийдвэр гаргах стратеги” нэртэй номондоо “салангид инкрементализм” гэдэг ойлголтыг танилцуулсан байдаг. Үүнийг “арай өөр” буюу өөр хоорондоо ялгаатай, “том зорилго” болоод алсын хараагүй бодлогын хооронд харьцуулалт хийж шийдвэр гаргах арга гэж үздэг. Зорилтууд нь одоогийн нөөц бололцоогоор тодорхойлогдох бөгөөд бодлогын хөгжлийг “туршилт ба алдааны” аргаар хийдэг. Шийдвэр нь аливаа төрлийн хяналт, зохицуулалтанд хамаарагддаггүй тул энэ нь салангид байна. Энэхүү ажил нь ойлголт, өөрчлөлтийн цар хүрээний хувьд дэвшилтэт байдлыг нэмэгдүүлдэг.

Бодлогын шинжилгээний хогийн сав загвар

Бодлогын шинжилгээний “хогийн сав” (Garbage Can Model) загвар нь хуучин хууль, дүрэм журмыг хүчингүй болгох, орчин үетэй нийцүүлж өөрчлөхөд илүү ашиглагддаг. Уг загварыг дан ганц энэ хандлагаар харж дүгнэж болохгүй бөгөөд түүний мөн чанарыг доорх хэсгүүдэд тайлбарлах болно.

Хэн: Засгийн газрын гаднах болон доторх оролцогчид

Хэрхэн сонголт хийх: Сонголт бол хоцрогдсон, хэрэгцээ шаардлагагүй төрөл бүрийн “хог хаягдал”-ыг хаяж чадах шийдлүүд бөгөөд оролцогчид өөрсдөө тарааж өгдөг хог хаягдал юм. Бодлогын үр дүн нь хог хаягдлын холимог үүргийг шийдвэрлэх юм.

¹⁴ Lindblom, Charles, 1977, Politics and Markets, Basic Books, New York

Үүнд: асуудал, шийдэл, оролцогчид, оролцогчийн нөөц, хэрхэн боловсруулж болох гэх мэт.

Хэрэгжүүлэлт / таамаглал: Оролцон тоглогчид болон үйл явцууд нь аль нэг түлхэц эсвэл хүчээр үйл ажиллагаа явуулж болно; Голын урсгалууд бие биенээсээ үл хамааран урсдаг.

Майкл Коэн, Жэймс Марч, Иохан Олсен (1972) нарын дэвшүүлсэн хогийн сав загварыг зарим нь түр ангилах загвар гэдгээр нь мэддэг. Энэ нь зорилго ба үнэт зүйлсийн хоёрдмол утга санаа, мэдлэг ба технологийн тодорхойгүй байдал, улс төрийн дүрэм болон ёс журам зэрэг бодлогыг бий болгодог улс төрийн нэр томъёоны талаарх таамаглал дээр суурилдаг. Энэ загвар нь зохион байгуулалтын иррационал байдал буюу, Коэн болон бусдын нэрлэдгээр зохион байгуулалттай анархи гэгчийг онцолдог. Тэдний үзэж байгаагаар, байгууллага гэдэг нь дэс дараатай бүтэц биш, харин үзэл санааны чөлөөт цуглуулга юм.¹⁵

Хогийн сав загвар нь анархи зохион байгуулалттай, эмх замбараагүй бодит байдалд байгууллагын шийдвэр гаргах үйл явцыг тайлбарладаг. Энэ загвар нь онолын хувьд хогийн сав шиг үйл явц бөгөөд дахин боловсруулах, эсвэл хаяхыг шийдвэрлэдэг.¹⁶

Энэ загварыг 1972 онд М.Кохен, Ж.Марч, Ж.Олсен нар “Байгууллагын сонголтын хогийн савны загвар” илтгэл, семинараар анх үндэслэжээ. Анархи зохион байгуулагдсан байгууллагуудад шийдвэрийн нөхцөл байдал, асуудлыг шийдвэрлэх шинж чанар нь тодорхой бус технологитой, оролцоо нь урсгалаар явагддаг ажээ.¹⁷

Зарим байгууллага нь зохион байгуулалтын (олон нийтийн, боловсрол, хууль ёсны бус гэх мэт) олон шинж чанартай байдаг ч эдгээр шинж чанарууд нь зохион байгуулалтын эмх замбараагүй, хэсэгчилэгдсэн тайлбартай байж болно. Энэ утгаараа зохион байгуулалтын шийдвэр гаргах (санаануудыг хэлэлцэж шийддэг уулзалт)-д сонголт хийх боломж, шийдвэрийн нөхцөл байдал нь бэлэг тэмдэгийн буюу “хог хаягдал”-ын шинжтэй байдаг бөгөөд оролцогчид “хог хаягдал” буюу сэтгэл хөдлөл, бэлэг тэмдгийн шинжтэй шийдвэрүүдийн бэрхшээлтэй учирдаг.

Анархи зохион байгуулалт яаж үүсдэг вэ гэхээр:

- Эрх мэдэл, зохион байгуулалтын эмх замбараагүй байдал нь динамик мэдрэмжээр тодорхойлогддог;
- Асуудлын шийдэл сул байдаг бөгөөд шийдлүүд нь хэлэлцээр хийх явцад байнга өөрчлөгдөж байдаг;
- Олон зүйл нэг дор тохиолддог бөгөөд тэдгээр нь бүгд хоорондоо өрсөлдөж байдаг;
- Бүх оролцогчид бүрэн оролцож чаддаггүй, цаг хугацаа, эрх мэдлээр хязгаарлагддаг;
- Оролцогчид төөрөгдөлд орсон нөхцөлд тэд ихэнхдээ байгууллага дахь өөрсдийн үүргээ ухамсарлахыг хичээдэг;

Зохион байгуулалтын анархист зан үйлийн онол нь асуудалд хандах хандлагын хувьд а) Тодорхой бус байдал; б) Технологийн тодорхой бус байдал; в) Урсгалаараа

¹⁵ Cohen, M.D.; March, J.G.; Olsen, J.P. (1972). "A garbage can model of organizational choice". *Administrative Science Quarterly*. 17 (1): 1–25.

¹⁶ McFarland, Daniel; Gomez, Charles. 2013. *Organizational Analysis*. Coursera. pp. 60–77.

¹⁷ Cohen, M.D.; March, J.G.; Olsen, J.P. (1972). "A garbage can model of organizational choice". *Administrative Science Quarterly*. 17 (1): 1–25.

оролцох; гэсэн гурван шинж чанараар ерөнхийдөө тодорхойлогддог бөгөөд энэ хандлагаар шийдвэрийн нөхцөл байдал, сонголтыг авч үздэг.¹⁸ Зохион байгуулалтын анархизмын эдгээр шинж чанарууд нь тухайн цаг үеийн байгууллагын болон зарим хэсгийнх нь онцлог шинж юм.¹⁹

Хог хаягдал" гэдэг нэр томъёо нь хогийн саванд байгаа эмх замбараагүй холимог, бохир зүйлсийг илүү сайн ойлгож авч үзэх арга замыг харгалзан үзэх ач холбогдолтой юм. Энэ загвар нь асуудал, шийдэл, оролцогчид (шийдвэр гаргагчдыг бие биенээс нь салгаж бие даасан хэлбэрээр)-ын гурван урсгалыг тус тусад нь дүрсэлдэг. Эдгээр гурван урсгал нь зөвхөн сонгож авах боломжийн дөрөв дэх урсгал үүсгэж, хог хаягдлаар урсдаг урсгал руу чиглэдэг.

Байгууллага нь тодорхой давуу эрхтэй эсвэл удирдамжгүй байна. Энэ нь янз бүрийн зөрчилдөх, буруу тодорхойлсон сонголт, зорилго, нэр томъёо дээр үндэслэдэг. Байгууллага нь хоорондоо уялдаа холбоотой бүтэц биш харин санаа бодлын сул цуглуулга гэх мэт илүү нарийн тайлбарлагдаж болно. Байгууллага нь өөрсдийн сонголтыг үйл ажиллагаагаар нь олж мэддэг, үйлдлүүд нь давуу тал дээр тулгуурладаг. Аль асуудал нь хамаатай, хамаагүй нь тодорхойгүй. Гэсэн хэдий ч байгууллагын зүгээс үйл ажиллагаа явуулж, юу хийсэн талаар ойлголт авахын тулд байгууллагаас дүрэм журам гаргаж өгдөг. Байгууллагын зохион байгуулалтын анархи хэлбэр нь хамтын талбар болон адилсал үүсэхэд хүндрэлтэй байж болно. Тодорхойгүй нөхцөл байдалд шийдвэр гаргах үйл явц нь шалтгаан, санаа бодол, утга учрыг ойлгох бодит байдлын үзэл санаанаас зайлсхийх хандлагатай байдаг. Тиймээс, ойлгомжтой орчинд бүтээгдсэн үр дагаврын оронд үндсээрээ эргэлзээгүй ертөнцийн утга учиртай тайлбар хийсэн шийдвэрүүд гарч ирдэг.²⁰

Шийдвэрийн нөхцөл байдлын төвөгтэй байдал нь бодит байдлыг илүү ойрхон төсөөлөхийн хэрээр үр дагавар үүсгэгчийн оронд хүчлүүр болж хувирдаг.

Шугаман рационал төлөвлөгөөнөөс харах юм бол, өгөгдсөн сонголт дээр суурилан үйлдэл хийж байгаа биш, харин үйлдлийн явцад сонголт илрүүлж байгаа нь харагдана. Бодлогын явцад, нөхцөл байдлын шийдвэрийг хайх бэрхшээл, асуудал ба мэдрэмжийг хайх сонголт, мөн асуудлыг хайх шийдлийг эрэлхийлж байдаг. Энэ загварт дөрвөн хувьсагч нэлээд хүнд, эсвэл бүр санмсаргүй байдлаар харилцан нөлөөлнө гэж төсөөлөгддөг байна. Эдгээр нь: 1) сонголтуудын урсгал, 2) асуудлуудын урсгал, 3) хувийн болон хамтын шийдвэрийн урсгал, 4) оролцогчдын хүч, нөлөөлөл (энерги)-ийн урсгал юм. Хогийн сав процессийн явцад асуудал, шийдлүүд, мөн оролцогчид нэг боломжит сонголтоос нөгөө рүү шилжиж байдаг. Иймэрхүү бодлогын тодорхойлолт нь реалист буюу бодит байдалд хэрэглэх боломжийн хувьд өндөр үр ашигтай ч, дедуктив хүчний хувьд сул талтай.

Аливаа зохион байгуулалтууд нь бүтэц, үйл явцыг шаарддаг бөгөөд тэдгээр нь тэдний үнэлэмжийг бататгаж, хувь хүмүүсийг өөрсдийн байр сууриа батлах, баталгаажуулах боломжийг олгодог. Тэд шийдвэр гаргахад оролцогчид өөрсдийн ажлаа хийж чаддаггүй тул ямар ч асуудалгүй, оролцогчдыг өөрсдийгөө илэрхийлэх өөр аргыг хайж олох хэрэгтэй болдог. Тэд “хүмүүсийг завгүй байлгаж, заримдаа тэднийг

¹⁸ Cohen, M.D.; March, J.G.; Olsen, J.P. (1972). "A garbage can model of organizational choice". *Administrative Science Quarterly*. 17 (1): 1–25.

¹⁹ McFarland, Daniel; Gomez, Charles. 2013. *Organizational Analysis*. Coursera. pp. 60–77.


²⁰ Cohen, M.D.; March, J.G.; Olsen, J.P. (1972). "A garbage can model of organizational choice". *Administrative Science Quarterly*. 17 (1): 1–25.

зугаатай өнгөрөөж, олон янзын туршлагыг тэдэнд өгөх, гудамжнаас хол байлгах, түүхийг ярих, нийгэмшүүлэхийг зөвшөөрдөг”²¹ (Birnbbaum, Robert: 1989).

Шийдвэр гаргах анархи загвар

Хогийн сав загвар нь шийдвэр гаргах үйл явцад ямар элементүүд оролцож байгаа, үр дагавар нь хэрхэн үүсэх, хэн энэ харилцаанд хүрч чадах, ямар элементүүд үүнийг тодорхойлдог зэрэгт анхаарал хандуулдаг. Энэ утгаараа зохион байгуулалтын онол нь байгууллага болон шийдвэрийн нөхцөл байдлын чиг хандлагыг хэрхэн тодорхойлох талаар илүү их үзэл бодолтой байдаг бол “хогийн сав” загвар нь эдгээр зохион байгуулалтын анархист шинжүүд хэрхэн шийдвэр гаргах талаар анхаарч үздэг. Тиймээс байгууллагын доторх болон гаднах хүмүүсээс үүсч буй асуудал, тэдгээрийн олон янзын шалтгаанд бүх анхаарлаа хандуулдаг. Жишээ нь гэр бүл, ажил мэргэжил, статус, мөнгөний хуваарилалт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээллүүд зэрэг тухайн үедээ хүчтэй хамааралтай байж болох бүх үйл явдлыг багтааж байдаг. Эдгээр асуудлууд нь бодитой, эсвэл үнэндээ чухал биш ч байж болно. Шийдвэр гаргагчдын зүгээс иймэрхүү байдлыг ойлгох шаардлагагүй бөгөөд гэхдээ тэд үүнийг ашиглан популизм хийж байдаг. "Хогийн сав загвар нь нөгөө талаасаа шийдвэр гаргах үйл явц боловч байгууллага доторх харьцангуй бие даасан хэд хэдэн урсгалын үр дүн юмуу тайлбар болж байдаг юм (Cohen, M.D.; March, J.G.; Olsen, J.P. 1972).

Зураг 1. М.Коэн, Ж.Марч, Ж.Олсен нарын шийдвэр гаргах загвар.



Эх сурвалж: Cohen, M.D.; March, J.G.; Olsen, J.P. (1972). "A garbage can model of organizational choice". Administrative Science Quarterly. 17 (1): 1–25.


“Хэдийгээр сонголт хийх боломжууд нь эхлээд шийдвэр гаргах хувилбаруудыг бий болгоход хүргэж магадгүй ч гэсэн, дараа нь тэдгээрийн үр дагаврыг шалгахын тулд эдгээр үр дагаврыг үнэлэх зорилготой, эцэст нь шийдвэр гаргахад энэ төрлийн загвар нь яг үнэндээ юу болох талаар муухан тайлбартай юм.”²²

Шийдэл нь хувь хүний эсвэл хамт олны бүтээгдэхүүн юм. Жишээ нь санаанууд, төлбөр тооцоо, хөтөлбөрүүд, үйл ажиллагааны журмыг багтааж болно. Эдгээр шийдлийн аль нь ч одоо байгаа асуудалтай холбоотой байх шаардлагагүй. Үүний оронд оролцогчид асуудлыг шийдэхийн тулд одоогоор идэвхтэй байгаа хайлтын шийдвэрүүдээ ашигладаг. "Хогийн сав загвар нь нөгөө талаасаа шийдвэр гаргах үйл явц боловч байгууллага доторх харьцангуй бие даасан хэд хэдэн урсгалын үр дүн юмуу тайлбар болж байдаг юм (Cohen, M.D.; March, J.G.; Olsen, J.P. 1972).

²¹ Birnbbaum, Robert (1989). "The Latent Organizational Functions of the Academic Senate: Why Senates Do Not Work But Will Not Go Away". The Journal of Higher Education. Vol. 60, No. 4. p. 439

²² Cohen, M.D.; March, J.G.; Olsen, J.P. (1972). "A garbage can model of organizational choice". Administrative Science Quarterly. 17 (1): 1–25.

Загвар 3. Шийдвэр гаргах анархи загвар.



Эх сурвалж: Cohen, M.D.; March, J.G.; Olsen, J.P. (1972). "A garbage can model of organizational choice". *Administrative Science Quarterly*. 17 (1): 1–25.

Сонголтууд нь байгууллагууд шийдвэр гаргах гэж нэрлэгддэг арга замаар үйл ажиллагаагаа явуулах боломжийг олгодог. Эдгээр боломжууд нь байнга тохиолддог бөгөөд байгууллагууд сонгох боломжоо тодорхойлох боломжтой байдаг. Асуудал, шийдэл, оролцогчдын эхний гурван урсгал нь сонгох боломжийн дөрвөн дэх урсгал руу шилжиж, боломж, цаг хугацаа, мөн ирээдүйд байгаа хүмүүстэй холилдож байдаг.

Асуудал, шийдэл, оролцогчдын эхний гурван урсгал нь сонголт хийх боломжийг урагшлуулдаг бөгөөд сонгох талбар нь эдгээр дөрвөн урсгалыг хангаж буй томоохон домэйн юм. Энэ талбар нь байгууллага (засгийн газар, сургууль, их сургууль), эсвэл энэ харилцан үйлчлэлийг бий болгох илүү том нөхцөл байдал байж болно. Жишээлбэл, зөвлөл эсвэл хороо сонгох талбар байж болох бөгөөд хорооны жилийн сонгууль нь боломжийн сонголт байж болно. Сонголт хийх боломж нь хороод, хэлтэс хоёрын хооронд гаргасан шийдвэр зэрэг янз бүрийн сонголттой газруудын хооронд шилжих боломжтой.

Сонголтуудын талбарт дөрвөн урсгалыг хэрхэн хольж буй үр дагавар нь янз бүр байж болно. Заримдаа шийдвэр гардаг. Бусад үед ямар ч шийдвэр гардаггүй. Заримдаа шийдвэр гаргах шатандаа явдаг, гэхдээ асуудлыг шийдэхийн тулд асуудлаа шийдэхгүй байдаг. Шийдвэрийн үйл явцын үр нөлөөний гурван гол асуудал нь асуудлын идэвхжил, асуудлын хүлээлт, шийдвэрийн үйл явц юм. Асуудлын үйл идэвхжил гэдэг нь сонголт хийх нөхцөл байдалд шийдэгдээгүй асуудлуудыг идэвхтэй холбож өгдөг. Энэ нь байгууллагад шийдвэр гаргах зөрчилдөөнийг барагдуулах арга барил юм.

Асуудлын хүлээлт нь асуудлууд цаг хугацааны хувьд идэвхжсэн боловч сонголтуудтай холбогдоогүй байдаг. Шийдвэрийн цаг бол тэвчээртэй сонголт юм. Байгууллагын сайн зохион байгуулалтын бүтэц нь асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэх замаар асуудлын идэвхгүй байдал, асуудлын хүлээлтийг бага байлгахад чиглэнэ. Ялангуяа хогийн сав загварт үр дүн ажиглагддаггүй. Загварчлалын процесс нь маш интерактив бөгөөд зарим үзэгдэл нь тоглолтын бусад бүтцийн онцлог хослолоос хамаардаг. Чухал асуудлууд чухал ач холбогдолгүй асуудлуудаас илүүтэй шийдэгдэж, чухал сонголтууд нь чухал бус асуудлуудаас илүүтэй асуудлыг шийдэхэд бага ач холбогдолтой байдаг ажээ.²³

Жон Киндон төрийн (нийтийн) бодлого, шийдвэр гаргаж байгаа засгийн газрыг зохион байгуулалттай анархизм гэж үзэж болно²⁴ гэжээ. Улс төрчид сонгуулийн

²³ Cohen, M.D.; March, J.G.; Olsen, J.P. (1972). "A garbage can model of organizational choice". *Administrative Science Quarterly*. 17 (1): 1–25.

²⁴ Kingdon, John W. (2003). *Agendas, alternatives, and public policies*, second edition. London, UK: Longman.

мөчлөгөөр байнга өөрчлөгдөж байдаг бөгөөд тэдний өрсөлдөөн олон талын урсгалаар орж ирдэг. Өнөөгийн улс төрийн үйл явдлуудаас үүсч буй асуудал, мөн хэвлэл мэдээллийн хэрэгслэлүүд анхаарлаа төвлөрүүлж чухал ач холбогдолтой гэж үзэж буй асуудлууд нь эргээд үр дүн муутай чухал бус бодлого, шийдвэрүүд байх нь түгээмэл юм. Харин хог мэт үзэгдэх чухал бус асуудлууд илүү ач холбогдол, үр дүнтэй байх тохиолдол элбэг. Тухайлбал, XIX зууны 60-аад онд Хаант Орост тариачдыг хамжлагаас чөлөөлсөн нь эрх баригчдын хувьд төдийлөн чухал биш шийдвэр байж болох ч эцсийн дүнд тус оронд капитализм хөгжих үндэс суурь болсон гэж түүхчид үздэг.

Бодлогыг тинк танк эсвэл лобби бүлгээр санал болгож болох боловч эдгээр бодлого нь түүний хамаарлыг дэмжих нөхцөл байдал үүсэх хүртэл олон нийт, нийгэм төдийлөн анхаарал тавихгүй байж болно. Жон Киндон нь удирдлагын шинжлэх ухааны зохион байгуулалтын үзэл баримтлал дээр тулгуурлан “Олон урсгалуудын хандлага” (Multiple Streams Approach)-ын үзэл баримтлалыг судалж, нийтийн бодлогын чиглэлд оруулжээ. Тэрээр эдгээр урсгалууд нь нэгдэж, эсвэл хосоороо бодлогын цонхонд сонголт хийх боломжийг өгч байна. Тэдгээр нь тодорхой бус байдал, өрсөлдөөн, төгс бус сонгон шалгаруулалт, хязгаарлагдмал цаг хугацаатай оролцогчид, шийдвэр гаргах үйл явц нь "бүрэн дүүрэн, оновчтой биш" байдаг ч зохион байгуулалтын анархист ерөнхий шинж чанарыг тодорхой харуулсан олон урсгал бүхий олон тооны гол элементүүд юм²⁵ гэжээ.

Бодлогын шинжилгээний институционал хандлага

Институц бол нийгмийн субъектуудын харилцаанд зуучлагч болж, тэднийг оновчтой зохицуулдаг, хэлбэржүүлдэг, нийгэм дэх янз бүрийн нэгжүүдийн хоорондох үйл ажиллагаа, мэдээлэл солилцох үйл явцыг харьцангуй тогтвортой явуулах хэрэгслийн үүргийг гүйцэтгэдэг. Нийгмийн эрэлт хэрэгцээг хангах үүднээс түүхэн ёсоор бүрэлдэн тогтсон, нийгэмд зайлшгүй шаардлагатай тодорхой чиг үүргийг гүйцэтгэгч, өөрийн үнэт зүйлс, хэм хэмжээ, зан үйлийн загвар, тусгай байгууллага, хяналтын систем бүхий, хамтын амьдралын үйл ажиллагааг зохион байгуулагч, зохицуулагч хэлбэр (гэр бүл, шашин, боловсрол г.м.) бол нийгмийн институт мөн.²⁶

Судлаачид А.Токвилийн үндэстнүүдийн талаарх тайлбарыг ерөнхийд нь тайлбарлаж, улс төрийн намуудын систем зэрэг томоохон хэмжээний улс төрийн институциудыг байгуулах талаар нэмэлт тайлбар өгч байна. Зарим онолчдын хувьд улс төрийн институциуд нь урт хугацааны туршид янз бүрийн бүлгүүдийн ашиг сонирхолд нөлөөлдөг учраас уг аргумент нь илүү сайн системчлэгдсэн бүтэцтэй байдаг гэж үздэг. Нөгөө хэсэг онолчдын хувьд улс төрийн институцжилт нь илүү түүхийн үйл явцтай холбоотой гэж үзсэн байна. Гэхдээ эрдэмтэн судлаачид улс төрийн институциуд нь үндсэндээ улс төрийн амьдралд нөлөөлдөг гэж үзэж байгаа ч онолын хувьд зөвхөн дунд шатны буюу мезо түвшний тоглогчдод харилцан үйлчилдэг гэж маргадаг. Эдгээр тоглогчид нь байгууллагын болон нөөцийн бусад арга хэрэгслэлээр хязгаарлагддаг боловч төрийн бодлогод нөлөөлөхийг оролддог байна. Төрийн бодлогод нөлөө үзүүлсний үр дагаварт нь уг хөтөлбөрийн сайн муу эсэхийг нь мэдэж авах бөгөөд ингэснээр программын тухай тэдний ашиг сонирхол, стратегид нөлөөлсөнөөр бодлогын ирээдүйн үйл явцыг тогтоодог. Онолын гол санаа нь макро түвшний улс

²⁵ Cairney, Paul; Jones, Michael D. (2016). "Kingdon's Multiple Streams Approach: What Is The Empirical Impact of this Universal Theory?". The Policy Studies Journal. 44.

²⁶ Ц.Батболд. Улс төрийн социологийн онолын үндэс. УБ., 2018. Арвай принтинг. тал 178-179

төрийн институт нь улс төрийн үйл явц болон төрийн хязгаарлагдмал бодлогод нөлөөлж чадахуйц тоглогчдыг бүхэлд нь хэлбэржүүлдэг ажээ.²⁷

Засаглалыг институтчлах гэдэг бол засгийн эрх нь эрх баригчдаас институт руу шилжиж байгааг илэрхийлдэг бөгөөд институт нь засаглалын цорын ганц эзэмшигч нь болдог байна. Энэ нь эрх баригчдыг алга болгох гэсэн хэрэг бус харин төрийн удирдлага дахь тэдний байрлал өөрчлөгддөг. Хэрэв өмнө нь эрх баригчид засаглалын хэрэгжүүлэхдээ өөрийн хувийн сонирхол, үзэмжээр шийдвэрлэдэг байсан бол институцчилэгдсэн нөхцөлд тэд зөвхөн сонгогчдын олонхийг төлөөлсөн засгийн дээд шатны агент төдий болдог. Хувийн засаглал устаж үгүй болсоноор засгийн эрх баригчдын үйлдэх үйл ажиллагаа нь эрх зүйн хүрээгээр хязгаарлагдсан. Өөрөөр хэлбэл, засаглал нь эрх зүйт институт болсон ажээ.²⁸

Девид Риччи “Улс төрийн шинжлэх ухааны гамшиг” бүтээлдээ улс төрийн шинжлэх ухаанд нь байнга өөрчлөгдөж байдаг ойлголтууд болох шудрага ёс, үндэстэн, эрх, эх оронч үзэл, нийгэм, сайн сайхан чанар, бурангуй ёс гэх мэт зүйлс ноёлж байсныг дурдсан байдаг. Д.Риччи одоогийн улс төрийн гамшгийн ихэнх ойлголтууд алга болж, цусгүй техникийн ойлголтуудаар солигдсон. Энэ нь хандлага, мэдлэг, нийгэмшилт болон бусад системийн элементүүд нь нэг бол туршлага дээр суурилсан эсвэл хэм хэмжээ болсон стандарт дээр суурилсан улс төрийн институцийн хөгжил юм гэж үзсэн.

Свен Стэйнмогийн “Татвар ба Ардчилал” (1993) номонд ардчилсан улс төрийн хэд хэдэн бодлогын ялгааг бичсэн байдаг.²⁹ С.Стэйнмо Америк, Их Британи, Шведийн татварын системийг сүүлийн зууны туршид тааварлагдаагүй замаар нилээд өөрчлөгдсөн болохыг тайлбарласан бөгөөд Шведийн татварын систем нь орлогыг илүү их хуримтлуулж байхад, Америк, Их Британы татварын систем нь эргэн хуваарилсан, хундэрсэн, татварын торгуулийн шинж чанартай болсон байна. Тэрээр дайны дараах жилүүдийн Америкийн татварын систем үр дүнгүй байсан бол, Шведийн татварын систем илүү тогтвортой, үр дүнтэй, гарцтай, өндөр ашигтай байсан талаар тайлбарласан. Харин Их Британы хувьд татварын систем нь тогтворгүй байдлаас алгуурхан гарсаар байна. Тэрээр энэхүү татварын бодлого дахь өөрчлөлтийг эргэн хуваарилалтын байдал, улсаас санхүүждэг хуваарилалтын хөтөлбөр зэрэгтэй холбон тайлбарласан.

Институционал загвар бол улс төр, нийгмийн утга агуулга, тэдгээрийн учир шалтгаан, мөн бие даасан тоглогчдын идэвхтэй оролцооны аль алиныг үл тоомсорлолгүйгээр бодлого боловсруулахад улс төрийн институцийн хувьд илүү бие даасан үүрэг гүйцэтгэхийг хичээдэг.³⁰ Теда Скокпол төр засгийн бодлого боловсруулах нь харилцан адилгүй замаас хамааралтай үйл явц гэж үзэх арга замыг нээж өгсөн. Тэрээр төр хэрхэн яаж шинээр бодлого зарчим бий болгохдоо нэгнээсээ хараат бас тодорхой хөгжих замналд маш ихээр найдсан байдгийг харуулсан юм. Лоүй (Lowi 1972)-г даган тэрээр шинээр үүсгэсэн бүтэц болон бодлого хэрхэн хувирч муж улсын

²⁷ Edwin Amenta. State-Centered and Political Institutional Theory: Retrospect and Prospect. The Handbook of Political Sociology: states, civil societies, and globalization. Cambridge University Press 2005. P-815. p 103

²⁸ Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ., 2013. Тод Магнат ХХК. хт 484. Тал 276-277

²⁹ Sven Steinmo. Taxation and Democracy: Swedish, British and American Approaches to Financing the Modern State. 1993., Published by: Yale University Press. P: 302

³⁰ Olsen, J.P. (1984). The new institutionalism: Organizational factors in political life. American Political Science Review, 78, 734-749.

нийгмийн бүлэглэлүүдэд хэрхэн багтаамжаа нэмэгдүүлэх, улс төрийн зорилгоо биелүүлэх болон чадамжийн өөрчлөлтийг тайлбарладаг ажээ.³¹

Төрд шинээр сонгогдсон хүмүүс эдгээр бодлогын чадавхийг улс төрийн тэмцэлдээ хэцүү нөхцөл байдалд ч ашиглаж чаддаг байна. Улс төрийн бүлэглэлүүд нь өөрсдөдөө элдэв янзын зөвшөөрөл батлан түүгээрээ хүчирхэгжиж бас хууль дүрмээр өөрсдийгөө шагнадаг аж. Харин шинэ бүлэглэлүүд бодлогын хүчээр урам ордог байна. Эдгээр бүлэглэлүүдийн аль аль нь эцэс сүүлдээ бодлогод нөлөөлдөг бөгөөд товчхоноор хэлэхэд шинээр эхэлж буй бодлого болон зарчмууд нь ирээдүйн нийгмийн зарчмын бүтэц, нийгмийн улс төрийн бодлогод маш том нөлөөтэй байдаг байна. Институтийн онол ийм түүхэн замналаар хийгддэг ажээ.³²

Бодлого ба институт

Ардчилсан нийгэм бол төв ба орон нутгийн засаглалаас бүрдсэн засгийн газрын бүтэц байгууламж, институциудын сүлжээ юм. Төв засаглал нь бодлогын хувьд гол үүрэгтэй хэдий ч орон нутгийн засаглал бодлогын түвшинд олон үүргийг бие дааж гүйцэтгэдэг. Энэ нь төв болон орон нутгийн нийгэм, эдийн засгийн ашиг сонирхлын зөрчилдөөнийг ялгаж салгахыг эрмэлзсэн төвлөрлийг сааруулсан тогтолцоо юм. Иргэдийн хувьд орон нутгийн засаглал нь тэдний өөрсдийнх нь эрх мэдлийн хүрээнд буюу өөрөө удирдах ёсны байгууллагаар дамжин орон нутгийн нийгмийн бүхий л хэсгийг хамгаалж байдаг хэмээн үздэг. Үүнд тодорхой анги, бүлэг давамгайлахгүй. Энэ нь нийгэм, эдийн засгийн ашиг сонирхлыг зохицуулан байршуулах замаар бүх хүн амын ашиг сонирхлыг хамгаалах ёстой гэсэн үг юм. Ямар ч байгууллага төрийн бодлогын бүхий л хүрээн дэх зорилтууддаа амжилттайгаар хүрч байгаагүй бөгөөд бодлогын алдаа нь нийтийн олонхийн ашиг сонирхолтой ерөнхийлөн нийцэж байж шийдэгдэх хандлагатай байдаг байна.

Олон ургальч нийгмийн хувьд хувь хүмүүс болон бүлгүүдийн үйл ажиллагаа ерөнхийдөө хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх зэрэг засаглалын ноёрхогч институтууд, тэдгээрийн шийдвэрийг хэрэгжүүлж буй төрийн байгууллагуудыг чиглэгддэг. Төрийн бодлогыг төрийн байгууллагууд боловсруулан хэрэгжүүлдэг. Засгийн газрын байгууллагууд болон төрийн бодлогод үндсэн гурван шинж чанар агуулагдаж байдаг:

1. Засгийн газар нь хууль ёсны эрх мэдлийг бодлогод өгдөг. Төрийн бодлого гэдэг нь тодорхой шийдвэрүүдийн үр дүн бөгөөд хууль ёсны санкцын хэрэглээгээр тодорхойлогддог. Үүнийг хүмүүсийг дуулгавартай байлгаж захирах хууль ёсны зарчим гэж үздэг.
2. Төрийн бодлогын хэрэглээ нь бүх нийтийн шинжтэй байдаг. Зөвхөн төрийн бодлого л бүх иргэдэд хүртээмжтэй.
3. Төрийн бодлогод албадлага хамаарагддаг. Энэ нь засгийн газрын гаргасан шийдвэрээ бататгах үйл ажиллагаанд хэрэглэгддэг. Бодлого нь засгийн газрын өөрийн нөөц болох албадлагын төрлөөр шийтгэл ноогдуулах хүчин чадалтай гэсэн санааг илэрхийлдэг. Зөвхөн засгийн газар л бодлогыг нь зөрчсөн хүмүүст хариуцлага хүлээлгэж болно. Засгийн газар нь албадлагыг монополчлох, удирдаж буй улс орныхоо бодлогыг боловсруулах, мөн ард иргэдээ дуулгавартай байлгаж захирах боломжтой байдаг тул хувь хүмүүс болон бүлэг ерөнхийдөө өөрсдийн ашиг сонирхолоо бодлогод тусгуулахын төлөө ажиллах болдог ажээ.

³¹ Ц.Батболд. Улс төрийн социологийн онолын үндэс. УБ., 2018. Арвай принтинг. тал 191

³² Edwin Amenta. State-Centered and Political Institutional Theory: Retrospect and Prospect. The Handbook of Political Sociology: states, civil societies, and globalization. Cambridge University Press 2005. P-815. p 107

Ийм учраас төрийн бодлого ба төрийн байгууллагуудын хооронд нягт уялдаа холбоо бүхий харилцаа оршдог. Энэ хүрээнд нийгэм, улс төр, удирдлагын шинжлэх ухааны судлаачид засгийн газрын бүтэц болон байгууллагуудын судалгаанд илүү анхаарч ажилладаг. Институцийн судалгаа нь төрийн бодлогын үндсэн чиглэл болж байдаг. Тиймээс бодлого боловсруулах системийн загваруудын нэг нь институтийн хандлага гэж нэрлэгдэж болно. Учир нь үндсэн хууль, засгийн газар эсвэл хууль тогтоох байгууллагын бий болгосон эдгээр институтуудийн харилцан үйлчлэлийн хүрээнд бий болсон бодлогоос нийгмийн амьдрал хамаардаг.

Бодлого боловсруулахад гүйцэтгэх засаглал болон кабинет, ерөнхий сайд, УИХ-ын гишүүд, өндөр дээд албан тушаалтнууд, сонирхлын бүлгүүдийн удирдагчид зэрэг эрх мэдэл бүхий хувь хүмүүс болон бүлгүүд эрх мэдлээ хэрэгжүүлдэг. Эрх мэдлийн хэрэгжүүлэлт бүр бодлого боловсруулах үйл явцыг бий болоход нөлөөлдөг хүчин зүйлсийн нэг нь юм. Энэ нь төрийн бодлого батлагдсанаар хэрэгжих үйл явц эхэлдэг гэсэн үг. Энэ үйл явц нь ерөнхийдөө төрийн институтууд гэж нэрлэгддэг хүчирхэг хувь хүмүүс болон бүлгүүдийн нөлөөн дор бий болдог холбоо бүхий шийдвэрүүдийн дарааллаас бүрддэг. Институцийн хандлага нь хууль, эрх зүйн хувьд заавал дагаж мөрдөх мөн хэрэгжүүлэх эрх бүхий шийдвэрт нийгмийн бүлэг болон засгийн газрын байгууллагууд хэрхэн нөлөөлдгийг тайлбарлахаар зорьдог. Шийдвэр гаргагчдад засгийн газрын бүтэц ба институциуд дахь олон талт байр суурьт албан ёсны эрх, эрх мэдлийг өгдөг дүрэм журмаар хязгаарлагдсан албан бөгөөд үндсэн хуулийн тогтолцооны хүрээнд үүрэг гүйцэтгэдэг хүмүүсийг багтаадаг. Институцийн хандлага нь төрийн бодлого, засгийн газрын байгууллага хоорондын харилцааг судлах оролдлого хийж байдаг.

Институционализм нь институцийн эрх зүйн болон бүтцийн асуудалд голлон анхаардаг бөгөөд бодлогын судалгаа шинжилгээ хийхэд үүнийг хэрэглэж болно. Бүтэц, байгууллага, тэдгээрийн зохицуулалт болон харилцан үйлчлэл нь төрийн бодлогод ач холбогдол бүхий нөлөө үзүүлдэг. Томас Дая засгийн газрын байгууллагууд тодорхой хугацааны турш тасралтгүй үргэлжилдэг хувь хүмүүс болон бүлгүүдийн зан үйлийн хэв маягийг бүтцэд оруулдаг гэж үзсэн байдаг.

Уламжлалын дагуу бол судалгаа засгийн газрын бүтэц ба институцийн дүр зураг дээр төвлөрдөг. Гэсэн хэдий ч уг хандлага засгийн газрын бүтэц болон төрийн бодлогын агуулга хоорондын уялдаа холбоог төдийлөн анхаарч үздэггүй. Институцийн хандлага нь төрийн бодлогын шийдвэрийн институтжсэн шинж чанарт үзүүлэх үр нөлөөний тал дээр системтэй асуулгад тулгуурлаагүй байдаг. Тиймээс засгийн газрын бүтэц ба бодлогын үр дүн хоорондын уялдаа холбоог огт судалж шинжлээгүй, орхигдуулсан гэж үздэг байна.

Хэдий нарийн төвөгтэй боловч, бүтцийн арга нь хоцрогдоогүй. Төрийн байгууллагууд нь үнэн хэрэгтээ хувь хүмүүс болон бүлгүүдийн зан төлвийн хэв маягийн хэлбэр юм. Эдгээр нь шийдвэр гаргах болон төрийн бодлогын агуулгад нөлөөлж байдаг. Байгууллагын хандлага нь засгийн газрын байгууллагууд тодорхой нэгэн бодлогын үр дүнг сайжруулахад чиглэсэн хэлбэр бүтэцтэй байж болох санааг агуулдаг. Эдгээр хэв маяг нь нийгмийн тодорхой ашиг сонирхолд давуу тал олгож, уг ашиг сонирхлыг бусад ашиг сонирхлоос хамгаалж байдаг.

Дүрэм журам ба институтийн зохицуулалтын нөлөө нь ихэнх тохиолдолд төвийг сахисан хандлагатай байдаггүй. Ихэнхдээ тэд нийгмийн зарим ашиг сонирхлыг бусдаас илүү үзэх хандлагатай байдаг. Тийм ч учраас тодорхой хувь хүмүүсийн бүлгүүдэд өөр хэлбэрээс илүүтэйгээр илүү их эрх мэдэл эсвэл засгийн газрын нэг хэлбэрийн дагуу бүтэцлэгдсэн хэв маягийн эрх мэдлийг ашиглах боломжтой байдал нь

таалагддаг. Өөрөөр хэлбэл бодлогын үр дагавар бүхий институцийн шинж чанарын нөлөө оршин байх болно гэсэн үг юм. Институцийн хандлагын хүрээнд хэн нэгэн институцийн зохицуулалт ба төрийн бодлогын агуулга хоорондын холбоог судлах боломжтой. Бодлогын асуудлуудыг институцийн зохицуулалтыг анхаарч системтэйгээр шалгаж болно.

Бодлогын шинжилгээнд зориулсан байгууллагын хандлагын үнэт зүйл нь институцийн зохицуулалт болон төрийн бодлогын агуулга хоорондын харилцан хамаарал юу болохыг таньж, түүнчлэн эдгээр харилцааг харьцуулах аргаар судлах явдал дээр суурилдаг. Гэсэн хэдий ч институцийн бүтэц дэх тодорхой өөрчлөлт нь төрийн бодлогод өөрчлөлт оруулахад хүргэж байна хэмээн дүгнэх нь буруу юм. Бүтэц, бодлогын хоорондын уялдаа холбоог судлахгүйгээр төрийн бодлого дахь институцийн зохицуулалтын үр нөлөөг үнэлж дүгнэхэд хүндрэлтэй байдаг. Энэ утгаараа Томас Дая "бүтэц ба бодлого нь нийгэмд хүчээр хийгдэж байгаа хүрээлэн буй орчны хүчин зүйлсээр тодорхойлогдож, хэрэв хүрээлэн буй орчин дахь нийгэм, эдийн засаг, улс төрийн хүчин зүйлс нь үр дүнтэй тогтмол байх тохиолдолд институтын зохицуулалт төрийн бодлогод бие даасан нөлөө бараг л үзүүлэхгүй"³³ хэмээн үзжээ.

Неоинституционал загвар нь улс төр, нийгмийн утга агуулга болон тэдгээрийн учир шалтгаан, мөн бие даасан тоглогчдын идэвхтэй оролцооны аль алиныг үл тоомсорлолгүй харгалзан үзэж бодлого боловсруулахад улс төрийн институцийн хувьд илүү бие даасан үүрэг гүйцэтгэхийг хичээдэг. Энэхүү загвар нь зохион байгуулалтын өөрчлөлтийг санамсаргүй үр дүн, тохиолдлын үйлдлийг үүсгэдэг маргаантай үйл явц гэж үздэг бөгөөд үр дагаврыг таамаглах, өөрчлөлтийг хууль тогтоомжоор хянах боломжгүйг хүлээн зөвшөөрдөг. Инститүц бол бүрэн эрх ба эрх мэдэлтэй гэдгээр төдийгүй, хамтарсан үйлдлийн биеийн хүчний, когнитив болон ёс суртахууны бүтцийг хангаж хувьсах чанартай гэдгээрээ чухал юм. Нөгөө талаас институт нь ач холбогдол, төлөвлөгөө, санамж, эрх ба алба бөгөөд тэр ч байтугай үнэт зүйлс, билэгдэл, шударга ёсны тухай хамт олны ойлголтыг төлөөлж байдаг. Түүнчлэн бодлого боловсруулалтын үйл явц ба үр ашигт нөлөөлдөг и

нституцийн тогтвортой болон залгамж халаатай түвшин энд байдаг.

Бодлогын судалгааны социал конструктив хандлага

Социал конструктивист сэтгэлгээ мэдлэгийн социологиос эхтэй бөгөөд нийгмийн шинжлэх ухаанаар дамжин тархжээ. Конструктивизм бол хүмүүсийн сэтгэл зүй болон мэдлэгийг хэрхэн олж авах талаар тайлбарладаг сэтгэл судлалын арга зүйн онол юм. Хүмүүсийн туршлага мэдлэг нь аливаа асуудлын утга учрыг ойлгоход чиглэгддэг гэдэг нь энэ онолын үндсийг харуулдаг. Жероми Брунер (Jerome Bruner) конструктивист онолыг хүмүүсийн одоогийн болон өнгөрсөн мэдлэгтээ үндэслэн шинэ санаа, ойлголтыг бий болгох идэвхтэй үйл явц юм гэж тодорхойлжээ. Конструктивизм хүмүүсийн сурах үйл явц нь утга учиртай, мэдлэг бүтээх үйл явцад идэвхтэй оролцдог гэж үздэг. Тиймээс боловсрол бол социал конструктивист сэтгэлгээний үндэс бөгөөд үүнээс үүссэн бүтээлч сэтгэлгээг шууд хэрэглэх боломжтой.

Судалгааны конструктив арга зүйн төрөл нь нийгмийн субьектив асуудал болох хүмүүсийн ухамсартай болон ухамсаргүй үйл ажиллагааны холбоо хамаарлуудыг судлах бөгөөд гэхдээ тэдгээр нь объектив нөхцөл байдал, нийгмийн институциудын үйл ажиллагаанд үзүүлэх үр нөлөөг дутуу үнэлдэг ч гэсэн детерминист төрлийн арга зүйн судалгаанд хувь нэмэр оруулдаг. Конструктив хандлагын арга зүй нь социологийн

³³ Dye, Thomas R., 1980, *Understanding Public Policy*, Prentice Hall, Englewood Cliffs.

судалгааны чанарын “зөөлөн” арга бөгөөд тоон “хатуу” аргуудаас ялгаатай нь нөхцөл байдлыг детерминист хандлагаар тодорхойлдог.³⁴

Социал конструктивизмыг Петер Бергер, Томас Лукманн (Peter Berger and Thomas Luckmann) нар нийгмийг бүтээх таамаглалаас гардаг бодит байдал гэж төсөөлж болно гэж үзсэн. Хүний мэдэх, харилцах замналын үр дүн нь нийгмийн бодит байдал бөгөөд нийгмийн бүтцийг үүсгэдэг. Тиймээс нийгмийн бүтэц, зохион байгуулалтын үйл явц, түүний дамжих арга хэрэгсэл нь хэлээр илэрхийлэгдэнэ. Хүмүүний бэлгэдлийн тогтолцооноос гадуурх бодит хандалт маш их асуудалтай байдаг гэж тэд үздэг. Энэ утгаар төрийн бодлогын талаарх ойлголтыг үүнтэй хамааруулж тайлбарладаг.

Хэл бол хамгийн тод тэмдэгтийн системийг авахын тулд зөвхөн баримтуудыг мэдээлдэггүй. Харин ямар нэгэн зүйлийн утга нь нийгмийн тодорхой орчинд байдаг бөгөөд энэ нь түүхэн болон нөхцөл байдлаас хамаарсан урьдчилан хараагүй тохиолдлын шинжтэй байдаг. Хүмүүс нь тэрхүү бэлгэдлийн системүүдээс хамаардаг учраас тэдний эргэн тойрны ертөнцийг ойлгохын тулд тэдгээрийн тусламжтайгаар бүтээсэн онолын фреймүүд нь ерөнхийдөө хүний түүхийн тухай болон нийгэмшлийн үр дүнгийн тухай өгүүлсэн ертөнцийн харилцааны арга зам юм. Бид өөрсдөдөө хэрэгтэй гэсэн утга санаан дээр тулгуурладаг. Бид нийгмийн бүтцийн болзошгүй нөхцөл байдал, тэдгээрийг бий болгосон хүчийг мартах хандлагатай байдаг. Тиймээс конструктивистууд нийгмийн бодит байдал үргэлж өөрчлөгдөж байдаг гэдгийг сануулж байдаг.

Социал конструктивизмын төрлүүд

Социал конструктивист сэтгэлгээ 1960-аад оноос цэцэглэн хөгжиж цаашид улам бүр өсөн нэмэгдэж буй ойлголтууд болох өөр өөр төлөөллийн дотоод сэтгэлгээгээр тухайлбал, Фердинанд де Соссюрагийн хэл шинжлэл, Эдмунд Хүссерл, Ханс-Георг Гадамер нарын феноменологи ба герменевтик, Жак Деррида, Мишель Фуко нарын постструктуралист сэтгэлгээ, Ричард Рортигийн прагматизмаар баяжсан.

Конструктивизмын “хүчтэй” ба “сул” хэлбэрүүд байх бөгөөд тэдгээр нь нийгмийн бодит байдлын талаар ялгаатай ханддаг:

- Хүчтэй конструктивизм нь аливаа социал бүтээн байгуулалтаас гадна бий болсон бодит зүйлсийг объектив бодит байдлын талаас нь ярих нь учир холбогдолгүй, учир нь бид түүнд шууд хүрч нэвтэрч чадахгүй гэсэн “хэцүү үнэнд” итгэдэг.
- Сул конструктивизм нь объектив бодит байдлын ойлголт бол хүний мэдлэгийн хүртээмж юм гэж үздэг. Энэ нь материаллаг ертөнц биш гэдгийг санаж байх нь чухал боловч, гэхдээ бид нийгмийн байгууламжийн тухай ярихдаа (материаллаг) ертөнцийн талаарх ойлголтуудад тулгуурладаг. Материаллаг объект, түүний доторх бүх мөн чанар, хүний эд зүйл зэрэг нь утга санааг бий болгох нийгмийн үйл явцад тодорхой байр суурийг эзэлдэг.

Хэн нэгний мэдэж байгаа субъектив байрлалд тухайн объектыг мэдэх нь социал конструктивизмын холбоос юм. Хэрэв хэн нэгэн мэдэгч болон мэдлэг хоёр салангид гэдгийг тогтоовол нэг нь давхар статустай байна. Социал конструктивистууд ихэвчлэн монист байр суурийг сонгодог. Өөрөөр хэлбэл, аливаа маргаанд хэн нэгний мэдсэн мэдлэг нь мэдэхийг оролдож буй ертөнцийн нэг л хэсэг юм. Мэдэх гэж байгаа зүйлс болон түүний тухай мэдлэг хоёрын зөрчил нь үр дүн юм.

³⁴ Ц.Батболд. Улс төрийн социологийн онолын үндэс. УБ., 2018. Арвай принтинг. тал 42

Энэхүү харилцан үйлчлэлийн гол учир шалтгаан нь мэдэгч ажиглаж мэдсэн зүйлээ мэдэгдэж буй онолын хүрээнд утга бүхий баримт (факт) болгоход оршино. Ингэснээр социал конструктивистууд Архимедын “тулах цэг” гэж байхгүй, бидний нийгмийн бодит байдлыг бүрдүүлж байгаа зүйлсийн мөн чанарыг харж чаддаг ямар ч үзэл бодол байхгүй. Бид соёл, нийгэм, улс төр, түүх болон бусад зүйлсээс бодит байдлыг харж чадна. Тийм учраас бид бүхэн социал бодит байдлын олон төрөлтэй учирдаг ба тэдгээрийн нэг бүр нь тодорхой үнэт зүйлстэй байхын зэрэгцээ хүлээн зөвшөөрдөг бүлгийн гишүүдтэй байдаг гэж үздэг.

Социал конструктивист судалгаа

Бодлогын шинжлэх ухаанд олон төрлийн конструктивизмыг ашигладаг. Хамгийн түгээмэл ашиглагддаг гурван шинжилгээ нь: а) фрэймин буюу хүрээний шинжилгээ (frame analysis); b) нарратив буюу өгүүлэмжийн шинжилгээ (narrative analysis); c) дискурс буюу хэлэлцүүлгийн шинжилгээ (discourse analysis); юм. Эдгээрийн шинжилгээ хийх түвшин харилцан адилгүй боловч тэдгээрийг хэл яриа, мэдрэмжинд голчлон анхаарал хандуулдгаар нь адилтгаж болно. Гол зорилго нь улс төрийн амьдрал дахь хүний мэдрэмжээ илэрхийлэх дадал зуршил (сонгуульд санал өгөх, дайн байлдаан г.м), үйл явц (хямрал г.м) болон институт (агентлаг, засгийн газар, улс үндэстэн)-ын учрыг тайлж ойлгох болон тайлбарлахад оршино.

Фрэймин (хүрээний буюу хэсэгчилсэн) шинжилгээ бол хүмүүс нийгэм, улс төр, эдийн засгийн тухайн нөхцөл байдал, үйл явцыг хэрхэн ойлгож байгааг нь шинжлэхэд ашигладаг нийгмийн шинжлэх ухааны судалгааны олон аргын нэг юм. Энэ нь Ирвин Гофманы 1974 онд хийсэн (Frame Analysis: An Essay on the Organization of Experience) шинжилгээний ажлын бүтээлтэй холбоотой гарч ирсэн шинжилгээний концепц юм. Судлаачид хүрээний онол болон шинжилгээг улс төр, нийгмийн хөдөлгөөн, коммуникаци болон төрийн бодлого, хөтөлбөрүүдийг судлахад өргөн ашигладаг (Johnson-Cartee, 1995). Хүрээний шинжилгээг фрагмент буюу хэсэгчилсэн шинжилгээ гэж нэрлэх явдал байдаг. Энэ нь судалж буй объектыг тодорхой бүтцэд оруулж ангилан авч үзсэнээр тухайн нөхцөл байдлын гол хэсэгт анхаарлаа хандуулсан хүрээ үүсгэж, бусад хэсгийг нь үл хайхран авч үзэхгүй орхидог. Ингэснээр уг хүрээ нь асуудлын улс төрийн үйл явцын гол хэсэг болдог. Ийм замаар асуудлыг тодорхойлсноор зайлшгүй тодорхой шийдэлд хүрэх, эсвэл эсрэгээрээ болох нь ч бий. Хүрээний шинжилгээний үйл явц бол “...харилцааны эх сурвалж болох байгууллагын мэдээллээр тодорхойлогдсон улс төрийн асуудал, эсвэл олон нийтийн маргаан, санал зөрөлдөөнийг судалдаг” (Nelson, Oxley, & Clawson, 1997, p. 221).

Нарратив (өгүүлэмжийн) шинжилгээг ихэвчлэн утга зохиолын онол болон Марк Жонсон, Аласдэйр Макинтайр (Alasdair MacIntyre) нарын философичид, Виллиам Вайт (William Whyte) шиг түүхчид хөгжүүлсэн байдаг бөгөөд мэдрэмж төрөх гэдэг нь ихэвчлэн үлгэр, түүх мөн хүмүүс хоорондоо болон орчинтойгоо харьцах харилцааны тусламжтайгаар бий болдог гэж үздэг үзэл санаанаас үүдэлтэй юм. Судлаачид судалгаа шинжилгээний ажлын хүрээнд ярьж, өдөр тутмын амьдралдаа хуваалцдаг түүхүүдийг тайлбарладаг.

Зохиолд дүрүүд тодорхой нөхцөлд үйл явдалд оролцдог. Заримд нь эсрэг талын хорон санаатны дүр оногдсон байхад зарим нь баатрын дүрээр, эсвэл хохирогч, гэм буруугүй хөндлөнгийн ажиглагчийн дүрээр дүрслэгддэг. Тухайн мөчид дүрүүд нь хүний эсвэл ямарваа нэгэн байгуулалын онцлог шинжийг харуулдаг. Тухайн хамааралтай орчныг жишээ нь хямралын нөхцөл байдал зэргийг харуулах нь зохиолыг дүрслэхэд чухал хувь нэмэр оруулдаг. Зохиолын төрөл бүрийн элементүүдийн дэс дараалсан байдал нь зохиолын үйл явдлыг өрнүүлдэг бөгөөд энэхүү үйл явдал нь

үзэгчдэд чухам юу болж байгааг ойлгоход тусалдаг. Бүтэц болон өгүүлэмжийн тусламжтайгаар улс төрийн тоглогчид бодит байдлыг зөрчилдөөнтэй аргаар дүрсэлж тайлбарлаж, хариу үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхийн тулд өөр хоорондоо маргалдаж байдаг. Бодлогын шинжлэлд Эмери Рое, Мишел фон Ээтен зэрэг судлаачид тухайн шинэ хэлэлцэх асуудлынхаа бодлогын үйл явцад дүрүүдийг оролцуулах болон болон бусад дүрүүдийн талаарх ойлголтыг бий болгох мөн зөрчил болон тухайн бодлогын төвөгтэй асуудлыг шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлэх арга хэрэгслийг дүрслэн гаргаж ашигласан.

Дискурс шинжилгээ нь М.Фукогийн постструктурализм болон Эрнесто Лаклау, Чантал Мүффэ нарын хөгжүүлсэн марксизмын дараах постструктуралист хандлага дээр тулгуурлан улс төрийн практик үйл явцад шүүмжлэлт шинжилгээ хийдэг бөгөөд фрэймин болон нарратив шинжилгээний аргаас илүү хийсвэр түвшинд хамаарагдаж байдаг. Дискурс шинжилгээ нийгмийн тодорхой үйл явдалд бий болсон үзэл санаа, ойлголтыг цогцоор нь тодорхойлохыг хичээдэг. Дискурс шинжилгээгээ нь нийгмийн практикт гарч ирдэг объект, субъектуудын эмзэг сэдэв болон ямар үзэл баримтлал ашиглахыг харуулдаг. Үүний үр дүнд, нийгмийн дадал зуршлаас улбаатай зүйлс гарч ирдэг. Тухайн дүрүүд буюу тоглогчид ярьж бичиж байхдаа юуг мэдэрсэн юуг илэрхийлэх гэснийг олж таних нь дискурс анализын гол зорилго биш хэдий ч текстэн доторх текст буюу зохиол дахь өгүүлэмжийн нөлөөг анхааран үзэж өөрөөр хэлбэл субъектаас салгаж авч үзэхэд гол анхаарлаа хандуулдаг. Үүнийг субъектив хандлагыг хасах гэж нэрлэдэг. Ингэснээр нийгмийн тухайн үйл явдалд юу орхигдсон, мөн юу гарч ирснийг харуулдаг. Олонх дискурс анализ нь Фукогийн архелогийн болон уг гарал үүслийн судлал шиг түүхэн судлал байдаг. Мөн түүнчлэн адилтгах болон ангилах аргаар дүн шинжилгээ хийх аргын жишээ нь: бодлого боловсруулах үйл явц дахь угсаатны ангилалыг задлан шинжлэх чиглэлээр ажиллаж байсан социал конструктивизмын судлаачид байдаг.

Социал конструктивизмын бодлого боловсруулах үйл явц

Социал конструктивизм нь орчин үед улс төрийн шинжлэх ухаан, социологи, төрийн удирдлага болон бодлогын судалгаа зэрэг нийгмийн шинжлэх ухааны төрөл бүрийн салбаруудад чухал үүрэг гүйцэтгэх болсон. Нийтийн удирдлагын онолын сүлжээний (PAT-Net) гишүүд болох хэсэг эрдэмтэд 1988 онд постмодернизмыг гаргаж ирж “Administrative Theory and Praxis” сэтгүүлд хэвлүүлснээр нийтийн удирдлагын онолд социал конструктивизм хөгжих үндсийг тавьсан. Феминист үзэл нь конструктивизмын сэтгэлгээнд хүчтэй байр байр суурь эзэлдэг. Бодлогын шинжлэх ухаан дахь социал конструктивизмын хөгжлийн ид үе нь мөн энэ үед тохиож байжээ. Вайл Эгон Куба болон Ивонна Линкольн (While Egon Cuba and Yvonna Lincoln) нар дүн шинжилгээн дэх конструктивизмын хандлагыг гаргаж ирсэн бол, Дэбора Стөун болон Жиандоменико Мажөун (Deborah Stone and Giandomenico Majone) нар бодлого дахь реторикийн үүрэг оролцооны талаарх номондоо бодлогын шинжлэх ухаанд “томоохон өөрчлөлт”-ийг эхлүүлсэн юм. Энэхүү санаа нь хожим Фрэнк Фишер, Жон Форестер нарын хянан тохиолдуулсан боть номонд илүү боловсронгуй болж өдгөөг хүртэл хөгжиж байна.³⁵

Бодлого боловсруулалтын талаарх социал конструктивизмын үзлийг хэрхэн хэрэгжүүлэв вэ гэдэг асуултад Жон Дризек хариулсан анхдагчдын нэг байсан. Энэ салбарт маш үнэтэй хувь нэмэр оруулсан тэрбээр “онолчтой арга хэрэгсэл” (эцэст нь зөв арга хэрэгсэл олдох боломжтой гэж үзэх итгэл) болон “бодитойгоор орших” (ингэж

³⁵ Pieter Wagenaar and Gjalte de Graaf Vrije. Policy, Constructivist Models. Universiteit Amsterdam, Netherlands

хийнэ гэсэн дундаж стандарт байдаг гэдэг үзэл) гэдэгтэй санал нийлээгүй юм. Ж.Дризекийн бодлоор “оновчтой арга хэрэгсэл” болон “бодитойгоор орших” философи нь Макс Веберийн “төмөр тор” болон Юрген Флабермас (Jurgen Flabermas)-ын зэрэгт амьдралын хэв маягийг колоничлох (colonization of the lifeworld)-д хүргээд зогсохгүй ашиглаж болохуйц бодлогын шинжлэлийг түгээх боломжгүй болгож улмаар нийгмийн шинжлэх ухааны үйл явцад саад хийж байна гэж үзсэн. Дризекийн “ардчиллын оновчтой байдал ба тасалдал” (discursive and democratic rationality) гэж нэрлэсэн өөр нэг арга бол эрх мэдлийн оронд бодит шалтгаанд тулгуурласан бодлого боловсруулах арга юм. Тэрбээр “Оролцооны ардчилал” нь үүнийг боломжтой болгох болно гэж тэр үзсэн.³⁶

Анна Ларасон Шнайдер, Хелен Инграм нар бодлого боловсруулалтын доройтол бол бүх бузар муугийн үндэс болдог гэж үзсэн. Бодлого боловсруулалтын доройтол бол улс төрчдийн хувийн ашиг сонирхлоо нуух ов мэх юм. Энэ нь хүмүүсийг шагнах/шийтгэх, бүлгээр нь ялгаварлах тогтолцоонд аваачдаг бөгөөд улс төрийн шалтгаанаар шинжлэх ухааныг урвуулан зүй бусаар ашиглахад хүргэдэг. Аливаа бодлогын асуудлаар мэргэжлийн шинжээчид мэтгэлцээнд ноёрхдог хэдий ч тэд улс төрийн захиалгад өртсөн тохиолдол багагүй байдаг бөгөөд энэ үед иргэдийн дунд шинжлэх ухааныг үл тоомсорлох хандлага ихсэж, эсэргүүцэл, зарга үүсдэг.³⁷ А.Шнайдер, Х.Инграм нарын “бодлогын дизайн” гэж нэрлэгддэг арга нь эдгээр алдааг засах долоон үндсэн зарчим дээр тулгуурласан байдаг. Бодлогын үйл явц дахь шинжээчдийн үүрэг роль гажуудах явдлыг Фишер авч үзсэн. Жон Дьюгийн үзэлд тулгуурлаж Фишер шинжээчдийн үүрэг бол иргэд зөвхөн өөрийн байр сууринаас шийдвэр гаргах, бас гаргахгүй байхад нь туслах явдал юм гэж үзсэн. Шинжээчид иргэдэд бодлого боловсруулах үйл явцад оролцоход нь туслаж иргэдэд зориулсан хурал, чуулган зохион байгуулах хэрэгтэй.

Дүгнэлт:

Бодлого судлалын хандлага 1960-аас 1970-аад оны үед бий болсон. Бодлого судлал нь улс төрийн шинжлэх ухаанд үл хамаарагдах субъектив дэд бүлгүүд (substantive)-ийн мөн чанар болох бодлого боловсруулах, бодлогын үйл явцын шинжилгээ, бодлогын агуулга, судалгаа, шинжилгээний арга зүй, бодлогын арга хэрэгсэл зэргийг багтаасан судалгааны бие даасан салбар юм. Судалгааны талбар нь (эрүүл мэнд, боловсролын бодлого гэх мэт) бодлогын шинжилгээний дэд хэсгүүдэд үл хамаарагдах хөтөлбөрийн үнэлгээ, нөлөөллийн судалгаа, бодлогын загвар, дизайны мөн чанарыг судалдаг. Энэ нь тодорхой зорилгод хүрэх зорилтууд бүхий бодлогод анхаарал төвлөрүүлж, альтернатив бодлогын шинж чанар, улс төрийн шалтгаан, үр нөлөөг системтэйгээр судлах явдал юм. Тиймээс бодлогын шинжилгээний талбар нь хоёр гол хэсэгт хуваагддаг: Энэ нь нэгдүгээрт, одоо байгаа бодлогын шинжилгээ, түүний хөгжлийг тайлбарласан байдаг. Хоёрдугаарт, бодлого боловсруулахтай холбоотой саналууд, тэдгээрийн шинэ бодлогыг тодорхойлох явдал юм. (жишээлбэл, нийгмийн халамжийг сайжруулах гэх мэт) Судалгаа шинжилгээний зорилгоос хамаарч ямар төрлийн шинжилгээ хийхийг тодорхойлдог бол, бодлого, хөтөлбөрийн үнэлгээ нь өөрөө бодлогын судалгаагаар тодорхойлогддог.

Бодлогын шинжилгээ болон бодлогод чиглэгдсэн шинжилгээ хийх хоёрын ялгааг авч үзье. Бодлогын шинжилгээний талаарх бидний ойлголт байнга өөрчлөгдөн хувирч байдаг бөгөөд янз бүрийн үзэл санаа, шинэ арга хэрэгсэл, хандлага зэрэг олон

³⁶ Dryzek, J. S. (1990). Discursive democracy: Politics, policy, and political science. Cambridge, UK: Cambridge University Press.

³⁷ Schneider, A. L., & Ingram, H. (1997). Policy design for democracy. Lawrence: University Press of Kansas.

зүйлсийн тусгалыг олдог учраас чухам юу болохыг ойлгохын тулд түүнийг гүнд нь ортол сайтар судлах хэрэгтэй. Гэсэн хэдий ч бодлогын шинжилгээг бодлого боловсруулах үйл явц, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг шинжлэх явдал гэж үзэж болох юм. Харин бодлогод чиглэгдсэн шинжилгээний хувьд түүнийг бодлого хэрэгжүүлэлтийн явцад хийх үүссэн хяналт шинжилгээнээс гаралтай гэж үзэх хандлага байдаг. Энэ нь эцсийн бүлэгт уг бодлогыг өөрийг нь бүхэлд нь шүүмжлэх, дахин өөрчлөх хандлагаас үүсэлтэйгээр бодлогын шинжилгээ, түүний арга хэрэгсэл, үе шат бүрийг илүү нарийвчлан авч үзэж шинжлэх ухааны түвшинд илүү ойртуулахад чиглэгдсэн илүү нарийвчлагдсан, шинжлэх ухааны сургууль (шкал) үүсгэх хандлага юм гэж ойлгож болно.

Summary:

This article, which focuses on scientific cognition, provides a brief overview of the theoretical model and scope of policy development. This article discusses the political system's approach to policy analysis, its nature, the limited nature and critique of the system approach, the rational approach to policy analysis, its nature, rational decision-making approach, the limitations of rational approach, the incremental approach to policy analysis, its nature and incremental decision-making. opportunities, strategic policy development, institutional approach to policy analysis, its nature, policies and institutions. It also discusses the "trash" model of policy analysis, its nature, the anarchic model of decision making, the social constructive approach to policy research, the types of social constructivism, social constructivist research, and the policy-making process of social constructivism.

Ном зүй:

- Ц.Батболд. Бодлогын шинжилгээний онол, арга зүйн үндэс. лс төрийн социологийн онолын үндэс. УБ., 2019. Удам соёл ХГ
- Easton, David, 1965, A Framework for Political Annlysis. N.J. Prentice Hall, Englewood Cliffs.
- Dye, Thomas R., 1980, Understandiizg Public Policy, Prentice Hall, Englewood Cliffs.
- Lineberry, Robert L., 1984, Anzerican Public Policy: What Government does and What Diference it Makes, Marcel Dekker, New York.
- Herbert A. Simon. 1982. Models of Bounded Rationality: Economic Analysis and Public Policy. MIT Press.
- Patton, Carl V. and David S. Sawicki, 1986, Basic Methods of Policy Analysis andplanning, Prentice-Hall, Englwood Cliffs.
- David F Paulsen, Robert B Denhardt. 1973. Pollution and public policy; a book of readings. New York, Dodd, Mead,
- Lindblom, Charles, "Still Muddling Through. Not Yet There", Public Aclministration Review, Vol. 39, 1979.
- Etzioni, A. 1967. Mixed Scanning: A 'third' approach to Decision-Making, Public Administration Review, Vol. 27
- Cohen, M.D.; March, J.G.; Olsen, J.P. (1972). "A garbage can model of organizational choice". Administrative Science Quarterly. 17 (1):
- McFarland, Daniel; Gomez, Charles. 2013. Organizational Analysis. Coursera.
- Birnbaum, Robert (1989). "The Latent Organizational Functions of the Academic Senate: Why Senates Do Not Work But Will Not Go Away". The Journal of Higher Education. Vol. 60, No. 4.
- Kingdon, John W. (2003). Agendas, alternatives, and public policies, second edition. London, UK: Longman.

- Cairney, Paul; Jones, Michael D. (2016). "Kingdon's Multiple Streams Approach: What Is The Empirical Impact of this Universal Theory?". *The Policy Studies Journal*. 44.
- Edwin Amenta. *State-Centered and Political Institutional Theory: Retrospect and Prospect. The Handbook of Political Sociology: states, civil societies, and globalization.* Cambridge University Press 2005.
- Olsen, J.P. (1984). The new institutionalism: Organizational factors in political life. *American Political Science Review*, 78,
- Pieter Wagenaar and Gjalte de Graaf Vrije. *Policy, Constructivist Models.* Universiteit Amsterdam, Netherlands
- Dryzek, J. S. (1990). *Discursive democracy: Politics, policy, and political science.* Cambridge, UK: Cambridge University Press.
- Schneider, A. L., & Ingram, H. (1997). *Policy design for democracy.* Lawrence: University Press of Kansas

ХӨГЖЛИЙН УЛС ТӨР БА ТҮҮНИЙ АРГА ЗҮЙ**О.Мөнхжаргал**МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхимийн багш**Ж.Төртогтох**МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, профессор,
Ардчилал судлалын төвийн захирал*Түлхүүр үг: хөгжил, тоглоомын дүрэм, институци, улс төрийн зохицол*

Хураангуй: Улс төрийг голдуу төр, засгийн албан үйл ажиллагаа, институциудтэй холбон олон янзаар тодорхойлж ирсэн уламжлалт үзэл өөрчлөгдөж байна (Мур, 2002). Улс төр бол хүмүүсийн хамтын бүхий л хэлбэрт нөөцийг ашиглах, бий болгох, хуваарилах шийдвэрүүдтэй холбоотойгоор албан болон албан бус, нийтийн болон хувийн харилцаагаар дамжин явагддаг зайлшгүй *үйл явц* (эсвэл үйл явцуудын бүрдэл) юм. Улс төрийг ингэж өргөн хүрээгээр авч үзэх нь хөгжиж буй орнуудад нийтлэг тохиолддог албан болон албан бус институциудын харилцан үйлчлэл, эрх мэдлийн албан болон албан бус эх үүсвэр, хэлбэрүүдийг илрүүлэн судлах бололцоо олгодог. Түүнчлэн улс төрийг хүний хамтын үйл ажиллагааны бүх түвшинд авч үзсэнээр улс төрийн үйл явцын шинжилгээг зөвхөн үндэсний хэмжээнд гэлгүй *орон нутгийн түвшинд*, мөн нөөцийн ашиглалт, хуваарилалт голлон явагдаж байдаг боловсрол, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн зэрэг *салбарууд* болон аж ахуйн нэгж, үйлдвэр, сургууль зэрэг *байгууллагуудын* түвшинд хийх боломжтой юм. Улс төр нь нэг талаас улс төрийн "тоглоомын" дүрмүүд, нөгөө талаас тэдгээр дүрмүүдийн дагуух "тоглолт" гэсэн хоорондоо ялгаатай атлаа уялдаатай хоёр түвшинд тодорхойлогдох ба хөгжлийн улс төр нь эдгээрт үндэслэгдсэн улс төрийн ээдрээтэй, онцгой нөхцөлүүдийг буюу хөгжлийг дэмжигч эсвэл саатуулагч эрх мэдэл, хүчин зүйлс, тэдгээрийг хамарсан үйл явцын динамикийг авч үздэг. Эдгээр нь тухайн улсын улс төрийн нөхцөл байдал, тогтцоос хамаардаг тул түүнийг илрүүлэх, ерөнхий хэв шинжийг тодорхойлох замаар үр дүнг баримжаалах, динамикийг шинжлэхэд улс төрийн зохицлын шинжилгээ нь арга зүйн хувьд чухал ач холбогдолтой юм.

Удиртгал:

Хүйтэн дайны дараа өрнөдийн ялагч гүрнүүдийн зүгээс Вашингтоны зөвшилцлийн хүрээнд буурай болон хөгжиж буй орнуудын уламжлалт бүтэц, институциудийг шинэчлэх, засаглалыг сайжруулах "стандарт" арга хэмжээнүүдийг олон улсын хамтын нийгэмлэг, санхүүгийн механизмуудад тулгуурлан хэрэгжүүлсэн (Уильямсон, 2002) нь улс орнуудад харилцан адилгүй үр дүн үзүүлж, заримд нь сөргөөр нөлөөлсөн (Юттинг нар, 2005). Дээрх байдлыг улс орнуудын дотоод улс төрийн нөхцөл байдал, эрх мэдлийн харилцаа нь тэдгээр стандарт гэгдэх арга хэмжээнүүдэд янз бүрийн хариу үйлчлэл үзүүлсэнтэй холбон тайлбарладаг ба бүтэлгүйтлийн нийтлэг шалтгаан нь хөгжлийн асуудалд улс төрийг үл хайхарсантай холбоотой хэмээн дүгнэгддэг. Энэ нь тухайн үед зонхилж байсан неолиберал эдийн засгийн номлол, технократ хандлага ёсоор хөгжлийн асуудалд эдийн засгийг эн

тэргүүнд, улс төрийг хоёрдогч байр сууринд тавин үздэг байсантай холбоотой юм. Харин 2000 аад оны эхэн үеэс хөгжилд улс төрийг зайлшгүй харгалзан үзэхийг хүлээн зөвшөөрч эхэлсэн. Улмаар аливаа өөрчлөлт, хөгжлийг бий болгодог эсвэл саатуулдаг *улс төрийн үйл явцуудыг* шинжлэх болсноор улс төр нь хөгжлийн сонголт, стратеги, чиглэл, үр дүнг шийдвэрлэхэд голлох нөлөөтэйг тогтоосон (Хики, 2013). Хувь хүмүүс болон байгууллагуудын үйлдэл нь улс төрийн орчин, нөхцөлдөө захирагддаг тул тэрхүү орчин нөхцөлийг бүрдүүлэгч бүтцийн болон институцийн хүчин зүйлсийг судлах нь хөгжлийн улс төрийн нэг үндсэн чиглэл болсон (мөн тэнд). Хөгжил бол нийгэм, эдийн засаг, улс төрийн харилцаа болон институциудыг хувиргах үйл явц болохын хувьд нэгэнт тогтнож, бэхэжсэн ашиг сонирхол, эрх мэдлийн бүтэц, тэдгээрээр үүсгэгдсэн институцийн зохицуулалтуудтай (эсвэл тоглоомын дүрмийг) тулгардгаараа гарцаагүй улс төрийн үйл явц юм. Дээрх онцлогуудаас үүдэн хөгжлийн улс төрийг авч үзэх, ялангуяа хоорондоо ялгаатай нийгмүүд дэх улс төрийн зохицол, хөгжлийн боломж бололцоог шинжлэх арга зүй шаардлага бий болсон. Адриан Лэфтвич (2005) улс төрийг нийгэм, түүний тодорхой хэсэг дэх нөөцүүдийг ашиглах, бий болгох, хуваарилахыг шийддэг албан болон албан бус улс төрийн үйл явцуудын бүрдэл гэж тодорхойлоод уг шийдвэр гаргах ерөнхий хүрээг Д.Истоны улс төрийн системээр авч үзсэн. Харин Муштак Хан (2005) шийдвэр гарах орчныг илүү тодруулан улс төрийн зохицол¹ хангагдаж буй байдлаар нь авч үзсэн бол Тим Келсалл (2020) түүний санаанд суурилан улс төрийн зохицлын дөрвөн төрлийг тодорхойлсон. Эдгээр нь эрх мэдэл, ашиг сонирхлыг гол болгох замаар улс төрийн нөхцөл байдал, онцлогийг улс төрийн дэглэм эсвэл албан институцийн хэм хэмжээнээс ахиулан авч үзэх боломж олгодгоороо хөгжлийн улс төрийн судалгааны зорилгыг хангахад чухал ач холбогдолтой юм.

Улс төрийг тодорхойлохуй

Улс орнуудын (эсвэл тэдгээрийн хэсгүүд дэх) улс төрийн үйл явц нь тэдгээрийн бүтэц, гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөө, эрх мэдэл, үзэл санаа, үзэл суртал, ашиг сонирхлуудын хуваарилалт болон тэнцвэрээс нь шалтгаалж өөр өөр байдаг (Адриан Лэфтвич, 2005). Тиймээс улс төрийг хамгийн түгээмэл үйл явцаар нь тодорхойлох шаардлагатай гэж үзвэл:

- Хүмүүсийн аливаа нийтлэг (гэр бүл, холбоо, улс г.м) тэсэж үлдэх болон цэцэглэн хөгжихийн тулд хамтын шийдвэр гаргах арга хэрэгсэлтэй байх зайлшгүй шаардлагатай болдог нь улс төр юм. Үүнд үндэслэн Адриан Лэфтвич² (2005) “*улс төр бол нөөцүүдийг ашиглах, бий болгох, хуваарилах шийдвэрүүдтэй холбоотой хамтын ажиллагаа, зөрчилдөөн, хэлэлцээний бүхий л үйл ажиллагаа*” хэмээн тодорхойлж албан болон албан бус, нийтийн болон хувийн эсвэл бүгдийнх нь холимог хэлбэрээр явагддаг болохыг онцолсон байдаг. Энэ тодорхойлолт нь улс төр (засаглал, эрх мэдэл, хамтын шийдвэр гаргалт) болон эдийн засгийн (ховор нөөцийн зарцуулалт) талаарх нийтлэг үзлүүдийг нэгтгэснээрээ тэдгээрийн хоорондын харилцааны ойлголтыг өргөжүүлэхэд тусалдаг.

¹ Mushtaq Khan (2005, 2000) “Political settlement” гэх уг ойлголтоор сөргөлдөгч анги, бүлгүүдийн хоорондох хүчний хуваарилалт, тэнцвэрийг авч үзсэн ба улс төр, эдийн засгийн тоглоомын дүрэм хүчирхэг бүлгүүдийн тохиролцоогоор тогтдог гээд уг зохицол хангагдаагүй бол тогтвортой байдал бий болохгүй гэж үздэг.

² Адриан Лэфтвич (1940-2013) бол Хөгжлийн манлайллын хөтөлбөр (DLP)-ийн судалгаа эрхэлсэн захирал бөгөөд улс төрийг хөгжлийн судалгаанд эргүүлэн авч ирэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн, хөгжлийн улс төрийн тэргүүлэх сэтгэгчдийн нэг байсан.

- Энэ утгаар авч үзвэл улс төр нь нэг буюу хэд хэдэн үйл явцуудын бүрдэл бөгөөд тодорхой нэг талбар буюу нэгж (парламент, шүүх, төрийн алба г.м) эсвэл эрх мэдэлтнээр (хаан, улс төрчид, төрийн албаныхан г.м) хязгаарлагддаг зүйл биш гэдэг нь улам тодрох болно. Улс төр бол эдийн засгийн адилаар хүмүүсийн хамтын үйл ажиллагааны *зайлиггүй* үйл явц болохын хувьд заавал засгийн газар, албан институцүүдийн дүрэм журмаар явагддаггүй. Хэдийгээр төрийн институциуд, түүгээр албажсан шийдвэр гаргалт нь улс төрийг илэрхийлэх гол илэрхийлэл *байж болох* (ялангуяа орчин үеийн бэхэжсэн, тогтвортой улс төрд) боловч хүмүүсийн бүх нийтлэгүүд, байгууллагуудын шийдвэр ингэж гардаггүй тул зөвхөн албан институцийн түвшинд улс төрийг тодорхойлох, авч үзэх нь хязгаарлагдмал бөгөөд учир дутагдалтай юм.

Улс төрийн хоёр түвшин

Улс төр болон түүний хөгжилд үзүүлэх үр дагаврыг ойлгохын тулд улс төр болон улс төрийн өрсөлдөөн явагдаж байдаг хоорондоо ялгаатай атлаа уялдаатай хоёр түвшнийг таних шаардлагатай (Линднер ба Ритенбергер, 2003). Эдгээр нь:

1. *Тоглоомын дүрмүүд* (институциуд) -ийг анхааран үздэг түвшин;
2. *Дүрмүүдийн дагуух тогтолтыг* анхааран үздэг түвшин.

1. Тоглоомын дүрмүүд

Тоглоомын дүрмүүд болон тэдгээр дүрмүүдийн талаарх тохиролцоо бол өрнөж буй аливаа улс төрийн үйл ажиллагааны үндсэн суурь юм. Тогтвортой улс төрийн хэлбэр нь улс төрийн суурь дүрмүүдээ ямагт зөвшилцлөөр тохирдогт оршино. Тухайлбал зарим судлаачид ардчиллын бэхжилтийг урамшуулах болон эс урамшуулах хөшүүрэг нь институциуд, дүрэм журмуудын бүрдлээр хэвшин тогтож “тогтолтын цорын ганц дүрэм” болсонтой зүйрлэсэн байдаг (Линц ба Степан, 1996).

Орчин үеийн ертөнцөд эрх мэдлийн төлөөх өрсөлдөөн, хуваарилалт, ашиглалт, хяналт болон шийдвэр гаргах, хариуцлага тооцох дүрмүүд нь албан институцийн хэлбэрээр үндсэн хуульд тусгагддаг. Харин тэдгээр дүрмүүдийг дагаж мөрдөх, зөвшилцөл хангагдахад соёл, улс төрийн соёл, үзэл суртал зэрэг илүү өргөн албан бус институциуд шийдвэрлэх үүрэгтэй. Иймэрхүү дүрэм болон үйл явцууд нь заавал албан эсвэл үндсэн хуульд бичигдсэн байх албагүй. Учир нь орчин үеийн төрүүд бий болохоос өмнөх хүн төрөлхтний ихэнх нийгмүүдэд үндсэн хууль байгаагүй ч тогтвортой байдал урт хугацаанд тогтносоор ирсэн байдаг. Тэдгээр болон орчин үеийн бүхий л тогтвортой улс төрийн хэлбэрүүд дэх улс төрийн тоглоомын дүрмийн талаарх зөвшилцөл нь тодорхой нийгэм-эдийн засгийн зорилгууд, бодлогууд, үйлдлүүдийг ямар нэг хэмжээгээр зөвшилцөх замаар явагддаг. Ийм зөвшилцөл элдэв зөрчилдөөнгүй, хялбархан явагддаггүй нь 19-20-р зууны өрнөдийн аж үйлдвэржилтийн үеийн баруун болон зүүнийхний тэмцлээс харагддаг. Өдгөө зарим хөгжиж буй орнууд улс төр, эдийн засгийн зөвшилцөлд хүрч, тогтвортой өсөлтийг хангаж байгаа ч үүнд хүртлээ ихэнх нь удаан үргэлжилсэн ширүүн зөрчилдөөнийг туулсан байдаг (Брютигам, 1997).

Адилхан ардчилсан капиталист нийгмүүд ч дотоод “зохицол” болон институцийн хэлбэрээрээ хоорондоо ялгаатай байдгийг Холл ба Соскис (2001) нар

"капитализмын олон янз байдал"³ -ын судалгаагаараа илрүүлсэн. Зүүн Азын хөгжлийн төрүүдийн институцийн зохицуулалтууд ч мөн өөр хоорондоо ялгаатай юм (Хаггард, 2004). Үүнээс үүдэн улс төрийн тогтвортой байдлыг хангах арга нь нийгэм-эдийн засгийн зорилгууд болон институцийн зохицлыг өөрчлөхгүй байх явдал бус харин тогтвортой байдлын үндсийг ганхуулахгүйгээр өөрчлөлтүүд явагддаг байх улс төрийн тоглоомын дүрмийг тогтооход анхаарах болсон. Үнэндээ ардчилсан улс төрийг ч гэсэн албан бус бичигдээгүй 2 дүрэм доороос нь тулж тэнцвэржүүлж байдаг. Эхнийх нь ялагдагчид 4, 5 жилийн дараа дахин оролдож үзэх боломжтойгоо мэддэг тул (ялагчид мөн адил) сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрч легитимийг хангуулдаг. Хоёрдох нь ялагчид эрх мэдлээ (үндсэн хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд) ялагдсан талын ашиг сонирхлыг нухчин дарах, заналхийлэхэд ашиглаж болохгүйгээ мэддэг. Хэрэв тэгвэл тохиролцоо буюу дүрэм бүхэлдээ мөрдөгдөхөө болих эрсдэлтэй тул хэн ч нийлбэр нь тэг-тэй тэнцэх тоглоомоор тоглохыг хүсдэггүй. Хэдийгээр ялагчид онолын хувьд "бүгдийг авах" боломжтой ч ингэж хандах нь ялагдсан талынхны үндсэн ашиг сонирхол, боломжуудыг үгүй хийх тул үүнээс зайлсхийдэг. Энэ утгаараа албан институци давамгайлсан ардчилсан капиталист улс төрийн хөгжил нь ялалтаас бий болох үр ашиг болон ялагдлаас үүдэх гарз хоёрыг аль алийг нь тогтмол бууруулахад чиглэж байдаг. Улс төр алдах, онох бооцоо ихтэй байх нь илүү сөргөлдөөнтэй, хүчирхийлэлтэй нөхцөлийг бий болгодог.

2. Дүрмийн дагуух тоглоомууд

Энэ түвшинд улс төрийн бодлого, үйл хэргийн талаарх өдөр тутмын мэтгэлцээн, маргаан зэрэг "хэвийн" улс төрийг авч үздэг. Энд дурдсан "хэвийн" гэдгээр тодорхой нэг улс төрийг ёс суртахууны хувьд зөв, зохистой, тохиромжтой гээд бусад хэлбэрийн улс төрийг хэвийн бус эсвэл "буруу" гээгүй ба харин ямар нэг байдлаар урьдчилан *таамаглах боломжтой*, үр дүн нь тухайн эрх мэдэл эсвэл эд баялгийн бүтцэд эрс өөрчлөлт бараг оруулахгүй, *таамаглах боломжгүй зүйлс багатай байдлыг хэлнэ*. "Хэвийн" улс төр бүхий тогтвортой улс төрийн нийтлэгүүдэд тоглоомын үндсэн дүрмүүд өөрчлөгдсөн ч (үндсэн хуулийн шинэчлэл г.м) ноцтой аюул заналхийлдэггүй. Улс төр, эдийн засгийн талаар санал зөрөлдөөн, мэтгэлцээн, өөрчлөлт бүгд явагдаж байдаг ч институцийн зохицуулалтууд болон үйл ажиллагааны горимуудаар дамжин өөрчлөлтийн явцад тогтвортой байдал нь хадгалагдаж байдаг.

Улс төрийн хамгийн чухал түвшин бол угтаа "дэглэм"-ийн төрлийг тогтоодог эхний түвшин юм. Эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжих нийгэм-эдийн засгийн зорилтуудыг тодорхойлох, эдийн засаг, засаг захиргаа, шүүхийн институцийг бий болгох, улс төр явагдах стандарт горимууд болон институциудийг бүрдүүлэх, хадгалах, хэрэгжүүлэхтэй холбоотой үндсэн үйл явцууд энд бүрэлддэг. Байгуулагдсан институциудын легитимийн талаар үр дүнтэй зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд "хэвийн" улс төр явагдах боломжгүй. Хэрэв хоккейг тогтсон дүрэмгүйгээр тогловол ойлгомжгүй, урьдчилан таамаглах аргагүй бөгөөд тоглоход хэцүү (магадгүй аюултай) гэдэгтэй адил юм.

Дээрх тодорхойлолтод үндэслэн хөгжлийн улс төрийг авч үзнэ.

³ Hall and Soskice (2001) <https://scholar.harvard.edu/files/hall/files/vofcintro.pdf>

3. Хөгжлийн улс төр

Юуны өмнө хөгжил бол хурдацтай эсвэл удаашралтайгаас үл хамааран хувиргах үйл явц байдаг ба үүнд эдийн засгийн өсөлт, нийгмийн хувирал, улс төрийн өөрчлөлтийг авч үздэг. Практикт энэхүү хувиргалт нь голдуу эрх мэдэл, баялгийн ашиглалт болон бүтцийг өргөн хүрээнд эрс өөрчлөхийг зорьдог. Үүгээрээ хөгжил бол нь улс төрийн бөгөөд гүнзгий зөрчилдөөнт шинж чанартай. Хэрэв улс төр нь өмнө тодорхойлсончлон нөөцийг ашиглах, бий болгох, хуваарилах шийдвэрүүдтэй холбогдон гардаг хамтын ажиллагаа, хэлэлцээр, зөрчилдөөн бүхий үйл ажиллагаанаас бүрддэг гэвэл *хөгжлийн улс төр* нь нөөцийг хэрхэн ашиглах, үйлдвэрлэх, хуваарилахыг өөрчлөх, ийм өөрчлөлтийн шийдвэр хэрхэн гардаг, тэдгээр нөхцөлийг тэтгэх, хэрэгжүүлэх, өргөжүүлэх улс төрийн тухай авч үздэг (Хики, 2014).

Хөгжлийн улс төрийн мөн чанарыг хоёр энгийн баталгаагаар нэгтгэж болно. Эдгээр нь:

- (a) *Хүмүүс нөөцийг ашиглах, үйлдвэрлэх, хуваарилах арга замаа өөрчлөх үед хоорондох харилцаа (нийгмийн болон улс төрийн) тухайлбал эрх мэдлийн харилцаа өөрчлөгддөг;*
- (b) *Хүмүүс улс төр болон нийгмийн (эрх мэдлийн) харилцаагаа өөрчлөх үедээ ихэвчлэн нөөцүүдийг ашиглах, үйлдвэрлэх, хуваарилах арга замаа мөн өөрчилдөг.*

Онцгой эрхийн хугацааг сунгах, үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийг хүлээн зөвшөөрөх, эмэгтэйчүүдийн хууль ёсны тэгш эрхийг хангах, боолчлолыг халах зэрэг улс төрийн өөрчлөлтүүд нь нөөцийн хуваарилалт болон эдийн засгийн хүчин чадалд хэрхэн нөлөөлж болдгийг харуулсан жишээ юм. Нөгөө талаас эдийн засгийн уг өөрчлөлтүүд нь эргээд улс төрийн өөрчлөлтийг өдөөж болно. Технологийн өөрчлөлт, худалдааны хөгжил, капиталын шинэ хэлбэрт хөрөнгө оруулах бизнес эрхлэгч анги бий болох зэрэг нь нийгэм, улс төрийн өөрчлөлт явагдах үүсгүүр болдог. Газрын шинэчлэл бол нөөцийн ашиглалт, хуваарилалтыг өөрчилснөөр хөдөөгийн баялгийн болон эрх мэдлийн тэнцвэрт байдлыг хэрхэн өөрчилж болдгийн жишээ юм. Бие биеэ харилцан нөхцөлдүүлсэн уг үйл явц нь хоёр чиглэлд ээлжлэн явагдаж байдаг. Гэхдээ хөгжиж буй олон оронд харилцан тохиролцсон, хэрэгжүүлэх боломжтой улс төрийн тоглоомын албан ёсны дүрэм нийтлэг биш юм. Оронд нь хоорондоо давхацсан эсвэл зөрчилдсөн олон дүрмүүдийн (албан ба албан бус) бүрдэл зэрэгцэн үйлчилдэг. Энэ нь "хэвийн" улс төрийг улам хэцүү, бараг боломжгүй болдог. Тохиролцсон дүрэмгүй (эсвэл дүрмүүд хоорондоо зөрчилдсөн), байнгын тодорхойгүй байдал, зарим ашиг сонирхлуудын хохирлоос болгоомжилсон айдас, зарим хэсэг нь цэргийн хүчийг хянадаг зэргээс үүдэн урьдчилан таамаглах боломжгүй байдал үүсэж хөгжлийн хөдөлгөгч хүч тогтвортой хадгалагдах боломж бүрддэггүй.

Ийм улс орнуудад хөгжлийн эвслүүд үүсэж, хөгжлийн сонголт, стратегиуд гарах тогтвортой нөхцөлийг бүрдүүлсэн харилцан тохиролцож, албажсан тоглоомын дүрэм байдаггүй. Үүнээс гадна гол бэрхшээл бол улс төр, эдийн засгийн засаглалын институциуд (эсвэл тэдгээрийн холимог) нь эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмждэггүй тодруулбал өсөлт нь ядуурлыг бууруулахад зориулагддаггүй явдал юм. Тиймээс хөгжлийн үйл ажиллагаанд улс төрийн тоглоомын харилцан зөвшөөрсөн, тууштай, уялдаатай институцийн дүрмүүдийн зэрэгцээ хөгжлийн улс төрийг хурдацтай бий болгож, тогтвортой хадгалах дүрмүүд мөн шаардагддаг. Улс орон бүр түүхэн өв уламжлал, нийгэм-эдийн засаг, улс төрийн бүтэц, соёлын хэв маяг, үзэл суртлын хэв

маягаараа ялгаатай байдаг. Тиймээс хөгжиж буй орнуудын улс төрийн тэдгээр ялгааг задлан шинжилж, харьцуулах замаар хөгжлийн баримжаатай тоглоомын дүрмүүдийг бий болгох эсвэл саатуулах нөлөөтэй албан болон албан бус эрх мэдлийн хэлбэрүүд, институциудийн харилцан үйлчлэл, хэв маягийг оношилж чадах хөгжлийн улс төрийн шинжилгээний арга зүйн ерөнхий хүрээ шаардлагатай болдог.

Улс төрийн шинжилгээний арга зүй

Хөгжлийн улс төрийн үзэл баримтлал, судлах асуудалтай холбоотойгоор улс төрийн шинжлэх ухааны голлох хандлагуудыг үнэлж, цаашид хэрэглэх арга зүйн хүрээг тодорхойлох шаардлагатай юм. Өдгөө хэрэглэгдэж байгаа улс төрийн шинжилгээний аргуудын дийлэнх нь тоглоомын дүрмүүдийг эхэлж тогтоод улмаар тэдгээр дүрмүүдийн хүрээнд өрнөж байгаа тоглолтуудад түлхүү анхаардаг. Харин тэдгээр тоглолтууд нь эргээд дүрмүүдээ өөрчилж болохыг анхаардаггүй. Тухайлбал Крик (2004:67) улс төрийг дүрмийн нэг хэлбэр болгон тодорхойлохдоо "...хүмүүс ялгаатай байдлыг шийдвэрлэх, олон янзын ашиг сонирхол, үнэт зүйлсийг нийцүүлэх, нийтлэг ашиг сонирхлыг хангасан төрийн бодлогууд гаргахын тулд институцичлагдсан журмуудаар хамтран ажиллах" хэмээн авч үзсэн нь үүний жишээ юм. *Олон ургалч* үзлүүд (Смит, 1995; Хэлд, 1996) мөн адил тогтсон дүрэм бүхий тогтвортой улс төрийн нийтлэгүүд дэх эрх мэдэл, нөлөөллийн хэлбэр, хэмжээгээрээ харилцан адилгүй олон янзын сонирхлын бүлгүүдийг төрийн бодлогод оролцуулахыг гол болгосон байдаг. Харин марксизм улс төрийн мөн чанарыг анги, ангийн зөрчлөөр авч үздэг тул (Каллиникос, 2004) капиталист ардчиллын улс төрийн дүрмүүд зөвхөн хувьсгалт үйлдлээр өөрчлөгдөж, солигдоно гэж үзсэн боловч ардчилал бэхэжсэн орнуудад парламентын улс төрийн тоглоомын дүрмүүдээр дамжин социалист өөрчлөлт ирж болохыг дурдсан (Милибанд, 1977). Энэ үзэл нь Марксизмаас үүсэж өндийн 19-р зууны сүүлчээс эсрэгцэх болсон ардчилсан социализмын гол цөм үндэслэл нь болдог (Гэй, 1962). Улс төрийн шинжлэх ухаан дахь рационал сонголт буюу "зах зээлийн бус шийдвэр гаргалтын эдийн засгийн судалгаа буюу эдийн засгийг улс төрийн шинжлэх ухаанд хэрэглэх" (Мюллер, 1979:1) нь өнөөгийн рационал сонголтын институцчилалд маш бат бөх шингэсэн байдаг (Уэйл, 2004). Хувь хүний зан төлөвт нарийвчлан төвлөрснөөр тухайн институцийн нөхцөл дэх рационал үйл ажиллагааг илрүүлж болдог ч институцийн дүрмүүд зөрчилдөж буй үеийн зан төлөв болон зонхилох дүрмүүд хэрхэн бий болох, өөрчлөгдөхийг шийдвэрлэдэг эрх мэдлийн бүтцүүд эсвэл улс төрийн динамикийн талаарх мэдээллийг бага өгдөг. Харин улс төрийн шинжлэх ухаан дахь түүхэн институцийн талынхан нь түүхэн өв уламжлал, эрх мэдлийн бүтэц болон шалтгаант хамааралд илүү мэдрэг ханддаг тул бүх институцийн зохицуулалтууд нь тодорхой нэг эсвэл хэд хэдэн талынхны ашиг сонирхлыг хадгалсан байдгийг дурддаг. Гэхдээ энэ хандлага нь улс төр, өөрчлөлтийн динамик, институцийн дүрмүүд хэрхэн бий болж, хэрэгжилт нь хангагддаг талаар хангалттай тайлбарладаггүй. Дээрхээс үзвэл улс төрийн шинжлэх ухааны голлох хандлагуудын үзэл баримтлал, тайлбарууд нь бүх нөхцөл байдалд бус зөвхөн хязгаарлагдмал тохиолдолд хүчинтэй байгааг анхаарах шаардлагатай юм.

Хөгжлийн үйл явцад аливаа шилдэг туршлага нь улс орнуудын улс төрийн нөхцөл байдлаас хамаарч ялгаатай үр дүн үзүүлдэг асуудалд улс төрийн ямар хүчин зүйлс хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох нь олон улсын байгууллагууд, тэдгээрийн судалгааны хүрээлэнгүүдийн тулгамдсан асуудал болсон. Эдгээрийн нэг болох Манчестерийн их сургуулийн дэргэдэх Үр нөлөөтэй төрүүд ба хүртээмжтэй хөгжлийн

төвөөс (ESID)⁴ хүртээмжтэй хөгжлийг хангахад "нөхцөл байдал", "чадавх", "эвслүүд" гэсэн гурван зүйлийг онцлоод арга зүйн ерөнхий хүрээг боловсруулсан нь хөгжлийн улс төрийн судалгаанд чухал ач холбогдолтой юм.

Нөхцөл байдал гэдэгт улс төрийн тоглоомын дүрэм болон эрх мэдлийн тэнцвэр хэрхэн зохион байгуулагдсаныг авч үздэг ба үүнийг Муштак Ханы (2005) боловсруулсан улс төрийн зохицлын санаанд тулгуурлан шинжилдэг. Уг арга нь улс төрийн зохицлын нэг хэлбэрийг нөгөөгөөс нь илүүд тавих зорилго агуулдаггүй. Харин ялгаатай зохицлууд нь хөгжлийн ялгаатай замналыг үүсгэдэг болохыг, мөн тэдгээр нь хөгжлийн ижил үр дүнд хүргэж буй асуудлыг хөнддөг. Ингэснээр улс орнуудын хөгжлийн ялгаа, явж буй замыг тайлбарлах боломжтой юм. Улс төрийн зохицлыг ноёлогч *болон өрсөлдөөнт гэсэн* хоёр нийтлэг хэв шинжид хуваах ба ноёлогч бүхий улс төрийн *зохицолд* засгийн газар хөгжлийн асуудалд илүү алсын хараатай ханддаг бол өрсөлдөөнт улс төрийн зохицолд богино зайны үйлдэл, шийдвэрүүд давамгайлах хандлагатай байдаг байна.

Аюулгүй байдал болон нийтийн бараа, үйлчилгээг нийт иргэдийн хэмжээнд хангуулах, эсвэл олон улсын хэмжээнд хэлэлцээр хийх бодит чадавхтай нийтийн эрх мэдлийн өөр хэлбэр байхгүй тул төр иргэдийнхээ сайн сайхныг хангах эцсийн хариуцлагыг хүлээдэг (ESID, 2020). Өнгөрсөн хугацаанд сайн засаглалын хөтөлбөр ёсоор хөгжлийн гол түлхүүр нь ардчилал, оновчтой институци байж ирсэн бол өдгөө төр эхлээд бодлогууд боловсруулж, хэрэгжүүлэх чадвартай байх ёстойг (Мигдал, 2001) чухалчлах болов. Тогтвортой хөгжлийн зорилгын 16-рт хөгжиж буй орнуудыг институцүүдээ *үр нөлөөтэй* төдийгүй хүртээмжтэй болгохыг даалгасан. Хүртээмжтэй хөгжлийг хангахад төрийн чадавх чухал ч энэ нь улсуудын хооронд болон улс доторх хэсгүүдэд, бодлогын салбаруудаар харилцан адилгүй байдаг. Үндэсний хэмжээнд ядуурлыг бууруулах, хөгжлийн өндөр түвшинд хүрэх нь төрийн чадавхтай шууд холбоотой юм. Тухайлбал, 2000-2015 онд Мянганы хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд төрийн чадавх өндөртэй орнууд ядуурлыг өндөр хувиар бууруулж, хөгжлийг хангахад илүү ахиц дэвшил гаргасан байна (Хюм нар, 2015).

Харин эвслүүд бол улс төрийн зохицол явагдах гол механизм юм. Ихэнх улс төрийн зохицлууд нь элитүүдийг нэгтгэж, нийгэмд тэгш сайжруулалт хийгдэх хөшүүргийг үүсгэж чаддаггүй. Энэ тохиолдолд төлөөлөгдөж чаддаггүй хэсгийнхэн нь үйл ажиллагаа, ахиц дэвшилд нь саад учруулж байгаа бүтцийн хориг саадтай тэмцэхээр эвссэн хувь хүмүүс болон бүлгүүдээр дамжуулж эерэг үр дүнд хүрдэг байна (Хики, 2020). Тэдгээр эвслүүд нь улс төрчид, төрийн албаныхан, бизнесийн удирдагчид, нийгмийн хөдөлгөөнүүд, шашны бүлгүүд, орон нутгийн эрх мэдэлтнүүд, оюунлаг хэсгийнхэн, олон улсын хандивлагчид зэрэг улс төрийн чухал оролцогчдын нэгдлээс бүрддэг. Бидний эргэн тойронд шинэ санаа болон дэвшилтэт бодлого, хууль тогтоомж санаачлах замаар тулгарсан бэрхшээлүүдийг давах гэсэн хамтын ажиллагаа, улс төрийн шинэчлэлийг дэмжсэн эвслүүд бидний эргэн тойронд үргэлж оршин байдаг. Тиймээс нийгмийн өөрчлөлт явагдахад эвслүүд хэрхэн хөдөлгөгч хүч болдгийг анхаарч үзэх шаардлагатай юм.

Английн судлаач Тим Келсалл (2020) улс төрийн зохицлын 4 төрлийг⁵ авч үзээд тэдгээрийн улс төрийн нөхцөл байдал, төрийн чадамж, эвсэл зэргийн онцлогийг тусгасан байна. Эдгээр нь:

⁴ ИБУИНВУ-ын Засгийн газрын Олон улсын хөгжлийн газрын санхүүжилтээр хөгжиж буй 26 улсын 80 гаруй эрдэмтдийг хамруулсан хөгжлийн улс төрийн тэргүүлэх судалгааны төв.

⁵ [What is political settlements analysis? - ESID \(effective-states.org\)](https://www.effective-states.org/what-is-political-settlements-analysis/)

ӨРГӨН - ТАРХМАЛ

Элитүүд өргөн хүрээг хамарсан ялангуяа нийгмийн хөгжилд ашиг тустай байхаар урамшуулагдсан хэдий ч үр ашигтай төрийн институцийг бий болгох, клиентелизм, популизмын эсрэг тэмцэх шаардлагатай болдог.

Тогтолцоог бүрэн хамарсан дээрээс доош чиглэлтэй арга барил нь бүтэлгүйтэх талтай тул шинэчлэл хийхэд үр дүнгээр урамшуулах, төрийн бус болон олон талт оролцогчдод тулгуурласан шийдлүүд зэрэгт анхаарах, мөн чухал асуудлууд дээр намуудын зөвшилцлийг хангах зэргээр эрх мэдэл тархмалаас үүдсэн дутууг нөхөх шаардлагатай.

ӨРГӨН - ТӨВЛӨРСӨН

Элитүүд хөгжлийг өргөн хүрээнд хангахад зорихын зэрэгцээ үүнийхээ дагуу шийдвэр гаргах, хэрэгжүүлэх чадвартай байдаг. Энэ тохиолдолд системийг хамарсан бодлого хөтөлбөрүүд амжилт олох магадлалтай. Тиймээс донорууд ч техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэхдээ таатай ханддаг. Шинэчлэгчид нь төлөөлөгдөөгүй, ашиг сонирхол нь тусгагдаагүй хэсэг байвал тэднийг хамруулах тал дээр ажилладаг.

ЯВЦУУ - ТАРХМАЛ

Элитүүд хөгжлийг өргөн хүрээнд хангахуйц хүртээмжтэй институцийг бий болгох хөшүүрэг дутмаг. Түүний оронд рент, нэмэлт орлогуудын төлөө хоорондоо өрсөлддөг. Хөгжлийн төлөөх шинэчлэгчид нийгэм дэх хүн ам ихтэй бүлгүүдийн улс төрийн дуу хоолой / зохион байгуулалтын хүчийг бэхжүүлэхэд хүчин чармайлт гаргах шаардлагатай болдог.

ЯВЦУУ - ТӨВЛӨРСӨН

Элитүүд хөгжлийг өргөн хүрээнд хангах институцийг бий болгох хөшүүрэг дутмаг байдаг тул махчин дүрэм тогтох хандлагатай. Гэхдээ "суурьшмал дээрэмчид" эсвэл үл ойшоогч удирдагчдын бүлгүүд нь зарим тохиолдолд хөгжлийн институцуудыг, ялангуяа эдийн засгийнхыг бий болгож болно. Энэ тохиолдолд шинэчлэлийг дэмжигч гаднын байгууллагууд засгийн газарт техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ нийгмийн хөгжлийн эдийн засгийн үр өгөөжийг тодруулан харуулж, нийгэмд сэргэлдэгч дуу хоолойг өдөөхгүй байхад анхаардаг.

Дүгнэлт

Хөгжлийн улс төрийн үзэл баримтлал, түүний арга зүй нь нэгэнт бодитоор бий болсон улс төрийн үйл явцуудыг танин мэдэх, шинжлэхэд анхаардаг ба улс төрийн болон өөрчлөлтийн янз бүрийн онолуудыг оновчтой байрлуулж, харьцуулсан болон түүхийн зохих судалгаатай нэгтгэж чадвал хөгжлийн өнгөрсөн, одоо, ирээдүйн замыг ангилах, хурдацтай өөрчлөлтийн нөхцөлд системтэй дүн шинжилгээ хийх боломжийг олгох юм.

Уг өгүүллээр тодорхойлсон гол үндэслэлүүдийг нэгтгэн дүгнэвэл:

Улс төр бол нөөцүүдийг ашиглах, бий болгох, хуваарилах шийдвэрүүдтэй холбоотой зөрчилдөөн, хэлэлцээр, хамтын ажиллагааны бүхий л үйл ажиллагаанаас бүрдэнэ. Улс төр нь үндсэн хоёр түвшинтэй. Эхнийх улс төрийн амьдралыг бүтээж, гол тулгуур нь болдог *тоглоомын дүрмүүдийг авч үздэг* бол хоёр дахь нь бодлого, эрх мэдлийн төлөөх "хэвийн" өрсөлдөөнийг буюу *дүрмийн дагуух тоглолтыг* авч үздэг. Улс төрийн тогтвортой байдал нь түүхэн, "уламжлалт" эсвэл орчин үеийн аль ч туршлагаас үзсэн "дүрмүүдээ" өндөр түвшинд зөвшилцөж, улс төрийн амьдрал нь

түүнийхээ дагуу хэвийн “тоглогддог” байдлаар тодорхойлогдож байна. Хөгжиж буй олон орнуудад тоглоомын үндсэн дүрэм нь сайн тогтоогүй байдаг. Тохиролцсон дүрэмгүйгээс ялагч бүгдийг авч ялагдагч хоосон хоцордог (эсвэл ийм айдастай) байдал нь тааварлашгүй байдлыг өдөөдөг. Улмаар бодлогын уялдаа, тууштай хэрэгжилт алдагдаж хөгжлийн эрч, үр дүнд сөргөөр нөлөөдөг. Гэтэл улс төрийн дүн шинжилгээ хийх ихэнх онол, арга зүйн хүрээ нь тоглоомын дүрмүүд нь хэдийнээ тогтож, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хөгжингүй улс төрийн нийтлэгүүдэд бий болж, тэдэнд зориулагдсан байдаг. Улмаар улс төрийн шинжилгээний уламжлалт арга зүйн дийлэнх нь хөгжиж буй орнуудын улс төрийн бодит нөхцөл байдал, нийгэм-эдийн засагтай оновчтой холбогддоггүй. Тухайлбал, хөгжиж буй орнуудын ихэнх шийдвэр нь албан бус улс төрийн үйл явцуудаар дамжин гардаг. Албан бус улс төрийн үйл ажиллагааны хэрэгцээ их байгаа нь тоглоомын дүрмүүдийн хүлээн зөвшөөрөгдөж буй эсэхийн үзүүлэлт болдог. Тиймээс хөгжлийн улс төрийн шинжилгээний арга зүйн хүрээ нь эрх мэдлийн албан болон албан бус эх сурвалжууд, хэлбэр, илэрхийлэлд мэдрэг, албан болон албан бус институцийн харилцан үйлчлэлүүдийг нэгтгэсэн, улс төрийн хоёр түвшнийг (тоглоомын дүрэм ба дүрмийн дагуух тоглолт) тайлбарлаж чадахуйц байхыг шаарддаг. Уг шаардлагад нийцүүлэн арга зүйн асуудалд хандах, нарийвчлан хөгжүүлэх боломжтой юм.

Abstract

This paper advances a view of politics which goes well beyond its conventional identification with a set of highly differentiated and largely formal activities, institutions and sites of government and the state. The approach adopted here stresses that politics is an essential and unavoidable process (or set of processes) in all human collectivities, formal and informal, public and private, concerned with decisions about the use, production and distribution of resources. This understanding of politics encourages to explore the interaction of both formal and informal institutions as well as formal and informal sources and forms of power, a situation which is much more typical of many developing countries. By widening focus in this way, and by recognizing the centrality of politics in all collective human activity, we are able to make more nuanced analyses of political processes not only at national levels but also at sub-national and local levels of the polity, across sectors such as education, agriculture or health, and in organizations such as firms, factories and colleges, where issues to do with the use and distribution of resources are always central. The first section starts by defining politics as two distinct but related levels: the rules of the political ‘game’ on the one hand, and the ‘games’ which occur within those rules. It concludes by arguing that because the politics of development is a special – and complicated - case of politics in general, it needs a framework of analysis which can help to identify the factors and forces which promote or hinder development and which enables us to trace the dynamics of the process involved.

Ашигласан материал

- Bräutigam, D. (1996) ‘Institutions, Economic Reform, and Democratic Consolidation in Mauritius’, *Comparative Politics*, 30(1), pp 45-62.
- Callinicos, A. (2004) ‘Marxism and Politics’ in Adrian Leftwich (ed) *What is Politics?* (Cambridge, Polity) pp 53-66.
- Crick, Bernard (2004) ‘Politics as a form of Rule’ in Adrian Leftwich (ed) *What is Politics? The Activity and Its Study* (Cambridge, Polity Press) pp.67-85.
- [David Hulme](#), [Antonio Savoia](#) and [Kunal Sen](#). 2014. “Governance as a global development goal? Setting, measuring and monitoring the Post-2015 Development Agenda”. ESID Working Paper No. 32
- Gay, Peter (1962) *The Dilemma of Democratic Socialism* (London, Collier Macmillan).
- Hall, P. and Soskice, D. (2001) *Varieties of Capitalism. The Institutional Foundations of Comparative Advantage* (Oxford University Press).
- Hickey, S. (2013). *Thinking about the politics of inclusive development: Towards a relational approach*.
- Hickey, S., Bukenya, B., & Sen, K. (2014). *The politics of inclusive development: Interrogating the evidence* (p. 416). Oxford University Press.
- Hulme, D.; Savoia, A.; Sen, K. Governance as a global development goal? Setting, measuring and monitoring the Post-2015 Development Agenda. Effective States and Inclusive Development Research Centre (ESID), University of Manchester, Manchester, UK (2014) 31 pp. [ESID Working Paper No. 32]

- Jütting, J., Corsi, E., Kauffmann, C., McDonnell, I., Osterrieder, H., Pinaud, N., & Wegner, L. (2005). What makes decentralisation in developing countries pro-poor?. *The European Journal of Development Research*, 17(4), 626-648.
- Joel S. Migdal., (2001) *State in society : studying how states and societies transform and constitute one another*, Location: Cambridge University Press
- John Williamson, 2012. What Washington Means by Policy Reform. <https://www.piie.com/commentary/speeches-papers/what-washington-means-policy-reform>
- Khan, Mushtaq (2005) 'Review of DFID's Governance Target Strategy Paper' (London, DFID) mimeo.
- Leftwich, A. (2006). *Drivers of change: refining the analytical framework*. York: Department of Politics, University of York.
- Linz, J.J. and Stepan, A. (1996) 'Toward Consolidated Democracies', *Journal of Democracy*, 7(2), pp 14-33.
- Miliband, Ralph (1977) *Marxism and Politics* (Oxford, Oxford University Press). Moore, Jr., Barrington (1966) *The Social Origins of Dictatorship and Democracy* (Boston, Beacon Press).
- Tim Kelsall, (2020). What is political settlements analysis? Available at: <https://www.effective-states.org/what-is-political-settlements-analysis/>
- Weale, Albert (2004) 'Politics as Collective Choice', in Adrian Leftwich (ed) *What is Politics? The Activity and Its Study* (Cambridge, Polity Press) pp 86- 99. 1979-1999 (Cambridge, Cambridge University Press).

**ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАСАГЛАЛЫН ТАЛААРХ ОНОЛЫН ХАНДЛАГА:
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИНСТИТУТ**

Я.Төгөлдөр

ШУТИС, Нийгмийн ухааны салбарын эрхлэгч, дэд профессор

Д.Бумдарь

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн профессор

Түлхүүр үг: ерөнхийлөгчийн засаглал, сонгодог ерөнхийлөгчийн засаглал, хагас ерөнхийлөгчийн засаглал, ерөнхийлөгчийн институт

Агуулга

- Хураангуй
- Ерөнхийлөгчийн засаглалын тухай онолын хандлага
- Монгол улсын ерөнхийлөгчийн институт

Хураангуй: “Ерөнхийлөгч” хэмээх нэр томъёо нь латин хэлний “prae” буюу өмнө, “sedereto sit” гэсэн үгнүүдээс бүтсэн praesidens “өмнө талд суух, тэргүүнд суух” хэмээх үгнээс гаралтай. Дундад зууны сүүл үеэс Англи хэлэнд president буюу ерөнхийлөгч хэмээх утгаараа хэрэглэгдэх болсон. Харин ерөнхийлөгчийн засаглалын тогтолцоо нь 1787 оны Америкийн үндсэн хуулиас эхтэй бөгөөд гүйцэтгэх засаглал болон төрийн тэргүүний хувьд “ерөнхийлөгч” гэсэн албан тушаалыг анх бий болгосон улс юм. Энэ үеэс ерөнхийлөгчийн засаглалын үзэл санаа дэлгэрч, 20-р зууны хоёрдугаар хагасаас хойш бусад улс орнуудад хэрэгжиж эхэлсэн.

Ерөнхийлөгч хэмээх улс төрийн албан тушаалын эрх мэдлийн цар хүрээ, бүрэн эрхийн хүрээ хязгаар, гүйцэтгэх засаглалд эзлэх байх суурь нь улс орнуудын улс төрийн тогтолцооноос хамааран харилцан адилгүй байдаг. Зарим улс ерөнхийлөгчдөө гүйцэтгэх эрх мэдлийг хуваарилан ерөнхийлөгчийн засаглалтай байх улс төрийн сонголтыг хийдэг бол зарим орон ерөнхийлөгчдөө бэлгэдлийн чиг үүрэг бүхий төрийн тэргүүний үүргийг хуваарилж парламентын засаглалтай байх сонголтууд практикт хэрэгжсээр ирсэн.

Монгол улсын хувьд төрийн тогтолцоонд “Ерөнхийлөгч” болон “Ерөнхийлөгчийн институт” хэмээх нэршил, практик хэрэгжилтийн хувьд бусад засаглалын субъектүүдийг бодвол харьцангуй шинэхэн, богино хугацааны хөгжлийн түүхтэй гэж үзэж болно.

Ийнхүү 1992 оноос хойших 30 жилийн хугацаанд парламентын засаглалтай Монгол улсын төрийн тогтолцоонд ерөнхийлөгчийн институт, төрийн тэргүүний статусын хязгаарлагдмал эрх мэдэлтэй эсэхийг судлах, гадны болон монголын судлаачдын хагас ерөнхийлөгчийн улс төрийн тогтолцоотой хэмээх дүгнэлтэд хүргэдэг үндэслэлүүдийг тодруулан авч үзэхийг зорьсон болно.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАСАГЛАЛЫН ТУХАЙ ОНОЛЫН ХАНДЛАГА

А. Сонгодог Ерөнхийлөгчийн тогтолцоо

Орчин үеийн ардчилсан засаглалтай улс төрийн тогтолцоонууд засаглалын эрх мэдлийг хуваарилсан байдлаараа хоёр хувилбараар хэрэгжиж байна. Нэг нь хууль тогтоох эрх мэдлийн байгууллагаас итгэл хүлээнээр хууль ёсны болж, ажиллах боломж нь хангагддаг гүйцэтгэх засаглал бүхий парламентын тогтолцоо, нөгөө нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийг байгууллагууд нь тусдаа, гүйцэтгэх засаглал нь бүрэн эрхийнхээ хугацаанд бие даан ажилладаг ерөнхийлөгчийн тогтолцоо юм. Дэлхийн цөөн хэдэн улсад уг хоёр тогтолцооны холимог хувилбар болох хагас ерөнхийлөгчийн тогтолцоо хэрэгжиж байна.

Аливаа улсын улс төрийн тогтолцоо нь 1.Эрх мэдлийг салгаж, хуваарилах; 2.Эрх мэдэл харилцан тэнцвэртэй байх; 3.Эрх мэдэл харилцан хяналттай байх зарчимд суурилдаг. Дээрх гурван зарчмаар төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч институтууд тус бүртээ тодорхой хуваарилагдсан эрх мэдэлтэй тул давхардахгүй, нэгнийхээ ажилд саад болохгүй, эрх мэдэл нь тэнцвэртэй тул аль нэг институтэд эрх мэдэл төвлөрөхгүй, харилцан хяналтын зарчмаар бие биеэ хариуцлагатай ажиллуулах боломжтой болдог.

Харин энэхүү төрийн эрх мэдэл хуваарилах онолыг улс орнууд харилцан адилгүй, хатуу болон зөөлөн гэсэн хоёр хувилбараар хэрэгжүүлдэг. Хатуу хувилбараар хууль тогтоох, гүйцэтгэх болох шүүх эрх мэдлийн институтууд салангид, ерөнхийлөгчийн тэргүүлэх гүйцэтгэх засаглалыг хэрэгжүүлэгч засгийн газар нь парламентаас хамаарал багатай ерөнхийлөгчийн тогтолцоо бий болно. Эс бол засгийн газрыг хууль тогтоох байгууллагаас томилсон ерөнхий сайд удирдан, рөнхийлөгч нь бэлэгдлийн чанартай (улс төрийн эрх мэдэл байхгүй) чиг үүрэг бүхий парламентын тогтолцоо бий болно.

Улмаар хүчтэй гүйцэтгэх засаглалтай ерөнхийлөгчийн тогтолцоо, эсвэл хүчтэй хууль тогтоох институцтэй парламентын тогтолцоо нь засаглалын сонгодог загварууд юм.

Ерөнхийлөгчийн засаглалтай орнууд:¹

Төв болон Өмнөд Америк (18): Аргентин, Боливи, Бразил, Чили, Колумб, Коста-Рика, Доминиканы Бүгд найрамдах улс, Эквадор, Сальвадор, Гватемал, Гондурас, Мексик, Никарагуа, Панам, Парагвай, Перу, Уругвай, Венесуэл

Африк (24): Ангол, Бенин, Бурунди, Камерун, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Чад, БН Ардчилсан Конго Улс, Габон, Гамби, Гана, Гвиней, Кени, Либери, Малави, Мозамбик, Нигер, Сьерра-Леоне, Сейшелийн арлууд, Судан, Өмнөд Судан, Танзани, Того, Замби, Зимбабве

Ази (5): Индонез, Мальдив, Филиппин, Палау, Өмнөд Солонгос

Төв ази (9): Афганистан, Иран, Беларусь, Кипр, Казахстан, Тажикистан, Туркменистан, Узбекистан, Йемен, Армени

¹ https://cs.mcgill.ca/~rwest/wikispeedia/wpcd/wp/l/List_of_countries_by_system_of_government.htm

Ерөнхийлөгчийн тогтолцоотой улс орны ерөнхийлөгч бүх ард түмнээс шууд сонгогддог бөгөөд бүрэн эрхийн хугацаа нь 4-6 жил байх, 4 жилийн хугацаатай сонгогдсон ерөнхийлөгч дахин нэг удаа сонгогдох онцлогтой байна. Ганц АНУ-ын ерөнхийлөгч бүх ард түмнээс шууд биш, харин сонгуулийн коллегияс сонгодог. ерөнхийлөгч нь гүйцэтгэх засаглалын тэргүүн, мөн төрийн тэргүүн байна. Бүрэн эрхийнхээ хугацаанд ерөнхийлөгч нь тогтвортой ажиллах боломжтой ч тодорхой нөхцөлд хууль тогтоох байгууллага импичментээр ерөнхийлөгчийг чөлөөлөх эрх зүйн боломж байгаа нь парламентын зүгээс ерөнхийлөгчид тавих хяналтын механизм юм.

Гүйцэтгэх засаглалын тэргүүний хувьд ерөнхийлөгч кабинетаа өөрөө томилох, чөлөөлөх бүрэн эрхтэйн дээр хууль санаачлах, томилох, санхүүгийн эрх мэдэл, гэрээ байгуулах, дайн зарлах эрх нь түүний үндсэн эрх болж баталгаажсан байдаг бөгөөд үүнд:

- *Хууль санаачлах эрх мэдэл:* хууль тогтоох эрх мэдлийн институттэй харилцаж ажиллах энэ зохицуулалт ихэнх улсад байдаг хэдий ч улс төрийн тогтолцооноос хамааран хууль санаачлах эрхийн цар хүрээ нь харин харилцан адилгүй байдаг.
- *Санхүүгийн эрх:* төсөвтэй холбоотой санал хураалтад мухардал үүсэх үед оролцох боломж, эсвэл зарим төрлийн төсвийн зарцуулалтад хориг тавих эрхээр илэрнэ.
- *Томилох эрх:* кабинетаа бүрдүүлэх, томилох эрхтэй. Зарим тохиолдолд хууль тогтоох байгууллагатай хамтрах зохицуулалт бий.
- *Гэрээ байгуулах эрх:* гэрээ байгуулах эрх өгдөг ч хууль тогтоох байгууллага соёрхон батлах зохицуулалт бий.
- *Дайн зарлах эрх:* ихэнх улсад хууль тогтоох байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр зарлах эрх хэрэгжих боломжтой.

Ерөнхийлөгчийн тогтолцоо нь өөрийн гэсэн давуу болон сул талуудтай. Судлаачид дараах дөрвөн давуу талыг онцолдог бөгөөд үүнд:

- *Хууль ёсны баталгаа.* Ард түмнээс шууд сонгогддог, бүх нийтийн саналаар гарч ирсэн гэдгээрээ маш өндөр түвшний хууль ёсны баталгаатай болдог.
- *Эрх мэдлийн хуваарилалт тодорхой байх.* Хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын зааг, харилцан хяналт тодорхой, ойлгомжтой байх давуу талтай гэж гэж үздэг байна. Парламентын засаглалд ялсан намын дарга ерөнхий сайд болох үед парламентын зүгээс гүйцэтгэх засаглалд хяналтад тавихад хүндрэлтэй болдог хэмээн тайлбарладаг.
- *Тогтвортой байх боломж.* Ерөнхийлөгч гүйцэтгэх засаглалыг тэргүүлж, сайд нараа өөрөө томилдог тул засгийн газар маш тогтвортой ажиллах нөхцөл бүрддэг. Мөн ерөнхийлөгчийн засаглалтай тогтолцоонд үндсэн хууль зөрчсөн тохиолдолд л ерөнхийлөгчийг огцруулах боломжтой ч ийм нөхцөл төдийлөн тохиолддоггүй.
- *Зохистой хариу үйлдэл.* Ерөнхийлөгчийн тогтолцоонд хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн харилцан хяналт илүү сайн хэрэгждэг гэж үздэг. Гэхдээ хууль тогтоох байгууллага ерөнхийлөгчийн санаачилсан гэрээ хэлэлцээрийг хүлээн авахгүй байх зохицуулалт хийгдсэн байдаг.

Б. Хагас ерөнхийлөгчийн тогтолцоо

Хагас ерөнхийлөгчийн засаглал хэмээх нэр томъёог судлаач М.Дюверже² хэрэглэсэн бөгөөд хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын харилцан хамааралд “хагас ерөнхийлөгчийн засаглалын” шинж оршиж байна хэмээн үзсэн байдаг. Хагас ерөнхийлөгчийн тогтолцоо бол “ард нийтээс сонгогдсон ерөнхийлөгч нь ерөнхий сайдтай хамтран гүйцэтгэх засаглалыг тэргүүлж, хууль тогтоох байгууллагаас итгэл үзүүлдэг³ тогтолцоо хэмээн судлаач Роберт Элжи тодорхойлжээ.

М.Дювержэгийн (Maurice Duverger) онолоор “хагас ерөнхийлөгчийн засаглал”⁴-ын шинж чанаруудыг дараах үндсэн гурван шалгуураар тодорхойлсон. Үүнд :

- Ерөнхийлөгчийг бүх нийтийн сонгуулиар сонгодог байх
- Үндсэн хуулиар олгогдсон хүчтэй эрх мэдэлтэй байх
- Парламентаас олгогдсон легитимт байдлын дагуу ерөнхийлөгч болон ерөнхий сайдын гүйцэтгэх засаглал дах эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэр хадгалагддаг. Гэхдээ парламентын зүгээс кабинетад хариуцлага тооцох асуудал үүсэхэд энэхүү тэнцвэртэй байдал алдагдана.

Гэвч засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх эрхийг давуу байдалтай ерөнхийлөгчид олгосон байх нь түгээмэл. Хоёрдмол байдлыг үүсгэх эрсдэлтэй хууль тогтоох эрх мэдэл хэрэгжүүлэгч байгууллага болон ерөнхийлөгчийн институтын эрх мэдлийн хязгаарыг хэрхэн тодорхойлж, үндсэн хуульд тусгасан байх нь асуудал дагуулдаг хэмээн судлаачид үздэг. Өөрөөр хэлбэл хагас ерөнхийлөгчийн засаглал нь ерөнхийлөгчийн болон парламентын засаглалын зарим шинжийг хослуулан үндсэн хуульд тусгаж өгснөөр хэрэгждэг байна. Тухайлбал:

- Засгийн газрыг байгуулах, огцруулах эрх
- Хууль тогтоох байгууллагыг тараах
- Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хязгаарлалт, огцруулах зэрэг юм.

Хагас ерөнхийлөгчийн засаглалыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд ерөнхийлөгч, ерөнхий сайд хоёрын эрх мэдлийг тэнцвэртэй хуваарилах шаардлагатай бөгөөд дараах эрх мэдлийг хамтран хэрэгжүүлэх нь хагас ерөнхийлөгчийн засаглалын амжилттай орших үндэс гэж судлаачид үзжээ. Үүнд:

- Дотоод, гадаад бодлого
- Тогтоол гаргах эрх мэдэл
- Томилох эрх мэдэл: төрийн болон улстөрийн албан тушаалтан
- Засгийн газрыг байгуулах эрх мэдэл
- Хориг тавих эрх⁵

Засгийн газар байгуулах, огцруулах эрх: Ерөнхий сайдыг томилох гурван хувилбар байдаг бөгөөд үүнд:

- Ерөнхийлөгч ерөнхий сайдыг томилох бүрэн эрхтэй байх

² Maurice Duverger, “A New Political System Model: Semi-Presidential Government.” *European Journal of Political Research* 8 (1980), pp. 165-87; see also Shugart and Carey, *Presidents and Assembly* and Elgie, *Semi-Presidentialism in Europe*.

³ Robert Elgie (2003). *Semi-presidentialism in Europe*. Oxford., p. 13.

⁴ Horst Bahro, Bernhard H. Bayerlein & Ernst Veser. Duverger’s concept: Semi-presidential government revisited. *European Journal of Political Research* 34: 201p, 1998

⁵ <https://www.constitutionaltransitions.org/wp-content/uploads/2017/05/Semi-Presidential-Government-in-the-Post-Authoritarian-Context.pdf>

- Ерөнхийлөгч томилж, парламент батламжлах
- Парламент томилж, ерөнхийлөгч ёсчлох хувилбаруудыг багтаасан

Ерөнхийлөгч засгийн газрыг байгуулах хувилбараар бол мөрийн хөтөлбөр ойролцоо нэгнийг сонгох, эсвэл улс төрийн зөвшилцөл хийх хэрэгцээ гарна. Учир нь засгийн газрыг огцруулах үл итгэх эрх хууль тогтоох байгууллагад байдаг учир эрх баригчдыг сонгох буюу эрх баригчдын санал болгосон гишүүдийг оруулах нь түгээмэл байна. Ерөнхийлөгч томилж, парламент батламжлах нь хяналт, тэнцвэрийг хангахад илүү нийцтэй хувилбарт тооцогддог. Учир нь ерөнхийлөгчийн эрх ашгаас өөр эрх ашгийг засгийн газар хэрэгжүүлэх, нөгөө талаас ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарлах, хянах сайн талтай гэж үздэг.

Хагас ерөнхийлөгчийн засаглалын тогтолцоонд засгийн газрыг огцруулах механизм нь дараах гурван шалтгаантай байна. Үүнд:

1. Засгийн газар ажиллаж чадахгүй тохиолдолд
2. Засгийн газар ерөнхийлөгчид хяналт тавьж чадахаа больсон тохиолдолд
3. Ерөнхийлөгч хамтарч ажиллаж чадахгүй болсон тохиолдолд огцрох зохицуулалт хийж өгдөг.

Засгийн газрыг огцруулах институци нь хууль тогтоох байгууллагаас уу, Ерөнхийлөгчийн институтын зүгээс гэдгээрээ мөн ангилагддаг. Тодруулбал:

- Ерөнхийлөгч, хууль тогтоох байгууллага хамтарч засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулна. Энэ тохиолдолд ерөнхийлөгч, парламент хоёрын хамтран байгуулсан засгийн газар байна.
- Зөвхөн хууль тогтоох байгууллага засгийн газрыг огцруулна. Ерөнхий сайд, ерөнхийлөгчийн байгуулсан кабинет ⁶ байна.

Хагас ерөнхийлөгчийн тогтолцоотой байх нь ардчиллын хямралыг арав дахин илүү авчирдаг хэмээн судлаач Элжи үзсэн байдаг. Учир нь ерөнхийлөгчид парламентыг татан буулгах эрх үндсэн хуулиар олгогддог бөгөөд засгийн газарт итгэл үзүүлэхгүй байдал удаа дараа давтагдах юм бол энэхүү эрх нь нээгддэг. Учир нь засгийн газрын кабинетын гишүүдийн томилох, санал болгох боломж ерөнхийлөгчид олгогдсон байвал парламентыг тарааж дахин сонгууль зарладаг. Гэвч энэ нь засаглалыг хямралд авчирах аюултай тул үндсэн хуульд дараах механизмыг суулгаж өгсөн байдаг.

- Ерөнхийлөгч хууль тогтоох байгууллагыг тараах үндэслэл нь төсвөө батлуулж чадахгүй байх. Эсвэл 2 удаа засгийн газарт итгэл үзүүлээгүй байх.
- Ерөнхийлөгч өөрийн эрх мэдлээ хууль бусаар нэмэгдүүлэхийн тулд онц байдлын үе, дайны үеийг ашиглан хууль тогтоох байгууллагыг тараах. Эсвэл хууль тогтоох байгууллага ерөнхийлөгчид импичмент тооцож эхлэх үед болон шинэ сонгуулийн дараа тараах. Эдгээр тохиолдолд үндсэн хуульд хязгаар тавьж өгдөг. Дээрх нөхцөл үүссэн үед тараах эрхийг олгохгүй механизм үйлчилдэг.
- Тараах давтамжийг холдуулах, процедурын зохицуулалт хийж өгөх зэргээр эрх мэдлийн хязгаарлалт хийж өгдөг.

Ерөнхийлөгч нь засаглалын хяналт-тэнцэлийн тогтолцоонд бие даасан субъект байх уу, эсвэл хамтран оролцогч байх уу гэсэн асуултад тухайн улс орон хэрхэн хариулж байгаагаас хамааран ерөнхийлөгчийн бүрэн эрх, чиг үүргийн хүрээ тодорхойлогдож, улс төрийн тогтолцоондоо эрх мэдлийн хуваарилалт болж, үндсэн хуульд тусдаг. Хагас ерөнхийлөгчийн засаглалын хамгийн чухал асуудал бол гүйцэтгэх

⁶ <https://www.constitutionaltransitions.org/wp-content/uploads/2017/05/Semi-Presidential-Government-in-the-Post-Authoritarian-Context.pdf>

эрх мэдлийг засаглалын субъектүүд хооронд хэрхэн хуваарилж, үндсэн хуульдаа яаж томьёолж тусгах тухай асуулт юм.

Манай улс парламентын засаглалтай ч ерөнхийлөгч нь гүйцэтгэх засаглалд оролцох эрхтэй байгаа нь хагас ерөнхийлөгчийн тогтолцоонд багтаах үндэслэл болж байгааг дараагийн хэсэгт тусгайлан авч үзье. Учир нь манай улсыг тодорхой шалгуураар судлан үзээд хагас ерөнхийлөгчийн засаглалтай 23⁷ улсын нэг нь Монгол Улс юм гэсэн импакт бүхий судалгааны үр дүн гаргасан бүтээл байдаг.⁸

Хагас ерөнхийлөгчийн засаглалтай улс орнууд гүйцэтгэх эрх мэдлээ хэрхэн хуваарилж байгаад үндэслэн засаглалд Ерөнхийлөгчийн оролцооны гурван загварыг гаргасан байдаг. Эдгээр нь:

1. **Төлөөлүүлэх загвар** (the principal-agent model):

Ерөнхийлөгчийн зүгээс бодлого боловсруулахад хяналт тавьж, засгийн газар нь түүний төлөөлөгчийн үүргийг гүйцэтгэн, бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хариулсна. Уг загвараар ерөнхийлөгч санаачлан засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээр огцруулах эрхтэй тул ерөнхийлөгчийн авторитар тогтолцоог бий болгох эрсдэл агуулдаг сул талтай. Энэ нь ерөнхийлөгч - хууль тогтоох байгууллагатай хамтран засгийн газрыг байгуулдаг тогтолцоонд түгээмэл ажиглагддаг эрх мэдлийн хуваарилалт юм. (Жишээ: ОХУ)

2. **Бэлэгдлийн загвар** (the figure head-principal model):

Бэлэгдлийн чиг үүрэг бүхий ерөнхийлөгч нь гүйцэтгэх эрх мэдэлд оролцохгүй, ёслолын чиг үүрэг гүйцэтгэх бөгөөд гүйцэтгэх эрх мэдэл нь ерөнхий сайд, түүний кабинетад төвлөрнө. (Жишээ: Финлянд, Ирланд улс)

3. **Арбитр, менежерийн загвар** (the arbiter-manager model).⁹

Ерөнхий сайд нь гүйцэтгэх засаглалын топ менежерийн чиг үүргийг гүйцэтгэж, засгийн газраа удирдаж ажиллана. Ерөнхийлөгч нь засгийн газрын үйл ажиллагаа, ерөнхий сайдад буюу гүйцэтгэх эрх мэдэлд хамаарах хууль, тогтоомжид хяналт тавина. Зарим улсад ерөнхийлөгч нь хууль тогтоох эрх мэдэлд хамааруулж болох хуульд хориг тавих эрх мэдэл хэрэгжүүлж байгаа нь нэмэлтээр арбитрын чиг үүрэг хэрэгжүүлж байна гэж үздэг. (Жишээ: Франц улс)

Ерөнхийлөгчийн институтын дээрх загварт үндэслэн, Монгол улсын ерөнхийлөгч бэлэгдлийн болон арбитр, менежерийн загварын шинжийг агуулсан гэж дүгнэж үзэх боломжтой байна.

Манай улс үндсэн хуульдаа парламентын засаглалтай улс гэж тунхагласан хэдий ч эрх мэдлийн хуваарилалт, тогтолцооны хувьд ерөнхийлөгчийн институтын

⁷ https://www.cs.mcgill.ca/~rwest/wikispeedia/wpcd/wp/l/List_of_countries_by_system_of_government.htm

⁸ Bahro, H. (1997a). *Semipresidentialism in post-communist states? On the dissemination of a form of government between parliamentarism and presidentialism* (Osteuropa-Recht 43: 1–18) бүтээлд Германы улс төр судлаач Horst Bahro, Ernst Veser нар тодорхой шалгуурын дагуу судлахад хуучин Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд багтаж байсан орнууд, мөн Монгол, Польш, Румын, Болгар, Словени, Хорват, Серби, Македон зэрэг посткоммунист орны дийлэнх нь хагас ерөнхийлөгчийн засаглал гэсэн ангилалд багтаж байна гэсэн сонирхолтой ажиглалт хийжээ.

⁹ <https://www.constitutionaltransitions.org/wp-content/uploads/2017/05/Semi-Presidential-Government-in-the-Post-Authoritarian-Context.pdf>

байр суурь засаглалд оролцох байдал нь хагас ерөнхийлөгчийн засаглалын шинжийг агуулж байгаа юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИНСТИТУТ

Б.Даш-Ёндон судлаачийн 1999 оны “Төрийн тэргүүн бол ерөнхийлөгч” бүтээлд төрийн тамгыг ерөнхийлөгч барина гэсэн заалтыг үндэс болгон төрийн тэргүүн бол байгууллага /институт биш, харин албан тушаалтан”¹⁰ гэж тайлбарласан байна.

Харин ихэнх судлаачдын бүтээлд ерөнхийлөгчийг тодорхой эрх мэдэлтэй бие хүн гэхээс илүүтэйгээр улс төрийн тогтолцоонд тодорхой чиг үүрэгтэй оролцогч засаглалын институт гэдгийг хүлээн зөвшөөрөх хандлага нийтлэг байна. Жишээлбэл, судлаач Д.Болд-Эрдэнэ “төрийн тэргүүн нь ард түмнээс сонгогдог, тэдний нийтлэг эрх ашиг, сонирхлыг илэрхийлдэг гэдэг талаасаа тодорхой албан тушаалтан мөн боловч засаглалыг хэрэгжүүлэхэд оролцоо, эрх мэдлийн хуваарилалтад гүйцэтгэж байгаа үүрэг, нөлөөллийн хувьд түүнийг засаглалын нэгэн онцгой субъект, институт гэж үзэхээс аргагүй”¹¹ гэсэн үндэслэл дэвшүүлжээ.

Монгол улсын анхны ерөнхийлөгч П.Очирбат нь ерөнхийлөгчийн институт гэсэн үндсэн хуулийн нэр томъёо, ойлголт байхгүй ч ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх гэсэн утгаар институт хэмээх ойлголтыг хэрэглэж заншсан тухай тайлбарлажээ.¹²

Л.Хангай “Монгол улсын ерөнхийлөгч бол засаглалын эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл явцад хуулиар олгогдсон тодорхой эрх үүрэгтэй оролцон нөлөөлөгч засаглалын онцгой субъект, байгууллага/ институт юм гэж үзэх бүрэн үндэслэл байна”¹³ гэж үзсэн бол академич Ж.Амарсанаа “ерөнхийлөгч бол улс төр, хууль зүйн талаасаа нэг хүн биш, төрийн бүхэл бүтэн институц юм” хэмээн онцолжээ.

Хуульч Б.Чимэд “ерөнхийлөгчийн байгууллага/ институт гэдэг үгийг хамтад нь хэрэглэж, төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч засаглалын нэг өвөрмөц байгууллага/ институт”¹⁴ хэмээн үзэж байсан нь түүний бүтээлүүдээс тодорхой харагддаг.

Эдгээрээс дүгнэхэд, Монгол улсын ерөнхийлөгч нь үндсэн хуулиар төрийн тодорхой эрх мэдэл хуваарилагдсан, улс төрийн тогтолцоонд тодорхой орон зай эзэлсэн институт болох нь тодорхой байна.

Харин ерөнхийлөгчийн институтийн өөрийн гэсэн онцлогийг бий болгож буй хоёр шинж чанар байна.

Нэгдүгээрт, Монгол улсын ерөнхийлөгч нь ганц бие хүнээр илэрхийлэгдэх хэдий ч засаглал дахь оролцооны хувьд дан ганц хувь улс төрчийн үүднээс биш, институтийн хүрээнд ажилладаг бусад улс орны ерөнхийлөгч нарын нийтлэг шинж агуулагдаж байна. Энэ нь Монгол улсын ерөнхийлөгч, ерөнхийлөгчийн тамгын газар, түүний бүтэц, зохион байгуулалтаас харж болно.

¹⁰ Монгол улсын үндсэн хуулийн үзэл баримтлалын асуудал. (1999).Товхимол 1. УБ., 92 дахь тал

¹¹ Философи, эрх зүйн судлал. 26 дугаар боть.(2011). УБ., 167 дахь тал.


¹² Ерөнхийлөгчийн институтийг боловсронгуй болгох нь. Онол парктикийн хурал.(2003). УБ., 99 дахь тал

¹³ Ерөнхийлөгчийн институтийг боловсронгуй болгох нь. Онол парктикийн хурал.(2003). УБ., 101 дэх тал

¹⁴ Мөн тэнд

Бүдүүвч 1.

Ерөнхийлөгчийн тамгын газрын бүтэц, зохион байгуулалт



Эх сурвалж: Монгол улсын ерөнхийлөгчийн 2013 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 11 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралт

Мөн Монгол улсын ерөнхийлөгч нь гүйцэтгэх эрх мэдэл хэрэгжүүлэгч субьектэд орох ба улс орноо гадаадад төлөөлөл, улсын дээд цол, одонгоор шагнах зэрэг бэлгэдлийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нь хагас ерөнхийлөгчийн тогтолцооны хэв шинжийг илэрхийлж байгаа юм.

Хоёрдугаарт, ерөнхийлөгчийн тухай хуулийн заалтаар “Ерөнхийлөгч төрийн тэргүүний хувьд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах ашиг сонирхлын үүднээс **хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг** байгууллагуудад зүй зохистой харилцан ажиллахад нь Үндсэн хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дэмжлэг нөлөө үзүүлнэ” хэмээн зааснаар түүнийг төрийн засаглалын аль ч байгууллагад хамааралтай, адил тэгш хамтран ажиллах эрх, оролцоотой байхаар заасан агуулга харагдаж байна.

Харин судлаачдын дүгнэлтээс үзэхэд Монгол улсын төрийн тогтолцоонд ерөнхийлөгчийн байр суурь, эрх үүргийг хэрэгжилт талаас нь шүүх эрх мэдэл, гүйцэтгэх засаглалд илүү ойр институт гэж үзэх үндэслэлүүд багагүй байна. Тухайлбал, ерөнхийлөгчийн хууль санаачлах эрх мэдэл, бүх ард түмнээс сонгогдог зарчим, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний эрх мэдэл, цар хүрээ зэрэг үндэслэлүүд нь сонгодог парламентын засаглалтай улс төрийн тогтолцооноос гажуудсан, улмаар хагас ерөнхийлөгчийн ангилалд хамаарах шинжүүд илэрч байгааг дурдах хэрэгтэй.

Улмаар ерөнхийлөгчийн үндсэн хуульд заасан үндсэн бүрэн эрх нь тооны хувьд цөөн, хязгаартай мэт боловч агуулгын хувьд өргөн хүрээгээр ерөнхийлсөн заалтууд орсон. Энэ нь Монгол улсын төрийн эрх барих дээд байгууллагаас гарах бүх шийдвэрт ерөнхийлөгч шууд болон шууд бусаар харилцах эрх нээлттэй байгааг илэрхийлж байгаа юм. Энэ үндэслэлээр МУ-ын Ерөнхийлөгчийн төрийн тогтолцоонд эзлэх байр суурь нь нэлээд өргөн хүрээний оролцоотой, Монгол Улсын эрх ашгийн төлөө

ажиллаж чадвал улс төрийн хүчнүүдийн эв нэгдэл, зөвшилцөл, уялдаа холбоотой төрийн бодлогын хэрэгжилтийг хангахад нөлөө бүхий институт болох дүгнэлтийг хийж болмоор байна.

Abstract

This paper outlines Mongolian political system focusing on the 2019 constitutional amendments that turned away from the Semi-Presidential system in Mongolia. Constitutionally, Mongolia's cabinet was to be formed by the Parliament upon its election, and was dependent on parliamentary support for its survival. But the constitutional amendments made in 2000, basically, weakened the presidential "filtering" of the prime ministerial nominee. Prior to 2000, due to this filtering power, the Parliament was unable to exercise its authority to form the cabinet without the president's prior approval. In short, we had a semi-presidential regime.

This research article shows how this situation was rectified as a whole through the constitutional amendments made in 2019.

Ашигласан эх сурвалж

Монгол Улсын Үндсэн хууль. 1992

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль. 1993

Үндэсний Аюулгүй Байдлын тухай хууль. 2001

Удирдлагын Академийн судалгааны тайлан. Монгол Улсын төрийн тогтолцоон дахь Ерөнхийлөгчийн байр суурь: бүрэн эрхийн шинжилгээ. 2019.

Хууль зүйн хүрээлэнгийн судалгааны тайлан. Монгол Улсын Үнсэн хууль дахь Ерөнхийлөгчийн институтын зарим томъёо. 2019

Л.Лүндээжанцан, Ч.Энхбаатар, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй. Улаанбаатар 2000

Монгол улсын үндсэн хуулийн үзэл баримтлалын асуудал. 1999.Товхимол 1.

Н.Лүндэндорж. "Төр эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага". 2002

Maurice Duverger, "A New Political System Model: Semi-Presidential Government." European Journal of Political Research 8 (1980), pp, 165-87; see also Shugart and Carey, Presidents and Assembly and Elgie, Semi-Presidentialism in Europe.

Linz, Juan J. 1994. Presidential or parliamentary democracy: Does it make a difference? In The failure of presidential democracy: Comparative perspective, edited by Juan J. Linz and Arturo Velenzuela, 3-87. Baltimore: John Hopkins University Press.

Robert Elgie (2003). Semi-presidentialism in Europe. Oxford.

Riggs, FW, 'Presidentialism vs Parliamentarism: Implications for Representativeness and Legitimacy' (1997) 18.3 International Political Science Review 253

Blondel, J, The Presidential Republic (Palgrave-MacMillan 2015)

<https://www.constitutionaltransitions.org/wp-content/uploads/2017/05/Semi-Presidential-Government-in-the-Post-Authoritarian-Context.pdf>

<https://www.constitutionaltransitions.org/wp-content/uploads/2017/05/Semi-Presidential-Government-in-the-Post-Authoritarian-Context.pdf>

[https://www.cs.mcgill.ca/~rwest/wikispeedia/wpcd/wp/l/List of countries by system of government.htm](https://www.cs.mcgill.ca/~rwest/wikispeedia/wpcd/wp/l/List_of_countries_by_system_of_government.htm)

<https://www.constitutionaltransitions.org/wp-content/uploads/2017/05/Semi-Presidential-Government-in-the-Post-Authoritarian-Context.pdf>

[https://dept.sophia.ac.jp/g/gs/wp-content/uploads/2020/08/Masako Shimizu.pdf](https://dept.sophia.ac.jp/g/gs/wp-content/uploads/2020/08/Masako_Shimizu.pdf)

ҮНДЭСНИЙ ӨӨРИЙН УХАМСРЫН ТӨЛӨВШИЛТӨНД УЛС ТӨРИЙН УХАМСРЫН НӨЛӨӨ

М.Мөнхзул

ХААИС, ЭЗБС, ХААХЭЗТ, дэд профессор

Г.Уянга

ХААИС, ЭЗБС, ХААХЭЗТ, ахлах багш

Хураангуй: Үндэсний ухамсрыг үндэсний өөрийн ухамсартай харьцуулбал үндэсний ухамсар нь тухайн хүнийг нийгэм, улс төрийн түүх, улс төрийн хамтын нийгэмлэг буюу нийгмийн ой санамжийн түвшинд холбох явдал юм. Харин үндэсний өөрийн ухамсар нь нийгэмлэгүүдтэй холбох механик холбоо биш, харин түүнийг хүлээн зөвшөөрдөг ухамсартай хэлбэр юм. Үүнийг үндэстний өмнө хүлээсэн үүрэг хариуцлага гэж үзнэ.

Түлхүүр үг: *Үндэсний өөрийн ухамсар, улс төрийн ухамсар, үндэстэн, угсаатан*

Үндэсний өөрийн ухамсар, улс төрийн ухамсрын харилцан хамаарлын асуудал, мөн зааг ялгааны тухай хэлэлцэх нь маш чухал. Улс төрийн ухамсар ба үндэсний өөрийн ухамсрын гол ялгаа нь соёл ухамсрын асуудалтай холбоотой. Үүнээс үүдэн соёл нь төр үүсэхээс өмнө байсан уу? эсвэл хожим үүссэн үү? гэдэг асуулт гарна. Үндэстний хувьд “иргэний улс төрийн” (өрнөдийн), “угсаатны соёл” (дорнын) хоёр янзын загварыг өөр хооронд нь сөргүүлэн тавих явдлыг онолын болон түүхийн харьцуулан судлах судалгаанд олонтаа шүүмжилж авч үзсэн байдаг. Тиймээс ч аливаа иргэний, улс төрийн, үндэсний өөрийн ухамсрын гол шинж нь “угсаатны”, “хэл шинжлэлийн” шинж төлөв байдаг¹ гэсэн инструменталь хандлага байдаг.

“Үндэсний ухамсар бол тухайн үндэстний хүн нэг бүрийн сэтгэлийг хөндөж чаддаг чавхдас утас мөн билээ. Чингис хаан өөрөө ч гэсэн нийт Монголчуудын үндэсний ухамсрын цөм нь болж байсан бөгөөд одоо ч тийм байна”². Н.Бердяевийн хэлснээр “орос улс түүхэн цаг хугацаандаа цуглуулсан олон үндэстний бөгөөд олон шашинт соёлын ачаа тээшээс хамааран дотоод үндэсний соёлыг ойлгох байдал нь харилцан адилгүй байсан”³ гэжээ. Аливаа улсын соёлын мөн чанар нь үзэл санааны орчин тойрны хил дээр оршдог гэж үзэж болно. “Үндэсний өөрийн ухамсрын судалгаа нь гол төлөв тухайн улсын түүхийн баримт нотолгоон дээр суурилан хийгддэг байна”⁴. Өөрөөр хэлбэл, үндэсний өөрийн ухамсар гэдэг ойлголттой холбоотой асуудлууд нь нарийн төвөгтэй учраас түүхийн баримт чухал. Үндэсний өөрийн ухамсрыг судлахдаа улс үндэстнийхээ түүхэн туршлагыг авч үзэх нь зүйтэй юм. “Түүхэн ухамсар нь улс төрийн соёлын нэг хэсэг нь мэт харагдах боловч илүү нарийвчлан авч үзэхэд түүхэн ухамсар нь улс төрийн ухамсрын зүгээр нэг

¹ Smith.A. *Nationalism and modernism*. New-York.,2013. P 276

² Цэнд-Аюуш.Г. *Улс төрийн ухамсар:түүхэн судалгаа*. УБ.,2012. 9 дэх тал

³ Андерсон.Б. *Нация и национализм*. М.,2003. Стр 65

⁴ Бахтин.М.М. *Творчество Франсуа Раблеи народная курьтура средневековья и Ренессанса*. М.,1965. Стр 7

бүрэлдэхүүн байгаад зогсохгүй соёлын өв уламжлалын бүхий л өгөгдлүүдийг нэгд нэгэнгүй хөндөж тэдгээрийн төрөлх шинж чанаруудыг тодорхойлж байдаг”⁵ байна.

Улс төрийн тогтворгүй байдал нь үндэсний өөрийн ухамсрын төлөвшилтөнд сөрөг нөлөөтэй байдаг байна. Үндэсний өөрийн ухамсрыг өргөн цар хүрээнд авч үзвэл энэ нь нийгэм, улс төрийн шинэ үзэл санааг тодорхойлох хэрэгцээ шаардлагатай холбоотой юм. Нийгэмд улс төрийн ухамсрыг шинээр тодорхойлох явцад тулгардаг нийтлэг асуудал нь нэгдүгээрт, 1980-аад оны сүүлээс өнөөдрийг хүртэл үргэлжилж буй нийгэм, улс төрийн үзэл санааны зөрчилдөөнт байдал, хоёрдугаарт, улс төрийн уламжлалт үзэл суртал ба үзэл санааны хувьд дэлхийн цар хүрээнд эрчимжиж буй өрнөдийн либерализм хоёрын хоорондох эсрэгцэл юм. Ийм байдал улс төрийн ухамсрын цогц ойлголтыг тогтооход төвөгтэй учраас түүхэн, улс төрийн өнцгөөс асуудлыг нарийвчлан судлах шаардлагатай.

Мөн үндэсний өөрийн ухамсрын эрт, эдүгээгийн түүхэн хэлбэрийн дийлэнх олонхи нь ерөөс үндэсний давуу тал, үндэсний онцгой чанарын үзэл санаатай холбогдож байгаагүй билээ. (Энэ чанар нь цөөн тохиолдолд буюу фашизм болон арьс өнгөөр ялгаварлах үзэлтэй холбоотойгоор илэрч байсан). Дурдаж буй энэ хэсэгт фашизмыг сэргээхтэй холбоотой зүйл огтхон ч үгүй билээ. Харин гол зорилго бол улс төрийн намууд үндэсний эрх ашгаа чиг баримжаа болгосон үзэл баримтлалыг төрийн бодлогын түвшинд тодорхойлох хэрэгтэй. Төрийн ашиг сонирхол нь үндэсний эсвэл эх оронч мэдрэмжийг ашигладаг. Учир нь хүний зорилго нь чиглэлтэй, тэр нь юуны өмнө улс төр ба төр улс лугаа холбогдсон үйл ажиллагааны үндэс нь ашиг сонирхол байдаг. “Ашиг сонирхлыг бодит байдал болгож хувиргахын тулд зохих арга хэрэгслээр бэхжүүлсэн хүний хүсэл зориг ба үйл ажиллагаанд холбогдсон байх ёстой”⁶. Гагцхүү хүсэл зориг, үйл ажиллагаа, арга хэрэгслийн ачаар л ашиг сонирхол практик дээр хэрэгжинэ.

Улс үндэстнээ гэх үзэл нь “ард түмний зохион байгуулалтын шилдэг хэлбэр, бүтээлч соёлын эрчим ба эдийн засгийн сайн сайхан байдлын эх булаг гэж үндэсний төр улсыг хүлээн зөвшөөрдөг ямар нэг ард түмний дийлэнх олонхийн оюун санааны байдал, ухамсрын үйл”⁷-д үндэслэж байдаг ажээ. Мөн үндэсний өөрийн ухамсрыг төлөвшүүлэхэд болон үндэсний мэдрэмжийг сэргээх ба дайчлахад өнгөрсөн ба өнөө үед шашин чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн билээ. Тухайлбал, “исламын шашин нь улс төрийн бодлогыг өөрийн зорилгод ашиглаж, эсвэл түүнд хэрэгсэл болгон ашиглагдаж Ойрхи болон Дундад дорнодод, эдүгээ Дундад ази, Азербайжан болон бусад бүс нутагт үндэсний төр улсаа тогтоон бэхжүүлэх нэгдмэл зорилгоо бэхжүүлэхээр зүтгэж байна”⁸.

“Үндэсний өөрийн ухамсар нь улс төрийн ухамсартай салшгүй холбогдон тухайн үндэстний түүхэн хөгжлийн цаг хугацааг дамжин оршдог”⁹. Тиймээс төрийн үзэл нь тодорхой нэгэн түүхийн үйл явцад үндэсний өөрийн ухамсрыг нь тусгадаг учраас түүхэнд маш чухал үүрэгтэй байсан байна. Улс төрийн ухамсрын үүрэг нь үндэсний төр улсын адилсалын суурь нь болж үндэсний-түүхийн оршихуйн залгамж холбоог таслахгүй байхад оршино. Тиймээс тэрхүү ухамсар нь тухайн түүхийн

⁵ Астафьева.О.Н. Многообразие моделей этнокультурной идентичности в современном информационно-коммуникативном пространстве. Глобализация и перспективы современной цивилизации. М.,2005. Стр 123

⁶ Peirce.C. The fixation of belief. Cambridge.,1877. P42

⁷ Hans.K. The idea of nationalism. New-York.,2005. P13

⁸ Поздняков.Э.А. Улс төрийн философи. УБ.,2005. 297 дахь тал

⁹ Шмаков.В. Закон синархий. Киев.,1994. Стр 34

нөхцөл байдалд үндэстний сүр сүлд болдог. Үндэсний өөрийн ухамсар бол аль нэгэн үндэсний эрх ашгийг илэрхийлэгч төр улс, нам болон улс төрийн бусад холбоодын үзэл санаа, улс төрийн бодлогын үндэс суурь, чиг баримжаа нь байх ёстой.

Тухайн түүхэн үе шатанд үндэсний өөрийн ухамсрыг тодорхойлдог гол зүйл нь “орчин үе”-ийн энгийн нэг ертөнцийг үзэх үзэл биш харин тухайн үндэстэн өнгөрсөн, одоо, ирээдүйгээ бүхэлд нь ухамсарлан ойлгохын илэрхийлэл байсаар ирсэн. Өөрөөр хэлбэл, улс төрийн ухамсар бол үндэсний-түүхийн нэгдмэл байдал буюу хамт туулсан өнгөрсөн үеийн нэгдмэл байдал, одоогийн нэгдэл, ирээдүйн нэгдлүүдийн нийлмэл тусгал юм. Нөгөө талаар түүхэн үйл явцад үндэсний өөрийн ухамсар нь зарим талаар улс төрийн ухамсарт нь оршиж ирсэн байдаг. “Хэрэв үндэсний өөрийн ухамсар нь үндэстний өнгөрсөн цаг үед холбогдолгүй аливаа нэг тусгалыг илэрхийлдэг бол, улс төрийн ухамсар нь үндэсний өөрийн ухамсрын цаг хугацаанд доройтож, сэргэж, улмаар одоо үеийн бодит байдлаас түүхэн ирээдүй рүү дамжин өнгөрдөг төвлөрлийн цэг юм”¹⁰. Өөрөөр хэлбэл, улс төрийн ухамсар нь тухайн түүхэн үед үндэсний төр-түүхийн ухамсрыг тусгагч үндэсний өөрийн ухамсрын цаг хугацаанд объективжсэн хэлбэр юм. “Улс төрийн ухамсар нь улс төрийн бодлогын нэгэн хэсэг болохынхоо хүрээнд дотоод агуулга буюу үндэсний өөрийн ухамсрын харьцангуй хэлбэрийн үнэн байдал, зохистой байдал, жинхэнэ байдал зэргийн өөр өөр түвшнүүдийг илэрхийлдэг”¹¹ байна.

“Коммунизмын задрал нь дэлхий нийтэд зөвхөн эдийн засаг, геополитикийн өөрчлөлт байгаад зогсоогүй, энэ нь улс төрийн ухамсрын өөрчлөлт байсан”¹². Үндэсний өөрийн ухамсар нь өөрийн уг гарлынхаа хувьд оюунлаг шинж чанартай тул түүнийг эрж хайх нь үзэл санааны үйл явц юм. Тиймээс “үзэл санааны өнөөгийн хямрал нь үндэсний өөрийн ухамсрыг тодорхойлдог үндэсний ертөнцийг үзэх үзлийн хямрал гэж нэрлэж болно. Энэ асуудал нь улмаар өнөөгийн үндэсний-түүхийн хамгийн хэцүү бөгөөд таамаглашгүй хүчин зүйл болж байна”¹³. Бүрэн төлөвшөөгүй, төөрөгдсөн үндэсний өөрийн ухамсарт харийн үнэт зүйлс, түүний үзэл санааны томъёоллууд орж ирвэл бас нэгэн шинэ асуудал болох болно. Гэхдээ эдгээр шинэ үнэт зүйлс нь тухайн үндэстний эртний сэтгэлгээ, уламжлалтай хэр зохицох нь бас нэгэн асуудал болон гарч ирж байгаа юм.

Үндэсний үзлийн агуулгад үндэсний мэдрэмж болон үндэсний өөрийн ухамсрын утга санаанууд улс төрийн ухамсрын томъёоллын үг өгүүлбэр болон хувирдаг. Тиймээс “нийгэм дэх үндэсний өөрийн ухамсар дотоод нэгдэлгүй байсан цагт улс төрийн ухамсар бүхэллэг байдлаар үүсэн хөгжихгүй”¹⁴. Өөрөөр хэлбэл, ерөнхий байдлаар бүрэлдэн тогтноогүй ертөнцийг үзэх үзэл тодорхой хэлбэр дүрс бүхий ухамсар болж хувьсаж чадахгүй гэсэн үг. “Нэг талаас үндэсний өөрийн ухамсрыг үндэсний мэдрэмж бүрэлдүүлдэг бол нөгөө талаас улс төрийн ухамсрыг үндэсний өөрийн ухамсар бий болгодог”¹⁵. Энэ байдал нь үндэстний түүхэн дэх улс төрийн өөрчлөлт, төрийн эргэлтэнд чухал үүргийг гүйцэтгэдэг байсан гэсэн үг. Цаг хугацаандаа нийцэх, үзэл баримтлалаа дэлхий нийтийн баримжаатай авч явах нь улс төрийн ухамсрын хөгжлийн зайлшгүй шаардлагатай нөхцөл байдаг. Улмаар үзэл

¹⁰ Мөн тэнд. Стр 232

¹¹ Путилов, С.В. *Русская идея как национальная идея: процесс концептуализации. Русская этнополитология и национальная идея.* М., 2006. Стр 94

¹² Катасонов, В.Н. *Национально-государственная идея России.* Пермь., 1998. Стр 9

¹³ Панарин, А.С. *Стратегическая нестабильность в XXI веке.* М., 2003. Стр 183

¹⁴ Мөн тэнд. Стр 77

¹⁵ Мөн тэнд

санааны тодорхойгүй байдал нь үндэсний өөрийн ухамсарт сөргөөр нөлөөлдөг. Хэрэв “үзэл санааг үндэсний өөрийн ухамсрын үр дагавар хэмээн үзвэл үндэсний өөрийн ухамсрыг улс төрийн ухамсрын гол утга санаа, суурь ойлголт хэмээн ойлгох болно”¹⁶.

“Хэрэв иргэд үзэл санааны төөрөгдөл дунд оршиж байвал үндэсний өөрийн ухамсар нь ямар ч үүрэггүй болж, улс төрийн ухамсрын тодорхойлолтыг боловсруулан гаргах түүхэн үүрэг хариуцлагаасаа ухрахад бэлэн болно”¹⁷. Харин ийм нөхцөл байдал бүрэлдэн бий болох шалтгаан нь нийгэмд үзэл санааны тогтворгүй байдал үүсэхтэй холбоотой. “Үндэсний өөрийн ухамсарт үндэсний түүхийн өмнөх үе шат байхгүй болсон нөхцөлд үндэсний адилсалыг сэргээх боломжгүй. Бид номны нэг хуудсыг тасдан авч хаявал дараагийн хуудсыг ойлгохгүйтэй адилхан”¹⁸. Учир нь түүх өөрөө залгамж холбоо бүхий тасралтгүй үйл явц билээ.

Улс төрийн ухамсар нь үндэстний хамтын өөрийн ухамсрыг төлөвшихөд түлхэц үзүүлж, төрийн бодлогын цар хүрээнд олон нийтийн хүсэл зоригийг тодорхой хэмжээгээр уялдуулан нийцүүлж, үндэсний үнэт зүйлийг нийгэмд бататгаж “Үндэстэн-төр улс, “ард түмний хүслийг” хэрэгжүүлэх замд тохиолдох саад бэрхшээлийн эсрэг олон нийтийн сэтгэлийн хөдөлгөөнийг сэргээдэг”¹⁹ ажээ. Энэхүү дүгнэлт нь үндэсний өөрийн ухамсар нь сэтгэл зүйн байдал буюу үндэсний ердийн ухамсрын түвшнээс онолын ухамсар болж улс төрийн ухамсрын түвшинд хүртлээ хэрэгждэг гэсэн санаа юм. Мөн улс төрийн ухамсар нь үндэсний ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгддэг ажээ.

Дүгнэлт

Хүний ухамсарт бүх үйл ажиллагаа итгэл үнэмшилтэй зайлшгүй холбогддог. Үндэсний өөрийн ухамсар зохих үзэл, улс төрийн бодлогын хэлбэрээр илэрнэ. Хэрвээ ийм улс төрийн бодлого болон үзэл санаа байхгүй бол ард түмэндээ үнэнч хайртай байх мэдрэмж, нөгөө л голомтын үнсээ хайрлах, өвгөдийн онгодыг хайрлах, эх орондоо үнэнч байх мэдрэмжээр л хязгаарлагдана. Гэтэл эдгээр нь байгаагаараа нийгмийн хөдөлгөгч хүч болохгүй. Үндэстэн төр улсын ашиг сонирхол бол төрийн амьдрал, үйл ажиллагааны суурь зарчим, гол хууль болж төрийн хүч нь үндэстний оршин тогтнолыг хадгалах зорилгод үйлчлэх ёстой. Харин өнөөгийн нөхцөлд үндэсний өөрийн ухамсар нь иргэний эв нэгдлийг бүрдүүлж, үндэсний сүр сүлдийг сэргээж, нийгмийн бүтээлч үйл ажиллагааг дэмжих гол тулгуур нь болж, үндэстэн хоорондын өрсөлдөөн нь хөгжлийг тэтгэгч, зөрчил нь бүх бололцоо чадварыг дайчлах хүчин нь болж байх ёстой.

Краткий обзор

Сравнивая национальное сознание с национальным самосознанием, национальное сознание заключается в подключении человека к социальной, политической историей, политической общности или к уровню социальной памяти. Но национальное самосознание - это не механическая связь с обществами, а сознательная форма, которая его признает. Это считается ответственность перед нацией.

¹⁶ Катасонов.В.Н. Национально-государственная идея России. Пермь.,1998. Стр 9

¹⁷ Мөн тэнд

¹⁸ Соловьев.В.С. Русская идея. М.,1988. Стр 220

¹⁹ Поздняков.Э.А. Улс төрийн философи. УБ.,2005. 297 дахь тал

Ашигласан ном зохиолууд

- Цэнд-Аюуш.Г. Улс төрийн ухамсар:түүхэн судалгаа. УБ.,2012
- Поздняков.Э.А. Улс төрийн философи. УБ.,2005
- Андерсон.Б. Нация и национализм. М.,2003
- Астафьева.О.Н. Многообразие моделей этнокультурной идентичности в современном информационно-коммуникативном пространстве. Глобализация и перспективы современной цивилизации. М.,2005
- Бахтин.М.М. Творчество Франсуа Раблеи народная культура средневековья и Ренессанса. М.,1965
- Катасонов.В.Н. Национально-государственная идея России. Пермь.,1998
- Путилов.С.В. Русская идея как национальная идея: процесс концептуализации. Русская этнополитология и национальная идея. М.,2006
- Панарин.А.С. Стратегическая нестабильность в XXI веке. М.,2003
- Соловьев.В.С. Русская идея. М.,1988
- Шмаков.В. Закон синархий. Киев.,1994
- Hans.K. The idea of nationalism. New-York.,2005
- Peirce.C. The fixation of belief. Cambridge.,1877
- Smith.A. Nationalism and modernism. New-York.,2013

УЛС ТӨРИЙН БИЗНЕСИЙН МӨЧЛӨГИЙН ОНОЛЫН ХАНДЛАГА, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Д.Бумдарь

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн профессор

Б.Сарантуяа

МУИС, Улс төр судлалын тэнхимийн магистрант

Түлхүүр үг: улс төрийн эдийн засаг, улс төрийн бизнесийн мөчлөг, сонгууль, оппортунист, партизан

Агуулга:

- Улс төрийн бизнесийн мөчлөгийн тухай ойлголт, онолын хандлага, үзэл баримтлал
- Нордхаусын хандлага: Оппортунист загвар
- Хиббс болон Виттман нарын хандлага: Партизан загвар
- Маккаллум, Лукас нарын хандлага
- Фрей, Шнейдер, Мослий нарын хандлага

Хураангуй: Улс төрийн эдийн засгийн онол, арга зүй, судлах зүйл, судалгааны ач холбогдол болон зарим төрлийн ухагдахуун нь тодорхой болсон ч манайд судалгааны эргэлтэнд ороогүй ойлголт, нэр томъёонууд байсаар байна. Тэдгээрийн нэг нь улс төрийн эдийн засаг дахь “*Улс төрийн эдийн засгийн \бизнесийн\ мөчлөг*” (Nordhaus, 1975) -тэй холбогдох нэр томъёо ойлголт юм. Улс төрийн эдийн засгийн мөчлөг буюу бизнесийн мөчлөг (цаашид Улс төрийн бизнесийн мөчлөг гэх.) нь манай улсын нийгмийн шинжлэх ухаанд төдийлөн сайн судлагдаагүй ойлголт юм.

Төр нь баялгийн тэгш хуваарилалт хийх иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалж, эрүүл саруул, гачигдах зүйлгүй амьдруулах үүрэгтэй ба үүнийг хэрэгжүүлэхийн төлөө намууд мөрийн хөтөлбөр боловсруулж төрийн эрхийг авахын тулд сонгуульд өрсөлддөг. Мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих боломж иргэдийн хувьд сонгууль байдаг. Гэтэл сонгууль нь санал авах улс төрийн бизнесийн мөчлөг болсон хэмээх хандлага байдаг. Энэ нь засгийн газар болон эрх баригч намын зүгээс сонгууль ойртоход эдийн засгийг сайжруулах бодлого баримталдаг ба сонгуулийн дараа үйл ажиллагаа нь идэвхгүй болдог үүнийг “Улс төрийн бизнесийн мөчлөг” хэмээн шууд ойлгох боломжтой юм.

Нөгөө талаас иргэдийн саналыг худалдан авах хамгийн боломжит үйл ажиллагаа нь төрийн зүгээс буюу засгийн газрын зүгээс нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлж мөнгөний тэтгэсэн, халамжилсан бодлогоор ялалт авчирч байгаа эсэх нь энэхүү онолын хандлагаар илрэн гарах юм.

УЛС ТӨРИЙН БИЗНЕСИЙН МӨЧЛӨГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОНОЛЫН ХАНДЛАГА, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Улс төрийн бизнесийн мөчлөг (англи. Political Business cycle) нь засгийн газрууд сонгуулийн жилүүдэд төсвийг тэлэх бодлого нь ихэвчлэн мөнгөний бодлогыг¹ хэрэгжүүлэх хандлагаар илэрхийлдэг.² Өөрөөр хэлбэл Улс төрийн бизнесийн мөчлөг нь улс төрийн оролцогчдын хөндлөнгийн оролцооноос үүдэлтэй эдийн засгийн үйл ажиллагааны хэлбэлзэл³ гэж нэрлэгддэг ба төсвийн тэлэлт нь зарлага нэмэгдэх тусам татварыг бууруулах замаар хийгддэг.

Улс төрийн бизнесийн мөчлөг гэдэг нэр томъёо нь сонгуулийн өмнөхөн эдийн засгийг идэвхжүүлж, улмаар өөрсдийн болон намынхаа дахин сонгогдох боломжийг эрс сайжруулна гэж найдаж буй одоогийн улс-төрчид бодлого (төсвийн бодлого⁴, мөнгөний бодлого) -ыг удирдан чиглүүлсний үр дүнд бий болсон бизнесийн мөчлөг гэж тодорхойлогддог. Улс төрийн эдийн засгийн мөчлөг болон бизнесийн мөчлөг (цаашид “Улс төрийн бизнесийн мөчлөг” гэх.) хэмээн нэрлэх нь адил ойлголт болно.

Судлаач Микал Калацки өндөр хөгжилтэй орнуудыг судалж үзээд елс төрийн бизнесийн мөчлөгийн онол, үзэл баримтлалыг анхлан гаргаж ирсэн. Тэрээр “Улс төрийн улирал” 1943 оны сэтгүүлд сонгуулийн өмнө засгийн газрууд эдийн засгаа идэвхжүүлж, тойргийнхоо дэмжлэгийг авч, капиталистууд (бизнес эрхлэгчид) сонгуулийн дараа бодлоо өөрчилдөг гэсэн санааг анх дэвшүүлсэн.

Микал Калецки капиталистууд (бизнес эрхлэгчид) бүрэн ажлын байр бий болгоход чиглэсэн засгийн газрын төсвийн нэмэгдэл зардлыг гаргахыг эсэргүүцдэг гэж таамагласан ба сонгуулийн дараа капиталистууд улс төрчдөд үзүүлэх нөлөөгөө ашиглан улс төрийн бизнесийн мөчлөгийг бий болгодог гэж үзсэн. Улс төрийн бизнесийн мөчлөгийн анхны эмпирик судалгааг Крамер (1971) хийсэн бөгөөд Туфте (1975, 1978) цааш нь боловсруулжээ.⁵

Микал Калецкийн санааг хэдэн арван жилийн дараа Уильям Нордхаус “Эдийн засгийн судалгааны тойм” (1975) бүтээлдээ өргөжүүлэн бичсэн. Улс төрийн бизнесийн мөчлөгийн тухай нэр ба ойлголтыг Нордхаус (1975) томъёолон гаргаж ирсэн. Тэрбээр энэ мөчлөг нь сонгуулийн өмнөх оппортунист манипуляциас үүдэлтэй гэж үзсэн; энэ санааг Калецки (1943), Шумпетер (1939) нар мөн хүлээн зөвшөөрсөн. Уильям Нордхаус “Сонгууль ойртох тусам одоогийн эрх баригчид “Филлипсийн муруй”-гаар⁶ дүрсэлсэн инфляц⁷ ба ажилгүйдлийн хоорондох богино хугацааны солилцоог

¹ Мөнгөний бодлого нь инфляцыг тогтвортой түвшинд байлгах, мөнгөний ханшийг тогтворжуулахад чиглэгдэнэ.

² Jeffrey Frankel in Handbook of Monetary Economics, 2010, article 7.2.2. Political Business Cycle

³ Jan Drahokoupil “Political Business Cycle” article in Encyclopedia Britannica, published 2015

⁴ Эдийн засагт төрийн сангийн тэлэх бодлого явуулснаар эдийн засагт ажилгүйдэл буурч инфляц өснө гэж үздэг.

⁵ Ji Eun Chung, Kwang Jung “Political Business Cycle and their policy Implications: An Extension of Alesina’s Model” article 2009, August

⁶ Шинэ Зеландийн эдийн засагч виллиам Филлипсээс эхлэлтэй бөгөөд цалингийн хэмжээ бага байвал аж илгүйдлийн түвшин өндөр байх хандлагатай. Нөгөөтэйгүүр хэрэв цалин бага, ажилгүйдэл өндөр байвал хүн амын нийт эрэлт багасаж, инфляцийн түвшин буурдаг гэж үзэж 1958 онд Филлипсийн муруйн тухай нйтлэлээ бичсэн.

⁷ Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн ерөнхий түвшин өсөж, тэр хэмжээгээр мөнгөний ханш буурах үзэгдэл юм. Инфляц нь нэг талаас хэрэглээний сагсан дахь бараа, үйлчилгээний үнэ, өргөн хэрэглээний

ашиглан ажилгүйдлийг бууруулдаг” гэж үзсэн. Нэгэнт сонгогдсон бол засгийн эрх барьж буй нам нь тэлэх бодлогоор түрүүлж бий болгосон инфляцыг бууруулах хэмнэлтийн бодлогыг баримталдаг.

Энэхүү хоёр голлох эрдэмтний үзэл баримтлал дээр үндэслэн улс төрийн бизнесийн мөчлөгийн тухай онол гарч ирсэн. Онол, үзэл баримтлал гарч ирэхэд улс төрийн бизнесийн мөчлөгтэй холбогдуулан хэрхэн мөчлөг гарч ирдэг тухай, мөчлөг руу хөтөлдөг улс төр, эдийн засгийн ямар механизм байдаг тухай, мөн сонгогчдын зан авирыг хэрхэн ангилах тухай ойлголттой холбогдох онолын хоёр загвар болон үзэл баримтлалууд гарч ирсэн.

Улс төрийн бизнесийн мөчлөгийн загварыг **Оппортунист** ба **Партизан** гэсэн хоёр ангилалд хувааж болох бөгөөд бусад үзэл баримтлалууд нь Рационал байдлаар судлах, Сэтгэл ханамжийн байдлаар улс төрийн бизнесийн мөчлөгийг судлах байна.

Хүснэгт 1: Оппортунист болон Партизан загварын төлөөлөгчид

	Оппортунист	Партизан
Уламжлалт	I	II
Филипсийн муруй бүхий макро эдийн засгийн загварууд.	Нордхаус 1975 он	Хиббс 1977 он
Оновчтой	III	IV
Макро эдийн засгийн бодлогын тоглоомын онолын хандлага.	Рогофф ба Сиберт 1988 Персонс болон Табеллини 2000	Алисена 1987 Алесина ба бусад 1997 он

Тайлбар: Хүснэгт 1-д бодлого боловсруулагчдын зан төлөв дээр тулгуурлан бодлого боловсруулагчид ба олон нийтийн хоорондын харилцааны дөрвөн загварыг нэгтгэн харуулав. Улс төрийн бизнесийн мөчлөгийн эхний үе шатыг I, II нүдэнд, харин хоёр дахь үеийг III, IV нүдэнд тэмдэглэлээ. Оппортунист загварыг I, III нүдэнд, харин партизан загварыг II, IV нүдэнд төлөөлөгчдийг тэмдэглэлээ. Дараа дараагийн хэсэгт нь эдгээр загваруудыг илүү нарийвчлан авч үзэх болно.


Улс төрийн бизнесийн мөчлөгийн онолын 3 нийтлэг ойлголт:

- Эдийн засаг дахь ашиглалт, ажил эрхлэлтийн түвшин, инфляцын түвшин хоёрын хооронд богино хугацааны харилцан солилцоо байдаг гэж үздэг ба үүнийг эдийн засагчид ерөнхийдөө хүлээн зөвшөөрдөг.
- Улс төрчид богино хугацааны улс төрийн зорилгоо урьтал болгож сонгуулийн өмнө жүжиглэдэг. Сонгуулийн өмнө тэд инфляцыг ажилгүйдлийн доод түвшингээр сольдог.
- Улс төрийн бизнесийн мөчлөгийг судалдаг хүмүүс тухайн нөхцөл байдалд ерөнхий ашиг сонирхолд нийцсэн нэг оновчтой бодлогын шийдэл байдаг гэж

бараа, үйлчилгээний эрэлт, мөн тэдгээрийн нийлүүлэлт, хангамжийн харьцаа, нийт хэрэглээний зардалд эзлэх хувийн жинтэй холбогдон өөрчлөгдөх боловч нөгөө талаас мөнгөний нийлүүлэлт, валютын ханш, хүн амын орлогын өсөлт болон бусад хүчин зүйлээс хамааран өөрчлөгддөг.

үздэг. Энэхүү шийдэл нь инфляц ба ажилгүйдлийн хоорондох тэнцвэрт байдлыг хадгалдаг.

Улс төрийн бизнесийн мөчлөгийн талаарх зарим эрдэмтдийн үзэл санааны холбоосууд⁸:



Бүдүүвч 1: Улс төрийн бизнесийн мөчлөгийн онолыг боловсруулагчдын үзэл санааны холбоос.

Улс төрийн бизнесийн мөчлөгийг схемчилсэн бүтцийн эхний эгнээнд Нордхаус, Макрее нарын сонгуулиар шалтгаалж үүсэх Оппортунист загварыг болон Хиббс, Виттман нарын Улс төрийн намын үзэл баримтлалаар үүсэх “Партизан загвар”-ыг оруулж, дараагийн эгнээнд “Оппортунист загвар”-ыг илүү оновчтой боловсруулан гарч ирсэн Рогофф, Сиберт нарыг болон партизаны загварыг илүү сайжруулан гарч ирсэн Алесина, Сакс нарыг орууллаа. Оппортунист болон партизан загвараас гадна Лукас, Маккаллум нарын боловсруулсан “Рационал байдлаар судалдаг үзэл” болон Фрей, Шнайдер, Мосли нарын “Сэтгэл ханамжийн байдлаар судалдаг” үзэл хандлага, загварууд байна.

Дээрх загварууд нь сонгогчдын оновчтой сонголтын түвшинг бууруулж, бодлогын гажуудал үүсгэж эдийн засгийн тэнцвэрт байдлыг алдагдуулдаг гэж үзсэн. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (ЭЗХАХБ) гишүүн орнуудын туршлагаас үзэхэд Улс төрийн бизнесийн мөчлөгийн шинж ажиглагдаж дээрх онол, загваруудтай нийцдэг. Мөн судлаач Алисена 1997 онд хийсэн өндөр хөгжилтэй орнуудад сонгуулийн жилүүдэд төсвийн бодлого харьцангуй сул буюу татвар бага, зардал ихтэй байдаг гэдгийг олж мэдсэн ба Алисена болон Робини нарын эрдэмтэд 1992 онд сонгуулийн дараа инфляц өсөх хандлагатай байдгийг тогтоосон.⁹

⁸ Такаши Томисани “Засгийн газрын улс төрийн бизнесийн мөчлөг” системийн загвар, Засгийн газрын дэмжлэгтэй судалгааны тайлан- 政治的景気循環の議院内閣 制モデル

⁹ Jeffrey Frankel in Handbook of Monetary Economics, 2010 article “Political Business Cycle”

Нордхаусын хандлага: Оппортунист загвар

Нордхаусын хандлага нь одоогийн “Засгийн газрууд” өөрсдийн улс төрийн нэр хүнд, дахин сонгуульд ялах гэсэн зорилгоор эдийн засгийг сайжруулах бодлого хийдэг гэж үздэг. Ихэвчлэн сонгуулийн өмнөх жил эдийн засгийг сайжруулан өсөлт, мөнгөний бодлогоор дэмжихийг хичээдэг бөгөөд энэ нь богино хугацаанд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болон ажилгүйдэлд үзүүлэх Филлипсийн муруйн нөлөөллийг ашиглан илэрч гардаг. Энэхүү сонгуулиар шалтгаалж улс төрийн бизнесийн мөчлөг явагдаж засгийн газрууд эдийн засгаа сайжруулах, нэр хүндээ өсгөхийг оролддог загварыг **“Оппортунист”** загвар хэмээн нэрлэсэн.

Оппортунист загвар:

Эрх бүхий “оппортунист” загварууд нь сонгууль болгоны өмнөх жил хагасын хугацаанд үйлдвэрлэлийн өсөлт нэмэгдэнэ гэж таамаглаж байгаа нь одоогийн эрх баригчдад дахин сонгогдох боломжийг олгож, эдийн засгийн өсөлтийг өдөөдөг гэж үздэг.

1970-аад оны дунд үеэс оппортунист бизнесийн мөчлөгийн албан ёсны онолууд гарч эхэлсэн бөгөөд хамгийн нөлөө бүхий нь Нордхаус (1975) тайлбарласан онол байсан. Эдийн засгийн бүтцийг доош чиглэсэн Филлипсийн муруйгаар хураангуйлж, ажилгүйдэл ба гэнэтийн инфляцын хоорондох солилцоог бий болгосон. Сонгогчид сонгуульд санал өгөх шийдвэрээ инфляц, ажилгүйдлийн үр дүнгээс хамгийн их хүсэж буй үр дүнтэйгээ харьцуулж үздэг хэмээн тодорхойлдог. Оппортунист эрх баригч бодлого боловсруулагч нь инфляц, ажилгүйдлээс цааш бодлого боловсруулдаггүй бөгөөд зөвхөн дахин сонгогдох асуудалд санаа тавьдаг. Оппортунист загварыг дараах байдлаар илэрхийлж болно.

- *Бодлого боловсруулагчийн (Засгийн газар) зорилго нь дахин сонгогдох магадлалыг хамгийн дээд хэмжээнд байлгахад оршино. Учир нь санал өгөх зан үйл нь өмнөх эрх баригчийн эрхэлж байсан эдийн засгийн гүйцэтгэлээс хамаарна. Тухайн үеийн эдийн засгийн гүйцэтгэлийг одоогийн инфляцын түвшин ба ажилгүйдлийн зан төлөвөөр хэмжэдэг тул сонгогчдын дургүйцлийг эдгээр хоёр хувьсагчаар нэмэгдэж буй алдагдлын функцээр илэрхийлж болно.*

Хиббс болон Виттман нарын хандлага: Партизан загвар

Хиббс болон Виттман нарын 1977 онд анхлан боловсруулсан улс төрийн намын үзэл баримтлал, ашиг сонирхлоор Улс төрийн бизнесийн мөчлөг явагддаг “Партизан” мөчлөг нь бүх ардчилсан орнуудад илрэн гарч ирэх ёстой бөгөөд олон улсын болон дотоодын улс төр-эдийн засгийн институт, бүтэц, стратегийн нөхцөлүүдийн хоорондох олон харилцан үйлчлэлээс ихээхэн хамааралтай байдаг.¹⁰ Хиббсийн партизаны онол нь зүүн, баруун үзэл баримтлалтай намын бодлого, үр дүнгийн тэргүүлэх чиглэлийн ялгавартай байдлаар тодорхойлж, инфляц эсвэл ажилгүйдлийн асуудалд онцлон анхаардаг.

Партизаны загварууд:

Партизаны загвар нь намуудын үзэл баримтлал, ашиг сонирхол болон эдийн засгийн зорилгын ялгаа нь улс төрийн бизнесийн мөчлөгийг өдөөж өгдөг гэж үздэг.

Тодруулбал:

¹⁰ Robert J. Franzese, Jr “Electoral and Partisan Cycle in Economic Policies and Outcomes” article- University of Michigan, 2002, p391

- Зүүний намууд эдийн засгийн бодит үйл ажиллагааг нэмэгдүүлэх буюу ажилгүйдлийг бага байлгахыг илүүд үздэг.
- Харин баруун талын намууд инфляцын асуудалд анхаарлаа төвлөрүүлдэг.

Энэ загварт барууны засгийн газрууд инфляцын түвшин, ажилгүйдлийн түвшинг засаглалынхаа туршид зүүн засгийн газруудтай харьцуулахад харьцангуй өндөр түвшинд хүргэж улмаар Нордхаусын загваруудаас ялгаатай мөчлөгийг бий болгодог. Партизаны загварыг тайлбарласан Алесина (1975) хувилбар дээр мөчлөгүүд нь урт хугацааны хөдөлмөрийн гэрээнүүдээс үүдэлтэй бөгөөд сонгуулийн дараа бодит цалин хөлсийг урьдчилан тооцоолоогүй мөнгөний тэлэлт эсвэл агшилтанд оруулахаас сэргийлдэг гэж үзсэн.

Маккаллум, Лукас нарын хандлага

Улс төрийн бизнесийн мөчлөгийн онол болон Филлипсийн муруйн талаар шинэ сонгодог онолчдоос шүүмжлэл гарч эхэлсэн нь Маккаллум (1978) байсан. Түүний үзэл баримтлал таамаглалаар улс төрийн бизнесийн мөчлөг байх ёсгүй учир нь бодлого өөрчлөгдөх бүрт сонгогчид өөрсдийн хүлээлтийг өөрчилдөг нь засгийн газар энэ мөчлөгийг ашиглаж чадахгүй гэж үзсэн. Алисина, Рогофф ба бусад эрдэмтэд 1980-аад оны эхэн үед Маккаллум (1978) шүүмжлэлийг няцааж оппортунист загварыг илүү оновчтой боловсруулсан. Маккулам (1978) онд ажилгүйдлийг АНУ-н сонгуультай холбоотой эсэхэд судалгаа хийж, сонгуулийн мөчлөгийн үе шатыг харуулсан таамаглал нь ажилгүйдлийн засвартай холбогдож, нөлөөлөл үзүүлдэггүй гэж үзсэн.

Лахлер (1978), Бек (1982) Томпсон ба Зук (1983) нар АНУ-д хийсэн судалгаагаа үндэслэн Маккалумын дүгнэлтийг дэмжиж байсан.

Судлаач Маккаллум “Улс төрийн бизнесийн мөчлөг: эмпирик судалгаа” өөрийн бүтээлдээ одоогийн засгийн газрууд өөрсдийн хүслээр байсан ч гэсэн сонгогдсон бүрэн эрхийнхээ сүүлчийн хугацаанд өсөлтийг бий болгож чадахгүй гэсэн таамаглалыг ил тод боловсруулан гаргасан байна. Цалин нэмэгдэж, бараа материалын үнийг буулгаж болох боловч үйлдвэрлэл өсөж, ажилгүйдэл буурахад ямар ч нөлөө үзүүлэхгүй гэсэн.¹¹ Тиймээс Маккулам өмнөх судлаачдын онолын хандлагад шүүмжлэлтэй хандаж илүү бодит байдлаар харах нь зүйтэй гэж **“Рационал байдлаар”** судалдаг загвар гарсан. Энэхүү загвар, онолыг илүү боловсруулсан нь дараа дараагийн оппортунист болон партизан загварыг илүү сайжруулан боловсруулахад чухал нөлөө үзүүлсэн.

Фрей, Шнейдер, Мослий нарын хандлага

Даунс Энтони “Ардчилал дахь эдийн засгийн онол” 1957 оны номондоо улс төрийн зан үйлийг эдийн засгийн хэрэгслээр судлахыг санал болгосон. Тэрээр “Улс төрчид хувийн ашиг сонирхолд хөтлөгддөг” гээд улс төрчдийг өөрсдийн сайн сайхан амьдралыг хамгийн дээд хэмжээнд байлгах сонирхолтой байх ёстой гэж үзсэн. Үүний дараа улс төрчдийн хувийн ашиг сонирхол эдийн засгийн онолын өнөөгийн сэтгэлгээнд судлагдах шаардлагатай болж Буканан ба Туллок (1962), Фрей ба Лау (1968), Уильям Нордхаус (1975) гэсэн судалгаанууд хийгдэх болсон.

Улс төр ба эдийн засгийн харилцан үйлчлэлийн талаарх судалгаанууд эдийн засгийн нөхцөл байдал сонгогчдын “зан төлөвт” хэр зэрэг нөлөөлж байгаа болон улс төрийн орчинд засгийн газрын “эдийн засгийн бодлогод” хэрхэн нөлөөлж байгаа гэсэн 2 асуудал төвлөрч болно. Энэ загварыг улс төрийн бизнесийн мөчлөгийг **“Сэтгэл**

¹¹ Bennett T. McCallum “The Political Business Cycle: An Empirical test”, University of Virginia

ханамжийн байдлаар” судлах онол гэх бөгөөд Фрей, Шнейдер (1978) нар эдийн засгийн үйл явдлууд Ерөнхийлөгчийн нэр хүндэд нөлөөлдөг гэж үздэг.¹²

Фрей, Шнейдер нар Нордхаус 1975 оны судалгаа болон Файр 1978 оны онолын судалгааг баталж саналаа хамгийн их байлгах сонирхолтой эрх баригчид өөрсдийн сонгуулийн амжилтыг нэмэгдүүлэхын тулд макро эдийн засгийн бодлогыг удирдан чиглүүлэх ёстой гэсэн санааг дэвшүүлсэн. Ийнхүү улс төрийн бизнесийн мөчлөгийн таамаглалд тодорхой хугацаатай сонгогдсон албан тушаалтнууд сонгуулийн жилүүдэд ажилгүйдэл, инфляц өндөр байсан ч эдийн засгийн таатай нөхцөлийг бүрдүүлэхийг хичээдэг гэж үздэг.

Мөнгөний бодлого¹³ болон төсвийн тэлэх бодлого¹⁴ нь богино хугацаанд улс төрийн хувьд түгээмэл үр дагаврыг авч ирдэг. Тэдгээр нь татварын бууралт, ажилгүйдлийн түвшин, зээлийн хүүгийн уналт, засгийн газрын тусгай ашиг сонирхол, шинэ засгийн газрын зардал гэх мэт байна. Энэхүү бодлогууд нь урт хугацаанд хэтрүүлэн хэрэгжүүлбэл инфляцыг түргэсгэх, гадаад худалдааны тэнцэлд хохирол учруулах, хадгаламжийн бага хүү бий болгох зэрэг тааламжгүй үр дүнд хүргэх боломжтой.

Тиймээс сонгууль дуусмагц улс төрчид дараагийн сонгууль хол байгааг тооцон үзэж татвараа нэмэх, зарлагаа бууруулах, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг удаашруулах, хүүгийн хүүг өсгөх гэх зэргээр амлалтаасаа буцаж эхэлдэг. Үүний үр дүнд сонгуулийг тогтмол зохион байгуулдаг улс орнуудад сонгуулийн үеэр зохиомлоор эдийн засгийн өсөлт бий болгох зэргээр засгийн газрыг өдөөж улс төрийн эдийн засгийн мөчлөгийн хэлбэлзлийг бий болгодог байна.

Хүснэгт 2-д дээр дурдсан таван хандлагын таамаглал, зарим онцлох дүгнэлтийг нэгтгэн харууллаа.

¹² David G. Golden, James M. Poterba, “The Price of Popularity: The Political Business Cycle Reexamined”, Harvard University, 1980, JSTOR,

¹³ мөнгөний бодлого нь инфляцыг тогтвортой түвшинд байлгах, мөнгөний ханшийг тогтворжуулахад чиглэгдэнэ.

¹⁴Эдийн засагт төрийн сангийн тэлэх бодлого явуулснаар эдийн засагт ажилгүйдэл буурч инфляц өснө гэж үздэг.

Хүснэгт 2: Улс төрийн бизнесийн мөчлөгийн таамаглалууд

Асуулт	Загвар-1 Оппортунист мөчлөг W.D. Nordhaus (1975) G.D. MacRea (1977)	Загвар-2 Үзэл суртлын мөчлөг D.G. Hibbs (1977) D.Wittman (1977)	Загвар-3 Хэт оновчтой сонгогчид R.E. Lucas (1976) B.T. McCallum (1987)	Загвар-4 Гадаад цочрол A. Alesina (1987) J. Sachs (1987)	Загвар-5 Чадваргүй улс төрийн намууд K. Rogoff (1987) A. Sibert (1988)
Сонгогчид	Оновчтой бус сонгогчид: Сүүлийн үеийн үйл явдалд илүү анхаарал хандуулдаг буюу хэтийн төлөвлөгөөг анхаардаггүй.	Оновчтой бус сонгогчид: Сүүлийн үеийн үйл явдалд илүү анхаарал хандуулдаг.	Хэт оновчтой сонгогчид: бүрэн дүүрэн мэдээллийн үндсэн дээр оновчтой урьдчилсан таамаглал гаргах чадвартай	Сонгогчид хэт оновчтой эсвэл оновчтой бус.	Сонгогчид хэт оновчтой эсвэл оновчтой бус.
Намууд	Оппортунист намууд: Сонгуульд сонгогдох магадлалыг хамгийн их байлгах бодлого баримтлах	Намуудын үзэл суртал: Намуудын сонголт нь эдийн засгийн бодит үр дүнд хамаатай болохоос сонгуулийн хэтийн төлөв биш.	намууд оппортунист эсвэл үзэл суртлын аль аль нь байна.	Намын үзэл сурталтай эсвэл Оппортунист үзэл сурталтай.	Намууд чадвараараа ялгаатай байдаг.
Эдийн засгийн бүтэц	Намууд бодлогын хэрэгслийн хяналтанд байдаг бөгөөд бодлого үр дүнтэй байдаг.	Намууд бодлогын хэрэгслийн хяналтанд байдаг бөгөөд бодлого үр дүнтэй байдаг.	Намууд бодлогын хэрэгслийн хяналтанд байдаг бөгөөд бодлого үр дүнтэй байдаг.	Намууд бодлогын хэрэгслийн хяналтанд байдаг бөгөөд бодлого үр дүнтэй байдаг.	Намууд бодлогын хэрэгслийн хяналтанд байдаг бөгөөд бодлого үр дүнтэй байдаг.
Цочролын эх үүсвэр	Улс төрийн шийдвэрээс үүссэн дотоод эдийн засгийн цочрол.	Цочрол үүсэх эх үүсвэр тодорхойгүй.	Бодлогын гадаад болон дотоод байдлыг цочирдуулдаг.	Бодлогын гаднах цочрол	Бодлогын дотоод эсвэл гадаад цочрол.
Намуудын чадвар	Эрх бүхий намууд	Эрх бүхий намууд	Эрх бүхий намууд	Эрх бүхий намууд	Намууд чадвараараа харилцан адилгүй байдаг.
Урьдчилсан таамаглал	Сонгуулийн мөчлөг дэх бизнесийн мөчлөг:	Төрийн өөрчлөлттэй холбоотой эдийн засгийн	Улс төрийг өдөөсөн эдийн засгийн мөчлөг байхгүй.	Хэт оновчтой болон сонгогчид	Хэт оновчтой сонгогчид

Сонгуулийн дараах хэмнэлт ба сонгуулийн өмнөх тэсрэлт	бодлогын өөрчлөлт: Зүүн жигүүрийн нам эрх барихад эдийн засгийн өсөлт гарах бол баруун жигүүрийн намууд эрх барихад инфляцын эсрэг хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлдэг.	Оппортунист намуудын хувьд нэр хүнд болон сонгууль нь эдийн засагт нөлөөлөхгүй гэж үздэг.	оппортунист намуудын хувьд сонгуулийн үер гадаад цочролд өртдөггүй.	намуудын чадвар дээр үндэслэж сонголт хийдэг. Илүү чадварлаг намууд удаан оршин тогтнодог.
---	--	---	---	--

Abstract:

Political economy theory, methodology, research topics, research significance and some types of concepts are clear, but we still have concepts and terms that are not in circulation in our country. One of them is the term “political economy / business cycle” in political economy theory. (Nordhaus, 1975). The political economy cycle or business cycle (hereinafter referred to as the political business cycle) is a concept that is not well studied in the social sciences of our country.

The term political business cycle is defined as a business cycle that results from the guidance of policies (fiscal policy, monetary policy) by current politicians who hope to stimulate the economy in the run-up to elections and dramatically improve their chances of re-election.

Ашигласан эх сурвалж:

- William D. Nordhaus (1975) “Alternative Approach to the Political Business Cycle”, Yale University.
- Alesina Alberto, Nouriel Roubini and Gerald D. Cohen (1997) “Political Cycles and the Macroeconomy”, Cambridge, MA: MIT Press.
- Jeffrey Frankel in Handbook of Monetary Economics ,2010 article 7.2.2. Political Business Cycle
- Jan Drahokoupil (2015) “Political Business Cycle” article in Encyclopedia Britannica.
- Eun Chung, Kwang Jung “Political Business Cycle and their policy Implications: An Extension of Alesina’s Model” article 2009, August
- Такаши Томисани “Засгийн газрын улс төрийн бизнесийн мөчлөг” системийн загвар, Засгийн газрын дэмжлэгтэй судалгааны тайлан- 政治的景気循環の議院内閣制モデル
- Jeffrey Frankel in Handbook of Monetary Economics, 2010 article “Political Business Cycle”
- Robert J. Franzese, Jr (2002) “Electoral and Partisan Cycle in Economic Policies and Outcomes” article- University of Michigan.
- Bennett T. McCallum (1980) “The Political Business Cycle: An Empirical test”, University of Virginia, David G. Golden, James M. Poterba, “The Price of Popularity: The Political Business Cycle Reexamined”, Harvard University.
- William D. Nordhaus (1989) “Alternative Approach to the Political Business Cycle”, Yale University.
- Douglas A. Hibbs (1987) “The American Political Economy: Macroeconomics and Electoral Politics” Harvard University Press.
- International Monetary Fund (1994) “Political Business Cycle and Expenditure Policies in Developing Countries”.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИУДЫН СТАТИСТИКТ ХИЙСЭН УЛС ТӨРИЙН ШИНЖИЛГЭЭ

Б.Эрдэнэдалай

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар

Улс төр судлалын тэнхимийн ахлах багш

Хураангуй: Энэхүү судалгааны ажлын хүрээнд Монгол улсад болж өнгөрсөн ерөнхийлөгчийн сонгуулиудын үр дүнд харьцуулсан шинжилгээ хийж, ерөнхийлөгчийн сонгуулийн онцлогийг сонгогчдын ирц, сонгуулийн үр дүнд нөлөөлж буй хүчин зүйлс, улс төрийн намын нөлөө, сонгуулийн үеийн хэвлэл мэдээллийн мониторингийн дүн, сонгууль бүрт нэмэгдэж буй сонгуулийн кампанит ажлын зардлын дүн зэрэгт хамаарал бий эсэхийг Сонгуулийн Ерөнхий Хороо, Үндэсний Аудитын Газар, Үндэсний Статистикийн Хороо зэрэг байгууллагуудын албан ёсны дүн мэдээнд үндэслэн дата статистикийн шинжилгээ хийсэн болно.

Түлхүүр үг: *ерөнхийлөгчийн сонгуулийн дүн, сонгогчдын оролцоо, сонгуулийн кампанит ажлын зардал, хэвлэлийн мониторинг*

Оршил

1990 онд Монгол улс ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш 31 жил өнгөрч байна. Аливаа улсын ардчиллын чанар, бэхжилтийг хангахад төрийн байгууллын тогтолцоо, институтууд хамгийн чухал үүрэгтэй. Монгол Улс 1992 онд шинэ үндсэн хуулиа батлан төрийн байгууллын хувьд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх тогтолцоотой байхын сацуу ерөнхийлөгчийн институттай улс болсон. Монголын улс төрд ерөнхийлөгчийн үүрэг, оролцоо тогтмол гол нөлөөлөгч байсаар ирсэн бөгөөд нийт иргэдийн шууд сонгуулиас сонгогддог гэдгээрээ өвөрмөц юм. Судалгааны ажлын хүрээнд 1993-2017 онд Монгол улсад болж өнгөрсөн ерөнхийлөгчийн сонгуулиудын үр дүнд харьцуулсан шинжилгээ хийж, ерөнхийлөгчийн сонгуулийн онцлогийг сонгогчдын ирц, сонгуулийн үр дүнд нөлөөлж буй хүчин зүйлс, улс төрийн намын нөлөө, сонгуулийн үеийн хэвлэл мэдээллийн мониторингийн дүн, сонгууль бүрт нэмэгдэж буй сонгуулийн кампанит ажлын зардлын дүн зэрэгт хамаарал бий эсэхийг Сонгуулийн Ерөнхий Хороо, Үндэсний Аудитын Газар, Үндэсний Статистикийн Хороо зэрэг байгууллагуудын албан ёсны дүн мэдээнд үндэслэн дата статистикийн шинжилгээ хийхийг зорилоо.

Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж, хэрэгжүүллээ. Үүнд:

- Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн бодит буюу боломжит мэдээллүүдийг тодорхойлох, түүнийг судлан шинжилгээ хийх.
- Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид болон улс төрийн намуудын сонгуулийн зардлыг харьцуулан судлах, ингэхдээ сонгуулийн кампанит ажлын зардал болон сонгогдох магадлалын хамаарлыг тодорхойлох.
- Судалгааны хүрээнд хийсэн харьцуулалт шинжилгээнд үндэслэн нөхцөл байдлыг сайжруулах, түүнд нөлөөлөх судалгааны санал, зөвлөмжийг боловсруулах.


Дээрх зорилтуудын хүрээнд судалгаанд ашиглах ёстой мэдээллийг олохын тулд Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ), Үндэсний Аудитын газар (ҮАГ), Улс төрийн намуудын сайт зэрэг боломжит мэдээллийн платформууд дээр хайлт хийж эхэлсэн. СЕХ-ны сайт дээр “1993-2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн” гэсэн файл байгаа боловч судлаачдад нээлттэй, боловсруулан анализ хийх боломжтой өгөгдөл биш .pdf өргөтгөлтэй байсан нь дата мэдээлэл боловсруулах ажилд нөлөөлж байсан. Мөн ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид болон улс төрийн намуудын сонгуулийн зардлыг харьцуулан судлах, ингэхдээ сонгуулийн кампанит ажлын зардал болон сонгогдох магадлалын хамаарлыг тодорхойлох зорилтын хүрээнд харьцуулагдах ёстой зардлын тайлангуудаас зөвхөн 2009, 2013, 2017 оны зардлын тайлан .pdf өргөтгөлтэй олдсон (СЕХ-ны сайт дээр зөвхөн 2013 оны зардлын тайлан байв). Бусад оны тайлангууд олдоогүй. Эндээс улс төрийн нам, нэр дэвшигчдийн санхүүгийн тайлан иргэд сонгогчдод нээлттэй, ил тод байх ёстой гэсэн зарчим, хуулийн заалт үйлчлэхгүй байгаа нь энэхүү судалгааны хүрээнд ажиглагдлаа. Хэдийгээр 2021 оны Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн дүн гарсан боловч СЕХ-ны сайт дээр мэдээлсэн дүн нээлттэй өгөгдөл биш байдлаар нийтлэгдсэн. Мөн тухайн дүнг мэдээлэхдээ тухайн хэсгийн хороод дээрх санал өгөх ёстой нийт сонгогчийн тоог оруулаагүй нь энэ удаагийн судалгааны зарим хэсгүүд дээр шинжилгээ хийхэд боломжгүй нөхцлийг үүсгэж байсан юм.

Шинжилгээний үр дүнгийн хэсэг

1. Сонгогчдын ирц, оролцоо

Ерөнхийлөгчийн сонгуульд оролцож саналаа өгсөн сонгогчдын ирц жилээс жилд буурсаар байгаа нь дараах зургаас харагдаж байна. 1993-2021 онд болж өнгөрсөн нийт 8 удаагийн сонгуульд орон нутаг дахь сонгогчдын ирц 36.5 хувиар, Улаанбаатар хот хотын сонгогчдын ирц 28.5 хувиар буурчээ.

Зураг 1. Сонгогчдын ирц: Орон нутаг ба Улаанбаатар хот



Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо. 2021. *Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн 1993-2021*

Өвөрхангай аймагт сонгуулийн ирц хамгийн өндөр буюу нийт сонгогчдын 72.3 хувь нь ерөнхийлөгчийн сонгуульд оролцож саналаа өгсөн бол Дорноговь аймагт хамгийн бага буюу тус хэмжээ 63.3 хувь байна.

Бүс нутгийн байршлаас үл хамааран сонгуулийн оролцооны эрэмбэ тодорхойлогдож байна. Тодруулбал, сонгогчдын оролцоо хамгийн өндөр 5 аймаг нь Төв, Хангай, Баруун бүс, Улаанбаатар хотод хамаарч байна.


Хүснэгт 1. Сонгогчдын оролцоо, аймгуудын эрэмбэ (2000 оноос хойш)

Аймаг	Оролцооны хувь	Эрэмбэ	Аймаг	Оролцооны хувь	Эрэмбэ
Өвөрхангай	72.3%	1	Говьсүмбэр	67.739%	12
Дундговь	70.0%	2	Хөвсгөл	67.6%	13
Ховд	70.0%	3	Баян-Өлгий	67.6%	14
Говь-Алтай	70.0%	4	Архангай	67.2%	15
Сэлэнгэ	69.1%	5	Орхон	66.3%	16
Баянхонгор	69.0%	6	Сүхбаатар	66.249%	17
Улаанбаатар	69.0%	7	Хэнтий	65.6%	18
Булган	68.7%	8	Завхан	65.6%	19
Дорнод	68.4%	9	Увс	65.2%	20
Дархан-Уул	67.9%	10	Өмнөговь	64.3%	21
Төв	67.809%	11	Дорноговь	63.3%	22
Нийт	68.1%				

Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо. 2021. *Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн 1993-2021*

Дээрх тоон мэдээллээс дүгнэхэд нийт аймгуудын 25 хувь нь 66.3 хүртэл хувийн ирцтэй, 50 хувь нь 67.8 хүртэл хувийн ирцтэй, 75 хувь нь 69.0 хүртэл хувийн ирцтэй байжээ. Энэхүү ангиллаар 4 хэсэгт хуваан сонгогчдын оролцоог аймгуудаар Зураг 2-т харууллаа. Үүнд хамгийн оролцоо сайтай аймгуудыг тод хөх өнгөөр, оролцоо багасах тусам бүдэг хөх өнгөөр тэмдэглэсэн болно.

Зураг 2. Сонгогчдын ирц: Аймгаар




Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо. 2021. *Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн 1993-2021*

2. Сонгогчдын ирц – хүчингүй болон цагаан санал

Сонгууль бүрт сонгогчдын ирцтэй холбоотойгоор гарч ирдэг асуудал бол хүчингүй санал байдаг. Мөн 2012 оны ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 55.10-т “Сонгогч нэг ч нэр дэвшигчийн төлөө санал өгөөгүй бол хэнийг ч дэмжээгүй санал гэж үзэн тухайн сонгогчийг санал өгсөн сонгогчдын тоонд оруулан тоолох ба энэ тохиолдолд уг саналын хуудсыг хүчинтэй саналын хуудаст тооцно” гэсэн заалт орсон нь цагаан сонголт гэх ойлголтыг гаргаж ирсэн.

Судалгааны энэ хэсэгт ерөнхийлөгчийн сонгуульд оролцож саналаа өгсөн сонгогчдын хүчингүй болон цагаан саналын нийт саналд эзлэх хувь хэмжээ жилээс жилд буурч байгаа боловч дахин сонгуулийн үеэр болон 2021 оны сонгуулиар огцом өсч 6-8 хувьд хүрсэн байна. Нийт саналын 97 хувь нь хүчинтэй санал байсан бол 3 хувь нь хүчингүй эсвэл цагаан санал байжээ. Орон нутаг эсвэл Улаанбаатар хотын сонгогчдоос үл хамааран хүчингүй болон цагаан саналын хувь хэмжээ ойролцоо байсаар ирсэн байна.

Зураг 3. Хүчингүй болон цагаан саналын нийт саналд эзлэх хувь



Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо. 2021. *Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн 1993-2021*

3. Сонгогчдын ирц ба тухайн орон нутгийн макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Судалгааны энэ хэсэгт сонгогчдын ирцэд тухайн орон нутгийн үйлдвэрлэл (Бодит ДНБ), ажил эрхлэлтийн түвшин (нийт хүн амд эзлэх ажилчдын тоо), эрүүл мэндийн үйлчилгээ (эмчийн хүрэлцээ), дахин сонгуульд оролцох зэрэг асуудал тус тус хамааралтай эсэхийг судалсан. (Хүснэгт 2)

Ерөнхийлөгчийн сонгуулийн 2001, 2005, 2009, 2013, 2017 (I, II), 2021* оны үр дүнгүүдийг ашиглан сонгогчдын оролцоонд нөлөөлж буй макро хувьсагчдын талаар бага хэмжээний үнэлгээ хийлээ. Энд нийт 21 аймаг болон Улаанбаатар хотын, 7 удаагийн сонгууль буюу 154 өгөгдлийг ашигласан бөгөөд 2 төрлөөр өгөгдлийг өөрчилж, үнэллээ ($\alpha = 0.05$). Ингэхдээ:

1. Сонгогч 4 жилийн хугацаанд тухайн хувьсагчийн дундаж утгаас хамааран сонгуульд оролцох эсэхээ шийддэг тохиолдол,

2. Сонгогч зөвхөн сонгуулийн өмнө буюу энэхүү судалгааны өгөгдлийн хувьд өмнөх жилийн эдийн засаг, нийгмийн байдлаас хамааран сонгуульд оролцох эсэхээ шийддэг тохиолдол хэмээн 2 төрлийн өгөгдөл үүсгэн үнэлгээг хийв.

Хүснэгт 2. Сонгогчдын оролцоонд нөлөөлж буй макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Нөлөөлөгч хүчин зүйлс	4 жилийн дундаж	Сонгуулийн өмнөх жил
Нэг хүнд ногдох БДНБ	Нөлөөгүй	Нөлөөгүй
ЕБС-ийн сурагчдын тоо	Нөлөөгүй	Нөлөөгүй
Ажилчдын нийт хүн амд эзлэх хувь	-	-
Эмчийн хүрэлцээ	-	-
Дахин сонгууль эсэх	-	-

Энд: 2021 оны тоон мэдээлэл хараахан нийтлэгдээгүй тул 4 жилийн дунджаар бус 3 жилийн дунджаар тооцооллыг хийсэн болно.

Үнэлгээнд Панел хамгийн бага квадратын арга, тогтмол нөлөөлөл эсвэл хувьсах нөлөөлөл (fixed or random effect model)-ийн арга зүйг ашигласан. Ерөнхий үр дүнгүүд арга зүйгээс үл хамааран хоорондоо нийцтэй байсан. Тухайн сонгогч сонгуульд оролцох эсэх шийдвэрээ гаргахдаа тухайн оршин суугаа газрын орлого, ажилгүйдэл, эрүүл мэндийн салбарын байдал зэрэг хувьсагчдыг харгалзах бөгөөд тухайн сонгогчдын боловсролын түвшин бас нөлөөлнө хэмээн таамаглалаа.

Үнэлгээний үр дүнд тухайн орон нутгийн бодит орлого сонгогчдын оролцоонд нөлөөгүй бол ажилгүйдэл бага, эрүүл мэндийн салбар сайн, эмчийн хүрэлцээ их, боловсролд хамрагдалт өндөр байх тусам сонгогч сонгуульд оролцож саналаа өгөх магадлал буурна. Дахин сонгууль зохион байгуулж буй тохиолдолд сонгогч сонгуульд оролцож саналаа өгөхгүй байх үр дүн гарсан.

4. Сонгогчдын ирц ба ялалт байгуулсан нэр дэвшигчийн авсан санал

Судалгааны энэ хэсэгт сонгогчдын ирц тогтвортой буурч байгаагаас үүдэн ялалт байгуулсан нэр дэвшигчийн нийт сонгогчоос авсан саналын хувь хэрхэн өөрчлөгдөж буйг шинжлэхэд буурч байгаа дүн гарлаа.



Зураг 4. Сонгуулийн ирц ба ялалт байгуулсан нэр дэвшигчийн авсан санал

Сонгуулийн ерөнхий хороо. 2021. *Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн 1993-2021*

Ерөнхийлөгчийн 1993 онд болж өнгөрсөн сонгуулийн ирц 92.7 хувьтай байснаар нийт сонгогчдын 54 хувь нь ерөнхийлөгчөө сонгож байв. Харин 2021 онд сонгуулийн ирц 59.3 хувь болж, 33.4 хувиар буурснаар нийт сонгогчдын 40.2 хувь нь ерөнхийлөгчийг сонгосон байна. Сонгуульд нэр дэвшигч дийлэнх иргэдийн саналаар сонгогдох ёстой боловч сонгуулийн оролцоо, идэвх сул байгаагаас ялалт байгуулсан нэр дэвшигчийн нийт сонгогчдоос авсан саналын хувь буурч, иргэдийн саналыг төлөөлөх чадвар буурсаар байгаа юм. Үүнээс гадна сонгуулийн сурталчилгааны хоног болон сонгуулийн ирц хооронд сул хэмжээний эерэг хамаарал ажиглагдлаа.


5. УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан улс төрийн намууд

1992-1997 оны хооронд болж өнгөрсөн сонгуулиудад парламентад олонх болсон улс төрийн нам болон ерөнхийлөгчийн нэр дэвшсэн улс төрийн нам ялгаатай байсан боловч 2000 оны УИХ-ын сонгуулиас энэ байдал өөрчлөгджээ.

Хүснэгт 3. УИХ-ын ба Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан намууд

Он	УИХ	Он	Ерөнхийлөгч
1992	МАН	1993	АН
1996	АН	1997	МАН
2000	МАН	2001	МАН
2004	МАН	2005	МАН
2008	МАН	2009	АН
2012	АН	2013	АН
2016	МАН	2017	АН
2020	МАН	2021	МАН

Зураг 5. Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн: Нэр дэвшигчдээр



Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо. 2021. *Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн 1993-2021*

Монгол улс ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш УИХ-ын болон ерөнхийлөгчийн тус бүр 8 удаагийн сонгуулийг зохион явуулсан. УИХ-ын сонгуульд МАН 6 удаа, АН 2 удаа, ерөнхийлөгчийн сонгуульд МАН, АН тус бүр 4 удаа ялалт байгуулсан байна.

Нэр дэвшигчийн авах саналд аль намаас нэр дэвшсэн эсэх хамгийн гол нөлөөлдөг нь дараах шинжилгээнд харагдлаа. (Гэхдээ энд ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн боловсрол, нас, хүйс, хувь хүний хүчин зүйлс нөлөөлдгийг авч үзэх хэрэгтэй)

Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулагдсан 1993-2021 оны хооронд нийт 23 нэр дэвшигч тус сонгуульд өрсөлджээ. Улсын хэмжээнд нэр дэвшигчдийн авсан саналд нөлөөлж буй хүчин зүйлсийг энгийн хамгийн бага квадратын аргаар үнэлэв. Ингэхэд аль улс төрийн намд харьяалагдаж буй нь нэр дэвшигчдийн авч буй саналд хамгийн хүчтэй нөлөөлж байсан. Өөрөөр хэлбэл, МАН-аас нэр дэвшиж байсан тохиолдолд авах саналын хэмжээ дунджаар 20.9 хувиар нэмэгдэхээр байна. Харин хүйс, эдийн засгийн мэргэжилтэй эсэх зэрэг хувьсагчид нь статистикийн хувьд ач холбогдолгүй байв.

Хүснэгт 4. Нэр дэвшигчийн авсан санал ба хувийн мэдээлэл хоорондын хамаарал


Хувьсагч	Хамаарал	Ач холбогдолтой эсэх
Нас	Нэр дэвшигчийн нас 1-ээр нэмэгдэхэд авах санал 1.4 хувиар буурна.	Ач холбогдолтой*
Нам	МАН-ын гишүүн бол авах санал 20.9 хувиар нэмэгдэнэ.	Ач холбогдолтой**
Хүйс	Эмэгтэй бол авах санал 11.9 хувиар буурна.	Ач холбогдолгүй
Мэргэжил	Эдийн засгийн мэргэжилтэй бол авах санал 4.1 хувиар буурна.	Ач холбогдолгүй

Энд: * - 90 хувийн ач холбогдол, ** - 95 хувийн ач холбогдлын түвшинг тус тус илэрхийлнэ.

6. Шилжилт хөдөлгөөн

Ерөнхийлөгчийн сонгуулийн жил болон тухайн сонгуулийн өмнөх жилүүдэд орон нутгаас Улаанбаатар хотыг чиглэсэн шилжилт хөдөлгөөн нэмэгддэг байна. Гэхдээ ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөх жил УИХ-ын сонгууль явагддаг, хүн амын шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх бусад олон хүчин зүйл байдгийг харгалзан үзэх нь зүйтэй.

Зураг 6. Хүн амын цэвэр шилжилт




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо. 1212.mn

7. Хэвлэлийн мониторинг

Судалгааны энэ хэсэгт ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа сонгогчдын сонголтод нөлөөлж буй эсэхийг судлахыг зорьсон. Үүний тулд иргэний нийгмийн байгууллагуудын сонгуулийн кампанит ажлын үеэр хийдэг хэвлэл мэдээллийн мониторингийн дүнг сонгогчдоос авсан саналтай харьцуулан шинжиллээ.

Глоб интернэшнл төв 2009 болон 2017 онуудад Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны хамгийн идэвхтэй 2 долоо хоногийн хугацаанд хэвлэл мэдээллийн мониторинг хийжээ. Судалгаанд үндэсний хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг 5 сувгийг хамруулсан бөгөөд сонгуулийн сурталчилгааны хугацаа, нэр дэвшигчдийн талаар мэдээлэл, сонгогчдын боловсрол зэргийг судалсан байна.


Зураг 7. Хэвлэлийн мониторинг: 2009 ба 2017 оны дүн



Эх сурвалж: Глоб интернэшнл. 2009, 2017. *Ерөнхийлөгчийн сонгуулийн хэвлэлийн мониторинг*

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн зурагтын сувгаар гарсан хугацаа болон авсан санал хооронд эерэг хамааралтай байна.

Зураг 8. Санал ба хэвлэл мэдээллээр цацагдсан хугацаа хоорондын хамаарал



Эх сурвалж: Глоб интернэшнл. 2009, 2017. *Ерөнхийлөгчийн сонгуулийн хэвлэлийн мониторинг*

Нэр дэвшигчдийн талаар мэдээллэсэн хугацаа болон тухайн нэр дэвшигчийн авсан санал хооронд хамаарлыг цэгэн түгэлтийн диаграмаар харуулав. Ерөнхий хамаарал эерэг бөгөөд тус хувьсагчид хоорондын корреляцийн коэффициент 0.67 гарсан юм. Өөрөөр хэлбэл, тухайн нэр дэвшигч зурагтаар их гарах тусам мэдээний утгаас үл хамааран сонгогдох магадлал нэмэгдэж байгааг харж болно. Гэхдээ энэхүү тооцоолол нь зөвхөн 2009, 2013 болон 2017 оны сонгуульд үндэслэн хийснийг анхаарах шаардлагатай.


8. Кампанит ажлын зардал

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн зардлын дэлгэрэнгүй тайланд тайлагнаснаар, сонгуулийн кампанит ажлын орлогын дийлэнх хувийг иргэдийн хандив

эзэлдэг бол зардлын дийлэнх хувь нь нэр дэвшигчийг сурталчлах, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг таниулахад зарцуулагдаж байна.


Нэр дэвшигчдийн орлого нь хуулийн этгээд, иргэд, намаас өгсөн хандив болон нэр дэвшигчийн хувийн хөрөнгөөс бүрддэг. Гэхдээ зардлын тайлан дээр тайлагнасан тоон мэдээллээс дүгнэхэд нэр дэвшигчид өөрийн хөрөнгөөс сонгуулийн кампанит ажилд зардал гаргаагүй байсан. Харин орлогын 50-иас дээш хувь нь иргэдийн хандиваас, үлдсэн хувь нь хуулийн этгээд болон намын хандиваас бүрдсэн байгаа нь дараах зургаас харагдаж байна.

Зураг 9. Нэр дэвшигчдийн орлогын задаргаа: 2009-2017 он



Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо. 2009-2017. Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын тайлан

Зураг 10. Нэр дэвшигчдийн зардлын задаргаа: Нэр дэвшигчийг сурталчлах, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах зардал ба бусад зардлын харьцаа (2009 ба 2017 он)



Н.Энхбаяр (МАХН)	Ц.Элбэгдорж/ АН	М.Энхболд/М АН	Х.Баттулга/АН	С.Ганбаатар/МА ХН
---------------------	--------------------	-------------------	---------------	----------------------

Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо. 2009-2017. *Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын тайлан*


Жич: Энд нэр дэвшигчийг сурталчлах, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах зардлын нийт зардалд эзлэх хувийг тодруулав.

Нэр дэвшигчийн зардлыг сурталчлах, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах зардал, уулзалт, хурал зохион байгуулах зардал, шуудан, шатахуун, цалин хөлс зэрэг бусад зардлууд бүрдүүлжээ. Үүнээс нэр дэвшигчийг сурталчлах, мөрийн хөтөлбөрийг таниулах зардал нийт зардлын дийлэнх хувийг эзэлж байгаа ч тухайн нэр дэвшигчийн онцлогоос хамааран зардлын бүтэц харилцан адилгүй байв.

Харин дараах шинжилгээний хэсгүүд дээр нэр дэвшигчдийн зардал болон санал хооронд сул хэмжээний эерэг хамаарал ажиглагдлаа. Нэр дэвшигчийг сурталчлах зардал, сонгуулийн нийт зардал болон авсан санал хоорондын хамаарлыг дараах 2 хэсэг зурагт харуулав.

Зураг 11. Нэр дэвшигчдийн зардал ба авсан санал хоорондын хамаарал

а. Нэр дэвшигчийг сурталчлах зардал ба санал хоорондын хамаарал **б. Нэр дэвшигчийн сонгуулийн зардал ба санал хоорондын хамаарал**



Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо. 2009-2017. *Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын тайлан*. Сонгуулийн ерөнхий хороо. 2017. *Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн 1993-2017*

Нийт 2009-2017 оны 3 удаагийн ерөнхийлөгчийн сонгуулийн тоон мэдээллээс дүгнэхэд тухайн 2 хувьсагч хооронд эерэг хамаарал (Корреляцийн коэффициент 0.60) ажиглагдав. Мөн тухайн нэр дэвшигчийн санал болон тодорхой бүлэг зардал хооронд хүчтэй хамаарал ажиглагдаагүй. Тухайлбал, нэр дэвшигчийг сурталчлах, мөрийн хөтөлбөрийг тайлбарлах зардал болон нэр дэвшигчийн авсан санал хооронд маш бага хэмжээний сөрөг хамаарал байсан.

Дүгнэлт

Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц, оролцоо, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, УИХ болон орон нутгийн сонгуулийн нөхцөл байдалтай хэрхэн холбогдож буй байдал, нэр дэвшигчдийн авч буй санал, нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар хийсэн судалгаа манай улсад дутмаг байна. Энэ төрлийн судалгааг тогтмол хийх нь сонгуулийн бодлогын шийдвэр гаргалтад чухал ач холбогдолтой билээ. Судалгааны хүрээнд шинжилгээ хийх явцад нээлттэй, харьцуулалт хийх боломжтой өгөгдөл тун дутмаг байгаа нь зарим төрлийн тооцоо, шинжилгээ хийх боломжийг хязгаарлаж байсан юм. 1993 оноос хойш Монгол улсад нийт 8 удаагийн ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулагдсан үр дүнд харьцуулалт шинжилгээ хийх нээлттэй ч судлаачдад олдсон өгөгдлийн хэмжээ, агуулга харьцангуй бага байна. Энэхүү судалгааны үр дүнд дараах асуудлуудыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага байгаа төдийгүй, цаашид энэ төрлийн судалгаа, шинжилгээний чанарыг сайжруулах ач холбогдолтой юм.

- Сонгуультай холбоотой бүхий л дүн, өгөгдлийг аймаг, сум, хороодоор илүү дэлгэрүүлэн мэдээлэх
- Сонгогчдын нас, хүйс, боловсрол, санал өгсөн цаг (үдээс өмнө эсвэл хойш)-ийн мэдээллийг байршлаар нь нээлттэй мэдээлэх
- Сонгуулийн кампанит ажлын санхүүгийн мониторингийг тогтмол хийх, мэдээллийг бүс нутгаар нээлттэй мэдээлэх
- Хэвлэл мэдээллийн мониторингийг тогтмол хийх
- Сонгуулийн үр дүнтэй холбоотой нэгтгэгдсэн бүх мэдээллийг судлаачдад нээлттэй өгөгдөл байдлаар мэдээлэх
- Сонгуулийн үр дүнтэй холбоотой нэгтгэгдсэн бүх мэдээллийг СЕХ болон тухайн үр дүнд хяналт тавьдаг, чиг үүргийн хувьд оролцдог бүх байгууллагуудын сайт дээр тогтмол байлгах, арилгахгүй байх. Ингэхдээ сонгуультай холбоотой бүх мэдээллийг нэг дороос нээлттэй хүргэх боломжийг СЕХ-нд хариуцуулах
- Цаашид Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн асуудал, сонгуулийн тогтолцоо, сонгуульд оролцож буй намуудын өрсөлдөөн, сонгуулийн кампанит ажлын онцлог, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийн харьцуулалт болон хэрэгжилт, сонгогчдын үйл байдал, хандлага зэргийг гүнзгийрүүлэн судлах, тогтмол харьцуулан анализ хийх зэрэг болно.

Ашигласан материал

Глоб интернэшнл. 2009. *Ерөнхийлөгчийн сонгуулийн хэвлэлийн мониторинг*

Глоб интернэшнл. 2017. *Ерөнхийлөгчийн сонгуулийн хэвлэлийн мониторинг*

Сонгуулийн ерөнхий хороо. 2021. *Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн 1993-2021*

Сонгуулийн ерөнхий хороо. 2009-2017. *Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын тайлан*

Үндэсний статистикийн хороо. www.1212.mn

**МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД
СОНГОГЧДЫН УЛС ТӨРИЙН ОРОЛЦООНЫ ТӨЛӨВ БАЙДАЛД ХИЙСЭН
ШИНЖИЛГЭЭ (2017, 2021 ОНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН
ЖИШЭЭН ДЭЭР)**

Г.Цэнд-Аюуш

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар
Улс төр судлалын тэнхимийн багш, доктор

О.Мөнхжаргал

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар
Улс төр судлалын тэнхимийн багш

Хураангуй: Германы социологч М.Вебер сонгуулийг төр, засгийн легитимт (хууль ёсны хүлээн зөвшөөрөгдөх-Г.Ц) байдлыг хангах ардчилсан хэлбэр гэж үзсэн байдаг. Тиймээс улс төрчид, иргэд сонгуулийг сонголтын хамгийн зохистой бөгөөд бодитой арга хэрэгсэл гэж нийтээр хүлээн зөвшөөрдөг нь дэлхийн улс орнуудад нэгэнт тогтсон жишиг билээ.

Энэхүү өгүүллийн зорилго нь “Монгол улсын 2021 оны ерөнхийлөгчийн сонгуульд иргэдийн улс төрийн оролцооны нийгэм-сэтгэл зүйн төлөв байдалд хийсэн шинжилгээний асуудлыг (2017, 2021 оны ерөнхийлөгчийн сонгуулийн жишээн дээр) авч үзэхэд чиглэгдсэн болно.

Түлхүүр үг: *сонгууль, сонгуулийн технологи, иргэдийн улс төрийн оролцоо, олхн түмний улс төрийн сэтгэл зүй.*

Монгол улс нийгмийн баримжаа бүхий ардчилсан өөрчлөлтөд шилжсэнээс хойш даруй 30 гаруй жилийн нүүр үзэж байна. Энэ хугацаанд Монголын иргэд сонгогчид УИХ, ерөнхийлөгчийн болоод орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нийт 20 гаруй удаагийн сонгуульд оролцож саналаа өгсөн байна. Өөрөөр хэлбэл, манай сонгогчид өнгөрсөн энэ бүхий л хугацаанд ардчилсан сонгуулийн зарчим, шаардлага, дэг жаяг, ёс зүйгээс суралцсаар ирсний зэрэгцээ, тэдний нийгэм-сэтгэл зүйн төлөв байдал байнга хувьсан өөрчлөгдөж ирснийг онцолж байна. Учир нь сонгууль бол олон нийтийг хамарсан улс төрийн кампанит үйл ажиллагаа тул тухайн үед иргэд сонгогчдын дунд сонгуульд өрсөлдөж байгаа хувь хүн, улс төрийн нам, эвсэл холбоодын талаар тааламжтай болон тааламжгүй, түүнчлэн эргэлзэж тээнэгэлзсэн байр суурь, хандлагыг бий болгодог учир сонгогчдын сэтгэл зүйг оновчтой тоймлож дүгнэх боломж хомс, магадлал бага байдаг. Ялангуяа улс төрчид, иргэд сонгогчид сонгуулийн үед хийгдэж байсан судалгааны үр дүнг сонгуулийн эцсийн үр дүнтэй харьцуулан үзэж баярлах, бухимдах хандлага түгээмэл ажиглагддаг тул энэ талын шинжилгээ хийх нь нэн ач холбогдолтой.

Судалгаа бол сонгуулийн бодит үр дүнг тооцсон алхам байдаг. Монголын иргэд сонгогчдын нийгэм-сэтгэл зүйн төлөв байдал нь улс орны дотоод, гадаад нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, улс төрийн үйл явцыг даган хувьсан өөрчлөгдөж ирсэн байдаг.

Соёл иргэншил, үндсэн хууль, ардчилал, сонгууль, улс төрийн соёл, иргэдийн оролцооны үзэл санаа, үнэт зүйлс өнө эртний түүхийн улбаатай бөгөөд дэлхийн бүс нутаг, улс орнуудыг хамарч даяарчлагдсан нийгэм-улс төрийн энэхүү үйл явц зогсолт, ухралтыг тойроогүй ч цуцалтгүй ургашлан хөгжиж, цар хүрээгээ тэлэн өнөөг хүртэл үргэлжилж байгаа билээ. Хүн төрөлхтний энэ түүхэн хөгжлийн хандлага Монгол түмнийг тойрч өнгөрөөгүй юм.

Манай Монголчууд өнө эртний соёл иргэншилтэй билээ. Тэдгээрийн салшгүй хэсэг нь төр ёс, улс төрийн соёл байдаг юм. Хүн төрөлхтний түүхэн үеүдэд иргэдийг төрөөс өөрөөр нэгтгэн зохион байгуулах аргагүй. Учир нь хүмүн төрөлхтөн хэзээ ч захиргаагүйгээр оршин тогтнож ирээгүй, оршин тогтнож чадахгүй. Тиймээс аль ч улс үндэстэн ёс суртахууны зэрэгцээгээр гол төлөв хууль, эрхийн хүчин зүйлд дулдуйдан оршин тогтнож ирсэн. Энэ утгаар Платон “улс төрийг хүмүүс хамтарч амьдрах урлаг буюу арга ухаан”, түүний шавь Аристотель “хүн бол улс төрийн амьтан мөн” гэсэн сургаал дэвшүүлсэн байдаг. Энэхүү жам ёс, зүй тогтлоор Монголын соёл иргэншил замнаж ирсэн юм.

Улс төр, төр ёсны болон төрийн тэргүүн, түшмэл даамалыг шалгаруулж олох шинж тэмдгийн талаар эртний Дорнын арга ухааныг манай монголчууд мэдэж, ашиглаж ирсэн байна.

“Монголын нууц товчоо”-ноос эхлэн “Их засаг” хууль, “Хөх судар”, “Хөх Монголын хөх туг”, “Алтан товч”, “Арван буянт номын цагаан түүх” зэрэг алдарт сурвалж бүтээлүүдэд монголчуудын төрийг үзэх үзэл, төрийнхөө сүр сүлдийг дээдлэх ёс суртахуунтай нягт холбоотой үндэсний улс төрийн ухамсар, сэтгэлгээ төр ёсны уламжлалд маш чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Жишээ нь: “Нууц товчоо”-нд Чингисийг хаан ширээнд залсантай нь холбогдуулан зан авирын дүрмийн үндсэн дээр (бихеворист-Г.Ц) төр улсыг жолоодох нь чухал гэсэн үзэл санааг:

Энэ шийдвэрээ эвдэхгүй

Эв зангиагаа таслахгүй

Эх захаа алдахгүй эгнэгт журамтай бай” гэж өгүүлсэн байдаг.

Улс төрийн оролцооны талаар товч өгүүлье: Оролцооны ардчилал нь эртний Грек, Ромын үеэс улс төрийн амьдралд бодит биелэлээ олж хөгжсөн байдаг. Тухайлбал, эртний Афинд шууд ардчилал хөгжиж байжээ. Хотын иргэд шууд оролцооны үндсэн дээр нийтийн өмнө тулгамдаж буй асуудлаа шийддэг байсан бөгөөд аажмаар үндэсний төр улсууд олноор бий болж хот, тосгоны тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ нэмэгдэж, хүн амын бүтцэд хэмжээлшгүй их өөрчлөлт гарсантай холбогдож төлөөллийн ардчилал үүсэж хөгжиж ирсэн билээ. Аливаа зүйл төгс төгөлдөр байдаггүйн адилаар төлөөллийн ардчилал ч өөрийн гэсэн сул талтай ч ардчиллын үнэт зүйл болсон чөлөөт, шударга сонгууль бол хүн төрөлхтний одоогоор олж мэдсэн хамгийн боломжийн арга хэрэгсэл ажээ. Төлөөллийн ардчиллын дутагдалтай талыг нөхөх, саармагжуулах хэлбэр бол оролцооны ардчилал хэмээн судлаачид дүгнэсэн байдаг. (Macpherson C.B. The Real World of Democracy. Oxford University Press.1966)

Оролцооны ардчиллын онцлог нь иргэд аливаа асуудлыг шийдэхдээ нийтийн талбай, хурлын танхимд цугларч харилцан зөвшилцөн шийдвэр гаргадагт оршино. Ингэхдээ иргэд мэдээллээр сайн хангагдсан байх бөгөөд орчин үед цахим технологийг өргөн ашиглах болсон нь оролцооны ардчиллыг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна. Оролцооны ардчиллын гол зорилго нь төрийн бодлого боловсруулах, шийдвэр

гаргах бүхий л үйл явц ил тод байж иргэд үүнд нийтээрээ хяналт тавин оролцоход оршино. Ингэснээр төрд итгэл өгөх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх замаар улс төр, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, аливаа бодлого шийдвэрт олон түмний дэмжлэгийг бий болгоход чухал нөлөөтэй. Судлаач К.Макферсон оролцооны ардчиллыг шударга, ил тод, хүмүүнлэг нийгмийг цогцлуулахад онцгой ач холбогдолтой гээд тэрээр нийгэмд шударга ёс тогтож, улс төрийн тогтолцоо төлөвших тусам оролцооны ардчиллыг шаарддаг гэж дүгнэсэн байдаг.

Монголчуудын улс төрийн ардчилсан оролцооны үндсийг 1992 оны шинэ үндсэн хууль баталгаажуулж өгсөн юм. Үндсэн хуулийн 1-р бүлгийн 3,1-д “Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ. (Монгол Улсын Үндсэн хууль. УБ.,1992) гэж хуульчилсан нь улс төрийн эрх, эрх чөлөөгөө эдлэх өргөн боломжийг ард иргэдэд олгосон юм. Энэ нь ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой гэсэн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын заалтыг эш үндэс болгосон хэрэг байв. (Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 21,3-р зүйл) Мөн А.Линкольны “Ардчилал бол ард түмнээс байгуулагдсан, ард түмний төлөө, ард түмний өөрсдийнх нь засаг” гэсэн үг Монголд бодит биелэлээ олох нөхцөл үндсэн хуулийн хүрээнд бүрдсэний нотолгоо мөн.

Үндсэн хуулийн хүрээнд иргэдийн улс төрийн оролцоог хангах, улс төрийн эрх, эрх чөлөөгөө эдлэх боломжийг олгосон суурь зарчим, зохицуулалтын дотроос дараах хоёр заалт хамгийн их ач холбогдолтой. Үүнд: Үндсэн хуулийн 2-р бүлгийн 16,9-д Монгол улсын иргэд “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийн удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Мөн хуулийн 16,10-т нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй... Аль нэгэн нам, олон нийтийн байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно гэж тус тус хуульчилсан нь Монголчуудын улс төрийн оролцооны эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн юм.

Монгол улсад эдүгээ хүчин төгөлдөр мөрдөж буй үндсэн хуулиас гадна Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн хууль, Төрийн бус байгууллагын хууль, Ард нийтийн санал асуулгын хуулиудаар иргэдийн улс төрийн оролцооны эрх зүйн орчинг зохицуулж байна.

Өнөөдөр Монголчуудын улс төрийн конвенциал буюу нийцтэй оролцооны хамгийн түгээмэл хэлбэрүүд дараах үйл ажиллагаагаар илэрч байна. Үүнд:

- Сонгуульд оролцож сонгож, сонгогдох
- Улс төрийн нам,эвсэл холбоо байгуулах, эвлэлдэн нэгдэх, гарах
- Хэвлэл мэдэллийн хэргэслээр өөрийн үзэл бодол,саналаа чөлөөтэй илэрхийлэх
- Төрийн үйл хэрэгт биечлэн болон төлөөлсөн байгууллагаараа шууд ба дам оролцох
- Хуулийн хүрээнд жагсаал цуглаан зохион байгуулах, оролцох зэргээр улс төрийн оролцоогоор дамжуулж улс төрийн эрхээ эдэлж байгаа юм.

Монголд чинээлэг тогтвортой дундаж давхрага бүрэлдэж амжаагүй учраас иргэдийн аж амьдрал улс төрөөс харьцангуй их хамааралтай байгааг тэмдэглэх

хэрэгтэй. Монголд ажилгүй хүмүүсийн тоо 100 гаруй мянга, ядуурлын түвшин 36%, баян хоосны ялгааг хэмждэг жиний коэффициент 0,36% байгаа нь өндөр үзүүлэлт юм. Мөн нийгмийн хөгжил, өөрчлөлтийг даган сонгогчдын улс төрийн ухамсар, үйл байдалд томоохон өөрчлөлтүүд гарч байгаа нь сүүлийн жилүүдийн судалгаанаас харагдаж байна.(Монголын нийгмийн өөрчлөлт.УБ., 2012. Г.Цэнд-Аюуш. Улс төрийн ухамсар: Түүхэн судалгаа. УБ.,2021)

Судалгаанаас харахад өндөр боловсролтой, ажил мэргэжилтэй орлого сайтай, нийгэмд зохих байр сууриа эзэлсэн сонгогчдын улс төрд хандах хандлага тогтвортой, сонголт хийхдээ гадны нөлөөнд автах байдал нь бага байдаг байна.

Харин ажил мэргэжилгүй, орлогын тогтсон эх үүсвэргүй, боловсрол багатай ба боловсролгүй сонгогчдын хувьд тэдний улс төрд хандах хандлага, сонгуульд оролцох оролцооны сэдэл харилцан адилгүй байгаа нь харагддаг. Тэдний нэг хэсэг нь улс төрийн идэвхтэй байр сууринд байх ба энэ бүлгийн хүмүүст нөлөөлдөг гол хүчин зүйл нь эдийн засгийн хөшүүрэг (нам, улс төрчдийн амлалт, сонгуулийн амлалт) байхад нөгөө хэсэг нь идэвхгүй “хөвөгч”, заримдаа бүр “хүнийссэн” төлөв байдалтай байдаг. Улс төрөөс хүнийссэн хэсгийнхний улс төрийн идэвхгүй байдалд нөлөөлдөг гол хүчин зүйл нь мөн л эдийн засгийн нөхцөл, амьжиргааны түвшний доройтол зэргээсээ үүдэн төр, улс төрийн нам, улс төрчдөд итгэх итгэл алдарсан байдагтай шууд холбоотой. (Улс төрийн барометр. Сант Марал судалгааны төв. УБ., 2009, Нийгэм, улс төрийн цаг үеийн судалгаа. НАХүрээлэн. УБ., 2013 оноос хойшхи)

Сонгуулийн кампанийн үеэр сонгогчдын улс төрийн төлөв байдалд дараах хүчин зүйлүүд хүчтэй нөлөө үзүүлдэг. Үүнд:

- Нам, Нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр
- Сонгуулийн сурталчилгаа, түүний хэлбэрүүд
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн нөлөө, ОНХ коммуникаци
- Намуудын нэр хүнд, нэр дэвшигчийн намын харьяалал
- Намаас нэр дэвшсэн нэр дэвшигчийн боловсрол, ажлын туршлага, нас, хүйс, угсаа гарвал
- Нэр дэвшигчийн бэл бэнчин гэх мэт.

Сонгогчдын хувьд дээрх хүчин зүйлсийн нөлөөлөлд автах магадлал өндөр байдаг нь нийгмийн эдийн засгийн хөгжлийн суурь асуудлуудтай холбоотой хэдий ч ардчилал, тэр дундаа оролцооны ардчилал бидэнд ийм боломжийг олгож буй хэрэг юм. Тиймээс иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, оролцоот ардчиллыг хөгжүүлэхэд дараах алхамуудыг хийх чухал ач холбогдолтой гэж дүгнэж болно. Үүнд:

- Иргэдийн улс төрийн оролцоо бол ардчилал, иргэний нийгмийн толь болдог тул Үндсэн хуулийн хэрэгжилтийг хангах, иргэдийн нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх
- Нийгмийн өмнө тулгамдаж буй нийтлэг асуудлуудыг шийдвэрлэх гарцыг зөв тодорхойлсон бодлого боловсруулж хэрэгжүүлэх. Энд улс төрийн намуудын чиглэсэн зорилготой бодлого, хөтөлбөрүүдийн өрсөлдөөн маш чухал болох нь тодорхой
- Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр орон нутаг, сум, хорооны тулгамдсан асуудлыг иргэд өөрсдөө хэлэлцэж шийдвэрлэдэг тогтолцоог бий болгох
- Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдал (улс төрчид, намууд, бизнесийн бүлгээс)-ыг хангах эрх зүйн орчинг сайжруулах
- Мэдээллийн үнэн бодит байдалд хөндлөнгийн хараат бус байгууллага мониторинг хийж, хянадаг болох

- Иргэдийн үзэл бодол, намын харьяаллаар ялгаварлан гадуурхахыг таслан зогсоох
- Хүний эрхийн үзэл санааг амьдралд хуулийн хүрээнд бодитойгоор тууштай хэрэгжүүлэх зэргийг дурьдаж болно.

Сонгогчдын үйл байдлын хувьслын нэг шинэ хандлага бол нийгэмд сонгогчдын 10-15 хувийг бүрдүүлдэг “шинэ сонгогч” гэсэн бүлэг үүсэж буй явдал. Сонгогчдын энэ бүлэг улс төрийн эрхэмлэлийн хувьд хөдлөнгийн, тогтворгүй байдлаараа онцлог. Тэд насны хувьд залуу, мэдээлэл сайтай, үзэл сурталд үл итгэх хандлагатай, засгийн газар, нээлттэй улс төрд эерэг байр суурьтай, сонгууль, үр дүнд хэрэглэгчийн байр сууринаас ханддаг.

Нийгэм-эдийн засгийн өөрчлөлтийн үйл явц нийгмийн тэгш бус байдлын өсөлттэй холбогдож үр дүн нь улс төрийн сэтгэл зүйн олон янз байдлыг бий болгодог. “Намын адилсал” бие хүний нийгэмшлийн процесст бүрэлддэг тул эцэг эхийнхээ дэмждэг тодорхой нэг намыг хүндэтгэх үзэлтэй болж, тэр нь удаан хугацаагаар хадгалагддаг ба шинээр үүссэн улс төрийн намуудын тогтвортой бус байдал нь өөрийн тогтвортой сонгогчдыг бүрдүүлж чадахгүй байдалд хүргэдэг. (Шинэ нам, ХҮН, бусад нам, 36 нам бий) Энэ байдал сонгуулиас сонгуулийн хооронд оршин тогтдог олон жижиг намуудын байр суурь, үзэл баримтлалын тодорхой бус байдлаас үүдэн нэг намаас нөгөөд шилжин санал өгөгчдийн тоо өндөр болдог. Эдийн засгийн шинэтгэл, сонгуулийн үр дүнгийн хоорондын хамаарал хүчтэй байдаг ба шилжилтийн үеийн улс орнуудын сонгогчдын үйл байдал өнгөрсөн үе рүүгээ хандсан /ретроспектив/ биш, харин ч ирээдүйд тэдний амьдралыг бололцооны болгож чадах намыг сонгогчид дэмжих болсон. /Я.Фидрнукийн судалгаа “Electoral Studies, 2000, №19.p.215/

Өрнийн соёл иргэншлийн ололт, туршлагатай Монголын нүүдлийн соёл иргэншлийг холбох онолын бэлтгэл, үзэл баримтлалтай, Монгол улсыг ардчилал, зах зээлийн харилцааны жам, хуулиар хөгжүүлэн мандуулах чин зорилготой, олон түмний хүчин чармайлт, итгэл найдвар, дэмжлэгт тулгуурлан тэднийг нэгтгэн зохион байгуулах, цаг үеийн хандлага, шаардлага, хэтийн төлөвийг мэдэрч хувьсах, төр засгийг жолоодох харьцангуй мэдлэг туршлагатай, Монгол эх орныхоо тусгаар тогтнол, язгуур эрх ашиг, хөгжил, дэвшлийн төлөөх (Д.Истон, К.Дойч нарын улс төрийн системийн онолын сонгодог загвар-Г.Ц) улс төрийн хүчнүүдийн өрсөлдөөний гол шалгуур бол сонгууль байдаг.(М.Веберийн номлол-Г.Ц)

Сонгууль бол бүгд найрамдах байгууллын амин сүнс юм. Ардчилал ба сонгууль нэг зоосны хоёр тал бөгөөд чухамдаа сонгуулийн үр дүн болсон засгийн шинэ өндөрлөгүүдийн үр бүтээлтэй ажлын бүтээлч хэрэгжилт биелэлтээр ардчиллын чанар харагдана. Энэ нь нийгэмд хүн яаж амьдарч байгааг, цаашид яаж сайн сайхан амьдрах вэ? гэдгийг илтгэнэ гэсэн үг. Иргэд сонгогчид ихэвчлэн сонгуулийн үеэр дэвшигддэг мөрийн хөтөлбөр, амлалтууд бодит байдалтай хэрхэн нийцэж, хэрэгжих вэ? гэдгийг хүлээдэг.

Онолын талаар цөөн зүйлийг тэмдэглэн хэлье. Сонгогчдын улс төрийн үйл байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах хандлага анх 1948 онд Мичиганы их сургуулийн А.Кэмпбэлл, Ф.Конверс, В.Миллер, Д. Стокис нарын эрдэмтэд (Cambell,A, Converse,P,E, Miller,W,E, Stoke, D,E. The Amerikan voter. New York.,1960) удирдан нийт улс орныг хамарсан сонгуулийн судалгаа хийсэн нь АНУ-д үндэсний хэмжээний анхны судалгаа болж чадсан байна. 1960-аад оноос Өрнөдийн хэд хэдэн оронд том хэмжээний цуврал судалгаа явуулах болсон ба энэ үеэс хойшхи өнгөрсөн хугацаанд

судалгааны ихээхэн баримт, материал цугларсны зэрэгцээ судалгааны онол, арга зүй, аргачлал нь улам боловсронгуй болсоор ирсэн байна.

Улс төрд хандах иргэдийн үйл байдал, улс төрийн оролцоо, идэвхийн тухай судалгаа гол нь ардчилсан нийгэм, түүний институтууд үүргээ хэрхэн биелүүлж, иргэд тэдгээрийг юу гэж ойлгож, тэдгээрт хэрхэн хандаж буйг харуулдаг. Тиймээс сонгогчийн үйл байдлын судалгаа дараах асуултад хариулахаас эхэлдэг. Үүнд: Хүмүүс хэнийг сонгодог бэ?, Тэд яагаад сонгодог вэ?, Юуг хүсэж, бодож, тэд сонголт хийдэг вэ? гэсэн энгийн асуултууд юм. Сонгогчдын санал өгч сонголт хийх чадварын тухай асуудал псефологчдын (хүмүүс сонгуульд саналаа хэрхэн өгдөгийг судалдаг салбар-Г.Ц) анхаарлыг ямагт татсаар ирсэн асуудлын нэг юм.

Сонгогчдын үйл байдлын судалгаа олон жил хөгжихдөө социологийн, нийгэм-сэтгэл зүйн, рационал сонголтын (International Encyclopedia of Political Science IPSA,2012,p.738) гэсэн гурван гол хандлагаар явж иржээ.

1. Социологийн хандлага: (С.Липсет,С.Роккан, Ч.Э.Мерриам, Г.Ф.Госнем) нарын судлаачид сонгогчийн улс төрийн үйл байдлыг түүний харьяалагдаж буй нийгмийн бүлэг болон нийгэмд эзэлж буй байр суурийнх нь онцлогоор гаргаж ирэхэд анхаардаг. Сонгогчдын дунд санал асуулга авах замаар социологийн судалгаа явуулж тоон судалгаан дээр суурилан сонгогчдын санал өгөх сэдлийн харилцан хамаарлыг гаргах замаар шинжилгээ хийнэ гэсэн үг. Ингэхдээ нийгэм, нийгэм ангийн байдал /зүүн чигийн нам-ажилчин анга, баруун чигийн нам-дунд анги /шашин, үзэл суртал, нийгмийн хувьсагч хүчин зүйлүүд /хүйс,нас,ажил мэргэжил,боловсрол, нийгмийн гарал, арьс өнгө, намын харьяалал, орлого, амьжиргааны түвшин гэх мэт/-ийг суурь болгон ашигладаг. Сонгогчдын үйл байдлыг судлах социологийн арга, хандлага нь дотроо микро, макро гэсэн хоёр түвшинд хуваагддаг.

Үүнд:

а/ Микросоциологийн тайлбар: Сонгогчдын үйл байдал нь бүлгийн үйл байдал байдаг бөгөөд тухайн хүний хатуу тогтсон үйл байдлын хэв шинж нь түүний харьяалж буй бүлгийн шинж агуулгатай давхцаж байсныг тогтоосон. Нийгэм эдийн засгийн статус , шашин шүтлэг, оршин сууж буй хот, суурин газруудын хэмжээ зэрэг тодотголуудын тусламжтайгаар бүлгийн хамаарлыг тогтоох боломжтой аж. (анх Ф.Лазефельд, Пауль болон түүний шавь нар Колумбийн их сургуульд 1940 оны АНУ-д болсон ерөнхийлөгчийн сонгуулийн үеийн санаа бодол бүрэлдэх үйл явцын судалгааг хийсэн байна)

Микро түвшний арга хандлагын гол санаа нь тухайн сонгогчийн хамаарах бүлгийн сонгуулийн оролцооний хэм хэмжээ нь жигд болох тусам тус бүлэгт хамаарах сонгогчийн гаргасан шийдвэр бүлгийнхээсээ ялгарах магадлал бага байна. Хэрэв хоорондоо зөрчилтэй хүчин зүйлс нэмэгдэж бүлгийн доторх сонгогчдын байр суурь зөрөх үед тэдний улс төрийн шийдвэр гаргах байдал эрс ялгаатай болох магадлал ихэсдэг гэж үздэг байна / 2021 оны сонгуулийн үеийн АН-ын дотоод зөрчил, хагарал / Энд сонгогчийн улс төрд хандах хандлага, санал бодол төлөвших хийгээд сонгуульд оролцож санал өгөхөд социал хүрээний үзүүлэх нөлөө хүчтэй гэдгийг тэд гол болгодог юм.

б/ Макросоциологийн тайлбар: Энэ чиглэлийн тайлбар нь Европд XIX зуунаас эхэлсэн хүн амын тодорхой бүлэг болон улс төрийн намуудын урт хугацаанд тогтсон тогтвортой харилцаа холбооны илэрхийлэл болон гарч ирсэн байна. Улс орнууд дахь сонгуулийн хууль, улс төрийн институтуудийн

хоорондын ялгаанаас үл хамааран улс төрийн намууд өөр өөрийн сонгогчид дэмжигчидтэй байдаг нийгмийн баазтай холбоотой бий болсон. Өөрөөр хэлбэл, макро түвшний арга, хандлага нь төр, улс төрийн намуудын тогтвортой дэмжигчдийн хүрээ, өөрчлөлтийг тандахад чиглэдэг. Энд нийгэм дэх үнэт зүйлсийн эрхэмлэл (идеал-Г.Ц) намуудад өөрийгөө адилсуулах үйл явц зэрэг хамаардаг.

2. Нийгэм-сэтгэл зүйн хандлага: /1950-иад оны Америкийн ерөнхийлөгчийн сонгуулийн үед Мичиганы их сургуулийн хэсэг судлаачид (А.Кемпбелл,Ф.Конверс,В.Миллер, Д.Стоке,Ж.Еванс) нийт улс орныг хамарсан судалгаа хийж бие хүний сэтгэл зүйн хандлага нь сонгогчийн сонгуульд санал өгөх гол үндэс болохыг онцлоод сонгогчид руу хандсан улс төрийн бодлого болон сонгогчдын санаа бодлын тогтворгүй байдлын хоорондын асуудал дээр төвлөрч сонгогчдын сэтгэл зүйн тогтсон хандлага хийгээд ухамсарлагдаагүй харилцаа тэдний сонголт хийх шийдвэрт хэрхэн нөлөөлдөг болохыг тодруулахад чиглэдэг. Тухайлбал, сонгогчдын олонхи нь яагаад нэг нам руу хошуурч саналаа өгдөг вэ?, сонголт хийхэд цаг үеийн нөхцөл байдал, нийгмээс үзүүлж буй дарамт шахалт эсвэл дэмжлэг хүний сэтгэл зүйд хэрхэн нөлөөлдөг вэ? зэрэг асуултуудад хариулт өгөхөд чиглэдэг. Энэ хандлагын суурь нь улс төрийн нийгэмшилт, мөн улс төрийн нам, улс төрчдийг тууштай дэмжигчдийн идэвхтэй үйл ажиллагаа чухал нөлөө үзүүлдэг.

Хувь хүний сэтгэл зүйг голлосон үндэслэлд нэг талаас, хувь хүн, гэр бүл болон нийгмийн нийгэмшүүлэх бүтцүүдээр дамжуулан төлөвшсөн намын ижилслээр илэрхийлсэн улс төрийн санаа бодол бүрэлдэх үйл явцыг онцгойлон авч үздэг./МАХН ба МАН-ын 100 жилийн ой энэ онд тохиож байгаа /Нөгөөтэйгүүр,социологийн хандлагатай харьцуулахад сонгуулийн үед шийдвэр гаргах тухайн цаг үеийн аспектиг буюу нэр дэвшигчдэд өгөх үнэлгээ болон улс төрийн тулгамдсан маргаантай асуудлын талаарх байр суурийг тусгасан байдаг. / халз мэтгэлцээн, зочны ярилцлага гэх мэт/ Эдгээр харилцан адилгүй хүчин зүйлийг хослуулснаараа хувь хүний сэтгэл зүйг үндэс болгосон энэ загвар сонгуулийн шийдвэр гаргах цогц үйл явцыг онолын харьцангуй өндөр түвшинд тусгахад шаардлагатай нөхцлийг бүрдүүлсэн байдаг юм. / зүү бол төмөр, зүрх бол сэтгэл. Чингис хаан биеийг хураахаар сэтгэлийг хураа-Г.Ц /

3. Рационал сонголтын хандлагын шинжилгээ нь эдийн засгийн үр ашигтай, оновчтой байх онолоос гарч ирсэн. Сонгогчид улс төрийн нам, нэр дэвшигчдээс сонголт хийх эцсийн мөчид саналынхаа өөрт ирэх магадлалтай ашиг тус,үнэ цэнийг бодож сонголтоо хийдэгт оршино. Рационал сонголтын хандлага нь / А.Даун , Р.Далтон/ АНУ-ын А.Даунсын “Ардчиллын эдийн засгийн онол” бүтээлд тусгалаа олсон байдаг. (А.Downs, An Ekonomik theory of democracy. New York.,1957. Dalton.R. Citizen polimics: Pablic opinion and political parties in advanced industrial democracies. Washington.,2008)

Энэ арга хандлагаар сонгогч нь санал өгөхдөө үр ашгийн тооцоонд суурилдаг аж. Ингэхдээ тэрээр засгийн газрын өнөрсөн бүрэн эрхийн хугацааны үйл ажиллагаанд үнэлэлт өгч одоогийн сөрөг хүчин засгийн эрхэнд байсан бол юу хийж чадах байсан гэдэгт харьцуулж үздэг. Үүний үндсэн дээр тэрээр өөрийнх нь хувийн зорилтуудыг хамгийн түрүүнд хэрэгжүүлж чадна гэж үзсэн намын төлөө саналаа өгдөг. Ийнхүү сонгогчийн шийдвэр эцсийн бүлэгт улс төрийн тулгамдсан асуудал,эрх баригч болон сөрөг хүчний дүр төрх, инфляцийн түвшин, ажилгүйчүүдийн тоо, эдийн засгийн өсөлт

зэрэг үзүүлэлтээс хамаардаг. Өөрөөр хэлбэл, улс төрийн болон эдийн засгийн шийдвэрийг үндсэндээ ижил зарчмаар гаргадаг гэж үздэг. Энэ хандлагын нэг сул тал нь сонгогчид тухайн үеийнхээ ашгийг харснаас цаг хугацаагаар алслагдсан хүсээгүй зүйлийг тооцоогүй байж болох талтай гэж шүүмжлэх явдал байдаг.

Өнгөрсөн зууны 80-аад оны үеэс ардчилсан улс орнуудад иргэд сонгогчдын улс төрийн төлөв байдалд нэлээдгүй өөрчлөлт гарч ирснийг үгүйсгэх аргагүй юм. Сонгуулиас сонгуулийн хооронд намыг дэмжигчдийн тоо, хувь өөрчлөгдөх нь хэвийн үзэгдэл болж, улс төрийн нам ба иргэдийн хоорондын холбоо суларч буйг илтгэх идэвхгүй сонгогчдын “арми”-йг бий болгосон. Намыг тууштай дэмжигчдийн тоо цөөрөх үзэгдэл АНУ-д, Европт эхлэн ажиглагдсан бол өнөөдөр энэ хандлага ардчилсан дэглэмтэй улс орнуудыг түүний дотор Монголыг ч хамарсан үзэгдэл болж байна. Сонгогчдын оролцоо сонгуулиас сонгуульд буурсаар байна. Энэ нь чухамхүү сонгогчийн нийгэм-сэтгэл зүйн уур амьсгалтай холбоотой.

Ямартай ч “Барууны ардчилсан орнуудад боловсрогдсон” нийгмийн сэтгэл зүйн”, “эдийн засгийн санал өгөлтийн онол”, “социологи хандлага”-ын гурван онол нь Монголын нөхцөлд хэрэгжиж байгаа гэж дүгнэж болно.

2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар:

2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль First Past the Post буюу “бариад эхэлж орсон нь түрүүлэх” сонгуулийн зарчмаар явагдсан. Сонгуульд нэр дэвшин өрсөлдөгчдөөс сонгуульд оролцсон нийт сонгогчдын хамгийн их санал авсан нь сонгогддог буюу мажоритар сонгуулийн хувилбарыг хэлж байна. Энэ системээр сонгогчид намыг бус тодорхой нэр дэвшигчийг сонгодог.

Улс төрийн шинжлэх ухаанд ерөнхийлөгч (president) нь латин хэлний “praesident” хэмээх үгнээс гаралтай бөгөөд төрийн тэргүүн, удирдагч гэсэн утгатай Бүгд найрамдах улсын хамгийн өндөр албан тушаалыг хэлдэг. (<https://dictionary.cambridge.org/dictionary/english/president>)

“Төрийн тэргүүн гэдэг бол төрийн байгууллагын тогтолцоонд дээд байр суурь эзэлж буй албан тушаалтан буюу байгууллага мөн бөгөөд гадаад, дотоодод улс орныхоо төрийн дээд төлөөлөл болохын хамт улс үндэстний эв нэгдлийг хангагч болдог”(М.В.Баглая. Конституционное право зарубежных стран. М.,1999,с.251) гэдэг утгаар ойлгодог байна. Төрийн тэргүүний ерөнхийлөгчийн хэлбэр дэлхийн олонх улс оронд төлөвшин тогтсон хэдий ч ерөнхийлөгчийн төрийн тогтолцоонд эзлэх байр суурь, тухайн улсын Үндсэн хуульд заасан статус нь өөр өөрийн онцлогтой, олон янзын хувилбартай байдаг. Жишээ нь, зарим улс оронд ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, засгийн газрын тэргүүнийг хамтад нь гүйцэтгэдэг байхад зарим оронд ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байж гүйцэтгэх засаглалыг ерөнхий сайд толгойлдог байх юм. Мөн ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа ч улс орон бүрд харилцан адилгүй байна. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 4-6 жил байх жишиг ихэнх улс оронд тогтсон байна.

Судлаачид ерөнхийлөгч бүхий улс орнуудыг үндсэн хуульд заасан ерөнхийлөгчийн бүрэн эрхийн байдал, бусад өвөрмөц онцлогыг харгалзан үзэж ерөнхийлөгчийн, хагас ерөнхийлөгчийн, парламентын БНУ гэж ангиж үзэх жишиг тогтсон. (НҮБ-ын гишүүн 193 орны 130 орчим нь төрийн тогтолцоондоо ерөнхийлөгчтэй байна)

Бүх иргэдээс шууд, нууц саналаар сонгогддог ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд Монгол ардын намын нэр дэвшигч, ерөнхий сайд асан У.Хүрэлсүх 823,326 буюу 67.76 хувийн санал аван үнэмлэхүй ялалт байгуулж, Монгол улсын зургаа дахь ерөнхийлөгч боллоо. Тэрээр **бүх аймаг, нийслэлийн бүх дүүрэгт үнэмлэхүй ялалт байгуулсан**. Хөдөлмөрийн үндэсний намын нэр дэвшигч Д.Энхбат 20.03 хувийн санал авч удаалсан бол Ардчилсан намын нэр дэвшигч С.Эрдэнэ 5.99 хувийн санал авав.

2017 оны ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн хэнийг нь ч дугуйлаагүй цагаан сонголтын тоо 99494 (2012 оны МҮЕСТХ-д цагаан сонголтын талаар нэг заалт орсон ба 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулиас эхлэн огт тэмдэглэгээ хийгээгүй сонгогчдын саналыг хүчинтэйд тооцдог болсон нь сонгогчдын улс төрийн эрхийг хүндэтгэж байгаа, нөгөө талаас сонгогчид улс төрийн намууд, нэр дэвшигчдэд таалагдахгүй байгаагаа илэрхийлэх боломжтой болсон юм) байсан бол энэ удаагийн сонгуульд 71937 болсон байна. Энэ удаагийн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэлтэй 2,041,985 иргэнээс 1,216,246 буюу 59.35 хувь нь сонгуульдаа оролцжээ. 2017 оны сонгуульд нэрийн жагсаалтад бүртгэлтэй 2151329 иргэнээс сонгуульд саналаа өгсөн сонгогчдын тоо 1207787 байсан ба сонгуулийн ирц 68.27 хувь (хоёр дахь санал хураалтын ирц 60.67) байсан юм. 2017 оны сонгуулийн кампанид сөрөг сурталчилгаа, нийгмийн сэтгэл хөдлөлд чиглэсэн албан ба албан бус хэвлэл мэдээллийн хэрэгслийн тактикууд давамгайлж байсан бол энэ удаагийн ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөх сонгуулиудаас ялгарах нэг онцлог нь сонгогчдын дийлэнх нэр дэвшигчид тодорсон цагаас л сонголтоо хийчихсэн, саналаа хэнд өгөхөө шийдээгүй хөвөгч сонгогч маш бага байсан явдал юм. Судалгааны дүнгүүдээс харахад сонгуулийн бүхий л хугацааны туршид **хөвөгч** сонгогчид 6-7 хувь байсан нь өмнөх УИХ болон ерөнхийлөгчийн сонгуулиудтай харьцуулахад маш бага үзүүлэлт юм.

Насны бүлгээр авч үзвэл: 18-19 насны залуучууд 56,45%, 65-70-аас дээш насныхан 76,99% ирцтэй оролцсон бол 20-29 насны залуучууд сонгуульд хамгийн бага буюу 44% ирцтэй оролцжээ. Харин **эмэгтэйчүүд урьдын адил** эрэгтэйчүүдээс 7,23%-иар илүү оролцсон байна. Энэ удаагийн сонгуульд **гадаад оронд** байгаа 7394 сонгогчийн 76% буюу 5618 иргэн саналаа өгсөн байна. Харин 2017 онд 7209 сонгогчийн 66,3% буюу 4767 иргэн сонгуульд оролцож саналаа өгсөн байсан.

2021 оны ерөнхийлөгчийн сонгууль **монголын сонгуулийн түүхэн дэх хамгийн бага ирцтэй сонгууль болов.**(2021. МУ-ын Сонгуулийн ерөнхий хороо) Энэ нь судлаачдаас сонгогчдын улс төрийн үйл байдлыг судлахдаа абсентизмын /сонгуульд санал өгөхөөс зайлсхийх үзэгдэл -Г.Ц / учир шалтгааныг тодруулахыг илүү анхаарахыг шаардах болсон. Тухайлбал, сонгуулийн эрх зүйн орчинд нэмэлт өөрчлөлт оруулах, сонгуулийн хууль тогтоомжид урьдчилан санал өгөх, шуудангаар санал өгөх зэрэг хэлбэрүүдийг нэмж боловсронгуй болгох, ерөнхийлөгчийн сонгуулийн үед шилжилт хөдөлгөөн хийхгүйгээр байгаа газраа саналаа өгөх боломжийг сонгогчдод олгох. Мөн сонгогчид тэр дундаа залуучуудад зориулсан сонгуулийн ач холбогдол, сонголт хийхийн давуу тал, үр өгөөж, сонгууль өгөх заавар, зөвлөмж зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгслийн төрөл бүрийн сувгийг ашиглан түгээдэг байх хэрэгцээ шаардлага тавигдаж байна.

Эцэст нь тэмдэглэхэд шинээр сонгогдсон ерөнхийлөгч У.Хүрэлсүх тангараг өргөхдөө хэлсэн үгнээс ишлэвэл: “Миний бие энэхүү их итгэл найдварыг ард түмнийхээ язгуур эрх ашгийг эрхэмлэн дээдэлж, улс орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдлээ сахин хамгаалахын төлөө хичээн зүтгээрэй гэсэн манай ард түмний асар их захиа даалгавар, үүрэг хариуцлага хэмээн хүлээн авч байна” гэсэн билээ.

Дүгнэлт

- I. 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийг угтаж МАН МАХН-тай нэгдэх гэрээ байгуулсан нь Ерөнхийлөгчийн сонгуульд саналаа хуваахгүй байх улс төрийн стратеги болсон
- II. Нэр дэвшигч У.Хүрэлсүх таван жил орчим Ерөнхий сайд хийсэн. Энэ хугацаанд хийж хэрэгжүүлсэн олон том ажлуудаа үргэлжлүүлэх, дуусгах ажилд хүч өгөх, УИХ, Засгийн газартай хамтарч ажиллах зорилготойгоо сонгуулийн сурталчилгааны үеэр онцолж байсан нь монголчуудын сэтгэл зүйг татсан нэг үзүүлэлт болсон гэж дүгнэж болно.
- III. Цар тахлын энэ үед эрх баригч нам засаглалыг хэрэгжүүлж чадна гэсэн итгэл бас **хүлээлт** нийгмийн сэтгэл зүйд илүүтэй байсан./ ЗГын хэрэгжүүлсэн арга хэмжээ, шийдвэрүүд/
- IV. 2021 оны Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн тандалтын судалгаагаар (МЕС судалгааны төвөөс 2021оны 5 сарын 17-20 өдрүүдэд) судалгаанд оролцогчдын 44% нь У.Хүрэлсүхийг /МАН/, 3% нь С.Эрдэнийг/АН/, 10% нь Д.Энхбатыг /ХҮН/,8% орчим нь цагаан сонголт,35% нь сонголтоо хараахан хийж амжаагүй гэсэн судалгааны үр дүн гарсан байна. Иргэд ч тогтвортой байдлыг хүсч МАН-аас нэр дэвшигчийг дэмжих магадлал өндөр байсан.
- V. Гурван нэр дэвшигч нийслэлд хангалттай сайн танигдсан учир сөрөг пиар явагдах шаардлага байсангүй, тиймдээ ч өмнөх сонгуулиас ялгаатай нь сонгууль эерэг аядуу уур амьсгалд болж өнгөрсөн болно.
- VI. 2020 оны УИХ-ын сонгуульд МАН-аа үнэмлэхүй ялалтанд хүргэсэн Намын дарга асан У.Хүрэлсүх Ерөнхийлөгчийн энэ удаагийн сонгуульд илт давуутай ялалт байгуулсан нь эрх баригч МАН-ын байр суурийг улам бататгав
- VII. Монгол Улсын үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр /2019-4-14/ ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааг 6 жил болгож, зөвхөн нэг удаа сонгогдох эрхтэйг хуульчилсаны дараах анхны Ерөнхийлөгчийн сонгууль болсноороо онцлог юм.

Ном зүй

Монгол Улсын Үндсэн хууль.УБ., 1992. 2019/ шинэчилсэн найруулга/

2021. Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороо

Аристотель.Улс төр. УБ., 2006

М.Вебер. Улс төр мэргэшил мөн. УБ., 2002

Үндсэн хуулийн хайлбар толь.УБ.,2020

Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь.УБ.,2020

Монголын нийгмийн өөрчлөлт.УБ.,2012

Г.Цэнд-Аюуш. Улс төрийн ухамсар: Түүхэн судалгаа. УБ., 2021)

М.В.Баглая. Конституционное право зарубежных стран. М.,1999

Улс төрийн барометр. Сант Марал судалгааны төв. УБ., 2009,

Нийгэм, улс төрийн цаг үеийн судалгаа. НАХүрээлэн. УБ., 2013 оноос хойшхи)

Macpherson C.B. The Real World of Democracy Oxford University Press.1966)

International Encyclopedia of Political Science IPSA, 2012,

Campbell, A., Converse, P. E., Miller, W. E., Stokes, D. E. The American voter. New York., 1960

A. Downs, An Economic theory of democracy. New York., 1957.

Dalton, R. Citizen politics: Public opinion and political parties in advanced industrial democracies. Washington., 2008)

Electoral Studies, 2000, №19.

<https://dictionary.cambridge.org/dictionary/english/president>

**МОНГОЛ ДАХЬ УЛС ТӨРИЙН НАМЫН СОНГУУЛИЙН ОРОЛЦОО,
ҮР ДҮН
(УИХ-ын сонгуулийн жишээн дээр)**

Д.Түмэнжаргал

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар
Улс төрийн тэнхимийн ахлах багш, доктор

Г.Эрдэнэбаяр

МУИС, ШУС, Хүмүүнлэгийн ухааны салбар
Философи, шашин судлалын тэнхимийн дэд профессор

Хураангуй: Монгол улс 1992 онд ардчилсан Үндсэн хууль баталснаас хойш УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн гурван шатны сонгуулийг ардчилсан сонгуулийн зарчмаар тус тус 8 удаа явуулсан байна. Энэхүү хугацаан дахь ардчилсан сонгуулийн үр дүнг авч үзэхэд өөрчлөлт, алдаа, оноо аль аль нь байж түүнийхээ үрээр нилээдгүй туршлагад хуримтлуулж байна.

Ардчилсан сонгуулийг шударга явуулахад эрх зүйн зохицуулалт болон зохион байгуулалтын асуудал чухлаас гадна улс төрийн намын төлөвшил, бодлого, улс төрийн намын боловсон хүчний бодлого, дотоод ардчилал, үзэл баримтлал, чиг баримжаа зэрэг нь ихээхэн шалтгаалдаг. Ийм учраас ардчилсан сонгуулийн үр дүнг улс төрийн намтай холбон авч үзэх нь зайлшгүй чухал юм.

Монгол улсад болж өнгөрсөн сонгуулиудаас УИХ-ын сонгуулийн үр дүнг жишээ болгон авч үзэж улс төрийн намын сонгуульд оролцож ирсэн байдал, үр дүн, сонгуулийн тогтолцоо улс төрийн намд хэрхэн нөлөөлж байгаад тулгуурлан энэхүү өгүүллийг бичсэн болно.

Түлхүүр үг: ардчилсан сонгууль, сонгуулийн тогтолцоо, УИХ-ын сонгууль, улс төрийн нам, эвсэл, улс төрийн намын төлөвшил, нэр дэвшигчид.

Оршил

“Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн”¹ хэмээн Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгасан байдаг.

Монголын ардчиллын төлөвшил, хөгжил, ардчилсан сонгуулийн үр дүн зэрэг нь улс төрийн намын төлөвшилтэй салшгүй холбоотой асуудал юм. Мөн Монголын өнөөгийн ардчилсан сонгуулийг тойрсон элдэв булхай, луйвар, сонгуулийг зөв, шударга, ил тод, нээлттэй, өрсөлдөөний тэгш, шударга байдлыг ханган явуулахад сөргөөр нөлөөлж байгаа гол хүчин зүйлс нь улс төрийн нам болохын зэрэгцээ улс төрийн хямрал, зөрчилт байдлыг ч улс намуудтай холбон авч үзэх нь зүйтэй.

Нөгөө талаас нь авч үзвэл Монгол улсад хэрэгжиж байгаа ардчилсан сонгуулийг явуулж буй мажоритар тогтолцоо нь улс төрийн намуудыг төлөвшүүлэх, олон намын

¹ Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 1994 он.

тогтолцоог дэмжих, өрсөлдөөний тэгш, шударга, байдлыг хангах, намуудын хатуу төвлөрлийг сааруулах, дотоод ардчиллыг хангах, олон ургальч үзлийг дэмжих зэрэгт сөргөөр нөлөөлж байгаа гол хүчин зүйлс нь болж байна. Мөн түүнчлэн Монгол улсад улс төрийн тогтвортой байдлыг хангах, төрийн залгамж чанарыг бэхжүүлэх, ардчилсан шударга сонгуулийн зарчмаар чанартай Парламентыг бий болгохын тул зэрэгт улс төрийн нам төлөвшил, дотоод ардчилал, нам, эвслүүдийн боловсон хүчний бодлого, дотоод хүний нөөц, сонгуульд нэр дэвшүүлэх сонгон шалгаруулалт гэх мэт асуудлууд ч ихээхэн сөргөөр нөлөөлж байна.

Энэ бүгдээс харахад сонгууль: сонгуулийн тогтолцоо, улс төрийн нам хоёр нь зайлшгүй харилцан хамааралтай нэг зоосны хоёр тал гэж ойлгож болох юм. Ийм учраас энэхүү сэдвийг өргөн хүрээнд болон нарийвчлан цаашид судлан шинжлэх, нарийн учир шалтгааныг тодруулж үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид анхаарах асуудлуудыг дэвшүүлэх нь судлаачдын судлах шаардлагатай тулгамдсан асуудлыг нэг байсаар байна. Улс төрийн нам болон сонгуулийг тойрсон олон асуудлууд байдаг. Энэ сэдвийн хүрээнд улс төрийн намын сонгуульд оролцсон байдал, сонгуулийн систем улс төрийн намд хэрхэн нөлөөлж байгаа талаар түлхүү авч үзсэн болно.

1. Улс төрийн намын сонгуулийн оролцооны өнөөгийн байдал

Монгол улс улс төрийн намын эрх зүйн байдлыг Монгол Улсын Үндсэн Хууль, Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн тухай хуулиудаар тодорхой зохицуулсан байдаг. Монголын улс төрийн намуудын тухай хууль анх 1990 оны 05-р сард Ардын Их Хурлын баталснаар шинээр улс төрийн намууд байгуулах эрх зүйн орчин бүрдсэн юм. Энэ цагаас хойш эдүгээ 30 гаруй улс төрийн нам байгуулагдсан ч улс төрийн өрсөлдөөний дунд нэгдэн нийлэх болон задрах үйл явцтай байна. Улс төрийн намын тухай хуульд 1991, 1996, 2005 оны 02-р сарын 17-ний өдөр, 2015 оны 11-р сарын 26-ний өдөр, 2015 оны 01-р сарын 29-ний өдөр, 2015 оны 12-р сарын 04-ний өдөр, 2018 оны 06-р сарын 21-ний өдөр, 2020 оны 05-р сарын 07-ны өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан.


Харин сонгуулийн хуульд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль 1992 оны 04-р сарын 04-ний өдөр, 2005 оны 12-р сарын 29-ний өдөр, 2008 оны 12-р сарын 19-ний өдөр, 2011 оны 12-р сарын 25-ны өдөр, 2015 оны 12-р сарын 25-ны өдөр тус тус шинэчлэн батлагдсан. Мөн 1996 оны 01-р сарын, 2006 оны 06 сарын 16-ны өдөр нэмэлт өөрчлөлт, 2007 оны 12-р сарын 26-ны өдөр, 2012 оны 11-р сарын 01-ний өдөр, 2015 оны 11-р сарын 26-ны өдөр, 2016 оны 05-р сарын 05-ны өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан². Мөн өнөөгийн байдлаар Сонгуулийн тухай хуулийг 2019 оны 12-р сарын 20-ны өдөр тус тусдаа бие даасан УИХ-ын, Ерөнхийлөгчийн, Орон нутгийн сонгуулийн хуулийн шинэчилэн боловсруулж баталгаажуулан мөрдөж байна. Энэ мэтчилэн Улс төрийн намын тухай хууль болон Монгол улсын сонгуулийн тухай хуулиудад тус тус өөрчилсөн байна.

² <https://www.gec.gov.mn/> Сонгуулийн Ерөнхий Хороо

Хүснэгт №1. УИХ-ын сонгуульд улс төрийн нам, эвслийн ялалт байгуулж авсан суудлын тоо (УИХ-ын сонгууль 1992-2020 он)

	Сонгуулийн жилүүд	Сонгуульд нэр дэвшигчдийн тоо	Мандатын тоо	МАХН (МАН)	Эвсэл	МоАН	АН	МАХН	МСДН	МҮДН	БНН	МУНН	90Ni	Эх орон МАШСН	Бие даагч	Үүнээс: эмэгтэй нэр дэвшигчид
1	1986.06.22	370	370	370	-		-		-	-	-	-			-	-
2	1990.07.29	2413	430	357	-	16	-	-	4	6	-	-	-		39	9
3	1992.06.28	293	76	70	4 МоАН МҮДН, НН ЭВСЭЛ	-	-	-	1	-	-	-	-		1	3
4	1996.06.30	302	76	25	50 АХ ЭВСЭЛ	-	-	-	-	-	-	1	-		-	7
5	2000.07.02	602	76	72	1 МУАН- МСДН АХ ЭВСЭЛ	-	-	-	-	-	-	-	1	1	1	8
6	2004.06.27	244	76	37	35 Эх орон ардчилал эвсэл	-	-	-	-	-	1	-	-		1	5
7	2008.06.29	356	76	44	1 Иргэний эвсэл	29	-	-	-	-	-	-	1		1	3
8	2012.06.28	544	76	26	11 МАХН МУАН ШЁЭВСЭЛ 2 ИЗ-НН	34	-	-	-	-	-	-	-		3	11
9	2016.06.29	498	76	65	-	-	9	1	-	-	-	-	-		1	1
10	2020.06.24	606	29	62	Та бидний эвсэл (МАХН- ИЗНН- МУАН)- 1, “Зөв хүн электорат ” эвслээс – 1		11								1	13

График №1. Сонгуульд ялалт байгуулсан намуудын жагсаалт
(УИХ-ын сонгуульд авсан суудлын тоогоор 1992-2020 он)



Монгол УИХ-ын сонгуулиуд буюу 1992-2020 оны нийтдээ 8 удаагийн сонгуулиар ялалт байгуулсан намуудыг дангаар нь авч үзэхэд 1992 оны УИХ-ын сонгуулиар МАХН буюу одоогийн МАН ялалт байгуулж 70 суудал, МСДН ялалт байгуулж 1 суудал, нийтдээ 2 нам ялалт байгуулж 71 суудал авсан. 1996 оны УИХ-ын сонгуульд МАХН буюу одоогийн МАН ялалт байгуулж 25 суудал, МУНН ялалт байгуулж 1 суудал, нийт 2 нам 26 суудал авсан.

1992 онд батлагдсан УИХ-ын сонгуулийн хуулийн дагуу төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллага болох Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх үйл ажиллагаа олон мандаттай (мажоритар), томсгосон тойргоор явагдсан. Энэ сонгуулиар 8 нам, МоАН-МҮДН-НН-ын болон МШАН-МАН-ын 2 эвсэл сонгуульд өрсөлдөн, нам эвслээс 275 нэр дэвшигч, бие даан 18 нэр дэвшигч өрсөлдөж нийт нэр дэвшигчдийн тоо 293-д хүрсэн. Энэ нь Монголын улс төрийн амьдралд болон ард түмний хувьд улс төрийн цоо шинэ үзэгдэл болсоноороо онцлог байв. УИХ-ын сонгуульд нэр дэвшигч бүр өөр өөрсдийн мөрийн хөтөлбөрийг боловсруулж сурталчилсан нь Улсын Их Хурлын сонгуулийг олон намын оролцоотой, ажил хэрэгч, өрсөлдөөнтэй явуулах боломж олгосон. Мөн түүнчлэн нийт сонгогчдын 95,6 хувь нь идэвхитэй оролцсоноороо анхны ардчилсан, чөлөөт сонгууль чухал ач холбогдолтой.

1996 оны сонгуулийн үр дүнд МАХН-наас 25, МҮАН, МСДН "Ардчилсан холбоо" эвслээс 50, МУНН-аас 1 нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүнээр тус тус сонгогдож байсан. МҮАН, МСДН "Ардчилсан холбоо" эвслээс олонхийн суудал авсан нь төрийн эрх мэдэл анх удаа улс төрийн шинэ залуу хүчинд шилжсэнээрээ онцлог үйл явдал болсон. Монголын Ардчилсан Холбоо, ардчилсан намуудын эвсэл тус улсын эдийн засаг болон улс төрд шинэчлэлт, өөрчлөлтийг гүйцэтгэх шинэ хөтөлбөр боловсруулж оролцсоны үр дүнд сонгуульд онцгой ялалт байгуулсан хэмээн судлаачид үздэг³. Олон жил төр барьсан, туршлагатай улс төрийн том хүчин болох МАХН (Одоогийн МАН) анх удаа цөөнх болж Засгийн эрх барих нам, хүчний байр суурьт эргэлт болсон билээ.

2000 оны УИХ-ын сонгуулиар МАХН (МАН) ялалт байгуулж 72 суудал, ИЗНН ялалт байгуулж 1 суудал, Эх орон МАШСН ялалт байгуулж 1 суудал тус тус авч нийтдээ 3 нм 74 суудал авсан байна. 2000 оны УИХ-ын сонгууль нь нам эвслээс хамгийн олон нэр дэвшигч өрсөлдсөнөөрөө онцлог сонгуулийн жил байсан. Тухайлбал: улс төрийн 13 нам дангаараа 575 нэр дэвшигчид, 3 эвсэл, 27 нь бие даан

³ http://www.khukhhot.mfa.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=36:2010-02-05-03-06-49&catid=8:2010-02-05-02-22-18&Itemid=16&lang=mn

нэр дэвшигч өрсөлдөж нийт нэр дэвшигчдийн тоо 602-т хүрсэн. 2000 оны УИХ-ын сонгуулиар МАХН 76 суудлын 72 суудлыг авч ахин төрийн эрхийг барих болсоноороо онцлогтой. Сонгуулийн явцад иргэдийг хуурах, амлах, зальдах явдал ихээр ажиглагдаж, сонгуулийн тогтолцооны гажуудлыг улам тод харуулж сонгогчдын итгэлийг алдсан гэж Монголын судлаачид үздэг.⁴ 2000 оны УИХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн тоог 1996 оны УИХ-ын сонгуультай харьцуулахад хоёр дахин илүү байснаараа онцлог юм⁵.

2004 оны УИХ-ын сонгуулиар МАХН (МАН) ялалт байгуулж 37 суудал, БНН ялалт байгуулж 1 суудал, нийт 2 нам ялалт байгуулж 38 суудал авсан. Энэ удаагийн УИХ-ын сонгуулиар УИХ-ын гишүүнд улс төрийн 7 нам дангаараа, 3 нам эвсэл болж оролцсон. Үүнээс нам эвслийн 229 нэр дэвшигч, бие даан 15 нэр дэвшигчид сонгуульд оролцож, сонгуулийн саналын хуудсанд нийт 244 нэр дэвшигчдийн нэр бичигдэж санал хураалтад орсон нь 2000 оныхоос бараг гурав дахин бага байсан. Мөн 2004 оны дөрөв дэх удаагийн сонгуулийн бас нэг онцлог бол Ардчилсан нам 2000 оны сонгуулийн дүнд дүгнэлт хийж хүчээ нэгтгэж чадсанаар энэ удаад амжилтанд хүрсэн гэж судлаачид дүгнэн үздэг.

2004 оны сонгуулийн онцлог нь нийт сонгогчдын 82,2 хувь санал өгч сонгуулийн дүн гарахад Ардчилсан хүчин болон МАХН хоёр тэгш тооны санал авсан. Энэ нь түүхэндээ анх удаа Их Эвслийн Засгийн газар байгуулсан улс төрийн хоёр том хүчин тэнцсэн үйл явдал болсон⁶. Мөн 2004 оны УИХ-ын сонгуулиар улс төрийн томоохон хүчнүүд тэнцүү шахам төлөөлөлтэй сонгогдож УИХ-ын олонх цөөнхгүй өвөрмөц парламент бүрдсэн нь “Зөвшилцөл” гэдэг ухагдахууныг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх шинэ боломж нээж өгсөнөөрөө онцлогтой.

2008 оны УИХ-ын сонгуулиар МАХН (МАН) ялалт байгуулж 44 суудал, АН ялалт байгуулж 29 суудал, ИЗН ялалт байгуулж 1 суудал тус тус авсан. Нийт 3 нам ялалт байгуулж 74 суудал авсан. 2008 оны Улсын Их Хурал нэг нам давамгайлснаас гадна, хүчтэй сөрөг хүчинтэй болсноороо онцлог сонгууль байсан. Ард түмэн ачааны хүндийг МАХН-д үүрүүлж, хянах, ажиглагчийн үүргийг АН-д хүлээлгэсэн гэж хэлж болохоор байсан.

Харин 2012 оны УИХ-ын сонгуулиар МАН буюу хуучнаар (МАХН) ялалт байгуулж 26 суудал, АН ялалт байгуулж 34 суудал, ИЗНН ялалт байгуулж 2 суудал тус тус авсан бөгөөд нийтдээ 3 нам оролцож 62 суудал авсан байна. 2012 оны Улсын Их Хурлын сонгууль нь УИХ-ын сонгуулийн шинэ хуулийн дагуу анх удаа холимог тогтолцоогоор явагдаж, аль ч нам олонхи болж чадаагүй бөгөөд хамгийн олон суудал авсан Ардчилсан Нам Шударга ёс эвсэл, ИЗНН-тай хамтран эвслийн (шийдэл, шинэчлэлийн) Засгийн газар байгуулан ажилласнаараа онцлог байсан.⁷ Энэ Засгийн газар нэг удаа солигдсон. 2014 оны 11-р сарын 05-ний өдөр УИХ-ын гишүүдийн 54 хувийн саналаар Н.Алтанхуягийн Шинэчлэлийн Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорсон. Гэхдээ Н.Алтанхуяг нь Ардчилсан намын түүхэнд хамгийн удаан хугацаагаар буюу 819 өдөр Ерөнхий сайдаар ажилласан хүн юм. Дараа 2014 оны 11-р сарын 21-ны өдрийн УИХ-ын хуралдаанаар албан ёсоор Ч.Сайханбилэг Монгол улсын 28 дахь Ерөнхий сайдаар томилогдон Шийдлийн Засгийн газар байгуулж ажилласан байна.

2016 оны УИХ-ын сонгуулиар МАН буюу хуучнаар (МАХН) ялалт байгуулж 65 суудал, АН ялалт байгуулж 9 суудал, МАХН ялалт байгуулж 1 суудал авч нийтдээ 3

⁴ <http://baabar.niitlech.mn/content/1629.shtml>

⁵ СЕХ. Монгол Улсын Их Хурлын сонгуулиудын дүн. УБ., 2013

⁶ СЕХ. “Ардчилсан төрийн сонгуулийн товчоон”. УБ., 2005 он

⁷ http://www.khukhhot.mfa.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=36:2010-02-05-03-06-49&catid=8:2010-02-05-02-22-18&Itemid=16&lang=mn

нам 75 суудал авчээ. Энэ сонгуульд нийт 477 нэр дэвшигч бүртгүүлсэн. Нийт 76 тойрогт нам, эвслийн жагсаалтаар 416 нэр дэвшигч бүртгүүлэхээр материалаа ирүүлснээс 9 нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан. Монгол улсын 29 дэхь Ерөнхий сайдаар МАН-аас Ж.Эрдэнэбат томилогдон Мэргэжлийн Засгийн газар байгуулан 2017 оны хүртэл ажилласан. Үүний дараа 2017-2021 он хүртэл У.Хүрэлсүх Засгийн газрын тэргүүнээр ажилласан. Энэ удаагийн УИХ-ын сонгуульд 69 бие даан нэр дэвшигч, 100 эмэгтэй нэр дэвшигч өрсөлдсөнөөрөө онцлог байсан. Мөн түүнчлэн УИХ-ын гишүүдээс эрэгтэй 63, эмэгтэй 13 гишүүн байгаа нь нийт улс төрийн нам, эвсэл хуулиар зааж өгсөн 20 хувийн жендерийн (хүйс)-ийн квотыг мөрдсөн бөгөөд нэр дэвшигчдийн 26 хувь нь эмэгтэйчүүд байна.

Дээрх үр дүнгээс харахад Монголд ардчилсан сонгууль хэрэгжиж олон ургальч үзэл дэлгэрч улс төрийн олон намууд сонгуульд өрсөлдөж ялалт байгуулж иржээ. Энэ нь ардчилсан сонгуулийн нэг онцлог бөгөөд ихээхэн ололт амжилтын нэг юм. Мөн 2016 оны сонгуулийн бас нэг онцлог нь эдийн засагч, эрх зүйч, улс төрч, инженер, сэтгүүлч зэрэг мэргэжлийн нэр дэвшигчид өрсөлдсөнөөс гадна жүжигчин, дуучин, зохиолч, яруу найрагч гэх мэт бусад төрөл бүрийн салбар, мэргэжлийн хүмүүс өрсөлдсөж байснаараа онцлог байв. Эдгээрээс 1 бие даан нэр дэвшигч буюу дуучин С.Жавхлан анх удаа ялалт байгуулж УИХ-ын гишүүнд сонгогдсон нь бас нэг онцлог нь юм.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд улс төрийн 13 нам, 4 эвсэл оролцохоо илэрхийлсэн. УИХ-ын сонгуульд нийт 606 хүнийг бүртгэж нэр дэвшигч бүртгүүлж үнэмлэх авсанаас 19.9 хувь нь буюу 121 нь бие даан нэр дэвшигч, 24.9 хувь нь буюу 151 нь эмэгтэй нэр дэвшигч байсан. Үүнд: Монгол Ардын Нам - 76, Ардчилсан Нам - 76, Монголын Ногоон Нам - 15, Та бидний эвсэл - 74, ШИНЭ эвсэл - 72, Зөв хүн электорат эвсэл - 53, Ард Түмний Нам, Эх Орончдын Нэгдсэн Нам, Ард Түмнээ Хайрлая Нам, Их Эв Нам тус бүр 1, Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам - 13, Хөгжлийн Хөтөлбөр Нам - 7, Сахигтун! Үндсэн хуулийн 19 эвсэл - 34, Зон Олны Нам - 30, Дэлхийн Монголчууд Нам - 3, Ард Түмний Олонхийн Засаглал Нам - 24, Гэр Хороолол Хөгжлийн Нам - 4 хүн нэр дэвшүүлж сонгуульд оролцлоо. 2020 оны УИХ-ын сонгуульд нийт Сонгуулийн дүнгээр Монгол Ардын Намаас - 62, Ардчилсан Намаас - 11, “Та бидний эвсэл”-ээс /МАХН-ИЗНН-МҮАН/ - 1, “Зөв хүн электорат” эвслээс - 1, бие даан нэр дэвшигч - 1 хүн тус тус Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон.

2020 оны УИХ-ын сонгууль нь дэлхий нийтийг хамарсан цар тахал (корона вирус) –ын үед болсноороо, сонгуулийн шинэ эрх зүйн зохицуулалтын хүрээнд болсноороо, хамгийн олон нэр дэвшигчид өрсөлдсөнөөрөө, олон намууд эвсэл болж оролцсоноороо, мөн хамгийн олон бие даан нэр дэвшигчид өрсөлдсөнөөрөө, сонгогчдын идэвхи оролцоо хамгийн өндөр байснаараа, залуу сонгогчид илүү идэвхитэй байснаараа зэрэг олон онцлогууд ажиглагдаж байв. Мөн 2020 оны 07-р сарын 02-ны өдрийн УИХ-ын Анхдугаар чуулганы хуралдаанаар У.Хүрэлсүхийг дахин улираан Монгол Улсын Ерөнхий Сайдад 98.5 хувийн саналаар томилсон юм. Энэ удаагийн Засгийн газрын онцлог нь 2019 оны 11-р сарын 14-ний өдрийн Үндсэн хуулийн шинэ өөрчлөлтийн хүрээнд эмхлэн байгуулагдсанаараа онцлог байсан. 2021 оны 01-р сарын 21-ны өдөр МУ-ын Ерөнхий Сайд У.Хүрэлсүх Монгол улсын түүхэнд анх удаа өөрийн хүсэлтээр огцрох өргөгдлөө өгөн УИХ-ийн гишүүд энэхүү саналыг 95 хувийн саналаар огцруулсан билээ. Үүний дараа буюу 2021 оны 01-р сарын 25-ны өдөр УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэнийг Засгийн газар тэргүүнээр сонгон ажиллуулсан.

График №2. Засгийн газрын байгуулж ажилласан Ерөнхий сайдуудын тоо
(УИХ-ын сонгууль 1992-2020 он)⁸



2016, 2020 оны УИХ-ын сонгуулиар МАН дангаараа ялалт байгуулж төрийн эрх барьж байх хугацаандаа Засгийн газраа тэргүүнээ 4 удаа сольсон юм. Энэ нь нэг талаас нь харвал улс төрийн тоглолт, эрх мэдэл, албан тушаалын өрсөлдөөн, нөгөө талаас нь харвал улс төрийн намын төлөвшил сул, дотоод ардчилалгүй байгаатай холбоотой бөгөөд төрийн залгамж чанарыг алдагдуулах сөрөг үр дагавартай.

Сүүлийн сонгуулийн жилүүдэд хуулийн хувьд хүчин төгөлдөр улс төрийн намуудаас иргэдийн улс төрийн сонирхлыг төлөөлөн уламжилж, багцлан, хэрэгжүүлж чадахуйц, олон ургальч үзлийг илэрхийлсэн нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн намууд цөөн байна.

Хүснэгт №2. УИХ-д олонхи болж, Засгийн газрыг дангаараа бүрдүүлсэн нам, эвслийн сонгуульд авсан санал, парламентад эзэлсэн суудлын хувийн харьцуулалт
(УИХ-ын сонгууль 1992-2020 он)⁹

Сонгууль болсон он	Оролцсон нам эвслийн нэр (тоо)	Авсан суудлын тоо	Нийт тойргийн хэмжээ
1992	- МСДН - Бие даагч - МоАН, МүДН, НН - МАХН (одоогийн МАН)	1 1 4 70	26
1996	- МУНН - МАХН (одоогийн МАН) - АХ эвсэл	1 25 50	76
2000	- ИЗ-НН эвсэл - Эх орон МАШСН - Бие даагч - АХ эвсэл - МАХН (одоогийн МАН)	1 1 1 1 72	76
2004	- Бие даагч - МАХН (одоогийн МАН) - АН, ИЗН, МАШСН- “Эх орон-Ардчилал” эвсэл	3 35 38	76


⁸ Парламентын институтын улс төр, эрх зүйн шинжилгээ сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ., 2018 он

⁹ Сонгуулийн Ерөнхий Хороо. УБ., 2016 он.

2008	• Бие даагч • АН • ИЗН • ИЭН • МАХН (одоогийн МАН)	1 28 1 1 45	26
2012	• АН • МАН (хуучнаар МАХН) • МАХН-МҮАН шударга ёс эвсэл • ИЗН, Ногоон нам • Бие даагч	33 26 12 2 3	26
2016	• МАН (хуучнаар МАХН) • АН • МАХН • Бие даагч	65 9 1 1	76
2020	• МАН • АН • “Та бидний эвсэл” (МАХН-ИЗНН-МҮАН) • “Зөв хүн электорат” эвсэл • Бие даагч	62 11 1 1 1	76

Монгол улсад явагдсан парламентын 7 удаагийн сонгуулийн үр дүнд нэг намын олонхийн танхим 4 удаа (1992, 2000, 2016, 2020), эвслийн танхим 5 удаа (1990, 1996, 2004, 2008, 2012 он) бүрэлдсэн байна. Монгол улсын 2012 оны Засгийн газрын танхимыг “хамгийн олон намуудын эвсэл”-ийн хэв шинжид багтаан үзэж болно. Харин 2016, 2020 оны Засгийн газрын танхимыг “нэг намын олонхийн” хэв шинжид хамруулан үзэж болно. Эвслийн энэ хэв шинжийг судлаач Майкл Лейсерсон “хэлэлцэн тохиролцох”-д суурилсан эвсэл гэж нэрлэсэн¹⁰.

График №3. Сонгуульд ялалт байгуулсан эвслүүдийн жагсаалт
(УИХ-ын сонгуульд авсан суудлын тоогоор 1992-2020 он)



Дээрх графикаас харахад Монгол улсад болж өнгөрсөн 1992 оноос 2020 он хүртэл нийт 8 удаагийн сонгуульд улс төрийн намууд хамтарч буюу эвсэл байгуулж сонгуульд өрсөлдсөнөөс эвслүүд нийт 7 суудал авч төрийн эрхийг барьж байсан байна.

¹⁰Г.Чулуунбаатар, А.Жамбал, Д.Болд-Эрдэнэ. Сонгуулийн хэлбэрүүдийн үйлчлэл, үр дагаврын асуудал. Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик. Илтгэлийн эмхтгэл. УБ., 2009

1992 оны УИХ-ын сонгуульд МоАН МҮДН, НН хамтарч оролцож 4 суудал авсан нь чамлахааргүй амжилт юм. Харин суудлын тоогоор авч үзвэл 1996 оны УИХ-ын сонгуулиар нэг эвсэл ялалт байгуулсан. Өөрөөр хэлбэл УИХ-ын нийт 7 удаагийн сонгуулиудаас 1996 оны сонгуулиар “Ардчилсан холбоо” эвсэл УИХ-д 50 суудал авч ялалт байгуулж Монгол улсад анх удаа "Ардчилсан холбоо" эвсэл ялалт байгуулж засгийн газрын эрх ардчилсан сонгуулийн зарчмаар, тайван энхийн замаар нэг улс төрийн хүчнээс нөгөө улс төрийн хүчинд шилжсэнээрээ онцлогтой.

1996 оны сонгуулиар сонгогдсон парламентын үед байгуулагдсан Засгийн газрыг огцруулах тухай хоёр удаа санал гарч, 1997 онд УИХ дахь МАХН-ын (одоогийн МАН) бүлгийн 24 гишүүний гаргасан саналыг УИХ хэлэлцэн олонхийн саналаар М.Энхсайханы Засгийн газарт итгэл хүлээлгэж байжээ. Харин 1998 онд энэ Засгийн газрыг эргээд огцруулж байсан нь нэг талаас Монголын төрийн түүхэн дэх ардчилсан засаглалын тогтолцооны хариуцлагын нэг хэлбэр болж тогтсоноороо онцлог байсан. Энэ УИХ шинээр 173 хууль баталж, давхардсан тоогоор 255 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.¹¹


2000 оны УИХ-ын сонгуульд МҮАН МСДН, АХ эвсэл ялалт байгуулж ганцхан суудал авч байсан нь олон намууд эвсэж сонгуульд оролцсон гэхэд амжилт муутай байв. Мөн түүнчлэн 2004 оны УИХ-ын сонгуульд ганцхан Эх орон-Ардчилал эвсэл ялалт байгуулж 35 суудал авсан нь суудлын тоо болоод чанарын хувьд ихээхэн өндөр үзүүлэлт, амжилттай сонгуульд оролцсон нь харагдаж байна. 2012 оны УИХ-ын сонгуульд ганцхан МАХН-МҮАН-Шударга ёс эвсэл ялалт байгуулж 11 суудал тус тус авч байсан нь мөн тэдний хувьд чамлахааргүй амжилт байсан юм. Харин 2016 оны УИХ-ын сонгуулиар 3 эвсэл оролцож өрсөлдсөн боловч нэг нь ч ялалт байгуулж чадаагүй юм. 2020 оны УИХ-ын сонгуулиар улс төрийн 13 нам, 4 эвсэл сонгуульд оролцохоор бүртгүүлсэн. УИХ-ын сонгуульд нийт 606 нэр дэвшигч оролцсон. Үүнээс Та бидний эвсэл - 74, ШИНЭ эвсэл - 72, Зөв хүн электорат эвсэл – 53 хүний нэр дэвшүүлж тус тус сонгуульд оролцсон. Энэ удаагийн сонгуулиар “Та бидний эвсэл”-ээс /МАХН-ИЗНН-МҮАН/ - 1, “Зөв хүн электорат” эвслээс – 1 нэр дэвшигч ялалт байгуулсан буюу нийт хоёр эвслээс хоёр нэр дэвшигч ялалт байгуулсан байна.

Дээрх байдлаас харахад 1992 оноос хойших УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулиудын дүнгээс ажиглахад нэг талаас нь харвал Монгол улс олон намын тогтолцоотой, сонголт хийх боломжоор бүрэн хангагдсан улс болох нь харагдаж байна гэж үзэх үндэслэлтэй 5 удаад нь ямар нэг хэмжээгээр олон болон цөөн намууд хоорондоо эвсэн сонгуульд оролцсон байна. Монголын улс төрийн намууд хоорондоо эвсэж байгаа нь сонгогчдод сонгох альтернатив боломжийг олгох, намууд төлөвших, олон намын төлөөллийг хангах, намуудын улс төрийн оролцоо нэмэгдэх зэрэгт эерэг талтай байж болох юм.

Харин нөгөө талаас нь харвал 8 удаагийн сонгуулийн 4 удаад нь нэг намын олонхи болсон түүхэн үр дүнг харж болно. Тодруулбал, 1992, 2000, 2016, 2020 оны УИХ-ын сонгуулиар нэг намын олонхи парламентыг бүрдүүлсэн билээ. Нэг нам дангаараа улс төрийн эрхийг барих нь улс төрийн намын төлөвшилд ихээхэн сөргөөр нөлөөлж олон намын тогтолцоотой улс орон гэж үзэхэд бэрхшээлийг дагуулж байна. Мөн түүнчлэн олон намын оролцоог хангах, олон ургальч үзлийг дэмжих, сонгогчдод сонголт хийх боломжоор хангахад саад бэрхшээл учруулж байна.

График №4. Сонгуульд оролцсон нийт нэр дэвшигчид
(УИХ-ын сонгууль 1992-2020 он)

¹¹ <http://www.ublifemn.n/s/4037>



Монгол УИХ-ын сонгуулиудын дүнгээс харахад 2000 оны УИХ-ын сонгуульд нийт 602 нэр дэвшигч буюу бусад бүх болж өнгөрсөн сонгуулиудаас хамгийн олон нэр дэвшигч өрсөлдсөнөөрөө онцлог байсан. Харин 2004 оны УИХ-ын сонгуульд хамгийн бага тооны нэр дэвшигчид буюу 244 нэр дэвшигч өрсөлдсөн байна. 2012 онд 544 нэр дэвшигч өрсөлдсөн бол, 2016 оны УИХ-ын сонгуульд 498 нэр дэвшигч өрсөлджээ. 2020 оны УИХ-ын сонгуулийн хамгийн олон буюу 606 нэр дэвшигч өрсөлдсөн. Энэ удаагийн сонгуульд улс төрийн нам, эвслүүд эвсэн, олон намаас олон нэр дэвшигчид өрсөлдсөн. Үүнээс 121 байсан нь сонгох, сонгогдох эрхээ эдэлж, улс төрийн оролцоо нилээдгүй өндөр байгааг харуулж байна.

Сонгуульд нэр дэвшигчид нь нас боловсрол болон салбар, төрөл бүрийн мэргэжлийн хүмүүс байдаг бөгөөд сүүлийн жилүүдэд бүр эдийн засагч, эрх зүйч, улс төр, нийгмийн мэргэжлийн хүмүүсээс гадна жүжигчин, дуучин, зохиолч, яруу найрагч гэх мэт олон салбарын хүмүүс өрсөлдөх болсноороо онцлог байв. Тухайлбал: 2016 оны УИХ-ын сонгуульд яруу найрагч 2, бөх 2, дуучин 1 нэр дэвшигч өрсөлдөж ялалт байгуулсан. Хамгийн сүүлийн буюу 2020 оны УИХ-ын сонгуульд сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн 38 нь анх удаа сонгогдсон, 13 нь буюу 17.1 хувь нь эмэгтэй, хамгийн ахмад нь 66 настай, хамгийн залуу нь 33 настай байна. Нийт гишүүдийн 14 /18.42%/ нь хуульч, эрх зүйч, 21 /27.63%/ нь эдийн засагч, 12 /15.79%/ нь инженер, агрономич, 14 /18.42%/ нь улс төр, нийгмийн ухаан, урлаг, утга зохиолын, 9 /11.84%/ нь эмч, багш, 6 /7.89%/ нь бусад мэргэжлийн хүн байснаараа онцлог байв.

Мөн насны хувьд Монгол улсын Үндсэн хуулийн 3-р бүлгийн 21-р зүйлийн 3 дахь хэсэг¹², Сонгуулийн тухай хуульд 2-р бүлгийн 11-р зүйлийн 11.6 дахь заалтад “УИХ-ын гишүүнээр Монгол улсын 25 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно¹³” заасны дагуу 25-аас дээш насны Монгол улсын иргэд нэр дэвшиж өрсөлддөг. Үүнээс 2012 оны УИХ-ын сонгуулиар хамгийн настай нь буюу 73 настай нэр дэвшигч УИХ-ын гишүүнээр сонгогдон ажилласан.

УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн ихэнхи хувь нь дахин улиран сонгогддог. Энэ нь Монгол улсад хэрэгжиж байгаа мажоритар тогтолцооны үр дүн юм. Учир нь сонгуулийн мажоритар тогтолцоо нь сонгогчдод энгийн ойлгомжтой, хэн нь илүү санал авсан нэр дэвшигч ялалт байгуулдаг. Мөн түүнчлэн Монгол улсад ард түмэнд танигдсан туршлагатай улс төрчид олон дахин сонгогдох магадлал өндөр учраас улиран олон удаа сонгогдох нь их байдаг.

2008 оны сонгуулиар олон түмний итгэлийг хүлээсэн 76 нэр дэвшигчээс 36 нэр дэвшигч нь 2004 оны сонгуулиар сонгогдсон төрийн түшээд байсан юм. 2008 оны сонгуульд өрсөлдүүлэхээр МАХН, АН болон бусад намууд халаас зузаан, бэлтэй олон

¹² Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992 он

¹³ Монгол улсын Сонгуулийн тухай хууль. УБ., 2015 он

бизнесмэнийг нэр дэвшүүлсэн боловч ихэнхи сонгогдож чадаагүй. Энэ нь наймаачдыг төрд гаргахаар түмнийхээ төлөө биш бизнесээ цэцэглүүлэх гэж улайрдаг гэсэн ойлголт сонгогчдын дунд байдагтай холбоотой. Бизнесмэнүүд хайр найргүй хөрөнгө цацаж, мөнгөөр бүхнийг бүтээнэ гэж бодсон ч сонгогчид тэдэнд хууртагдаагүй. Цөөнгүй бизнесмэнүүд хоёр тэрбум төгрөгөөс ч их хөрөнгө зарсан ч ялагдал хүлээсэн.

Монголын сонгогчдын дараагийн нэгэн онцлог нь сүүлийн жилүүдэд эмэгтэй улс төрчдийг дэмжих байдал тогтвортой ажиглагдаж байна.

График №5. Сонгуульд ялалт байгуулсан эмэгтэй УИХ-ын гишүүдийн тоо (УИХ-ын сонгууль 1992-2020 он)



Тухайлбал: 1992 оны УИХ-ын сонгуульд 3 эмэгтэй нэр дэвшигч ялалт байгуулсан. 1996 оны УИХ-ын сонгуульд 7 эмэгтэй нэр дэвшигч, 2000 оны УИХ-ын сонгуульд 8 эмэгтэй нэр дэвшигч, 2004 оны УИХ-ын сонгуульд 5 эмэгтэй нэр дэвшигч, 2008 оны УИХ-ын сонгуульд 2 эмэгтэй нэр дэвшигч тус тус ялалт байгуулж УИХ-ын гишүүнээр сонгогдсон.

Харин 2012 оны сонгуулийн жишээн дээр үзэхэд эмэгтэй нэр дэвшигчийн сонгогдох магадлал эрэгтэй нэр дэвшигчдээс 2,5 дахин өндөр байсан. 2012 оны сонгуулиар 9 эмэгтэй гишүүн ялалт байгуулж, нийт гишүүдийн 11,8 хувийг эзэлсэн. 2016 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд түүхэндээ хамгийн олон буюу 13 эмэгтэй нэр дэвшигчид сонгуульд ялалт байгуулж УИХ-ын гишүүн болж байсан бол 2020 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд мөн 13 эмэгтэй нэр дэвшигч ялалт байгуулж нийт нэр дэвшигчдийн 17.1 хувийг эзэлсэн. Энэ тоо баримтаас харахад шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо идэвх өндөр байгаа бөгөөд эмэгтэй нэр дэвшигчдийг сонгох байдал цаашид өсөх хандлагатай байна.

2. Монголын сонгуулийн тогтолцоо ба улс төрийн намын харилцан хамаарал

Дэлхийн улсуудын судлаачид Монгол улсыг “олон намын тогтолцоотой” ардчилсан улс гэж дүгнэдэг. Гэсэн хэдий ч ардчилсан сонгуулийн үр дүнгээс харахад 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012, 2016 онуудад төрийн эрхийг гартаа авч, байр тогтвортой хадгалж УИХ-д суудал авч, засгийн эрхийг 2-3 нам ээлжлэн барьсаар байна. Төрийн эрх барьж байгаа намуудын бодит байдлаас авч үзэхэд 1-2 намын ноёрхсон шинжтэй байна.

1990 оноос Монголын ард түмэн ардчилсан замаар төр барих эрхээ жинхэнэ утгаар нь эдлэх болсон. 1992 оны Үндсэн хуулийн 3-р зүйлд “Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэнэ”¹⁴ гэж заасан байдаг. 1990 оноос улс төрийн амьдралд

¹⁴ Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992

гарсан өөрчлөлт, шинэчлэлтээс үүдэн сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгож шинэчлэх алхмуудыг хийж эхэлсэн. Үүний үр дүнд Монгол Улс түүхэндээ анх удаа Ардын Их Хурлыг сонгуулиар байгуулсан. Энэ сонгууль нь холимог тогтолцоогоор явагдаж улс төрийн олон намууд анх удаа өрсөлдөж оролцсон шинэ, чөлөөт сонгууль болж өнгөрсөн боловч энэхүү ардчилсан сонгууль нь зөвхөн хэлбэрийн төдий л байсан.

АИХ-ын танхим нь цөөн намуудын эвлээс бүрдэж байсан. Монгол Ардын Хувьсгалт Нам нь орон нутгийн төлөөллийг сонгоход 53.4 хувь, АИХ-ыг сонгох сонгуулиар нийт 84.8 хувийн саналыг авч байсан. Ингэж МАХН Монгол улсын парламентын нийт 422 суудлын 357 суудлыг авч чадсан. Харин Монголын Ардчилсан Нам 16 суудал, Монголын Үндэсний Дэвшлийн Нам 6 суудал, Монголын Социаль Демократ Нам 4 суудал тус тус эзэлсэн бөгөөд үлдсэн суудлыг гишүүн бусчууд, залуучуудын холбооны нэр дэвшигчид эзэлсэн. Энэ сонгууль нь олон намын төлөөлөл оролцсон түүхэндээ анхны сонгууль гэхэд сөрөг хүчнийхэн чамлахааргүй амжилтанд хүрч байсан¹⁵.

1990 оны анхны АИХ-ын сонгууль, 1992, 1996 оны УИХ-ын сонгуулиудын үйл явц нь шилжилтийн эхэн үеийн бэрхшээл, нийгмийн соёл, ухамсрын төлөвшөөгүй байдал, ардчилсан сонгуулийн туршлага дутмаг зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж зарим нэг зөрчилтэй асуудлууд гарч ирсэн. Энэхүү гажуудал нь сонгуулийн тогтолцооны төлөвшилтийн шилжилтийн үеийн бэрхшээлтэй асуудлуудтай холбоотой.

Хүснэгт № 3. Монгол дахь засгийн газрын танхимын бүрдэлтийн харьцаа¹⁶

Он	Сонгуулийн тогтолцоо	Засгийн газрын танхим	Засгийн газар бүрдүүлсэн нам, эвсэл
1990	Холимог	Хамгийн цөөн намуудын эвсэл	МАХН болон Монголын Ардчилсан нам, Монголын Үндэсний Дэвшлийн нам, Монголын Социаль Демократ-Нам
1992	Олон мандаттай мажоритар тогтолцоо	Нэг намын олонхи	МАХН (одоогийн МАН)
1996	Нэг мандаттай мажоритар тогтолцоо	Олон намын эвсэл	МҮАН-МСДН-ын "Ардчилсан холбоо эвсэл"
2000	Нэг мандаттай мажоритар тогтолцоо	Нэг намын олонхи	МАХН (одоогийн МАН)
2004	Нэг мандаттай мажоритар тогтолцоо	Хамгийн ойр байр суурьтай намын эвсэл	"Эх орон- Ардчилал" эвсэл
2008	Олон мандаттай мажоритар тогтолцоо	Хамгийн цөөн намуудын эвсэл	МАХН-АН-ын хамтарсан Засгийн газар
2012	Холимог тогтолцоо	Олон намуудын эвсэл	"АН болон МАХН-МҮАН-ын Шударга ёс эвсэл" Шинэчлэлийн Засгийн газар
2016	Нэг мандаттай мажоритар тогтолцоо	Нэг намын олонхи	МАН

¹⁵Удо. Баркманн. "МАХН-ын улс төрийн өөрийн ойлголтын тухайд". Монгол улсын ШУА-ын ОУСХ. Герман: судалгаа, мэдээлэл. УБ., 2005

¹⁶ Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик /Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл/ УБ., 2009 он

2020	Олон мандаттай мажоритар	Нэг намын олонхи	МАН
------	-----------------------------	------------------	-----

Монгол улсын шинэ Үндсэн хуулийг баталсны дараа хууль тогтоох дээд байгууллага 1992 онд батлагдсан УИХ-ын сонгуулийн хуулийн дагуу олон мандаттай мажоритар тогтолцоогоор томсгосон тойргоор явагдсан бөгөөд УИХ-ын танхим нь нэг намын олонхиос бүрдэж байсан. 1996 оны УИХ-ын сонгууль нь 1995 онд сонгуулийн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу нэг мандаттай мажоритар тогтолцоогоор явагдаж УИХ-ын танхим нь олон намын эвлээс бүрдэж байсан. Харин 2000 оны УИХ-ын сонгууль нь нэг мандаттай мажоритар тогтолцоогоор явагдсан бөгөөд УИХ-ын танхим нь нэг намын олонхиос бүрдэж байсан. 2004 оны УИХ-ын сонгууль нь нэг мандаттай мажоритар тогтолцоогоор явагдсан бөгөөд УИХ-ын танхим нь хамгийн ойр байр суурьтай намын эвлээс бүрдэж байсан юм.

1992, 1996, 2000 онд болж өнгөрсөн Монголын УИХ-ын ээлжит сонгуулиуд нь шилжилтийн үеийн өвөрмөц бэрхшээлтэй үед явагдсан бөгөөд тухайн сонгуульд оролцож байсан улс төрийн субъект, улс төрийн нам хүчин, сонгогчдын төлөвшил, сонгуулийн үйл ажиллагаа зохион байгуулах арга нь дутуу, сонгуульд бохир технологи хэрэглэсэн, эрх зүйн орчин нь сайн бүрдээгүй зэрэг хүчин зүйлүүдтэй ихээхэн холбоотой.

2008 оны УИХ-ын сонгууль нь “ялагч бүхнийг авна” гэсэн зарчимтай уламжлалт мажоритар тогтолцоогоор олон мандаттай томсгосон тойргоор явагдсан бөгөөд УИХ-ын танхим нь хамгийн цөөн намуудын эвслээс бүрдэж байсан. 2008 оны УИХ-ын сонгуулиар намууд хоорондын төдийгүй, нам доторх өрсөлдөөн бий болсон бөгөөд 5 хүний амь насанд хүрсэн, нийгэмд эмх замбараагүй байдал үүсгэж гэмт хэргийг дэвэргэсэн, соёлын болон түүхийн дахин давтагдашгүй бүтээлийг устгасан, Монгол улсын эдийн засагт сөргөөр нөлөөлсөн, ардчиллын зарчмуудыг гажуудуулсан сонгууль болж өнгөрсөн.

2012 оны УИХ-ын сонгууль нь шинэ эрх зүйн зохицуулалтын хүрээнд, сонгуулийн холимог тогтолцоогоор явагдсан бөгөөд УИХ-ын танхим нь олон намуудын эвслээс бүрдэж байсан. Монгол улс 2011 онд сонгуулийн хуулиндаа өөрчлөлт оруулж шинэ тогтолцоогоор буюу 2012 оны УИХ-ын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулсан ч сонгуулийн зарим тойрогт сонгуулийн дүн будлиантаж удаан хугацаагаар үргэлжилсний эцэст шүүхээр шийдэгдсэн гэх мэт сонгуультай холбоотой зарим зөрчил, маргаан гарсаар байна. Мөн холимог сонгуулийн тогтолцоог хэрэглэснээр Монгол улсад олон жижиг намууд төрд орж ирэх боломжийг олгож, намуудын өрсөлдөх боломж, жижиг намууд нэгдэж, намуудын төлөвших үйл явц үргэлжилсээр, эвслийн Засгийн газрыг бүрдүүлдэг. Нөгөө талаар хэтэрхий олон жижиг намууд нь үзэл бодлын зөрчилдөөн үүсгэж, эвслийн Засгийн газар байгуулсны дараа жижиг намуудын дунд байр суурь, ашиг сонирхлын зөрчилдөөн бий болж Засгийн газар удаа дараа солигдох, улс төрийн тогтвортой байдал алдагдах зэрэг сөргөөр нөлөөлөх байдал ажиглагдаж байна. Эвслийн Засгийн газрын талаар Монгол улсын Үндсэн хуулинд ямар нэг эрх зүйн зохицуулалт байдаггүй нь бүр ч мухардалд хүргэж болзошгүй юм. 2012 оны УИХ-ын сонгуулиар гадаадад суугаа Монгол улсын иргэдээ сонгуульд оролцуулсан, ухаалаг үнэмлэхтэй, санал тоолох автомат машиныг ашигласан зэрэг нь өмнөх сонгуулиудиа онцлогтой болж өнгөрсөн.

2016 оны УИХ-ын сонгууль нь 2015 онд шинэчлэн баталсан Сонгуулийн тухай хуулийн дагуу уламжлалт нэг мандаттай мажоритар тогтолцоогоор явагдсан бөгөөд УИХ-ын танхим нь нэг намын олонхиос бүрдэж байна. 2016 оны шинэ Сонгуулийн тухай багц хуулийг гаргахдаа УИХ нь Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэрэгжүүлснээс гадна олон мандаттай сонгуулийн тойргийн тогтолцоог нэг мандаттай

тойргийн тогтолцоо болгон өөрчилснөөр мажоритар тойргийн тоо 26-аас 76 болж нэмэгдсэн. Дээрх шинэчлэлтүүдийг танилцуулахаас өмнө олон нийтийн дунд хэлэлцүүлэг явуулаагүй, сонгууль болох өдрөөс 2 сар хүрэхгүй хугацааны өмнө сонгуулийн тогтолцоонд болон сонгуулийн хууль эрх зүйн хүрээний бусад талуудад ийм томоохон өөрчлөлт хийсэн нь олон улсын сайн туршлагыг дордуулсан явдал болсон. Энэ үйл явц нь улс төрийн нөлөөллөөс ангид байж чадсан уу гэсэн асуудал гарч судлаачид өөр өөрсдийн байр сууринаас дүгнэлт өгсөөр байна¹⁷.

2020 оны УИХ-ын сонгууль нь 2019 онд шинэчлэн баталсан УИХ-ын сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд олон мандаттай томсгосон тойргоор явагдсан бөгөөд мөн адил нэг намын олонхи буюу МАН 62 суудал авч УИХ-ын олонхийг бүрдүүлээд байна. Энэ удаагийн сонгуулийг 29 тойрогт зохион байгуулж явуулсан. Мажоритар тогтолцоо өөрөө сонгогчдын санал ихээр гээгдүүлдэг, том намыг дэмжсэн тогтолцоо учраас мөн л өмнөх дутагдал давтагдсаар байна. Сонгогчдын санал маш ихээр гээгдэж байна. Улс төрийн намын хөгжил, төлөвшил, дотоод ардчилал, олон намын тогтолцоог төлөвшүүлэх, олон намын өрсөлдөөн, олон ургальч үзэл зэрэгт сөргөөр нөлөөлсөөр байна.

Сонгуулийн тогтолцоо нь парламентын намын тоонд нөлөөлөх нөлөөллийн үр дүнг хэмжих гол хэмжүүр нь парламент дахь намуудын “үр ашигтай тоо” юм. Сонгуулийн тогтолцоо Дуглас, В.Райн нарын тооцоолсноор бүгд парламентын “бүтээмэл олонхи”-ийг бий болгох боломжтой ч сонгуулийн харьцангуй болон нэг мандаттай мажоритар тогтолцоо гол төлөв бүтээмэл болон бодит олонхийг бүрдүүлдэг. Харин хувь тэнцүүлсэн тогтолцоо нь бодит цөөнхийг бүрдүүлдэг.

Манай улсын хувьд сонгуулийн олонхийн мажоритар тогтолцоог голлон хэрэглэж байснаас шалтгаалж гол төлөв бүтээмэл болон бодит олонхи (бодит олонхи 1992, 2000, 2016) , (бүтээмэл олонхи 1996, 2008) бүрэлдэж байна.

Монгол улс ардчилалд шилжсэнээс хойших 30 жилийн хугацаанд УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг сонгох бүх нийтийн сонгуулийг тус бүр 8 удаа явуулж сонгуулийн хэд хэдэн тогтолцоог туршиж үзсэн. Гэсэн хэдий боловч мажоритар тогтолцоог дийлэнхдээ хэрэглэсэн хэвээр байна. Энэхүү тогтолцоо нь хүчтэй хоёр намыг дэмждэг учраас улс төрийн намыг төлөвшүүлэх, олон намын тогтолцоог бүрдүүлэхэд сөргөөр нөлөөлсөн хэвээр байна. Эрх барьж буй улс төрийн намууд нь төлөөллийн байгууллагыг сонгохдоо олон намыг тогтолцоо, олон ургальч үзлийг дэмжсэн, сонгогчдын саналыг илүү харгалзан үзсэн тогтолцоог сонгож тогтвортой хэрэглэх асуудалд төдийлөн анхаарал хандуулахгүй байсаар байна. УИХ-ын 8 удаагийн сонгууль явуулсан сонгуулийн тогтолцоонууд, эрх зүйн орчин, бусад хүчин зүйлүүдээс нөлөөлсөн эерэг, сөрөг үр дагаврын аль аль нь байсаар байна.

Хэлэлцүүлэг:

Нэг: Намыг улс төрийн үзэгдэл, улс төрийн онолын асуудал болохын хувьд нь улс

төрчид, судлаачид тал бүрээс нь анхааран судалсаар ирсэн. Улс төрийн нам, намын системийн асуудал нь хамрах хүрээ өргөн, агуулгын хувьд олон талтай учраас түүнтэй уялдаж холбогддоггүй улс төрийн онолын болон практикийн асуудал нэг ч байдаггүй гэж хэлж болно. Тодруулбал,

1. Төрийн удирдлага,

¹⁷ 2002 оны Венецийн комиссын дүрэм. II.2.b Сонгуулийн асуудлаарх сайн туршлага "сайн туршлагын дүрэм"-ээр сонгуулийн хуулийн үндсэн элементүүдэд сонгууль болохоос өмнөх сүүлийн 12 сарын дотор нэмэлт өөрчлөлт оруулах ёсгүй гэж зөвлөдөг.

2. Засаглалын болон улс төрийн тогтолцооны онол,
3. Улс төрийн ухамсар, соёл,
4. Улс төрийн хэм хэмжээ ёс зүй,
5. Сонгууль, сонгуулийн тогтолцоо,
6. Элит, болон хошуучлал судлалын онол гэх зэрэг улс төрийн ерөнхий онолын асуудалтай шууд болон дам ямар нэг байдлаар холбогддог.

Хоёр: Мөн түүнчлэн улс төрийн нам, намын систем нь ардчилсан төрийн тогтолцооны гол тулгуур үндэс нь болдог. Төрийн ардчилсан тогтолцоонд нам, намын системийн үзүүлэх нөлөө нь тэдгээрийн төрийн засаглалын системд эзлэх байр суурь, статус, гүйцэтгэх үүргээр дамжин илэрч байдаг. Намууд төрийн засаглалын системд байр суурь эзлэн тодорхой үйл ажиллагаа явуулахын тулд өөрсдийн улс төрийн зорилго, бодлогоо сонгуулийн мөрийн хөтөлбөртөө тусган, олон түмний дэмжлэг, итгэлийг олж авахыг эрмэлздэг. Ингэхийн тулд намууд төрийн сонгуульд оролцон шударгаар өрсөлддөг. Үүний эцэст сонгогч олон түмний дэмжлэг олж авсан нам, намуудын эвсэл нь төрийн засаглалын бүтцэд өөрсдийн хууль ёсны байр сууриа эзэлдэг. Ийм намуудын улс төрийн бодлого, хөтөлбөр нь төрийн бодлогын үндэс болж, улс орны хөгжил, дэвшлийн цаашдын хувь заяанд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Энэ утгаараа төрийн ардчилсан институцийн салшгүй бүрдэл, элемент болсон нам, намын системийн асуудал улс төрчид, судлаачдын анхаарлыг зүй ёсоор татаж байдаг.

Гурав: Улс төрийн намууд нь төр, иргэн хоёрыг холбон нэгтгэгч “түүр” болж байдаг утгаараа улс төрийн онолын сонирхол татсан асуудлын нэг болдог. Иргэний нийгэмд нийгмийн янз бүрийн бүлгүүд ашиг сонирхол, үзэл бодлоороо бие биенээсээ өвөрмөцөөр ялгарч байдаг. Тэрхүү сонирхол, үзлүүд нь олон ургальч өнгө аястай байдгаараа онцлогтой. Үүнтэй уялдан хүмүүсийн хувьд ашиг сонирхол, үзэл бодлоо бодитой хамгаалан илэрхийлж, түүнийгээ нэгдмэл байдлаар төрийн бодлогод тусгахыг эрмэлздэг. Үүнийг хэрэгжүүлэх улс төрийн гол механизм нь намууд болдог. Тийм ч учраас хүмүүс ашиг сонирхол, үзэл бодлын ойролцоо байдлаараа улс төрийн тодорхой нэг намд харьяалагдан түүгээр дамжуулан төрийн засаглалыг хэрэгжүүлэхэд оролцдог. Энэ утгаараа улс төрийн намууд хүмүүсийн нийгэмшилтийн үйл явцад чухал нөлөө үзүүлж байдаг байна.

Дөрөв: Нам, намын систем нь өөрөө улс төрийн сонирхол татсан үзэгдэл юм. Цаг үеийн өөрчлөлттэй уялдан улс төрийн энэ үзэгдэлийн хүрээнд ч ихээхэн хувьсал, өөрчлөлт гарах болсон юм. Тухайлбал, орчин үеийн улс төрийн намууд улс төрийн үзэл бодол, зохион байгуулалт, нийгэмд эзлэх байр суурь, үүрэг үйл ажиллагаа, дотоод ардчиллын хувьд шинэ байдлаар төлөвшин хөгжих болсон билээ. Үүнтэй уялдан онолын болон практикийн хувьд бодитой судлан шийдвэрлэвэл зохих төвөгтэй олон шинэлэг асуудал дэвшигдэх болсон юм. Тэдгээрийг бодитой оношлон шийдвэрлэх нь улс төрийн амьдралын хүрээний олон асуудлыг зөв танин мэдэх бололцоог бүрдүүлдэг. Ингэхлээр нам, намын системийн асуудал нь ардчилсан нийгэм, түүний хүрээнд үйлчилж байдаг нийгэм улс төрийн хууль, жам ёсны мөн чанарыг нээн илрүүлж, бодитой танин мэдэхэд онолын болон практик учир зүйн талаасаа нэн чухал юм.¹⁸

Нам, намын системийн асуудал нь улс төр судлалын гол томоохон зангилаа асуудлын нэг юм. Иймд улс төрийн амьдрал болон улс төрийн тогтолцооны хүрээний онолын болон практик шинжтэй аливаа асуудлыг бодитой авч үзэх чухал нөхцөл нь нам, намын системийн асуудлыг тусгайлан шинжлэх судлах явдал зайлшгүй чухал юм.

Хэдийгээр нам судлал талаас нь, нам, намын систем талаас нь онолын хувьд авч үзэн судалсан бүтээлүүд байдгаас гадна эрх зүйн орчин, улс төрийн намын төлөвшил, улс төрийн намын санхүүжилт, ардчиллын төлөвшилтэй улс төрийн намыг

¹⁸ Д.Болд-Эрдэнэ. Нам судлалын онол. УБ., 2002

холбон авч үзэж судалсан судалгааны бүтээл болон эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл нилээдгүй байдаг.

Гэсэн хэдий боловч сонгууль болон улс төрийн нам хоёрын хооронд дахь асуудлуудыг яг цав нарийвчлан судалсан судалгаа, шинжилгээний бүтээл одоогоор хомс байна. Цаашид энэ асуудлаар нарийвчлан тодорхой судалгаа, шинжилгээний ажил, нэг сэдэвт бүтээл, төсөл хөтөлбөрийн хүрээнд судлах судалгаа үгүйлэгдсээр байна.

Дүгнэлт, санал:

Монгол улс ардчилсан тогтолцоонд шилжиж, парламентат ёс, түүний институт бүрэлдэн тогтож засаглалыг хуваах зарчим хэрэгжиж, ардчилсан сонгуулийг явуулаад 30 жил болж байгаа хэдий ч эерэг сөрөг олон хүчин зүйлийн улмаас боловсронгуй болгох, засаж сайжруулах, шийдвэрлэх асуудлууд тулгарсаар байна.

Монгол улс ардчилалд шилжсэнээс хойшхи хугацаанд ардчилсан сонгуулийг явуулаад нилээгүй хугацаа өнгөрч байгаа ч сонгууль түүнийг тойрсон бэрхшээлтэй олон асуудлууд нэмэгдсээр байгаа дотоод аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Иймд сонгууль, түүнийг тойрсон дараахь хэд хэдэн асуудлуудыг судлан авч үзэж, бэрхшээлтэй асуудлуудыг илрүүлэн гаргаж, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх нь дотоод аюулгүй байдал алдагдахаас сэргийлэхэд чухал ач холбогдолтой.

Монголд хэрэглэж ирсэн мажоритар тогтолцооны сайн талуудыг авч сул, дутагдалтай талуудын алдааг засах, сайжруулах үүднээс холбогдох хуульд нарийвчлан тусгахдаа бүх ард түмний дунд хэлэлцүүлэг явуулах нь зүйтэй. Ингэхдээ уг хэлэлцүүлэгт өөрийн орны түүх, улс төрийн нөхцөл байдал, улс төрийн төлөвшил, иргэдийн улс төрийн боловсрол зэргийг харгалзан үзэх хэрэгтэй. Мөн сонгогчдод сонгуулийн тогтолцоо, түүний төрлүүдийн талаар мэдээлэл өгч тодорхой ойлголттой болгох ажлыг зохион байгуулах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Ардчиллын хөгжлийн нэг гол үзүүлэлт-хэвлэлийн эрх чөлөөний зөрчигдсөн, хэвлэл мэдээллийн чөлөөт байдал Монголд тэгш биш байгаа нь иргэдийн хүсэл сонирхлоо илэрхийлэх, зөв сонголтоо хийхэд нь сөргөөр нөлөөлөөд зогсохгүй ардчилсан сонгуулийн үндсэн зарчмуудыг зөрчиж байна. Энэ байдал нь эрх баригчид, төр, улс төрийн намуудын зүгээс иргэдийн санаа бодолд сөрөг нөлөө үзүүлэх нөхцлийг бүрдүүлж байна.

Монгол дахь ардчилал хөгжих болоогүйг 2008 оны 07-р сарын 01-ний эмгэнэлт үйл явдал тодорхой харуулсан. Ардчилсан сонгуулийн үр дүнд ард түмний шууд оролцоог үндэслэн төрийн эрх барих Улсын Их Хурал байгуулагддаг. Улмаар Засгийн газар байгуулагддаг учраас сонгууль шударга бус, ёс төдий байж огт болохгүй. Үүнд хамгийн их хамааралтай нь улс төрийн намууд юм.

Ардчилсан сонгуулиар парламентыг бүрдүүлэхэд бэрхшээл учруулж байгаа гол асуудал нь эрх зүйн зохицуулалт ойлгомжгүй, цоорхой ихтэй, улс төрийн намууд хуулиа зөрчдөг, сонгуульд шударга бус, тэгш бусаар өрсөлддөг, улс төрийн намууд ардчилсан сонгуулийн үндсэн зарчмуудыг гажуудуулдаг, мөрийн хөтөлбөрөө биелүүлдэггүй, ард түмнийг хуурсан өнөө маргаашаа түр аргацаасан мөрийн хөтөлбөр боловсруулдаг, намын чиг баримжаа, үзэл баримтлал нь тодорхойгүй, нэр дэвшигчид нь сонгогчдын саналыг худалдан авдаг, бэлэг сэлт тараадаг, хууль бусаар сөрөг сурталчилгаа явуулдаг, сонгуульд улс төрийн соёлтой оролцож чаддаггүй, улс төрийн намууд олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй хаалтын гэрээ хийдэг, далд болон сөрөг сурталчилгаа хийдэг гэх мэт ардчилсан сонгуулийг тойрсон бүх сөрөг асуудлууд нь улс төрийн намаас үүдэлтэй байгаатай холбоотой.

Монголын улс төрийн намууд үзэл баримтлал, чиг баримжаагаа тодорхой болгож чадаагүй, нийгэмд чиглэсэн үүргээ биелүүлдэггүй, намын санхүүжилт нь ил тод бус, намын дотоод ардчилалгүй, бүтэц зохион байгуулалт, боловсон хүчний бодлогодоо анхаардаггүй, намуудад **хариуцлагын тогтолцоо, эргэх механизм** байхгүй байна. Мөн Монголын сонгуулийг шударга, зөв, ил тод, соёлтой явуулахад төрийн ба төрийн бус байгууллага, улс төрийн намууд, нэр дэвшигчид, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд тус тусдаа хариуцлага хүлээдэг тогтолцоог байхгүй байна. Улс төрийн намууд, нэр дэвшигчид сонгогчдын боловсролын төвшин, мөн улс төрийн соёлын дэвшилт өөрчлөлтүүдийг сонгуулийн үйл ажиллагаандаа харгалзан үзэх нь зүйтэй байна.

Монголын улс төрийн намын санхүүжилтийн ил тод бус байдал нь улс төрийн хямралыг бий болгогч гол хүчин зүйл нь болж байна. 2016 оны сонгуулийн үр дүнд олонхийн суудал авч төрийн эрхийг барьж байгаа МАН-ыг тойрсон 60 тэр бум, ЖДҮ-ийн асуудал нь улс төрийн намын санхүүжилтийг хянах тогтолцоо байхгүй, хууль хэрэгждэггүй, санхүүжилт ил тод бус байгаатай холбоотой юм. Мөн мэргэшсэн, мэргэжлийн өндөр чадавхитай боловсон хүчинг сонгуульд нэр дэвшүүлэхийн оронд намын санхүүжилтээ зузаатгах үүднээс хэн илүү хандив өгч байна гэдгийг гол шалгуур үзүүлэлт болгож гишүүнчлэлээ бүрдүүлж байна. Үүнээс үүдээд нам дагасан бизнесийн бүлэглэлүүд бүрдэж, эцсийн дүндээ өнөөдрийн хямралт байдал бий болж байна гэж үзэж байна.

Нөгөө талаас нь авч үзвэл Монгол улсад хэрэгжүүлж ирсэн сонгуулийн мажоритар тогтолцоотой холбон авч үзэж болно. Мажоритар тогтолцоо нь хүчтэй хоёр намыг дэмждэг, санал гээгдүүлдэг учраас цөөн саналаар ялалт байгуулах өндөр магадлалтай гэх мэт дутагдалтай талуудтай. Монгол улсыг хэдийгээр олон намын тогтолцоотой улс орон гэж дэлхийн улсууд дүгнэдэг ч бодит байдлаас харахад сонгуулийн мажоритар тогтолцоо нь МАН, АН гэсэн хоёр хүчтэй намыг ээлжлэн төр барих гол суурь нь болж байна. Ямар ч тогтолцоо эерэг, сөрөг талтай. Өнөөгийн хэрэглэж буй сонгуулийн тогтолцооны дутагдалтай талуудыг засаж сайжруулахад гол анхаарлаа хандуулах нь зүйтэй байна. Бодит байдал дээр төрийн эрх барьж буй улс төрийн намууд одоогийн хэрэглэж буй сонгуулийн мажоритар тогтолцоог өөрчлөх сонирхол бага байгааг сонгуулийн жилүүдэд хэрэглэж ирсэн үр дүнгээс харагдаж байна. Энэ нь олон намын оролцоог хангах, олон намыг тогтолцоог жинхэнэ утгаар хэрэгжүүлэх, олон ургальч үзлийг дэмжих, сонгогчдод альетнариив боломжийг олгох гэх мэт асуудлуудыг орхигдуулж байна.

Гаргалгаа: 1. Эрх зүйн зөв зохицуулалт хийх, 2. Намын санхүүжилтын асуудлыг шийдэх, 3. Сонгуульд нэр дэвшүүлэх шалгуур үзүүлэлтийг өндөрсгөх, 4. Сонгогчдын оролцоог нэмэгдүүлэх, улс төрийн ухамсрыг дээшлүүлэх. 5. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд хяналт тавих. Үнэн бодит, тэнцвэртэй мэдээллээр хангах нөхцөл боломжийг бүрдүүлж улс төрөөс ангид байлгах. 6. Төрийн албаны мерит зарчмын хэрэгжилтийг хангах. Үндэслэлгүй аль ч улс төрийн хүчин төрийн эрхийг барьж үндэслэлгүй халж сэлгэдэг байдлыг хуулиар хориглосон заалт оруулах. 7. Эрх мэдлийн хуваарилалтын асуудлыг оновчтой, тодорхой болгох. 8. Хатуу хариуцлагын тогтолцоо бий болгох гэсэн үндсэн хэд хэдэн асуудлыг шийдсэнээр ардчилсан шударга сонгуулийг явуулах, мэргэжлийн мэргэшсэн парламентыг бүрдүүлэх нөхцлийг бий болгож, өнөөгийн хямралт байдлаас гарч, дотоод аюулгүй байдлыг хангахад чухал үндсэн суурь нь болно гэж үзэж байна.

Ашигласан материал:

Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992

Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 1994

Д.Болд-Эрдэнэ. Нам судлалын онол. УБ., 2002

Венецийн комиссын дүрэм. 2002. II.2.b.

Улс төрийн намын тухай хууль. УБ., 2005

СЕХ. “Ардчилсан төрийн сонгуулийн товчоон”. УБ., 2005

Удо. Баркманн. "МАХН-ын улс төрийн өөрийн ойлголтын тухайд". Монгол улсын ШУА-ын ОУСХ. Герман: судалгаа, мэдээлэл. УБ., 2005

Г.Чулуунбаатар, А.Жамбал, Д.Болд-Эрдэнэ. Сонгуулийн хэлбэрүүдийн үйлчлэл, үр дагаврын асуудал. Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик. Илтгэлийн эмхтгэл. УБ., 2009

Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик /Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл/ УБ., 2009 он

Д.Түмэнжаргал. Монголын сонгуулийн систем: эрэл, шийдэл. УБ., 2012

СЕХ. Монгол Улсын Их Хурлын сонгуулиудын дүн. УБ., 2013

Сонгуулийн тухай хууль. УБ., 2015

Д.Түмэнжаргал. Монголын сонгуулийн сонгуулийн үйл явц, өөрчлөлтийн судалгаа. Жилин. 2017

Парламентын институтын улс төр, эрх зүйн шинжилгээ сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ., 2018 он

<https://www.gec.gov.mn/> Сонгуулийн Ерөнхий Хороо

<http://baabar.niitlelch.mn/content/1629.shtml>

<http://www.ublfe.mn/n/s/4037>

ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНЭЭР СОНГОГДОХ ШАЛГУУРЫН АСУУДАЛ

Д.Сүхболд

Улаанбаатар Эрдэм Их Сургууль

Сургалт эрхэлсэн дэд захирал, дэд профессор

Хураангуй: Тус өгүүллэгээр парламентын гишүүнээр сонгогдох үндсэн хуулийн болон үндсэн хуулийн бус шалгуурын асуудлыг хөндсөн болно. Тухайлбал үндсэн хуулийн шалгуурууд болох нас, иргэний харьяалал, тухайн сонгуулийн тойрогтоо оршин суух асуудал, сонгох, сонгогдох эрх хязгаарлагдаагүй байх зэрэг шалгуурыг олон улсын туршлагыг үндэслэж авч үзэв. Мөн үндсэн хуулийн бус шалгуур болох парламентын гишүүнээр сонгогдох болон сонгогдсоны дараа хувь хүний зүгээс үүрэг хариуцлагаа ухамсарлаж, гүйцэтгэж буй ажлаасаа сэтгэл ханамж авах байдал, хувийн ашиг сонирхол, амбиц зэрэг нь парламентын гишүүнийг аливаа зүй бус үйлдэл хийхгүй байхад нөлөөлж, гишүүнийг сонгогчидтой нь хэрхэн уялдуулж болох талаар өгүүлэхийг зорив.

Түлхүүр үг: парламент, парламентын гишүүн, хоёр танхимтай парламент, үндсэн хууль, сонгууль, сонгуулийн тойрог, шалгуур

Keywords: Parliament, Member of Parliament, bicameral parliament, constitution, elections, constituencies, criteria

Парламентын гишүүн бол ард түмнээс мандат авч хууль тогтоох байгууллагад сонгогдсон, нэг талаас хууль тогтоох, нөгөө талаас ард иргэдийг төлөөлөх чиг үүрэг бүхий төрийн өндөр албан тушаалтан юм. Төрийн өндөр албан тушаалтанд тавигдах шалгуурын асуудал нь улс төрийн сэтгэлгээний түүхэнд анхаарал татсан асуудлуудын нэг байсаар ирсэн. Тодруулбал нэр алдартай олон сэтгэгчид¹ улс орныг шалгарсан шилдэг хүмүүс удирдах ёстой юу, шалгарсан шилдэг хүмүүс гэж хэнийг хэлэх вэ, тэд бусдаас юугаараа ялгарах вэ, тэдэнд ямар шалгуур тавигдах ёстой вэ, гэсэн асуултуудад хариулт өгөхийг зорьж байлаа. Тэгвэл бүгд найрамдах засаглалын гол амин зүрх болсон хууль тогтоох байгууллагын гишүүнээр сонгогдохын тулд ямар шалгуурт нийцэх ёстой вэ.

Парламент нэг эсвэл хоёр танхимтай байхаас шалтгаалж тавигдах шалгуурын асуудал өөр өөрөөр яригдана. Хоёр танхимтай бол танхим тус бүрийн гишүүдэд тавих шалгуур нь харилцан адилгүй байдаг. Нас, мэдлэг боловсрол, туршлага, сонгуулийн тойргийн харьяалал гэх мэт.

Олон улсын туршлагыг үзэхэд парламентын доод танхимын гишүүдэд нас, тухайн улсын иргэний харьяалал, мэдлэг, туршлага зэрэг нийтлэг шаардлагыг тавих боловч хамгийн чухал нь тухайн тойргийнхоо ард иргэдийн итгэл, хүндлэлийг илүүтэй олж авсан, тэдний итгэлийг дааж чадах хүн байх нь чухалчилдаг. Харин эд хөрөнгө, шашин шүтлэг, боловсрол, мэргэжлийн шалгуурыг хоёрдугаарт тавьдаг. Хамгийн гол нь хүмүүс өөрсдийн төлөөлөгчөө чөлөөт сонгуулийн зарчмаар тодруулж чадсан л бол

¹ Тухайлбал эртний Грекийн сэтгэгчид болох Платон Аристотель, Хятадын Күнз, Италийн Макиэвелли нар өөрсдийн зохиол бүтээлүүддээ энэ асуудлыг чухалчилж авч үзсэн байдаг.

сонгууль зохистой явагдсан гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл доод буюу ардын төлөөлөгчдийн танхимын гишүүд тухайн тойргийн сонгогчдынхоо итгэлийг олж авсан л бол багш, инженер, хуульч, дуучин, тамирчин хэн ч байж болно.

Дээд танхимын гишүүдийн хувьд энэ асуудал огт өөрөөр яригдана. Учир нь тэдгээр эрхмүүд тухайн улсын нэрийн өмнөөс гадаад улстай гэрээ байгуулах, хэлэлцээр хийх асуудлаар Ерөнхийлөгчтэй зөвшилцөх, Ерөнхийлөгчийн гадаад улстай байгуулах гэрээ хэлэлцээрийг парламентын дээд танхимын нэгдсэн чуулганаар хэлэлцэж батлах, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах, шүүх эрх мэдлийг байгуулахад оролцох, импичментийн талаар эцсийн шийдвэр гаргах зэрэг улсын болон олон улсын төвшний, бодлогын асуудлуудыг шийдвэрлэхэд голлон оролцох ёстой юм. Иймээс парламентын дээд танхимын гишүүнээр сонгогдох насны доод хязгаарыг 30-40 насаар тогтоодог агаад ёс зүй болон мэдлэг болдовсрол, туршлагын хувьд бүрэн төлөвшсөн байх ёстой гэсэн нийтлэг шалгуурыг тавьдаг. Тухайлбал Иран, Итали, Франц, Японы дээд танхимд сонгогдохын тулд 40-өөс доошгүй настай байх шалгуур тавигддаг бол АНУ-ын Сенатад сонгогдохын тулд 30 нас хүрсэн байхыг шаарддаг.² Учир нь парламентын дээд танхимын гишүүд тойргийн биш нийт улсын төвшний төлөөлөл юм.

Энэхүү өгүүллэгээр нэгдүгээрт, парламентын гишүүнээр сонгогдохын тулд үндсэн хууль болон сонгуулийн тухай хуульд заагдсан ямар шалгуурыг давах ёстой вэ?

Хоёрдугаарт, парламентын гишүүнээр сонгогдох болон сонгогдсоны дараа хувь хүний зүгээс үүрэг хариуцлагаа ухамсарлаж, гүйцэтгэж буй ажлаасаа сэтгэл ханамж авах байдал, хувийн ашиг сонирхол, амбиц зэрэг нь парламентын гишүүнийг аливаа зүй бус үйлдэл хийхгүй байхад нөлөөлж, гишүүнийг сонгогчидтой нь хэрхэн уялдуулж болох талаар өгүүлэхийг зорив.

Дээрх зорилгоос үүдэн парламентын гишүүнээр сонгогдох шалгуурыг үндсэн хуулийн болон үндсэн хуулийн бус гэж хоёр ангилж болно.

Нэг. Парламентын гишүүнээр сонгогдох үндсэн хуулийн шалгуур.

Парламентын гишүүнээр сонгогдох шалгуурыг юуны өмнө улс орнуудын үндсэн хууль, сонгуулийн тухай хуулиас хайж болно. Улс орнуудын үндсэн хууль болон сонгуулийн тухай хуульд хууль тогтоох байгууллагын гишүүнээр сонгогдохын тулд дараах нийтлэг шалгууруудыг хангасан байх ёстой хэмээн үздэг. Гэхдээ парламент нэг танхимтай юу, эсвэл хоёр танхимтай юу гэдгээс хамаарч тавигдах шалгуурын асуудал өөр, өөрөөр тавигдана гэдгийг анхараах ёстой.

1. Парламентын гишүүний нас. Нас бол тухайн хүний туршлагын хэмжүүр. Нас ахих тутам хүний мэдлэг боловсрол, амьдралаас олж авах туршлага нэмэгдэж байдаг нь байгалийн болон их тооны хууль. Тухайлбал 25 настай залуу өндөр боловсрол эзэмшиж, олон шинжлэх ухаанаар судалгаа шинжилгээ хийж, бусдад өндөр боловсролтой хэмээн магтагддаг байсан ч тухайн залууг улсын Ерөнхийлөгчөөр сонгохгүй, парламентын дээд танхимын гишүүн болгохгүй, дээд шүүхийн шүүгчээр ажиллах боломжгүй. Учир нь энэхүү төрийн өндөр албан тушаалуудыг хашихад 25 настай залуугийн амьдрал, практикаас олж авсан мэдлэг, туршлага нь аргагүй дутагдана. Өөрөөр хэлбэл 25 настай залууг зөвхөн боловсролын төвшинг нь харгалзан үзээд төрийн өндөр албан тушаалд тавьдаггүй. Энэхүү жишээ нь туршлага боловсролоос илүү үнэтэйг харуулна. Маш олон удаагийн туршилтыг хийсний үр дүн

² Д.Лхагвасүрэн, Р.Ууганбаатар, М.Сайнбаяр, Д.Сүхболд, Д.Зоригтбаатар “БНМАУ: Үндсэн хуулийн тайлбар философи” 178 дахь тал. УБ.,2020

нь математик дундажтайгаа тэнцүү байдгийн адилаар нас бол хүний туршлага, мэдлэгийн хэмжээг шууд илэрхийлнэ. Тиймдээ ч Монголчууд өвгөн хүний үг хурц, үрээ морины явдал хурц, дөч хүрсэн эр, дөрвөөр дарсан ат хэмээх хэлцүүдээр нас, туршлага хоёрын шууд хамаарлыг илэрхийлжээ. Энэ үүднээс парламентын гишүүний нас бол парламентын бүхий л үйл ажиллагааны чанарт нөлөөлдөг чухал хүчин зүйл юм.

Дэлхийн улсуудад нэг танхимтай парламентын гишүүдийн насыг 18-25 насаар тогтоосон байдаг. Энэ нь парламент бол нийгмийн төлөөллийн байгууллага учраас нийгмийн бүтцийг аль болохоор харгалзан үзэх ёстой гэсэн үзэл баримтлалтай холбоотой. Хэрвээ парламентад сонгогдох гишүүдийн насны доод хязгаарыг 30-35 нас болговол нийгэм дахь залуусын төлөөллийг хангаж чадахгүй байдалд хүрэх сөрөг талтай хэмээн судлаачид үздэг. Харин хоёр танхимтай парламент бүхий улсуудад доод танхимын гишүүдийг мөн 18-25 настай байхаар, дээд танхимын гишүүдийн насны доод хязгаарыг өмнө дурдсанчлан 30-40 насаар тогтоосон байдаг.

/Парламентын засаглалтай зарим орны парламентын гишүүнээр сонгогдох насны доод хязгаар/³

Парламентын гишүүнээр сонгогдох насны доод хязгаар	18 нас	21 нас	25 нас	30 нас
Улс орнууд	Албани, Андорра, Багамын арлууд, Бельги, Белиз, Ботсван, Нидерланд, Словян, Хорват зэрэг 9 улс.	Австрали, Барбадос, Болгар, Доминик, Израиль, Ирланд, Латва, Сент-Винсент ба Гренадин, Сент-Люси, Сингапур, Словак, Чех, Ямайка, Канад, Эстони зэрэг 16 улс.	Бангладеш, Литва, Турк, Япон зэрэг 4 улс	Ирак

2.Иргэний харьяалал. Ард иргэдийн төлөөлөл болсон парламентад гагцхүү тухайн улсын харьяалалтай иргэн сонгогдох жишиг олон улсад тогтжээ. Тухайлбал Олон үндэстнээс бүрдсэн АНУ-ын Үндсэн хуулиар долоон жилийн туршид Нэгдсэн Улсын иргэн байгаагүй хүнийг Төлөөлөгчдийн танхимд⁴, есөн жилийн туршид Нэгдсэн Улсын иргэн байгаагүй хүнийг Сенатын танхимд сонгохгүй⁵ хэмээн заажээ.

Английн парламентад сонгогдохын тулд заавал Их Британийн иргэн байх, эсвэл бүх насаараа Британийн иргэн байх зөвшөөрлийг авсан хүн сонгогдох эрхтэй.⁶ Мөн Австрали⁷, Энэтхэг⁸ улсуудын парламентад тухайн улсын иргэний харьяалалгүй хүн сонгогдох эрхгүй байдаг.

³ /Парламентын засаглалтай зарим орны парламентын гишүүнээр сонгогдох насны доод хязгаар. Харьцуулсан судалгаа. (СТ-15/215). Улсын Их Хурлын Тамгын газрын судалгаа шинжилгээний хэлтэс. УБ 2015/

⁴ “Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн хууль” Нэгдүгээр зүйл: *Хоёрдугаар хэсэг*. УБ.,2000. Орч.Д.Цолмон, Ч.Лхагважав.

⁵ Мөн тэнд. Нэгдүгээр зүйл: *гуравдугаар хэсэг*.

⁶ <https://www.parliament.uk/get-involved/vote-in-general-elections/standing/>

⁷ https://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/Practice7/HTML/Chapter5/Qualifications_and_disqualifications

⁸ https://rajyasabha.nic.in/rsnew/about_parliament/rajya_sabha_introduction.asp

Монгол улсын хувьд үндсэн хуулийн 3.21 дүгээр зүйлд заасанчлан Улсын Их Хурлын гишүүнээр Монгол улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно. Энэхүү асуудал нь хоёр үндсэн шалтгаантай холбогдоно. Нэгд, манайх төрт ёсны олон зуун жилийн түүхтэй, түүгээрээ омогшин бахархдаг, үндэсний өв уламжлал, ёс заншлын хувьд өөрийн гэсэн өвөрмөц соёлтой, хоёрдугаарт, газарзүйн байрлалын хувьд хоёр их гүрний дунд оршдог, нэгдмэл төрийн байгууламжтай, цөөхөн хүн амтай, жижиг улсын хувьд парламентын гишүүнээр сонгогдох хүнд тавигдах наад захын шалгуур бол Монгол улсын уугуул иргэн байх гэсэн шалгуур юм.

3.Суурьшлын байдал буюу тухайн сонгуулийн тойрогтоо амьдардаг эсэх. Парламентын гишүүнээр сонгогдохын тулд тухайн сонгуулийн тойрогтоо амьдрах ёстой эсэх асуудал нь парламент судлалын маргаантай асуудлын нэг юм. Рациональ байдлаар харвал тухайн сонгуулийн тойрогтоо амьдардаг байх шалгуур нь парламентын гишүүнийг өөрийн тойргийн нөхцөл байдал, нийгэм, эдийн засаг, хууль эрх зүй, ард иргэдийн эрх ашгийн талаар мэдлэг, мэдээлэлтэй байлгах гол суурь зарчмын нэг юм. Өөрөөр хэлбэл парламентын гишүүн тухайн тойрог, орон нутгийн онцлогийг заавал харгалзан үзэх ёстой бөгөөд энэ нь тэдгээрийн онцлогт нийцсэн хууль тогтоомжийг баталж байх гол шалгуур болдог. Гэтэл нөгөө талаас нь А-г төлөөлөхийн тулд заавал А-тай адилхан байх ёстой юу гэсэн асуудлыг сөргүүлж тавьж болох юм. Тухайн тойрогт амьдардаггүй атлаа тойргийн иргэдийг амжилттай төлөөлж, тэдний өмнө тулгарсан олон асуудлыг шийдвэрлэж чаддаг, нэр хүндтэй парламентын гишүүд цөөнгүй байдаг.

Тэгэхээр маргаантай энэ асуудлыг зөв шийдвэрлэх гарц бол парламентын хоёр танхимын зохион байгуулалт юм. Тодруулбал парламентын доод танхим нийт ард түмнийг төлөөлсөн байдаг учраас гишүүд нь тухайн тойрогтоо амьдарч, нутаг орныхоо онцлогт тохирсон шийдвэрийг гаргаж байх нь зүйн хэрэг. Тэгвэл парламентын дээд танхим нь тойргийн төлөөлөл гэхээсээ илүү улсын түвшний төлөөллийг илүү илэрхийлдэг, бодлогын танхим учраас гишүүд нь заавал тухайн тойрогтоо оршин суух шаардлагагүй. Гэвч энэ нь тухайн улсын төрийн байгууламжийн хэлбэрээс ихэд шалтгаалах юм. Тодруулбал холбооны төрийн байгууламжтай улсуудын дээд танхим зөвхөн холбооны улсуудын төлөөллөөс сонгогддог учраас гишүүд нь тухайн холбооны нэгж, тойрогтоо амьдрах шаардлагыг зарим улсууд үндсэн хуулиараа тавьсан байдаг. Тухайлбал АНУ-ын үндсэн хуулиар Төлөөлөгчдийн болон Сенатын танхимд сонгогдохын тулд заавал тухайн муж улсдаа сонгуулийн үеэр оршин сууж байх⁹ шаардлагатай. Харин нэгдмэл төрийн байгууламжтай улсуудын дээд танхим ихэвчлэн засаг захиргааны нэгжийн төлөөллөөс сонгогдохоос гадна нийгмийг бүтцийг тусгах үүднээс мэргэжлийн холбоод, нийгмийн шигшмэл иргэдийн төлөөллөөс томилж бүрдүүлдэг учраас гишүүд нь заавал тойрогтоо оршин суух шаардлагагүй юм.

4.Сонгох, сонгогдох эрх нь хязгаарлагдаагүй байх шалгуур. Парламентын гишүүнээр сонгогдохын тулд сэтгэцийн хувьд эрүүл, урьд өмнө нь ямар нэг ял шийтгэл эдлээгүй байх ёстой гэсэн шалгуурыг тавих явдал нийтлэг байдаг. Тухайлбал Бүгд Найрамдах Турк улсын Үндсэн хуулийн 76 дугаар зүйлд зааснаар нэг жилээс багагүй хугацаагаар хорих ялаар шийтгүүлсэн болон төрийн албанд ажиллах эрхээ хасуулсан, бусдын эд хөрөнгийг шамшигдуулсан, авилга авсан, хулгай, хээл хахуул, залилан, хуурамч бичиг баримт үйлдсэн, хууль бус тендерт оролцсон хэмээн шүүхээс буруутгагдсан, төрийн нууцыг задруулсан, терроризмд оролцсон болон тийм үйл

⁹ “Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн хууль” Нэгдүгээр зүйл: *Хоёрдугаар болон гуравдугаар хэсэг*. 20,23 дахь тал. УБ.,2000. Орч.Д.Цолмон, Ч.Лхагважав

ажиллагааг хөхүүлэн дэмжсэний улмаас улсаас хуулийн дагуу арга хэмжээ авагдсан болон ял шийтгэл эдэлж байгаа хүмүүс Үндэсний Дээд Ассамблейд сонгогдох эрхгүй.¹⁰

Сингапур улсын Үндсэн хуулийн 45 дугаар зүйлд зааснаар сэтгэц мэдрэлийн хувьд эрүүл бус нь шүүх эмнэлгийн магадлан дүгнэлтээр тогтоогдсон,¹¹ мөн 44 дугаар зүйлд зааснаар Сингапурын болон Малайзын холбооны улсын шүүхээр гэм буруутай нь тогтоогдон, нэгээс багагүй жилийн хугацаагаар шоронд хоригдох ялаар шийтгүүлсэн болон 2000-аас багагүй ам доллартой тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр торгуулж, дээрх ял шийтгэлийн хугацаа нь дуусаагүй хүнийг парламентын гишүүнд нэр дэвшигчээр бүртгэж авдаггүй.¹²

5.Парламентын гишүүнээр сонгогдох бусад шалгуур. Парламентын гишүүнд тавигдах дээрх нийтлэг шалгуураас цэргийн алба хаасан байх, эдийн засаг, санхүүгийн хувьд дампуураагүй буюу төлбөрийн чадвартай, тодорхой хөрөнгө чинээтэй байх, парламентын сонгуульд өрсөлдөхийн тулд эрхэлж байсан төрийн албан тушаалаасаа татгалзах, боловсрол, мэдлэг туршлага сайтай байх, цэрэг, цагдаа, шүүх, прокурор зэрэг хууль хүчний байгууллагуудад ажилладаггүй байх, шашны бүлэглэлийн гишүүн биш байх, зэрэг бусад шалгуурууд улс орнуудын Үндсэн хууль болон сонгуулийн тухай хууль тогтоомжоор тавигдсан байдаг. Тухайлбал Мексик улсын Үндсэн хуульд зааснаар Төлөөлөгчдийн танхимд сонгогдохын тулд ямар нэгэн шашны бүлэглэлийн гишүүн байхыг хориглодог.¹³

Турк улсын үндсэн хуульд зааснаар анхан шатны боловсрол эзэмшээгүй буюу бичиг үсэг тайлагдаагүй иргэд, мөн, цэргийн алба хаахаас зайлсхийсэн хүмүүс, шүүгч, прокурор, төрийн байгууллага, яам агентлаг, цэрэг армийн албан тушаалтнууд Үндэсний Дээд Ассамблейд нэр дэвших эрхгүй.¹⁴

Дээр өгүүлсэн Сингапур улсад парламентын гишүүнээр сонгогдохын тулд 21 нас хүрсэн байх, 10-аас доошгүй жил эрх орондоо байнга оршин суусан байх, хуулийн хариуцлага хүлээгээгүй байх зэрэг нийтлэг шалгуураас гадна парламентын хуралдаанд идэвхтэй оролцож, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх мэдлэг чадвартай, үүний тулд биеийн байдлын хувьд эрүүл, англи, малай, мандарин, тамил хэлнүүдийн аль нэгийг унших, бичих, ярих чадварын хэмжээнд эзэмшсэн байх ёстой.¹⁵ Мөн тус улсын Үндсэн хуульд зааснаар эдийн засаг, санхүүгийн хувьд төлбөрийн чадваргүй буюу дампуурсан, хууль бус санхүүгийн ашиг олох зорилгоор бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаа, урьд өмнө нь парламентын болон ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн төлөөлөгчөөр ажиллаж, сонгуулийн зардлын тайлангаа албан ёсоор тайлагнаагүй зэрэг тохиолдлуудад парламентын гишүүнээр сонгогдох эрхгүй.

Монгол улсын хувьд өмнөх жилүүдийг бодвол парламентын сонгуульд нэр дэвшигчдэд тавих шалгуурыг өндөрсгөж байна. Тухайлбал Монгол улсын 2019 онд батлагдсан сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд зааснаар Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигч нь банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүх болон арбитрын шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр

¹⁰ Turkey's Constitution of 1982 with Amendments through 2017. Article.76
https://www.constituteproject.org/constitution/Turkey_2017.pdf?lang=en

¹¹ Constitution of the republic Singapore. Article 45.

<http://www.unesco.org/education/edurights/media/docs/c987002fecaf6f27ffc5d2a18b4488280df3c3362.pdf>

¹² Constitution of the republic Singapore. Article 44.

¹³ Mexico's Constitution of 1917 with Amendments through 2015. Article 55.
https://www.constituteproject.org/constitution/Mexico_2015.pdf?lang=en

¹⁴ Turkey's Constitution of 1982 with Amendments through 2017. Article.76
https://www.constituteproject.org/constitution/Turkey_2017.pdf?lang=en

¹⁵ Constitution of the republic Singapore. Article 44.

төлбөргүй байх, мөн татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх, аль нэг компанийн 51, түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өргүй байх ёстой.¹⁶ Мөн сонгуулийн хуулийн 29 дүгээр зүйлд зааснаар Монгол Улсын Их Хуралд нэр дэвшигч нь тухайн ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө дараах эрхэлсэн ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байх ёстой. Үүнд:

-Төрийн жинхэнэ албан хаагч

-Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан

-Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал.¹⁷

Монгол улсын сонгуулийн тухай хуулиар парламентын гишүүнд нэр дэвшигчдэд тавигдах шалгуурыг энэ мэтчилэн өндөрсгөсөн боловч сонгуулийн тухай хууль тогтворгүй, парламентын ээлжит сонгууль явагдах өмнөх жил бүр эрх баригч нам өөрийн эрх ашигт зориулж өөрчилдөг сөрөг хандлага байсаар байна. Ийм учраас парламентын гишүүнд тавигдах шалгуурыг зарим улсууд өмнө өгүүлсэнчлэн үндсэн хуульдаа зохицуулж өгдөг онцлогтой.

Хоёр. Парламентын гишүүнд тавигдах үндсэн хуулийн бус шалгуур.

Харин одоо парламентад сонгогдсон гишүүний зүгээс үүрэг хариуцлагаа ухамсарлаж, гүйцэтгэж буй ажлаасаа сэтгэл ханамж авах байдал, хувийн ашиг сонирхол, амбиц зэрэг нь гишүүнийг ёс зүйгүй үйлдэл гаргах, эх орныхоо эсрэг муу зүйл хийхгүй байхад нөлөөлж, гишүүнийг сонгогчидтой нь хэрхэн уялдуулж болох талаар ярилцъя. Өөрөөр хэлбэл парламентын гишүүн байх явдал нь өөрөө парламентын гишүүнд тавигдах үндсэн хуулийн бус шалгуурын аяндаа бий болгох юм.

Парламентын гишүүдийг сонгох хүмүүс нь тухайн улсын ард иргэдийн олонхын төлөөлөл яалт ч үгүй мөн. Тэгвэл нийтийн сонголтоор ард иргэд хэнийг хууль тогтоох байгууллагын гишүүнээр тодруулах магадлал өндөр вэ? Үүний хариулт бол тухайн тойргийнхоо итгэлийг дааж чадах хүн юм. Харин эд хөрөнгө, шашин шүтлэг, боловсрол, мэргэжил үүнд төдий л хамаагүй. Хэрвээ хүмүүс өөрсдийгөө төлөөлөх төлөөлөгчөө чөлөөт сонгуулийн зарчмаар тодруулж чадсан л бол сонгууль зохистой явагдсан гэж үзэж болно. Ингэж үзэх хэд хэдэн шалтгаан бий. Үүнд:

Нэгдүгээрт, ард иргэдийн дундаас шилэгдэн гарч ирэхийн тулд тухайн нэр дэвшигчид нь өөрсдийгөө тодорхой хэмжээгээр таниулж чадсан байх нь гарцаагүй.

Хоёрдугаарт, парламентын гишүүнд нэр дэвшиж буй хүн тойргийнхоо өмнө үүрэг хүлээн, олон түмний итгэлийг нь даах амлалтыг өгдөг. Тиймээс хувь хүний мөн чанараараа тэрхүү итгэлийг даахын төлөө ажиллах эрмэлзэлтэй байх нь дамжиггүй.

Гуравдугаарт, парламентын гишүүд хувь хүний хүсэл эрмэлзлээрээ ажлаа сайн гүйцэтгэх хандлагатай байдаг. Өөрөөр хэлбэл бусдын өмнө өөрөөрөө бахархахын тулд хүлээсэн үүргээ нэр төртэйгээр гүйцэтгэхийг зорьдог. Иймээс сонгогчдоо ам сайтай байлгахын төлөө бүхий л хүч чадлаа дайчлах нь зүйн хэрэг юм.¹⁸

Дөрөвдүгээрт, дээрх давуу талууд нь дангаараа үүсэх боломжгүй тул үүний хажуугаар сонгуулийг 4 жил тутам тогтмол явуулж механик хөшүүргийг бий болгож, сонгогчдынхоо өмнө хариуцлага хүлээдэг байх нөхцөлийг бүрдүүлдэгт оршино. Ингэснээр парламентын гишүүд өөрт оногдсон эрх мэдэл хязгаартайг ойлгож, тэрхүү

¹⁶ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. <https://www.legalinfo.mn/law/details/14869>

¹⁷ Мөн тэнд

¹⁸ Д.Лхагвасүрэн, Р.Ууганбаатар, М.Сайнбаяр, Д.Сүхболд, Д.Зоригтбаатар “БНМАУ: Үндсэн хуулийн тайлбар философи” 147 дахь тал. УБ.,2020

эрх мэдэл нь дуусгавар болох үед үргэлжлүүлэх цорын ганц арга зам нь хүлээлгэсэн үүргээ хариуцлагатайгаар гүйцэтгэх гэдгийг ойлгодог байна.

Тавдугаарт, парламентын гишүүдийн бүрэн эрхийнхээ хугацаанд батлан гаргаж буй хууль тогтоомж нь нийгмийн бүхий л хэсгийг хамардаг бөгөөд үүнд тэд өөрсдөө болон ойр дотны хүмүүс нь ч хамаардаг. Баталж буй хууль нь өөрсдийнх нь амьдралд бас хамааралтай гэдгийг мэдсэнээр төрийн эрх барьж буй хүмүүс болон ард түмний хувьд байнгын холбоо үүсэх хамгийн чухал хүчин зүйл бий болох талтай.

Энэхүү зарчмуудыг бүрэн утгаар нь хэрэгжүүлсэн жишээ ховор бөгөөд ингэж чадаагүйн улмаас дарангуйлалд шилжсэн тохиолдол олон. Хууль тогтоох байгууллага шийдвэрээ өөрсдийн болон нийгмийн тодорхой нэг бүлгийн эрх ашигт нийцүүлэн гаргахгүй гэх баталгаа хаана байна хэмээн асууж магадгүй. Тэгвэл үүний баталгаа нь төрийн эрх мэдлийн хуваарилалт дээр үндэслэсэн засаглалын тогтолцоо, шударга үндсэн хууль, ард иргэдийн оновчтой сонголт, эрх чөлөөний үзэл баримтлал зэрэг үнэт зүйлүүд юм. Хүмүүс тодорхой нэгэн шударга бус хуулийг дагаад байж болох хэдий ч эрх чөлөөгөө алдахыг хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй.

Дүгнэлт

Монгол улсын хувьд парламент судлалын зарим ном бүтээлүүдэд парламентын гишүүнд тавих шалгууртай холбоотой зарим судалгаанууд байдаг авч тус асуудлыг парламентын бүтэц, зохион байгуулалт гэсэн ерөнхий сэдэвт хамаатуулж, өнгөц төдий судалсан байдал ажиглагддаг. Тиймээс хууль тогтоох байгууллагын гишүүнээр сонгогдох шалгуурын асуудлыг нарийвчилж судлахад нэмэр болох үүднээс тус өгүүллэгийг бичсэн болно.

Цаашид парламентын гишүүнээр сонгогдох шалгуурын асуудлыг нарийвчлан судалж, улс төрийн шинжлэх ухааны эргэлтэд оруулах, энэ талаарх олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх шаардлагатай. Ингэснээр Монгол дахь үндсэн хуульт төрийн байгуулал, ардчилсан улс төрийн дэглэм, улс төрийн манлайлал, ёс зүйн хөгжилд эерэг нөлөөллийг үзүүлэх болно.

Summary: This article addresses both constitutional and unconstitutional criteria for being elected to parliament. For example, constitutional criteria such as age, citizenship, residency in the constituency, and the right to vote and stand for election were considered based on international experience. And we also intended to talk that the unconstitutional criterion is the awareness of the person of his obligations and satisfaction of work, which he or she fulfills after the election in parliament, personal interests and ambitions, to prevent completion by a member of parliament of any violations, and how a member can communicate with his constituents.

Ашигласан ном бүтээл, эх сурвалжууд

“Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн хууль” УБ.,2000. Орч.Д.Цолмон, Ч.Лхагважав.

Д.Лхагвасүрэн, Р.Ууганбаатар, М.Сайнбаяр, Д.Сүхболд, Д.Зоригтбаатар “БНМАУ: Үндсэн хуулийн тайлбар философи” УБ.,2020

Д.Сүхболд “Монгол дахь парламентын бүтцийн тулгамдсан асуудал ба хоёр танхимтай парламентын хэрэгцээ, шаардлага” Докторын зэрэг горилсон нэгэн сэдэвт диссертаци. УБ., 2019

By Alexander Hamilton, James Madison, and John Jay. “The Federalist Papers” Introduction and Notes by Charles R. Kesler. ISBN 978-0-451-52881-0. Copyright 1961. Softcover with 648 pages including notes and index.

Парламентын засаглалтай зарим орны парламентын гишүүнээр сонгогдох насны доод хязгаар. Харьцуулсан судалгаа. (СТ-15/215). Улсын Их Хурлын Тамгын газрын судалгаа шинжилгээний хэлтэс. УБ 2015

Turkey's Constitution of 1982 with Amendments through 2017.

Constitution of the republic Singapore.

Mexico's Constitution of 1917 with Amendments through 2015.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. 2019 оны 12 сарын 20 өдөр

УЛС ТӨРИЙН НАМЫН ТӨЛӨВШЛИЙН ЗАРИМ АСУУДАЛД

Б.Эрдэнэдалай

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар

Улс төр судлалын тэнхимийн ахлах багш, доктор

Н.Батжаргал

МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн докторант

Хураангуй: Иргэдийн улс төрд хандах хандлага намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн биелэлт, эдийн засгийн байдлаас шууд хамааралтай байгаа нь Монголын улс төрийн ардчилал, түүнд тулгарч буй сорилт бэрхшээлүүдийг гэтлэн давахад улс төрийн намуудын бодлого хөтөлбөрийн шинэчлэлт, хэрэгжилт тэдгээрийг дагасан хөгжил, төлөвшил чухал ач холбогдолтойг харуулж байна. Гэхдээ намуудын төлөвшлийг судалсан, харьцуулсан зүйл ховор, цаашид улс төрийн намуудын төлөвшлийг хэмжих, тодорхойлох хэрэгцээ байсаар байна. Энэхүү өгүүлэлд улс төрийн намын төлөвшлийн асуудлыг судалж буй судлаачид, судалгааны байгууллагуудын үзэл хандлагыг тодорхойлох, ойролцоо утга илэрхийлдэг нэр томьёо, хэмжих шалгуур, гадаад орны намын институцлэлийг тодорхойлж буй аргыг судалж, Монголын улс төрийн намын төлөвшлийг тодорхойлоход ашиглах боломжтой зарим шалгууруудыг санал болгох зорилготой болно.

Түлхүүр үг: намын үүрэг, намын төлөвшил, намын институцлэл, хэмжих шалгуур

Улс төрийн нам нь нийгмийн харилцаанд улс төрийн үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх үүрэгтэй байгууллага бөгөөд улс төрийн системийн гол бүрдүүлэгч юм. Хөрөнгөтний хувьсгал, парламентын хөгжилтэй холбоотойгоор улс төрийн нам үүссэн гэж үздэг. М.Веберийн ангилснаар улс төрийн нам гурван үе шат дамжин төлөвшжээ. Аристократ бүлэглэлийн төрхтэй анх үүсч улмаар улс төрийн клубын хэлбэрт орж, тэр нь олон түмнийг хамарсан нам болон хувирчээ. Английн консерватив, либерал намын эхийг тори, виги гэсэн аристократ бүлэглэл ХҮИ зууны хоёрдугаар хагаст тавьжээ. XIX зууны 30-аад онд эдгээр бүлэглэл нь парламентад суудал авах зорилгоор улс төрийн клуб байгуулсан. XIX зуунд орчин үеийн намын төлөвшлийн эхлэл тавигдсан гэж судлаачид үздэг (Базарпүрэв, 2005). Нийгмийн гишүүд сонгох улс төрийн эрхээр хангагдаж, зохион байгуулалттай ажилчны хөдөлгөөн үүсэн улс төрийн нам байгуулагдахад чухал түлхэц болсон байна. Янз бүрийн хориг, хязгаарлалтыг аажмаар үгүй хийснээр сонгогчдын эгнээ өргөжсөн бөгөөд тэдгээрийн дэмжлэгийг олж авахын тулд нам ардчилал, үндэсний эрх ашиг, иргэдийн сонирхлыг хамгаалах уриа дэвшүүлж байжээ.

Судлаач Д.Истон "Улс төрийн системийн гол зорилго нь нийгмийн бүлгүүдийн ашиг сонирхлоос үүдэлтэй гарч ирдэг зөрүүтэй үзэл санааг аль болох хурцатгалгүй тухайн цаг үед нь шийдэх нь чухал. Үүний тулд юуны өмнө нийгмийн баялгийг зөв, зохистой хуваарилах асуудал тавигддаг. Энэ нь улс төрийн системийн хийх ёстой үндсэн үүрэг" (Easton, 1967) гэж тодорхойлсон. Мөн судлаач М.Сланн "Ардчилсан орнуудад улс төрийн намууд нь сонгуульд ялах, улс төрийн эрх мэдлээрээ дамжуулан

нийгэм, эдийн засгийн хүрээнд тодорхой хууль, тогтоомжийг дэвшүүлэн хамгаалах, эсвэл эсэргүүцэх явдал юм” (Slann, 1998) гэж үзсэн. Францын улс төрийн философич Реймон Арон “...намуудын зорилго бол засаглалыг хэрэгжүүлэх биш, харин засаглалыг хэрэгжүүлэхэд оролцох явдал юм” (УИХ-ын Тамгын газрын судалгааны төв, 2011) гэжээ. Эндээс үзвэл засаглалыг хэрэгжүүлэхэд намуудын хууль ёсны зохистой оролцоо нь ардчилсан нийгэм дэх хэвийн бөгөөд эрүүл үзэгдэл мөн ажээ. Эдгээрээс аливаа орны нийгмийн тогтвортой хөгжилд намууд голлох үүрэг гүйцэтгэж байдаг учраас ардчилал, улс төрийн хөгжлийн гол хэмжүүрийг чөлөөт сонгууль, төлөвшсөн намын бодлого, үйл ажиллагаагаар дүгнэдэг нь харагдаж байна.

Намууд хөгжлийнхөө явцад үзэл баримтлал, хэв маяг, зохион байгуулалт, үйл ажиллагаагаа нийгмийн хөгжлийн ололт, ардчиллын бэхжилттэй уялдуулж ирсэн. Судлаач доктор С.Мөнхбат орчин үеийн намууд нийгэмд ямар үүргүүдийг хүлээж ажилладгийг дараах байдлаар схемчилжээ.

Зураг 1. Орчин үеийн намын гүйцэтгэх үүрэг



Эх сурвалж: С.Мөнхбат. *Монгол дахь улс төрийн намын бүтэц зохион байгуулалтын төлөвшилтийн асуудал*. Докторын диссертаци. УБ., 2009. хуу 52-55

Монголын улс төрийн намууд нийгэм, улс төр, эдийн засгийн олон хүчин зүйлээс хамаарч тэдний өмнө тулгарч буй сорилтууд тэдгээрийг дагасан хэв маягийн өөрчлөлтүүд нь намыг олон янзаар ойлгож, дүгнэхэд хүргэж байгаа. Энэ асуудалд манай судлаачид өөр өөр байр сууринаас хандаж байна. Судлаачдын нэг хэсэг нь Монголд улс төрийн ардчилсан хэв маягийн намууд байхгүй. Харин мөнгө-санхүү, бизнесийн бүлэглэлийн эрхшээлд орсон, тэдний явцуу сонирхлыг илэрхийлсэн нам нэртэй “олигархихсан бүлэглэл” байна¹ гэж үзэж байхад нөгөө хэсэг нь манай намууд төлөвшөөгүй учраас тэдгээрийг намын аль нэг ардчилсан хэв шинжид хамруулан үзэх боломжгүй гэж дүгнэж² буй бол үлдсэн хэсэг нь монголын намуудад төлөвшилтийн үйл явц явагдаж байна. Харин тэдгээрийн төлөвшилт нь орчин үеийн намын хөгжлийн олон хэв маягийн шинжүүдийг өөртөө агуулсан завсрын буюу эрлийз (гибрид) шинж

¹ Б.Дэлгэрмаа. Өнөөгийн Монголын нийгэм дэх олон намын тогтолцооны төлөв байдал. Шинэ толь., 2007. №59, 29 дэх тал. Д.Ганхуяг. Намуудын мандал ба бууралт. Өдрийн сонин., 2005. №286. Ж.Батхуяг. Парламентат ёсны хямрал ба намууд. Өдрийн сонин., 2006. №49. Д.Чулуунжав. Нам шиг намуудтай болох юмсан. Улс төрийн сонин., 2007. №43

² Д.Болд-Эрдэнэ. Улс төрийн намын төлөвшил. Монголын ардчиллын төлөвшил бүтээл. хуудас. 97. Ш.Содном. Улс төрийн намын бүтэц, зохион байгуулалтын төлөв, хандлага. Улс төрийн намуудын төлөвшил, шинэчлэл, хөгжлийн хандлага сэдэвт ЭШ-ний хурлын эмхэтгэл. УБ., 2007. А.Цанжид. Намын шинэчлэлийн зарим асуудал. Улс төрийн намуудын төлөвшил, шинэчлэл, хөгжлийн хандлага сэдэвт ЭШ-ний хурлын эмхэтгэл. УБ., 2007. Т.Гантулга. Улс төрийн намуудын бодлого, үйл ажиллагааны шинэчлэлийн зарим асуудлууд. Улс төрийн намуудын төлөвшил, шинэчлэлт, хөгжлийн хандлага сэдэвт ЭШ-ний хурлын эмхэтгэл. УБ., 2007

төлөвтэйгээр явагдаж байна гэж дүгнэсэн³ байна. Гэвч судлаачдын хувьд Монголын намуудын төлөвшилд сөрөг нөлөө үзүүлж буй дараах хүчин зүйлүүд нийтлэг байгааг хүлээн зөвшөөрч байна. Үүнд:

- Улс төрийн системийн хөгжил, төлөвшлийн таатай бус орчин
- Эрх зүйн боловсронгуй бус зохицуулалт, орчин
- Улс төрийн үнэт зүйлс бэхжээгүй нийгмийн хөрс
- Бизнес-санхүүгийн бүлэглэлийн оролцоо, мөнгөний нөлөө
- Бүтэц, зохион байгуулалтын төвлөрөл, үйл ажиллагааны уян хатан бус байдал
- Дотоод ардчилал, гишүүд, дэмжигчдийн оролцооны хаалттай орчин
- Улс төрийн ашиг сонирхлын зөрчил зэрэг болно.

Улс төрийн нам сонгуульд амжилттай оролцох, сонгуулийн бус үед улс төрийн үйл ажиллагаа явуулж улс орны хөгжлийн бодлогыг тодорхойлох, намын бүтцийг тогтвортой ажиллуулах, үүний тулд тухайн улс төрийн намын бүх түвшний гишүүд намын шийдвэрлэх ёстой аливаа асуудалд санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг, оролцдог, бүх төлөөлөх түвшний сонгуулиудад хүйс харгалзахгүйгээр нэр дэвшин өрсөлдөх, нэр дэвшигчид саналаа өгөх, намын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцах, хянах зэргээр намын үйл ажиллагаанд оролцдог хариуцлагатай гишүүдтэй байх нь намын төлөвшил, дотоод ардчиллыг тодорхойлно (Эрдэнэдалай, 2021). Германы судлаач К.Насмахер “Орчин үеийн Өрнөд Европ, Умард Америкийн ардчиллын түүх бол үндсэндээ нам төвт ардчиллын туршлага бөгөөд улс төрийн намгүйгээр ардчиллыг бүтээн байгуулах оролдлогууд амжилтгүй болж байсан” (Nassmacher, 2003) гэж үзсэн. Тийм учраас аливаа улс орны улс төрийн тогтолцоо, тэр дундаа ардчилалд шилжиж буй орнуудад улс төрийн нам, намын төлөвшил чухал үүрэгтэй гэдэг нь дээрх судлаачдын байр суурь, судалгааны дүнгүүдээс харагдаж байна.

Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа батлан олон намын тогтолцоонд шилжсэн цагаас хойш улс төрийн намуудын тоо тогтмол өссөөр эдүгээ Улсын Дээд шүүхэд 35 улс төрийн нам бүртгэгджээ. Мөн Улсын Их Хурлын, Ерөнхийлөгчийн ба Аймаг нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль тус бүр 8 удаа болжээ. Гэвч өнгөрсөн хугацаанд улс төрийн намуудын төлөвшил, чанарын асуудалд улс төр судлаачид төдийгүй нийгмийн зүгээс шүүмжлэлтэй хандсаар ирлээ. Тухайлбал, Оюу толгой, Таван толгой, Ураны орд зэрэг газрын баялгаа эдийн засгийн эргэлтэд оруулах асуудалд намуудын баримталж байгаа бодлого, байр суурь олон түмний улс төрийн үнэлэмж, хандлагад нөлөөлөх болсон. 2008, 2012 оны УИХ-ын сонгуулийн амлалтууд нийгэмд “хишиг хүртэх” хүлээлтийг бий болгосон. Мөн намууд засгийн эрхэнд гарахын тулд сонгогчдод хэр хэмжээнээсээ хэтэрсэн эдийн засгийн амлалт өгч сонгогддог. Намуудын сонгуулийн амлалт нь буцаад эдийн засагтаа маш хүчтэй нөлөөлдөг болсон. Улс төрийн намууд сонгуулийн амлалтаа хэрэгжүүлэхийн төлөө эдийн засгаа золиослоход бэлэн гэдгээ харуулж ирсэн. 2010 оноос хүн амд бэлэн мөнгө тарааснаар инфляци газар авч, 2010 онд 13 хувь өсч, ирэх онуудад хүчтэй нөлөөлөх тогтворгүй байдал үүсээд байна. Төрийн эдийн засгийн бодлого маш муу байсны нотолгоо нь сүүлийн жилүүдэд инфляцийн түвшин хамгийн хурдтай өссөн явдал юм. Зарим талаараа Ковид-19-тэй холбоотойгоор макро эдийн засгийн тогтворгүй байдал үүсэх, цаашлаад засгийн газрын гаргасан шийдвэрүүд нь

³ Э.Гэрэлт-Од. Монгол дахь улс төрийн намуудын дотоод ардчиллын төлөвшлийн асуудал (1990 оноос хойш) улс төрийн ухааны докторын диссертаци.УБ., 2009. С.Мөнхбат. Монгол дахь улс төрийн намын бүтэц, зохион байгуулалтын төлөвшилтийн зарим асуудал. улс төрийн ухааны докторын диссертаци. УБ., 2009

сонгуулийн санал авахад нөлөөлөх зэргээр иргэдийн эрх ашгийн төлөө биш зүйлүүд ажиглагдаж байна.

Улс төрийн шинжлэх ухаанд намын төлөвшлийг олон янзаар тайлбарлаж байсан бөгөөд судлаачдын судалгааны бүтээлүүдээс харахад дараах нэр томьёонуудыг хэрэглэж байна. Үүнд:

- Хэлбэржилт (formation). XX зууны дунд үеийн судлаачид Г.Алмонд, Б.Паул, Л.Морлино, Д.Истон нар намыг улс төрийн тогтолцооны хэсэг болгон бүрэлдэх, төлөвшүүлэх, хэлбэрших ёстой гэж үзэж байсан.
- Төлөвшил (maturation). XX зууны сүүлээр судлаач Ж.А.Шумпетер, Р.Даль, Л.Даймонд, Р.Катз, П.Майр нар улс төрийн намыг орчин үеийн ардчиллын чухал институт, нам бол амьд организм гэж тодорхойлж байсан.
- Институцлэл (institutionalization). Сүүлийн үед Европын судлаачид, Фернандо Касал Бэрта⁴ нар улс төрийн намын хөгжлийн сорилт, бэрхшээл, өөрчлөлтийг судлан, улс төрийн тогтолцооны тогтвортой байдлыг хангаж чадаж буй эсэх, нийгэм дэх сонирхлыг илэрхийлэх, нэгтгэх, хэрэгжүүлэх үүргээ гүйцэтгэж буй байдал, хууль эрх зүйн зохицуулалт ардчиллын хөгжлийг дэмжиж буй эсэхийг институцлэл хэмээх ойлголтоор илэрхийлж судлах болсон.
- Үр дүнтэй нам (effective party). Харин орчин үеийн Америкийн судлаачид болох Эрика Бэрд, Жулиан Күбэл⁵ нар улс төрийн намыг ардчиллын үнэт зүйлийг дэмждэг, дотоод ардчилалтай, үйл ажиллагаа нь нээлттэй, олон нийтэд хүрч чаддаг байх ёстой гэж үзээд үр дүнтэй, өгөөжтэй нам хэмээх нэр томьёог боловсруулаад байна.

Монголын улс төрийн намуудыг төлөвшсөн, эсвэл төлөвшөөгүй гэж дүгнэх бэрхшээлтэй ч дараах зарим шалтгааны улмаас намын төлөвшлийг тодорхойлоход хүндрэл үүсч байна. Үүнд:

- Намын төлөвшил гэж юуг, ямар үзүүлэлтүүдийг тодорхойлж байгаа нь ойлгомжгүй. Намын төлөвшлийн талаар судлаачид, сонирхогчид олонтаа хэлэлцсэн, судалгаа хийж байсан ч “төлөвшил” хэмээх ойлголтыг өнөөдрийг хүртэл тодорхойлоогүй байна. 1990 оноос өмнө хэлбэржилт /formation/ хэмээх ойлголтыг түлхүү хэрэглэж байсан бол 1990 оноос хойш гадаад хэлний ямар үгийг дүйцүүлж хэрэглэж байгаа талаар судалгаа хийгдээгүй.
- Намуудын түүхэн хөгжил, улс төрийн тогтолцооны ялгаа байсаар байгаа. 1921 онд байгуулагдсан МАН 1990 онд улс төрийн шинэ тогтолцоонд шилжихэд давуу байдлаа хадгалж үлдсэн нь 1990 оноос хойш байгуулагдсан намуудтай харьцуулан дүгнэх боломжгүй байдлыг үүсгэж байна. Ардчилалд шилжсэнээс хойш 31 жилийн түүхэнд МАН давамгайлсан төрийн бүтэц зохион байгуулагдаж байсан. Төрийн албанд бүхэлд нь нэг намын боловсон хүчин, дэмжигчдийг томилсон нь тухайн нам улс төрийн өрсөлдөөнд ямагт давуу байдлаа хадгалах боломжийг бүрдүүлсэн. Мөн сонгуулийн тогтолцоо эрх баригч намуудад ээлтэй тогтолцоогоор шийдэгдэж ирсэн. Сөрөг хүчний намууд сонгогчдын дэмжлэг авдаг хэдий ч, ихэнхдээ парламентад суудал авч чаддаггүй.
- Намын талаарх иргэд, олон нийтийн ойлголт сул, намд итгэх итгэл буурсаар байна. Судалгааны байгууллагуудын “Улс төрийн барометр” судалгааны дүнгээр иргэдийн намд итгэх итгэл улам буурч байгаа. Мөн иргэдийн болон

⁴ Party Institutionalization <https://whogoverns.eu/party-systems/party-institutionalization/>

⁵ Best Practices of Effective Parties: Three Training Modules for Political Parties. NDI <https://www.ndi.org/publications/best-practices-effective-parties-three-training-modules-political-parties>

намын гишүүдийн улс төрийн боловсрол бага. 2018-2020 онд хийгдсэн “Монголын улс төрийн намын дотоод ардчиллын индекс” судалгаанд намын гишүүдийн улс төрийн болон намын дотоод ардчиллын талаарх ойлголт сул байсан гэж дүгнэжээ. Эдгээр асуудлууд нь намын төлөвшлийг хөндлөнгөөс тодорхойлоход бэрхшээлтэй байдлыг үүсгэж байна.

- Эрх зүйн орчны дэмжлэг, зохицуулалт хангалтгүй. Улс төрийн намын тухай анхны хууль 1990 оны 5 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан бөгөөд уг хууль нь таван бүлэг, арван таван зүйлтэй байв. Тус хуулийг намуудын эрх зүйн орчныг сайжруулах шаардлагын дагуу хүчингүй болгож, 2005 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр Улс төрийн намын тухай шинэ хуулийг баталсан. Энэ хууль таван бүлэг, хорин дөрвөн зүйлтэй. Гэвч ардчилал, олон ургальч үзэл, хүний эрхийг дэмжсэн, хариуцлагатай институт болгон төлөвшүүлэх зохицуулалтууд дутуу байсаар байгаа нь намын төлөвшилд сөргөөр нөлөөлж байна. 2014 оноос Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэд хэдэн төслийг хэлэлцүүлж байгаа ч өдийг хүртэл батлагдаагүй байна.

Цаашид намын төлөвшлийг тодорхойлох боломжтой нэр томъёо нь улс төрийн намын институцлэл (political party institutionalization) байх боломжтойг судалгааны байгууллагууд, судлаачид тодорхойлж, арга зүйг боловсруулж, харьцуулаад эхэлжээ. Тухайлбал, Дэлхийн болон бүс нутгийн судалгааны Германы хүрээлэн (German Institute for Global and Area Studies) болон Ардчиллын төрлүүд (Varieties of Democracy) судалгаанаас харж болно.

Учир нь судлаач М.Липсет (Lipset, 2000) “Улс төрийн намуудын зайлшгүй үүрэг” өгүүлэлдээ “Олон намын тогтолцоотой ардчилсан улсад улс төрийн намууд өрсөлдөөний замаар засгийн эрхийг олж авдаг. Тиймээс улс төрийн нам бол ардчилсан тогтолцооны орлуулшгүй чухал институт юм” гэж тодорхойлсон байдаг.

Орчин үед улс төрийн намын институцлэлийн талаарх ойлголт цэгцрээгүй ч нийгмийн хандлагаар намын институцлэлийг үзэл баримтлалын дагуу нэгдэх, зохион байгуулагдах, үүргээ гүйцэтгэх чадавх гэж тайлбарлаж байна. Мөн судлаач С.Хантингтон (Huntington, 1968) “нам институцлэх гэдэг нь байгууллага, журам нь үнэ цэн, тогтвортой байдлыг олж авах үйл явц юм” гэж тодорхойлсон. Судлаач Селзник, Брүүм (Selznick, Broom, 1955) нар намын институцлэл гэдэгт үнэ цэнийг чухалчилж, “үнэ цэн-сэлбэлт” буюу “value-infusion” гэсэн нэр томъёог ашигласан. Харин судлаач А.Панибиенко (Panebianco, 1988), С.Линдберг (Lindberg, 2007) нар намын институцлэлд үнэ цэн дээр нэмээд тогтвортой байдал буюу “stability” чухал гэж үзэж байна.

Намын институцлэлийг “тогтвортой байдал”, “үнэ цэнийн сэлбэлт”-ээр тодорхойлбол, институцлэлийг бүрэн илэрхийлж чадах эсэх нь эргэлзээтэй байна. Судлаач К.Жанда (Janda, 1980) хамгийн гол нь намууд бол байгууллагууд тул системийн өгөх ёстой бүх ашиг тусыг өгч чадахгүй. Харин судлаач А.Панибиенко (Panebianco, 1988) “институцлэгдсэн нам” нь гаднаасаа бие даасан, дотооддоо тодорхой хэмжээний “системчилсэн” байх ёстой гэж үзжээ. Энэ нь бусад намуудаас хараат бусаар ажиллах бүтцийг бий болгосноор тодорхойлогдож болох юм.

Тэгэхээр улс төрийн намын институцлэл гэдэг нь сонгуульд оролцож буй улс төрийн намуудын хувьд байгууллагын тогтвортой байдал, үнэ цэн нэмэгдэх үйл явц юм. Эцэст нь намын дотоод болон гадаад харилцаа институцлэгдэх ёстой. Мөн намыг институцлэгдсэн гэдгийг тодорхойлоход ямар шалгуур хэрэгтэй вэ гэдгийг тодорхойлох хэрэгтэй.

Дэлхийн болон бүс нутгийн судалгааны Германы хүрээлэн (German Institute for Global and Area Studies) болон Ардчиллын төрлүүд (Varieties of Democracy, 2021) судалгаанаас харахад дараах шалгуурыг ашиглаж байна. Үүнд:

- Байгууллагын түвшин (level of organization) нам байгууллага болохын хувьд хэрхэн институцлэгдсэн байдлыг тодорхойлох,
- Дотоод уялдаа холбоо (coherence) нь ихэнх судлаачдын оруулсан хоёр дахь шалгуур юм. Дээр дурдсан "байгууллагын түвшин" -тэй адил уялдаа холбоог хэрхэн уялдуулж байгаагаар намын институцлэлийг тодорхойлох,
- Бие даасан байдал (autonomy) нь төрөөс хараат бус байдлаар намын институцлэлийг тодорхойлох,
- Нийгмийн дэмжлэг (root in society). Энэ нь тухайн нам нийгэмтэй нягт уялдаа холбоо байгаа, дэмжлэг авдаг эсэхийг тус тус тодорхойлох хэрэгтэй болох юм.

Судлаачдын болон судалгааны байгууллагуудын судалгаа, дүгнэлтэд үндэслэн улс төрийн намын институцлэлийг хэмжих дараах шалгуурууд боломжтой байна.

Хүснэгт 1. Намын институцлэлийг хэмжих шалгуур

Хэмжилт	Шалгуур
Нийгмийн дэмжлэг: Улс төрийн нам нийгмийн тогтвортой дэмжлэг авдаг эсэх	Намын нас
	Олон намын тогтолцоо бүрдсэн үеэс нам ажиллаж эхэлсэн эсэх
	Сонгогчдын дэмжлэг, өөрчлөлт
	Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч ажилладаг эсэх
Бие даасан байдал: Нам нь нийгмийн үндэс угсааг үл харгалзан нам доторх хувь хүмүүс болон намын гаднах нийгмийн бүлгүүдээс харьцангуй хараат бус байдаг	Намын манлайлагчдын тоо
	Намын манлайлагчдын сонгуулийн дэмжлэг
	Хувь хүн, бүлгээс хараат бусаар шийдвэр гаргадаг эсэх
	Намын талаар олон нийтийн дэмжлэг
Байгууллага: Намын ашиг сонирхлын төлөө ажилладаг зохион байгуулалтын аппарат	Гишүүнчлэлийн чадавх
	Намын их хурал тогтмол хуралддаг эсэх
	Намын хөрөнгө, санхүүжилт
	Сонгуулийн бус үед үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж, ажиллаж чадаж байгаа эсэх
Уялдаа холбоо: Нам нь эвлэлдэн нэгдсэн байгууллагын хувьд санал зөрөлдөх, байр суурийн ялгаатай байдлыг тэвчих	Парламентын бүлэгтэй хэрхэн хамтарч ажилладаг
	Нам доторх бүлэг хооронд зохицуулсан механизм бий эсэх
	Нам доторх зөрчилдөөн, тэвчих чадвар

Эцэст нь дүгнэхэд, улс төрийн нам хэмээх институцийн төлөвшлийг хэрхэн ойлгох, ялгаатай нэр томъёог хэмжиж болох эсэх нь улс төр судлаачид болон улс төрд оролцогчдын анхааралд байсаар ирсэн. Улс төрийн шинжлэх ухаанд formation, maturation, institutionalization, effective party зэрэг нэр томъёог улс төрийн намын төлөвшилтэй холбон хэрэглэж байна.

Монголын намуудын төлөвшлийг хэрхэн тодорхойлох аргачлал байхгүй, намуудын түүх, хөгжил нь харилцан адилгүй, намуудад хандах иргэдийн хандлага, итгэл хүлээлгэх байдал сул, олон нийтэд үнэлэгддэггүй, намын эрх зүйн зохицуулалт хангалтгүй зэрэг асуудлууд байна. Цаашид Монголын улс төрийн нөхцөл байдал, онцлогт тохирсон намын институцлэлийн индексийг боловсруулж, намын төлөвшлийг нарийвчлан тогтоох хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Ашигласан ном, материал

- Базарпүрэв, С. 2005. *Улс төрийн шинжлэх ухаан*. хуу 66
- Болд-Эрдэнэ, Д. 2008. *Монголын улс төрийн нам, намын системийн төлөвшил*. УБ., Гэрэлт-Од, Э. *Монгол дахь улс төрийн намуудын дотоод ардчиллын асуудал: 1990 оноос хойш*. Улс төрийн ухааны докторын диссертаци. УБ.,
- Мөнхбат, С. 2009. *Монгол дахь улс төрийн намын бүтэц зохион байгуулалтын төлөвшилтийн асуудал*. Улс төрийн ухааны докторын диссертаци. УБ., 2009 он.
- Сантмарал, УТБА. *Улс төрийн барометр* судалгаанууд. 1990-2000 он.
- УИХ-ын Тамгын газрын судалгааны төв. 2011. *Улс төрийн намын гишүүнчлэл, төлөвшил, нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгууль, парламент болон орон нутгийн сонгуулийг зэрэг явуулах нь (зарим орны жишээн дээр)*. УБ.,
- Эрдэнэдалай, Б. 2021. *Монгол дахь улс төрийн намуудын санхүүжилтийн тулгамдсан асуудал, цаашидын хандлага*. УБ., Хуу 12
- Basedau, Matthias; Stroh, Alexander. 2008. *Measuring Party Institutionalization in Developing Countries: A New Research Instrument Applied to 28 African Political Parties*, GIGA Working Papers, No. 69, German Institute of Global and Area Studies (GIGA), Hamburg
- Best Practices of Effective Parties: Three Training Modules for Political Parties. NDI <https://www.ndi.org/publications/best-practices-effective-parties-three-training-modules-political-parties>
- German Institute for Global and Area Studies <https://www.giga-hamburg.de/en/>
- Easton, D.A. 1967. *Systems analysis of Political life*. New York. pp.21
- Janda, Kenneth. 1980. *Political Parties: A Cross-National Survey*. New York: Free Press.
- Lindberg, Staffan. 2007. *Institutionalization of party systems? Stability and fluidity among legislative parties in Africa's democracies*, in: *Government and Opposition*, No. 2, Vol. 42, pp. 215-241.
- Lipset, Seymour Martin. 2000. *The Indispensability of Political Parties*, in: *Journal of Democracy*, No. 1, Vol. 11, pp.48-55.
- Nassmacher, Karl-Heinz. 2003. "Introduction: Political Parties, Funding and Democracy" *Chapter 1 in Funding of Political Parties and Election Campaigns: Handbook Series*. International IDEA. pp.6-7
- Huntington, Samuel. 1968. *Political Order in Changing Societies*. New Haven: Yale University Press.
- Panebianco, Angelo. 1988. *Political Parties: Organization and Power*. Cambridge: Cambridge University Press.
- Party Institutionalization <https://whogoverns.eu/party-systems/party-institutionalization/>

Selznick, Philip / Broom, Leonard. 1955. *Sociology: A text with adapted readings*. New York: Harper & Row.

Slann, M. 1998. *Governments and Nations in the Post Cold War Era*. USA. pp 194

Varieties of Democracy <https://www.v-dem.net/>

НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ БАЙГУУЛЛАГА ИРГЭДИЙГ ТӨЛӨӨЛӨХ НЬ

Д.Ундрах

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн дэд профессор

Г.Ануцэцэн

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар
Улс төр судлалын тэнхимийн магистрант

Хураангуй: Энэхүү судалгааны ажлын хүрээнд нутгийн өөрөө удирдах ёсны талаарх үүсэл, хөгжил, ойлголт, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төлөвшүүлэх асуудлыг хөндөж, өнөөгийн байдалд хийсэн үнэлгээ зэргийг танилцуулж дүгнэлт гаргасан болно.

Abstract: This study focuses on the origins, development, and understanding of local self-governance, the activities of local self-governing organizations, and the issues of increasing , building citizen participation, and presents an analysis of the current situation.

Түлхүүр үгс: өөрөө удирдах ёс, засаг захиргаа, нутаг дэвсгэр, иргэдийн оролцоо

Удиртгал:

Нутгийн өөрөө удирдах ёсны талаарх ойлголт, онол-арга зүйг судлаж, нутгийн удирдлага дахь иргэдийн оролцоо хийгээд иргэдийн төлөөллийн байгууллага иргэдийг төлөөлж чадаж байгаа эсэхийг тодруулснаар иргэдийн оролцоог нэмэгдүүлэх бодит боломж, арга замыг дэвшүүлэхийг зорилоо.

Нутгийн өөрөө удирдах ёсны тухай ойлголт

“Өөрөө удирдах ёс” гэсэн ойлголтыг анх Францын хувьсгалын үед төртэй харилцах засаг захиргааны нэгжийн бие даасан байдлыг илэрхийлэхийн тулд хэрэглэжээ. Нутгийн өөрөө удирдах ёсны онолын үндэс нь XIX зууны эхэнд Европын орнууд болон Америкт тавигдсан бөгөөд гол төлөөлөгчид нь Д. Морган, А. Токвиль, Л. Штейн, Р. Гнейст зэрэг эрдэмтэд байв.

Европын зөвлөлөөс 1985 онд баталсан “Нутгийн өөрөө удирдах ёсны тухай” Хартийн (European Charter of Local Self-government) 3.12-д “Нутгийн өөрөө удирдах ёс гэдэг нь нутаг дэвсгэрийн бие даасан субъектээс өөрийн хариуцлага дор төрийн хэргийн үлэмж хэсгийг тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн, хуулийн хүрээнд шийдвэрлэх, удирдлагыг хэрэгжүүлэх эрх, бодит чадвар юм” гэж тодорхойлжээ.¹

¹ Орон нутгийн удирдлага. УБ 2019., 42 дахь тал

Орон нутгийн удирдлага, нутгийн өөрөө удирдах ёсны онолын үндэс

Орон нутгийн өөрөө удирдах засаглал (ёс)-ын онолууд XIX зууны эхний хагаст бие хүн ба төр, орон нутаг ба төв засаглалын хоорондын харилцааны маргаан тэмцлийг шийдвэрлэх ардчилсан засаглалын арга хэрэгсэл болон гарч иржээ. Орон нутгийн бие даасан байдлыг хангахад чиглэсэн эрх мэдлийн төлөөх өөрөө удирдах ёсны байгууллагын XVIII-XIX зууны шинэчлэлийн цувралууд нь тодорхой онолын үндэслэлд суурилан хөгжсөн юм. Орон нутгийн өөрөө удирдах ёсны онолын үндэслэлийг боловсруулахад Алексис де Токвиль, Рудольф фон Гнейст, Лоренц фон Штейн, Пауль Лабанд нар гол үүрэг гүйцэтгэжээ. Орон нутгийн өөрөө удирдах ёсны онолыг орчин үеийн судлаачид янз бүрээр авч үзсэн. Тухайлбал Григорий С. Михайлов нарын эрдэмтэд аж ахуй ба нийгмийн, төрийн, улс төрийн гэж гурав ангилсан. Харин Н.И.Лазаревский нарын эрдэмтэд чөлөөт нийгмийн онол, өөрөө удирдах ёсны эдийн засаг-нийгмийн онол, өөрөө удирдах нэгж, хуулийн этгээд болох тухай онол, өөрөө удирдах ёсны улс төрийн онол гэж дөрөв ангилсан. Орчин үеийн судлаачдын олонх нутгийн өөрөө удирдах ёсны хөгжлийн онолын үндсийг чөлөөт хамтлагийн (коммуни), нийгмийн, төрийн, дуализмын, нийгмийн үйлчилгээний гэсэн таван чиглэлд авч үздэг.

Нутгийн өөрөө удирдах ёсны онолын үндсийг:

- Чөлөөт хүй нэгдэл (коммун)-ийн
- Нийгмийн
- Улсын салбарын
- Дуализмын
- Нийгмийн үйлчилгээний гэсэн таван чиглэлд авч үздэг.

I. Чөлөөт коммуны онол /The theory of natural law/:

XIX зууны эхээр Германы эрдэмтдийн боловсруулсан жам ёсны эрхийн сургаал дээр тулгуурлаж энэ онол бий болжээ. Тус онолыг С. Хэрбэр, М. Арэнс, Э. Мейэр, О. Лабанд, О. Ресслер нар хөгжүүлжээ. Энэхүү онолын үзэл баримтлал коммуны хэрэгт төр оролцох ёсгүй гэж үздэгт оршино. Уг үзлийг баримтлагчид нь “нутаг усныхан өөрийн ажил хэрэг, ахуй, амьдралаа эрхлэх нь хүний эрх чөлөөний нэгэн адил зүй ёсны ангижруулагшгүй шинжийг агуулж байдаг ба коммуны удирдлага нь:

- Төрийг удирдахаас ялгаатай
- Төрөөс бус дотроосоо бий болох ёстой
- Хуулийн хүрээнд ажиллах ба гагцхүү хуулиар төрөөс тусгаарлагдана хэмээн үзэж байв. Гадаад орчны нөлөөллөөс ангид өөрсдийн асуудлаа өөрсдийн эрх тааваар бие даан шийдвэрлэх бүлэг хүмүүс гэж ойлгож болох юм. Энэ онолоор орон нутгийн иргэдийн өөрсдийн асуудлаа бие даан шийдвэрлэх эрх нь улсын салбарын удирдлагатай огт хамааралгүй бөгөөд хүний заяамал эрх болно. Энэ утгаараа үзвэл улс оронд эрх мэдлийн 1. Хууль тогтоох, 2. Гүйцэтгэх, 3. Шүүх, 4. Орон нутгийн өөрөө удирдлагын дөрвөн хуваарилалт байдаг хэмээн сургадаг. Энэ онол XIX зууны 30, 40-өөд оны үед олон улс орны хууль эрх зүйн баримтуудад тусгалаа олсон байдаг. Тухайлбал, 1831 оны Бельгийн үндсэн хуульд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн зэрэгцээ коммуны эрх мэдэл оршино гэж заажээ.

II. Өөрийгөө удирдах аж ахуй ба нийгмийн онол /The economic and public theory of local self-government/:

Энэ онол нь чөлөөт коммуны онолын адил төр, нийгмийн хоорондох зөрчилт байдлаас үүссэн байна. Тус онолыг анх хөгжүүлэгчид нь Германы О. Рэсслер, Р. Моль, Оросын В.Н.Лешков, А.И. Васильчиков нарын эрдэмтэд байв.

Гол үзэл санаа нь: Нутгийн удирдлага нь ихэвчлэн аж ахуй, нийгэм, эдийн засгийн асуудлууд тул тэдгээр нь улс төрийн шинж чанартай биш бөгөөд орон нутаг өөрөө асуудлаа шийдвэрлэх ёстой. Нутгийн удирдлагыг улсын салбарын удирдлагаас тусгаарлан авч үзэхийн шалтгаан нь орон нутаг өмч хөрөнгөө захиран зарцуулах эрх чөлөөнд орших бөгөөд үүгээр орон нутгийн удирдлагын бие даасан байдлыг хэмжиж болно хэмээн үзэж байв. Орон нутгийн өөрөө өөрийгөө захирах засаглал бол орон нутгийн эдийн засгийн харилцааны гол үндэс юм.² Лешков орон нутгийн удирдлага, улсын салбарын удирдлага нь хоёр өөр мөн чанартай тул саланги, тусгаар орших ёстой гэсэн санаа гаргажээ. Гэвч энэ хоёр удирдлага нэг нэгнийхээ үйл ажиллагаанд хяналтын үүрэг гүйцэтгэж болохыг нь үгүйсгээгүй юм. Түүнчлэн улсын салбарын удирдлага эрх мэдэл дээр суурилдаг бол орон нутгийн удирдлага иргэдийн хэрэгцээ, сонголт дээр тулгуурладаг гэжээ.³ Нийгмийн онолоор бол нутгийн удирдлага зорилгоо хэрэгжүүлэх нь зөвхөн тэдний эрхийн асуудал бөгөөд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь төрийн байгууллага биш гэж үздэг байсан байна. Нийгмийн онол нутгийн өөрөө удирдах байгууллага нь бие даасан, тухайн нутаг дэвсгэрийн ашиг сонирхлыг илэрхийлэгч болохоос төрийн байгууллага биш гэсэн санааг гаргаж тавьснаар нутгийн өөрөө удирдах ёсны онолын хөгжилд чухал хувь нэмэр оруулсан юм.⁴

III. Төрийн онол /The theory of state/:

Гол төлөөлөгчид: Рудольф Фон Гнейст, Лоренц Фон Штейн нар юм. Тус онол нь 1917 оноос өмнө Орос оронд ихээхэн нөлөөтэй байсан бөгөөд Н.И.Лазаревский, А.Д. Градовский, В.П.Безобразов нарын төрийн онолчид дорвитой хөгжүүлсэн ажээ.

Онолын мөн чанар нь: 1. Нутгийн иргэдийн байгуулсан өөрөө удирдах байгууллагыг төрийн байгууллагад шилжүүлэх, 2. Нутгийн иргэдийн байгуулсан өөрөө удирдах байгууллагыг төрийн хяналтад оруулах, 3.ӨУЁ-ны байгууллага нь төрийн хүсэл сонирхлыг илэрхийлэхгүй, өөрсдийн ашиг сонирхолтой байж болох бөгөөд энэ нь төрийн ашиг сонирхолд нийцэхгүй байж болно. Энэ онолоор нутгийн өөрөө удирдах ёс төрийн удирдлага зохион байгуулалтын нэг хэсэг гэж үзсэн. Өөрөө удирдах ёсны бүрэн эрх нь төрөөс зөвшөөрсөн хэмжээгээр хэрэгждэг байна.⁵

IV. Дуализмын онол / The theory of dualism/:

Гол төлөөлөгч нь В.М.Гессен. Тэрээр хувь хүн, иргэний нийгэм болон төр засгийн хооронд үр ашигтай хоёр талын харилцааг бий болгох нөхцөлийг бүрдүүлдэг гэжээ. Энэ онолыг Борис Н. Чичерин орон нутгийн удирдлагын эрх мэдлийн үйл ажиллагаа нутгийн эрх ашгаас давж, төрийн захиргааны хэрэгслийн үүрэг гүйцэтгэдэг гэж үзжээ. Дуализмын онол нь хангалттай хөгжөөгүй боловч түүний агуулга дараах шинж чанартай:

² Нийтийн удирдлагын үндэс. Хамтын бүтээл. УБ.,2018

³ Орон нутгийн удирдлага. УБ.,2019

⁴ Мөн тэнд

⁵ Нийтийн удирдлагын үндэс. Хамтын бүтээл. УБ.,2018

- Улс, үндэстний болон орон нутгийн ашиг сонирхол, тэдгээрийн хослол хэрэгцээ;
- Орон нутгийн болон үндэстний хэмжээний олон шийдвэрлэх асуудлыг салгах, боломжгүй;
- Орон нутгийн засаг захиргаа төрийн болон хувийн хэвшлийн хуулийн чиг үүргийг хэрэгжүүлэх;
- Төрийн нийтлэг болон өөрөө удирдах байгууллагын зарчмуудыг хослуулах зэрэг болно.⁶

V. Нийгмийн үйлчилгээний онол / Theory of social service /:

Онолын гол үзэл санаа нь нутгийн өөрийн удирдлагын үйл ажиллагааны гол зорилго бол нутаг дэвсгэрийн оршин суугчдын сайн сайхан байдлыг хангах явдал гэж үзжээ. Мөн оршин суугчдадаа үйлчилгээ үзүүлэх нь нутгийн өөрийн удирдлагын үүрэг гэж үздэг байна.

Эдгээр онолын чиглэлүүд тухайн цаг үеийн нөхцөл байдалд хэрэгжих боломжоор тодорхойлогдож ирсэн бөгөөд давуу болон сул талуудтай, амьдралд дангаараа хэрэглэгдэхгүй болох нь түүхийн явцад тодохой болсон байна. Өөрөө удирдах ёс тухайн улс төрийн байгууламж, улс төрийн тогтолцооны хэв маяг, хэлбэр, иргэдийн аж төрөх ёс, зан заншил, уламжлал зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой юм.⁷

Нутгийн өөрөө удирдах ёсны үндсэн хэв загварууд

Дэлхийн улс орнуудад нутгийн удирдлагын байгууллага нь эрх мэдлийн хуваарилалтаасаа хамаараад тогтсон хэдэн загвар байдаг.

Англо-саксоны загвар нь Англиас уламжлалтай бөгөөд иргэний эрх чөлөөг дээд зэргээр дээдэлдэг, төрийн аппаратын хүнд суртал бага АНУ, Канад, Австрали зэрэг улсад төлөвшсөн бөгөөд нутгийн удирдлагын бие даасан байдлын хамгийн өндөр түвшнийг илэрхийлдэг.⁸ Нутаг дэвсгэр-засаг захиргааны нэгжийн удирдах байгууллагуудыг төв засгийн газраас байгуулах буюу томилдоггүй, гагцхүү нутгийн өөрийн удирдлагын байгууллагаас сонгож аль болох томилгоот албан тушаалаас татгалздаг байна. Иргэдээс сонгосон төлөөллийн байгууллага нь нутгийн удирдлагын хүрээнд голлох байр суурьтай байдаг, өөрөөр хэлбэл “орон нутгийн ашиг сонирхлын хүрээнд хамаарах бүхий л эрх мэдлийг” нутгийн өөрөө удирдах байгууллагад өгдөг. Сонгуульт албан тушаалтнуудад хэн нэгэн дээд албан тушаалтнаас хараат бус байж зөвхөн өөрийн сонгогчдоос хамааралтай байх боломжоор хангагдсан гэж үздэг. /АНУ, Их Британи, Канад, Австрали, Шинэ Зеланд гэх мэт/⁹

Эх газрын буюу Францын загвар нь Францаас уламжлагдсан, эх газрын Европын, франц хэлт Африк, Латин Америк, Ойрхи Дорнодын улсуудад хэрэглэгддэг тус загвар нь орон нутаг дахь төрийн шууд удирдлагыг өөрөө удирдах ёстой хослуулдаг. Төрийн удирдлагатай хослох зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн удирдлагаас гаргаж байгаа шийдвэр хуульд нийцсэн эсэхийг хянах эрх бүхий Засгийн газрын комиссар (commissaire du gouvernement) ажиллуулдаг. Засгийн газрын комиссар нь хянахын зэрэгцээ засаг захиргааны нэгж болон нутгийн өөрийн

⁶ Нийтийн удирдлагын үндэс. Хамтын бүтээл. УБ., 2018

⁷ Нийтийн удирдлагын үндэс. Хамтын бүтээл. УБ., 2018

⁸ Орон нутгийн удирдлага. УБ 2019

⁹ Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь. Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж, УБ 2019

удирдлагын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх шүүх ажиллагаанд саналаа илэрхийлж оролцдог байна.¹⁰

Германы загвар буюу холимог загвар: Германы нутгийн өөрийн удирдлагын зохион байгуулалт өвөрмөц онцлогтой бөгөөд нутгийн өөрөө удирдах ёсны Европын Хартийн үзэл баримтлалд нийцсэн, Англо-саксоны ч, Эх газрын ч зарчмыг хадгалсан байдаг.¹¹ Төрийн удирдлагын болон нутгийн өөрөө удирдах байгууллагууд нь нэгэн нэгдсэн институтэд багтсан байдаг.¹²

Нутгийн өөрөө удирдах ёсны шинж:

- Нутгийн өөрөө удирдах байгууллага нь нутаг дэвсгэрийнхээ дотоод асуудлыг болон бие даан шийдвэрлэдэг байх
- Нутгийн өөрөө удирдах байгууллагын гаргаж буй шийдвэр нь тухайн нутаг дэвсгэртээ засаглах буюу заавал биелэх шинжтэй байх
- Нутгийн өөрөө удирдах байгууллага нь гадны ямар нэгэн дарамт шахалтанд орохгүйгээр бие даан өөрийнхөө асуудлыг шийдвэрлэж хэрэгжүүлдэг байх

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэгтэй. Үүнд:

1. Орон нутгийн хэргийг шийдвэрлэхэд иргэдийн оролцоог хангах
2. Орон нутгийн өмч болон санхүүгийн нөөцийг удирдах
3. Нутаг дэвсгэрийн хөгжлийг хангах
4. Нутаг дэвсгэрийн нийгэм ахуй, соёлын болон иргэдийн амьдралд зайлшгүй шаардлагатай бусад нөхцлийг хангах
5. Харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавих юм.

Монгол Улсын нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага

Монгол улс социалист тогтолцооноос татгалзаж, улс төр, нийгэм, эдийн засгийн шинэ харилцаанд шилжин орсноор нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан шинэчлэл хийх шаардлага тулгарсан. 1992 оны Үндсэн хуулиар ардчиллын бодит баталгааны нэг болох нутгийн өөрөө удирдах байгууллагын шинэ тогтолцоог бий болгосон. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх зүйн зохицуулалт нь Үндсэн хуульд тусгагдснаар энэ байгууллага Үндсэн хуулийн байгууллага болж, баг хороо, засаг захиргааны анхан шатны нэгж гэж анх удаа хуульчлагдсан.¹³

2006 онд батлагдсан Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар “Нутгийн өөрөө удирдах ёс нь чөлөөт сонгуулиар сонгогдсон төлөөлөгчидтэй, түүнд тайлагнадаг гүйцэтгэх байгууллагатай, тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн асуудлыг иргэдийн ашиг, сонирхолд нийцүүлэн хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх эрх зүйн бодит

¹⁰ Орон нутгийн удирдлага. УБ., 2019

¹¹ Орон нутгийн удирдлага. УБ., 2019

¹² Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь. Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж., УБ 2019

¹³ Монгол улсын Үндсэн Хууль. 1992., УБ

чадвар мөн” гэж тодорхойлсон болно. Энэ нь Монгол Улсын хувьд “Нутгийн өөрөө удирдах ёс” гэж юу болохыг анх удаа тодорхойлж өгсөн болно¹⁴.


“Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-д Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоо нь:

- Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
- Баг, хорооны Иргэдийн нийтийн хурал
- Хурлын хуралдааны чөлөө цагт тэдгээрийн тэргүүлэгчид
- Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны засаг дарга гэжээ.

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь чөлөөт, тэгш, шууд сонгуулийн үндсэн дээр байгуулагддаг, тухайн нутгийн иргэдийн хууль ёсны нийлэг эрх ашгийг илэрхийлэх, тэднийг төлөөлөх, тухайн нутаг дэвсгэрийн амьдралын асуудлыг иргэдийнх нь эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэх, эрхлэн хөтлөх үүрэг бүхий, үйл ажиллагаа нь төлөөллийн ардчиллын зарчим дээр үндэслэсэн шийдвэр гаргаж, хамтын хариуцлага хүлээдэг байгууллага билээ. Энэ нь Монгол Улсын Үндсэн Хуульд зааснаар аймаг нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, баг хорооны иргэдийн нийтийн хурал юм. Монгол Улсын Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр Хурлын болон сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно” гэжээ. ЗЗНДНТУТХууль батлагдангуут иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлыг байгуулах сонгууль 1992 оны 9 дүгээр сард орон даяар явагджээ. Үүнээс хойш Монгол Улсад орон нутгийн 7 удаагийн сонгууль болсон.

¹⁴ Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль .2006., “Төрийн эмхэтгэл, 2007 оны 02 дугаар”

Схем 1. Засаг захиргаа нутаг дэвсгэр, түүний удирдлага¹⁵




Эх сурвалж: / Монгол Улсын Төрийн Тогтолцооны товч нэгтгэл

¹⁵ Монгол Улсын Төрийн Тогтолцооны товч нэгтгэл. УБ 2018., 423 дахь тал

Улаанбаатар хот, түүний удирдлага


Схем 2. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ба ажлын албаны бүтэц¹⁶



Эх сурвалж: / Судлаач өөрөө бэлтгэв. /

¹⁶ Эх сурвалж: Судлаач өөрөө бэлтгэв.

Схем 3. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтэц¹⁷



Эх сурвалж: / Судлаач өөрөө бэлтгэв. /

¹⁷ Эх сурвалж: Судлаач өөрөө бэлтгэв.

Иргэдийн төлөөллийн байгууллага ба иргэдийн оролцоо

Иргэдийн төлөөлөгчдийн хурал бол нутгийн өөрөө удирдах ёсны дээд байгууллага. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдөө сонгох нь УИХ-ын гишүүнийг сонгохоос ч чухал байх учиртай. Учир нь тухайн иргэдийн төлөөлөгчдийн хурал бол орон нутагт юу хийх, төсвийг хэрхэн зарцуулах зэрэг нийгэм орон нутагт хэрэгтэй шийдвэрүүдийг олон нийттэй хамтран ажилладаг төлөөллийн байгууллага юм.¹⁸

Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь харъяалах нутаг дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий засаг төрийн төлөөлөгч юм. Сум, дүүргийн Засаг даргад тухай тухайн ИТХ-аас нэр дэвшүүлж, дээд шатны Засаг дарга томилно.¹⁹

ИТХ нь сонгогдсон нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засаг, хөгжлийн бодлогын асуудлыг ИТХ болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, гаргасан шийдвэрээ хэрэгжүүлдэг юм. Мөн нутгийн өөрөө удирдах байгууллагын хувьд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, иргэдийн эрх ашгийг хамгаалж, тэдэнтэй тогтмол холбоотой ажиллан, санал гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэн, Засаг даргыг нэр дэвшүүлэх, түүнийг чөлөөлөх, огцруулах болон Засаг дарга, тухайн нутаг дэвсгэрт төрийн үйлчилгээг үзүүлэх байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах үүрэгтэй.

1992 оноос хойш нутгийн захиргааны байгууллагууд болох ИТХ, Засаг дарга түүний тамгын газар иргэдийн хэрэгцээ шаардлага, ая тухтай амьдралын баталгааг хангуулах үүрэгтэйгээр ажиллаж эхэлсэн. Энэ талаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд хуульчилж өгсөн. Иргэдийн оролцоог хангах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр заасан холбогдох хуулийн заалтыг авч үзье.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль

24 дүгээр зүйл. Хуралд асуудал оруулах эрх /Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. 2006 оны шинэчилсэн найруулга/

“...Хурлын тэргүүлэгчид, хороо, түүнчлэн төлөөлөгч, тухайн нэгжийн Засаг дарга асуудал хэлэлцүүлэхээр оруулах эрхтэй

Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн тухайн шатны Хуралд, сум дүүрэг, баг, хорооны Хурал зохих дээд шатны Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно...” гэж заасан.

Хуульд заасан энэ эрхийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар “Тунгаамал төв” ТББ-аас 2018 онд 200 орчим иргэдээс судалгаа авахад дараах үр дүн гарсан байна.


“Та ИТХ-ын төлөөлөгчдөө ямар нэгэн асуудал тавьж уулзаж байсан уу? Шийдвэрлэж чадсан уу?” гэсэн асуултад *чадсан-19, чадаагүй-14, асуудал тавьж байгаагүй-148* хүн хариулсан байна.²⁰

¹⁸ <http://www.Eagle.mn/>

¹⁹ Орон нутгийн удирдлага. УБ 2019., 85 дахь тал

²⁰ Төрийн байгуулал судлал. УБ 2018., 85 дахь тал № 01

График 1. ИТХ-ын төлөөлөгчдөө хандсан байдлын судалгаа ²¹



Энэхүү судалгаанаас харахад иргэдийн зарим хэсэг нь иргэдийн төлөөллийн байгууллагадаа ханддаггүй, хандахыг хүсдэггүй, хэрхэн хандах учраа олдоггүй нөгөө талаас ИТХ нь иргэдээс санал авдаггүй, санал тусгах нь муу, санаачилга гаргахгүй байгааг харуулж байна.


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.9-д /МУ-ын ЗЗНДНТУТХ-ийн 2020 оны шинэчилсэн найруулгын 12.1.6, 12.1.7, 12.1.8/ зааснаар ИТХ-ын төлөөлөгчид тухайн нэгжид оршин суугаа иргэдийн хүсэл зоригийг илэрхийлэх, сонгогчидтойгоо тогтмол холбоотой ажиллах, саналыг харгалзан үзэх, иргэдийг мэдээллээр хангах, ил тод байх, иргэдээс ирсэн өргөдөл санал гомдлыг шийдвэрлэх ёстой. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11 дэх хэсэгт “Иргэн, хуулийн этгээд нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад мэдээллийг ИТХ-аас авах эрхтэй.” ²²

Мөн 2015 онд хийгдсэн “Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх иргэдийн хандлагын суурь түвшин тогтоох судалгааны тайлан”-д дурьдсанаар судалгаанд оролцсон нийслэлийн иргэдийн 65.6 хувь нь өөрийн тойргоос НИТХ-д сонгогдсон төлөөлөгчдөө хараагүй, 15 орчим хувь нь хаана харснаа санахгүй, 20 орчим хувь нь сонгуулийн компанит ажлаас хойш телевизийн сувгаар, уулзалтаас харсан, нэрийг нь мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн байна.

²¹ Төрийн байгуулал судлал. УБ 2018., 85 дахь тал. № 01

²² “Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь”. Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж., УБ., 2019


График 2. “Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх иргэдийн хандлагын суурь түвшин тогтоох судалгаа” 2015²³



Аймгийн ИТХ-ын төлөөлөгчөө мэдэж байгаа 37.3 хувь, НИТХ-ын төлөөлөгчийг 15.8 хувь нь мэддэг гэж хариулсан бол сум, дүүргийн төлөөлөгчөө нэрлэж байгаа үзүүлэлт 3 дахин өндөр байсан.

Дараах судалгаа НИТХ-ын иргэдтэй харилцах харилцаа, иргэдийн оролцоо, иргэд оролцоогоо нэмэгдүүлэхэд юу саад болж байгаа талаар 2021 онд нийслэлийн иргэдээс авсан ба дараах үр дүн гарсан байна.

График 3. НИТХ нийслэлийн иргэдтэй харилцах харилцааны үнэлгээ²⁴




Судалгаанд хамрагдагсдын дөнгөж 18% нь л НИТХ нь хотын оршин суугчидтай сайн харилцаатай байдаг гэж үзсэн байна. Судалгаан оролцогчдын 44% нь энэ харилцааг муу гэж үзсэн байна

²³ “Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь”. Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж., УБ., 2019

²⁴ Төрийн байгуулал судлал. УБ 2021., 89 дэхь тал.№ 03

График 4. ИТХ-ын иргэдийн оролцоо, оролцоог нэмэгдүүлэхэд гарч буй байдлын шалтгаан ²⁵



Хүмүүс илүү их оролцож чадахгүй байгаагийн хамгийн том шалтгаан бол мэдлэг, мэдээлэл (36%), цаг хугацаа (30%) гэж үзсэн байна. Энэ үзүүлэлтийг дотор нь задалж үзвэл төрийн байгууллагад ажиллагсад цаг хугацаа (42%), сонирхол (19%), мэдлэг, мэдээлэл (17%) оролцож чадахгүй байгаагийн шалтгаан гэж үзсэн байхад хувийн хэвшил, бизнесийн байгууллагад ажиллагсад мэдлэг, мэдээлэл (54%), цаг хугацаа (18%) гэж үзсэн байна. Харин оюутнуудын олонх буюу 84% нь мэдлэг, мэдээлэл авах шаардлагатай байгааг илэрхийлжээ

Дүгнэлт

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа ил тод байж шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангах, хяналт тавихад иргэд оролцох тэр тусмаа шууд оролцох оролцоо чухал бөгөөд эдгээр нь хангалттай биш байна. Иргэдийг төрийн үйл хэрэгт оролцуулах, тэдний санал бодлыг төрийн байгууллагаас гарах шийдвэрт тусгах асуудал яригддаг боловч үр дүн муу байсаар байна. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын нь угтаа иргэдийн “төлөөллийн байгууллага” бөгөөд иргэдийг хэрхэн төлөөлж чадаж байгаа эсэхээр нь тухайн байгууллагын үйл ажиллагааны чанар, чадвар, үйл ажиллагааны хэрэгжилтийг нь үнэлж дүгнэнэ. Иргэдээс өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаанд тааруу үнэлгээ өгч байгаа шалтгаан нь:

- Тухайн нэгжид оршин суугаа иргэдийн хүсэл зоригийг бүрэн илэрхийлж чадахгүй
- Хурлаас хийж байгаа ажлын талаар мэдээлэл дутуу олгох
- Иргэдтэй харилцах эргэх холбоо сул гэх мэт шалтгаанууд бий юм.

НӨУЁБ-ыг чанаржуулах, төлөөллийг сайжруулахын тулд хууль эрх зүйн таатай орчин хэрэгтэй төдийгүй иргэдийн оролцоо, улс төрийн боловсрол, мэдээдэл сайтай байх, шаардлага чухал юм. Тиймээс иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд:

- Засаг захиргааны байгуулал, НЗДТГ болон НИТХ харилцаа холбоогоо нэмэгдүүлэх, эргэх холбоог сайжруулах,
- Мэдээллийн хүртээмжийг сайжруулах

²⁵ Төрийн байгуулал судлал. УБ 2021., 89 дэхь тал.№ 03

- Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Засаг даргын тамгын газрын нээлттэй хаалганы өдөр төлөөлөгчдийн нээлттэй өдрийг сайжруулах, хүртээмжтэй болгох
- Иргэдийн хэрэгцээг хангахуйц мэдээллийн санг бүрдүүлэх
- Иргэд, төрийн бус байгууллага, нутгийн удирдлагын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах
- Иргэд, төрийн байгууллагын чирэгдлийг арилгах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байгаа юм.

Ном зүй

Монгол Улсын Үндсэн Хууль. (1992). УБ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. (2006). УБ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. (2020). УБ. Шинэчилсэн найруулга

Нийтийн удирдлагын үндэс. Хамтын бүтээл. (2018).УБ

Орон нутгийн удирдлага. (2019). УБ

Konrad Adenauer Stiftung.Төрийн байгуулал судлал. (2018). УБ., №01

Konrad Adenauer Stiftung. Төрийн байгуулал судлал. (2021) . УБ., №03

Konrad Adenauer Stiftung, National university of Mongolia (Department of political science). Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь. Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж. (2019).УБ

<http://www.Legalinfo.mn/>

<http://Eagle.mn/>

<http://lawforum.parliament.mn/>

**МОНГОЛ УЛСЫН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗӨВЛӨЛДӨХ САНАЛ АСУУЛГЫН
ХЭРЭГЖИЛТ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Г.Туяагэрэл

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар
Улс төр судлалын тэнхимийн ахлах багш, доктор

С.Мөнхбат

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар
Улс төр судлалын тэнхимийн багш, доктор

Ц.Бямбачулуун

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар
Улс төр судлалын тэнхимийн докторант

Хураангуй: Монгол Улсын Үндсэн хуулийн гуравдугаар зүйлд ард түмэн төрийн үйл хэрэгт оролцох, иргэдийн оролцоог хангах, “Зөвлөлдөх санал асуулгын хууль”-иар тодорхой асуудлыг шийдвэрлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Зөвлөлдөх ардчиллын зарчмаар нийслэлийн хөгжилд олон нийтийн санал асуулга зохион байгуулах, орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн төлөвлөлтийг зөвлөлдөх санал асуулгын дагуу төсөвлөх, нутгийн өөрөө удирдах ёсны зарчимд зөвлөлдөх ардчиллын зарчмыг баримтлах зэргээр тодорхой үйл ажиллагаанд хэрэгжүүлэх, эрх зүйн орчны талаар дурдсан болно.

Түлхүүр үг: зөвлөлдөх ардчилал, иргэдийн оролцоо, ИТХ, ИНХ, орон нутгийн хөгжлийн сан, зөвлөлдөх санал асуулга

Нутгийн өөрөө удирдах байгууллагын өнөөгийн бодит байдал, иргэдийн оролцоо

Монгол улс ардчилсан шинэ үндсэн хуулиа батлан мөрдсөнөөс хойш 30 орчим жил болж байгаа бөгөөд тус хууль улс орныхоо тусгаар, тогтнолыг баталгаажуулж, хүний эрх, эрх чөлөөг бодитой хангах, иргэн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сайн дураараа эвлэлдэн нэгдэх, төрийг удирдах хэрэгт оролцох боломжийг нээж, өмчийн харилцааг цоо шинээр тогтоосон. Үндсэн хуулийг дагаж мөрдсөн хугацаанд Монгол орон улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, шинжлэх ухаан, боловсрол, эрүүл мэндийн салбарт бодитой ахиц, дэвшилд хүч, төрийн бүх шатны байгууллагыг чөлөөт ардчилсан сонгуулиар байгуулдаг тогтолцоог бүрдүүлж чадсан байна. Өөрөөр хэлбэл, ардчилсан нийгмийн нэг онцлог нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаа өөрсдөө сонгож, орон нутгийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан үйл ажиллагаандаа оролцдог.¹

¹ Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг дээшлүүлэх нь (2006). //Бямбачулуун Ц. НӨУБ-ын сонгууль/ Эрхэлсэн: Ц. Баасандорж, Баруун бүсийн онол, практикийн бага хурлын эмхтгэл / УБ., “СОЁМБО ПРИНТИНГ” ХХК. х-301

Монгол улсын өнөөгийн улс төрийн нөхцөл байдлын ээдрээтэй цаг үед хамтын оюун ухаанаа дайчлан зөвлөлдөх² (1.“ЗӨВЛӨЛДӨХ”-аливаа тогтоох, төлөвлөх үйл хэргийг олноороо хамтран хуралдаж, хянан шүүмжилж хэлэлцэх, зөвлөлдөн хэлэлцэх, “ХЭЛЭЛЦЭХ”-хэлэхийн үйлдэлцэх хэв, харилцан ярилцах; 2.Олноор буюу бусдын хамт хэлэх, шүүмжлэн хэлэлцэх, хурал дээр зөвлөн хэлэлцэв; хэлэлцэх хэрэг (хурал зөвлөгөөнөөр ярилцах хэргийн товъёог жагсаалт); хэлэлцэх асуудал (ярилцвал зохих хэрэг) гэж тайлбарласнаас үзвэл зөвлөлдөх гэдэг нь өргөн агуулгатай хэлэлцэх гэсэн утгыг дотроо багтаасан ойлголт болох нь харагдаж байна. Deliberative democracy буюу уг үгийн утгыг зөвлөлдөх ардчилал хэмээн оруулан хэрэглэж байна)³-ын хүчээр оновчтой шийдвэр гаргаж ард түмнээ шинэ эрин, шинэ хөгжилд тууштай чиглүүлэх шаардлага гарч байна. Зөвлөлдөх гэдэг нь нутгийн өөрөө удирдах байгууллагаас иргэдийн хэрэгцээг зөв тодорхойлох үйл ажиллагаагаа чиглүүлэхэд хэрэглэдэг арга зам, механизм юм.

XXI зууны монголчууд бидэнд нэгдэх, нэгдэж хамтдаа тодорхой нэг шийдэлд хүрэх асуудал олон байна. Иймд бидэнд нэгдэх туйлын чухал шаардлагатай цаг иржээ. Гэхдээ бидний нэгдэл бол худал амлалт өгч, сонгуулийн хугацааны зорилт харах бус, тухайн орон нутгийн иргэд амьдралынхаа аливаа асуудлыг өөрсдөө шийдвэрлэж, эрх ашгаа өөрсдөө хамгаалж, хариуцлагаа өөрсдөө хүлээж, нутаг дэвсгэр, өөрийгөө тэтгэх аж ахуй, нийгмийн цогцолборыг бий болгох эрх мэдэл, боломжийг тэдэнд олгох нь орон нутгийн түвшинд ардчиллыг хүргэх гол нөхцөл мөн⁴. Хэрвээ нэгэн зүгт нэгдэж, нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаа, түүний тогтолцооны гажуудлыг салбар салбараар нь өөрчлөн шинэчлэл, нийгмийг дэг журам нь оруулж, тулгамдсан асуудлаа өөрсдийн оролцоотойгоор шийдвэрлэж, шударга ёстой үнэт зүйлтэй, сайн сайхан ирээдүйг цогцлооч, сэтгэл зүрх, тэмцье, зүтгэе гэсэн нэгдлүүд байвал энэ улс орон зөв чиглэлдээ орж, зөв замаар явж чадна. Улс төрийн намууд, фракц хөдөлгөөнүүд ч, мөн адил ард түмэн улс орныхоо сайн сайхны төлөөлөх хөгжлийн урт хугацааны бодлогын асуудлыг шийдэх, түүнийг нь дэмждэг тогтолцоог бий болгож чадвал хамгийн эрүүл саруул хөгжлийн бодлого болно.⁵

Ихэнх орнууд иргэдтэйгээ зөвлөлдөх гэдэг нэр томъёо хэрэглэж байгааг анхаарах нь зүйтэй. Иргэдтэйгээ зөвлөлдөх гэдэг нь тэгш харилцаа, харилцан ойлголцлыг агуулж байна.⁶

Энэ бүхний үр дүнд иргэдийн идэвх сэргэж нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаанд оролцох нь улам бүр нэмэгдсээр байна.

Иймээс Монгол Улсын нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаанд зөвлөлдөх ардчиллын механизмыг ашиглах эхлэлийг тавиад байна. Нутгийн өөрөө удирдах байгууллагын өнөөгийн бодит байдал, иргэдийн оролцоо нь орон нутгийн өөрөө удирдах байгууллагын анхан шатны нэгж болох ИНХ-аар дамжуулан иргэд орон нутгийн нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхэд оролцох нь ардчиллын анхан шатны элемент, шууд ардчилал мөн боловч энэ нь бодит байдалд дараах байдлаар гажуудсан байдаг:

² Цэвэл Я. (1966). Монгол хэлний товч тайлбар толь. УБ., х-278

³ МУ-ын ЗГХЭГ, МУИС. (2018). Ази дахь зөвлөлдөх ардчиллын туршлага” олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ., 10 сарын 11-12

⁴ Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг дээшлүүлэх нь (2006). //Бямбачулуун Ц. НӨУБ-ын сонгууль/ Эрхэлсэн: Ц. Баасандорж, Баруун бүсийн онол, практикийн бага хурлын эмхтгэл / УБ., “СОЁМБО ПРИНТИНГ” ХХК. х-301

⁵ МУИХТГ (2015). Үндсэн хууль ба зөвлөлдөх ардчилал: Онол практикийн бага хурлын эмхтгэл //Занданшатар Г. Үндсэн хууль ба зөвлөлдөх ардчилал: Илтгэл/ УБ., “СОЁМБО ПРИНТИНГ” ХХК. х-61

⁶ НҮБХХ, УИХТГ. (2014). Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь төслийн хүрээнд //Хууль боловсруулах ажиллагаанд оролцоог хангах, иргэд байгууллага, олон нийтийн санал авах практикийн судалгаа. УБ., х-33-34

- ИНХ-ын ирцийн гажуудал: Тухайлбал, УБ хотын 1 хорооны ИНХ-д 30 өрхөөс 1 хүн гэдэг ирц бүрдэлтэд 3 мянгаас 100 хүний ихэнх нь өөрийгөө сонгосон “Хэт” идэвхтнүүд, халамж хүртэж амташсан цөөнх, тэтгэврийнхэн төлөөлдөг.
- Орон нутагт улс төржсөн талцал үүссэн: Хот, хөдөөгүй туйлширсан, улс төржсөн талцлыг иргэд шүүмжилдэг хэдий ч амьдралаа бодоод аргагүй дагадаг, олонх нь оролцдоггүй.
- Нам дагасан ургийн олонх бий болох. Хөдөө орон нутагт, нэн ялангуяа олонх багуудад төрөл, садны олонх багийн даргын сонгууль, ИНХ-ын шийдвэрийг төлөөлөх болсон.
- Хотод: Иргэдийн эрх ашгийг бус, намын бүлгийн эрх ашиг, захиалгыг төлөөлсөн ИНХ-ууд хуралдах нь түгээмэл.
- Намын харьяаллаар төрийн албанд халаа, сэлгээ хийх үзэгдэл хавтгайрсан.
- УИХ-ын гишүүд ИТХ-ын ажлыг амлах, булааж хийх, УИХ-ын сонгууль нэр дэвшигчид тухайн тойрогт ИТХ-ын хийх ёстой ажлыг амлаж, сонгогдох нь уламжлал болсон.
- ИТХ-ын олонх засаг даргын шударга бус үйлдлийн хаацайлж, хамгаалах. ИТХ дахь нэг намын олонх өөрсдийн лидерээ засаг даргаар сонгож, томилуулснаар түүнийг хянах, шүүмжлэх үүргээ гүйцэтгэхгүй, намын эрх ашгийн үүднээс хаацайлж, хамгаалах нь уламжлал болсон.
- Нутгийн өөрийн удирдлагын шууд ардчиллын үндэс болох ИНХ-д 30 өрхөөс 1 хүн оролцсоноор ирц бүрдсэн гэж үзэж байгаа нь орон нутгийн иргэдийн үзэл бодлыг илэрхийлэх, тэдний төлөөллийг хангах боломжгүй нөхцөл юм. Үүнд: Энэ нь тухайн орон нутгийн иргэдийн төлөөлөл, тэдний үзэл бодлыг илэрхийлж, боломжийг бүрдүүлэх нөхцөлгүй, цөөн тооны тусгай (тэтгэврийн ажилгүй, улс төржсөн хэт идэвхтэй, төрөөс бэлэнчлэх сонирхолтой хэсэг бүлэг гэх мэт) хүмүүсийн оролцооны гажуудсан үзэгдэл юм.
- Сайн дураар ИНХ-д оролцож буй тэдгээр цөөн хүмүүсийн үзэл бодол нийт иргэдийн үзэл бодлыг төлөөлж чадахгүй. Энэ нь “Өөрийгөө сонгосон сонгогчдын санал асуулга (ӨСССА)-тай төстэй гажуудал” үүсгэдэг.
- ИНХ-ын шийдвэрүүд улс төржсөн талцлын бодит үр дүн болж, улс төрийн фракц бүлэглэлийн баялгийг хуваарилах өрсөлдөөний талбар болж байдаг.⁷
- Нөөц баялгийг намынхан болон дэмжигчид дээ хуваарилах. Эрх мэдэл албан тушаалаар дамжуулан, ажлын байр, төсөл хөтөлбөр, зээл тусламж, орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-ийн хөрөнгийг хуваарилах үзэгдэл ихээхэн шүүмжлэл дагуулж байна. ОНХС нь дараах хууль, дүрэм журмуудын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.
Хүснэгт-1. ОНХС-гийн эрх зүйн орчныг хүрээнд ашиглах хууль, эрх зүйн баримт бичгүүд

ХУУЛИУД

ТОГТООЛ, ЖУРАМ

⁷ Ганболд Ц. & Батболд Ц. (2018). Монголын Улсын нутгийн өөрөө удирдах байгууллагад зөвлөлдөх ардчиллыг ашиглах боломж, ач холбогдол //Ази дахь зөвлөлдөх ардчиллын туршлага” олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл / УБ., х-144-145

- “Төслийн тухай хууль”(2011)
- “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль” (2015)
- “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль” (2006, 2022)
- “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль” (1996)
- “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” (2005)
- “Төрийн аудитын тухай хууль” (2003)
- “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль” (2015)
- “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль” (2011)
- “Шилэн дансны тухай хууль” (2014)
- “Нийтийн сонсголын тухай хууль” (2015)
- “Хууль тогтоомжийн тухай хууль” (2015)
- “Захиргааны ерөнхий хууль” (2015)
- “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай” (2015)
- “Хот суурины газрыг дахин хөгжүүлэх тухай хууль” (2015)
- “Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль” (2017)
- “Төрийн сангийн үйл ажиллагааны журам” Засгийн газрын 2012 оны 205-р тогтоолын хавсралт.
- “Олон нийтийн оролцооны худалдан авах ажиллагааны журам” Сангийн сайдын 2013 оны 2 дугаар сарын 21-ний 39-р тушаалаар батлагдсан.
- “Дотоод аудитын дүрэм” ЗГ-ын 2015 оны 483-р тогтоолын хавсралт.
- “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос Орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэг тооцох аргачлал”, “Аргачлал батлах тухай” Сангийн сайдын 2016 оны тушаалаар батлагдсан.
- “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон ОНХС-гаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал” ЗГ-ын 2017 оны 230-р тогтоолын хавсралт.
- “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” ЗГ-ын 2017 оны 89-р тогтоолын хавсралт.
- “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” Сангийн сайдын 2018 оны 228-р тушаалаар батлагдсан.

Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС) нь Засгийн газраас орон нутгийг хөгжүүлэх зорилгоор өгч буй шилжүүлэг бөгөөд гол онцлог нь иргэдтэй хамтран орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилготой. Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 17-ний өдрийн 230 дугаар тогтоолоор батлагдсан орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан (ОНХНС) болон ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлалын дагуу тус сангийн хөрөнгийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт жил бүр хуваарилдаг. ОНХНС-д 2013-2020 онд нийт 1 их наяд 137 тэрбум төгрөгийн хөрөнгө хуваарилсан. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг иргэдтэй хамтран төлөвлөж хэрэгжүүлдэг бөгөөд энэ үйл явцад баг, хорооны Засаг даргаас эхлээд баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурал (ИНХ) болон бүх шатны

иргэдийн төлөөлөгчдийн хурал хүртэлх бүх шатны байгууллагууд оролцон хамтын шийдвэр гаргадаг. ОНХС-гийн зорилгыг “Нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ” хэмээн тодорхойлсон.

ОНХС нь иргэдийн оролцоотой төлөвлөлт, төслийн үнэлгээ эрэмбэлэлт, хэрэгжилт болон худалдан авах ажиллагаа, хяналт-шинжилгээ үнэлгээ, хөрөнгийн удирдлага гэсэн үндсэн 5 үе шатыг хамран зохион байгуулагддаг. Үе шат бүрд иргэд оролцох, мэдээллээр хангагдах, хяналт-шинжилгээ хийх боломж бий.

2011 онд Төсвийн тухай хуульд тусгалаа олсноос хойш ОНХС-гийн үйл ажиллагаа нь 21 аймгийн 330 сум, нийслэлийн 9 дүүрэгт хэрэгжиж ирсэн. Уг сан нь орон нутгийн онцлогт тохируулан орон нутгийн хөгжлийг дэмжих, иргэдэд мэдээлэл хүргэх, олон нийтийн санал авах, иргэдийн оролцоотойгоор тулгамдсан асуудлыг тодорхойлох, тэдгээрийг шийдвэрлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээг боловсруулах, төслийн жагсаалт боловсруулах, төслийг хэлэлцэх, саналыг эрэмбэлэн шийдвэр гаргах, төслийн хэрэгжилтийг хангах, хянаж үнэлэх, ОНХС-гийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгдсэн үйл явц юм.

Зөвлөлдөх санал асуулгын хэрэгжилт, эрх зүйн орчин

Ардчилал бол иргэн бүрийн үзэл бодлыг тусгахын төлөөх зөвлөлдөөн бөгөөд зөвлөлдөх ардчилал нь аливаа асуудлыг шийдвэрлэхдээ иргэдийн төлөөллийг мэдээллээр тэнцвэртэй хангаж, тэгш эрхтэй оролцуулж, улмаар оновчтой шийдэх явдал мөн. “Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй” гэсэн ардын үгийг мөрдлөг болгож ирсэн Монголчуудын хувьд 1992 оны Үндсэн хуулийг хэлэлцэж баталсан үйл явц бүхэлдээ зөвлөлдөх ардчиллын нэгэн тод жишээ, үлгэр дуурайлал байсан гэж үзэж болно.

Монгол Улсын Үндсэн хууль бол Монголын ард түмний оюун санааны хамтын бүтээл билээ. Ард түмний төлөөллийн оролцоотойгоор төр засгаас шийдвэр гаргахын өмнө болон гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн талаар зөвлөлдөж, тэдний санал бодлыг сонсож шударгаар шийдэх улс төрийн аргачлал бол зөвлөлдөх санал асуулга мөн.


Иймд зөвлөлдөх санал асуулга нь улс төр, эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлыг олон нийтийн санал бодолд тулгуурлан, сонирхогч талуудын оролцоог хангасны үндсэн дээр зөвлөлдөж, хамтын оюун ухаанаар шийдвэр гаргах үйл явц юм.

Зөвлөлдөх ардчиллын зарчим, үзэл санаа, үйл ажиллагааны хэм хэмжээг баримталсан Зөвлөлдөх санал асуулгын хууль Монгол Улсад 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан эдүгээ хүчин төгөлдөр үйлчилж буй батлагдсан “Зөвлөлдөх санал асуулгын хууль”-иар тодорхой асуудлыг иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэхээр хуульчилсан байна. Зөвлөлдөх санал асуулгын зорилго:

- МУҮХ-ийн гуравдугаар зүйлд ард түмэн төрийн үйл хэрэгт оролцох, иргэдийн оролцоог хангах, төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.
- Нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн тусламжтайгаар олж илрүүлэх
- Тухайн асуудлын эрэмбэ, түүний шийдвэрлэх арга зам, гаргах шийдвэрийн асуудлын талаар иргэдтэй зөвлөлдөх
- Иргэд олон нийтийн тулгамдсан асуудлын талаар мэдлэг, мэдээлэл өгөх зорилгоор зөвлөлдөх санал асуулгын тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулна.

Зөвлөлдөх санал асуулга зохион байгуулах журам нь хоёр үе шаттай явагддаг. Зөвлөлдөх санал асуулгын нэг дэх шатанд зөвлөлдөх санал асуулгын сэдвээр урьдчилсан мэдлэг, мэдээлэл өгөхгүйгээр санал асуулгын хуудсаар сонгогдсон иргэнээс саналыг нь авна. Хоёр дахь шатанд санал авахдаа оролцогч иргэдийн санал бодлыг сонсох зөвлөлдөх уулзалт хэлбэрээр зохион байгуулах бөгөөд нийт оролцогчдоос 15-аас илүүгүй хүнтэй хэсэг болгон хувааж, бүрэлдэхүүнийг тохиолдлын зарчмаар сонгоно. Хэлэлцүүлгийн эхэнд эрдэмтэн, судлаач, мэргэжлийн хүмүүс урьдчилан бэлдсэн тэнцвэртэй мэдээллийг өгөх ба үүний дараа оролцогч иргэд хэсэг бүлгийн хэлэлцүүлэг хийнэ. Зөвлөлдөх санал асуулгад оролцогчид хэлэлцүүлгийн үеэр бусад иргэдийн санаа бодлыг сонсох, мэргэжлийн хүмүүст асуулт тавьж, хариулт авах боломжтой. Хэлэлцэх асуудлын талаарх танилцуулга, мэдээллийг оролцогчдод урьдчилан хүргүүлсэн байна. Зөвлөлдөх санал асуулгад оролцогч хэлэлцүүлгийн дараа эхний шатанд бөглөсөн судалгааны асуулгад дахин хариулна. Энэ нь тухайн сэдвээр мэдээлэлтэй болсны дараа оролцогчийн үзэл бодол өөрчлөгдсөн эсэх, ямар байр сууринаас хандсан болохыг дүгнэх боломжийг олгодог. Өөрөөр хэлбэл, зөвлөлдөх санал асуулгын нэг болон хоёр дахь шатны судалгааны дүнг харьцуулж, иргэд тухайн хэлэлцүүлж буй асуудлаар анх ямар бодолтой байсан, хэлэлцүүлгийн дараа буюу мэдээлэлтэй болсны дараа асуудалд хэрхэн хандсаныг харьцуулан харах боломжийг олгоно.

Зураг-1. Зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулах



Зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулах зөвлөлийн чиг үүрэг:

1. Зөвлөлдөх санал асуулгын асуултыг боловсруулах, хамрах хүрээ, тухайн зөвлөлдөх санал асуулгын үе шав бүрийн санал авах өдрийг тогтоох

2. Зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулах;
3. Зөвлөлдөх санал асуулгын хоёр дахь шатанд тухайн сэдвээр мэдээлэл өгөх судлаач, мэргэжилтэн, хөндлөнгийн шинжээч, төрийн байгууллага, албан тушаалтныг шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд санал болгох;
4. Зөвлөлдөх санал асуулгын дүнг хэлэлцэж, зөвлөмж гаргах;
5. Зөвлөлдөх санал асуулгын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх;
6. Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчим хангагдаж байгаа эсэхэд хяналт тавих.

Зураг-2. *Зөвлөлдөх санал асуулгын асуулт, санал авах журам*



Зөвлөлдөх санал асуулгаар авах санал авах ажлыг статистикийн байгууллага гүйцэтгэнэ.



Хөндлөнгийн бие даасан, хараат бус, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

Зураг-3. *Зөвлөлдөх санал асуулгын асуулт, санал авах журам*



Зураг-4. Санал асуулгын хуудсанд дараах зүйлийг тусгана:



Зураг-5. Зөвлөлдөх санал асуулгын асуулт, санал авах журам.



Зөвлөлдөх санал асуулгыг дараах асуудлыг шийдвэрлэхэд заавал явуулна.⁸
Үүнд:

- Монгол Улсын үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль
- Орон нутгийг хөгжүүлэх сангаас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ
- Хот, суурин газрын хэсэгчилсэн төлөвлөлт (нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж).

Хүснэгт-2. *Зөвлөлдөх санал асуулга явуулах, шийдвэр гаргах*

Зөвлөлдөх санал асуулга явуулах	Шийдвэр гаргах эрх бүхий этгээд	Шийдвэрт тусгах асуудал
МУҮХНӨӨЖТХ-ийн 5.3.3-т заасан асуудлыг УИХ хэлэлцэн шийдвэрлэх үндэслэл шаардлагыг тодорхойлох	Улсын Их Хурал	- Зөвлөлдөх санал асуулгын сэдэв - Зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулж, явуулах хугацаа
Орон нутгийг хөгжүүлэх сангаас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ	Бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	- Зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулж,
Хот, суурин газрын хэсэгчилсэн төлөвлөлт		

⁸ Монгол Улсын Хууль (2017). Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль. УБ., 6.1 дэх заалт


/нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж/	Хот байгуулалтын тухай хуульд заасан эрх бүхий этгээд	явуулах нутаг дэвсгэр
Бусад асуудлаар зөвлөлдөх санал асуулгыг санаачлан явуулж болно.	Хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн бх шатны байгууллага, ЗХХАкт нийтийн эрх зүйн бусад этгээд, Бүх шатны НӨУБ.	- Зөвлөлдөх санал асуулгын төсөв.

Зөвлөлдөх уулзтанд зохион байгуулах журамд дараах зүйлийг заавал тусгана:

- Зөвлөлдөх санал асуулгын асуулт бүрээр эерэг, сөрөг мэдээллийг тэгш агуулсан лавлагаа, танилцуулгыг бэлтгэх
- Зөвлөлдөх санал асуулгад оролцогчид олгох урамшуулал, томилолтын зардлыг төлөх
- Хоёр дахь шатны зөвлөлдөх санал асуулга буюу зөвлөлдөх уулзалтад оролцогчийг 15-аас илүүгүй хүнтэй хэсэг болж, бүрэлдэхүүнийг тохиолдлын зарчмаар сонгох
- Хэсэг бүрд явагдах хэлэлцүүлгийг хөтлөх бэлтгэгдсэн хөтлөгч /модератор/ нь тухайн хэсгийн оролцогчид мэдээллийг бүрэн хүргэж, оролцогчийн тэгш оролцоог хангах үүргийг хариуцах
- Хэсэгт явагдах хэлэлцүүлгийн бүх ажиллагааг дууны болон дүрсний бичлэгээр баталгаажуулах
- Хэсэгт явагдсан хэлэлцүүлэгт оролцогчийн асуултыг нэгтгэн зөвлөлдөх уулзалтын нийт оролцогчид тухайн санал асуулгын сэдвээр олон талт мэдээлэл, тайлбар, танилцуулгыг шийдвэр гаргах эрх бүхий этгээд, хөндлөнгийн судлаач, мэргэжилтэн, шинжээч өгөх.

Зөвлөлдөх санал асуулгаар санал авах ажлыг гүйцэтгэх үүрэг бүхий статистикийн байгууллага зөвлөлдөх асуулгын нэг дэх болон хоёр дахь шатны дүнг тоон болон бусад үзүүлэлтээр харьцуулан гаргасан дүгнэлтийг зөвлөлдөх санал асуулгын үр, дүнгийн тайланд тусгаж Зөвлөлдөх зөвлөлд танилцуулна. Зөвлөлдөх санал асуулгын дүнг Зөвлөлдөх зөвлөл хэлэлцэн зөвлөмж гаргаж, Улсын Их Хуралд хүргүүлнэ. Ингэснээр УИХ зөвлөлдөх санал асуулгын дүнд үндэслэсэн зөвлөмжийг хуульд заасны дагуу хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг Зөвлөлдөх зөвлөл болон олон нийтэд өгнө.

Зураг-6. Зөвлөлдөх санал асуулгаас гарах шийдвэр



Зөвлөлдөх санал асуулга явуулахтай холбогдсон зардлыг улсын төсөв болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

Монгол Улсад анх удаа 2015 оны 11 сарын 4-өөс 12 сарын 22-ний хооронд Улаанбаатар хотын хэмжээнд дэд бүтцийн томоохон төслүүдийг эрэмбэлэх асуудлаар зөвлөлдөх санал асуулгын иргэдийн дунд зохион байгуулсан. Тус төсөл нь “Иргэдийн оролцоо-Хотын маргааш” зөвлөлдөх санал асуулгын судалгааны ажлын хүрээнд судалгаа шинжилгээний “Эм Эм Си Жи” ХХК нь Улаанбаатар хотын 8 дүүрэгт 1500 иргэнээс мэдээлэл цуглуулалтыг зохион байгуулж, 400 иргэнийг Төрийн ордонд болох хэлэлцүүлэгт урьж оролцуулах, уригдсан иргэдээс судалгааг явуулсан. Урьдчилсан судалгаанд оролцсон иргэдийн 75% нь буюу 1127 иргэн зөвлөлдөх хэлэлцүүлэгт оролцоно гэж хариулсан бол 10.9% нь буюу 163 нь оролцож магадгүй, 14.1% нь буюу 212 нь оролцохгүй гэсэн байна.

Монгол Улсын үндэсний статистикийн хорооноос 2018 онд Налайх дүүргийн нутаг дэвсгэрт хууль бусаар нүүрс олборлож байгаа иргэдийн эрүүл мэнд, амь нас хохирч байгаа болон байгаль орчныг бохирдуулж байгаа асуудлыг таслан зогсоох, хууль бус олборлолтын улмаас үүссэн ам, цооногуудыг дахин ашиглуулахгүй, хаах чиглэлээр зөвлөлдөх санал асуулгад статистикийн шинжлэх ухааны үндсэн гол аргуудын нэг болох энгийн санамсаргүй түүврийн аргаар Налайх дүүргийн нийт 10.5 мянган өрхөөс 940 өрхийг сонгож, тэдгээрт амьдран суугаа 18, түүнээс дээш насны 24 мянга гаруй иргэдээс 940 иргэнийг сонгон, эхний болон хоёр дахь шатны санал асуулгыг амжилттай явуулсан байна. Эхний санал асуулгад хамрагдсан 887 иргэнээс 511 иргэнд урилга хүргүүлснээс хоёр дахь шатны санал асуулгын судалгаанд 278 иргэн бүрэн хамрагдсан байна.

Зөвлөлдөх санал асуулга зохион байгуулахтай холбогдуулан Азийн сан, Стэнфордын их сургуулийн Зөвлөлдөх ардчилал төвөөс зохион байгуулагчдын чадавхыг бэхжүүлэх, аргачлал, арга зүйгээр хангах сургалт, зөвлөмжийг өгч туслалцаа үзүүлж, хамтран ажиллаж байна.

Зөвлөлдөх ардчиллыг нутгийн өөрийн удирдлагын өнөөгийн бодит байдал ашиглаваас дараах онцлогтой.⁹ Үүнд:

- Зөвлөлдөх ардчилал нь улс төрийн фракц, бүлгүүдийн сонирхол, үзэл бодолд хөтлөгдсөний улмаас бусдын эрх ашигт халдах эвсэл сөргөөр нөлөөлж болзошгүй сөрөг үр дагавраас зайлсхийх боломж олгодог.
- Зөвлөлдөх олон нийтийн үзэл бодлын бас нэг чухал хэсэг нь эрүүл, саруулаар сэтгэдэг, харилцан зөвлөлдөх дээр үндэслэсэн нийгэмд тодорхой үзэл бодол сонирхлоор бусдаас ялгарсан улс төрийн бие даасан бүлэглэл, фракц үүсэхгүй байх боломжийг олгодог.
- Орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогыг тодорхойлоход иргэдийн оролцоо, тэдний санаа бодол их чухал бөгөөд иргэд өөрсдийн асуудлаа илүү мэддэг гэдэг утгаараа ач холбогдол өндөр юм. Мөн энэ нь орон нутгийн засаглалын легитимийг ч дээшлүүлэх үүрэг гүйцэтгэдэг.

Дүгнэлт

Нутгийн өөрөө удирдах ёс нь ард түмний эрх мэдлийн хэвтээ хуваарилалтын бодит илэрхийлэл төдийгүй төрөөс (төвөөс) захирч, чиглүүлж оролцохгүйгээр зөвхөн нутгийн иргэд орон нутгийнхаа асуудлыг өөрсдөө бие даан шийдвэрлэх боломжийг хангасан эдийн засгийн төдийгүй эрх зүйн онцгой статус, ардчилсан ёсны чухал институц юм. Манайд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага дахь иргэдийн оролцооны талаарх олон нийтийн ойлголт, хандлага хангалтгүй байгаа нь:

1. ИТХ-ийн сонгуульд төдийлөн ач холбогдол өгөхгүй байх
2. ИТХ-ын үйл ажиллагаанд ардчилсан зарчим алдагдах
3. ИТХ-үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй байхад хүргэж байна.

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлэхэд олон нийтийн санаа бодлыг илэрхийлэх, шийдвэрт тусгах боломжийг олгодог зөвлөлдөх санал асуулгыг хэрэглэх нь тус байгууллагын хөгжилд төдийгүй, монгол улс дахь ардчиллыг бэхжүүлэхэд зохих үүрэг гүйцэтгэх төлөвтэй байна.

Монгол Улсын нутгийн өөрөө удирдах байгууллагын дутагдалтай талуудыг нөхөхөд “Зөвлөлдөх ардчилал” эерэг үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

- Орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн чухал шийдвэрүүд явцуу ашиг сонирхлоос холдож, амьдралд ойр, оновчтой болоход нөлөөлнө.
- Нутгийн өөрөө удирдах байгууллагад зөвлөлдөх ардчиллыг хэрэглэх нь зохистой. Тухайлбал, Хүн амын тоо олон байх тусам зөвлөлдөх ардчилал илүү оновчтой.
- Иргэд зөвлөлдөх ардчиллаар дамжуулан, улс төрийн оролцоо, соёлд суралцах төдийгүй ИНХ-д ач холбогдол өгч оролцох хандлага нэмэгдэх боломжтой.
- Зөвлөлдөх ардчиллыг ашиглах боломж, ач холбогдол нь ардчиллын бусад институциудээс илүүтэй нутгийн өөрөө удирдах байгууллагад байна.
- Улс төрийн намаар талцах үзэгдлийг эрс бууруулах ач холбогдолтой.
- Сонгодог ардчиллыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой.
- Дэлхийн хүн ам ихтэй улс орны туршлагаас харахад төрийн бодлого, шийдвэрт иргэдийн саналыг тусгахад зөвлөлдөх санал асуулгыг ашиглаж байна.

⁹ Ганболд Ц. (2020). Монголын улс төр онол, номлол, нийтлэл. УБ., I боть. “МУИС-Монгол судлалын хүрээлэн” х-361

ИТХ-ын хувьд орон нутагтаа байгаа иргэдийг аль болох өргөн хүрээнд оролцуулах боломжийг эрж хайх хэрэгтэй. Олон хүмүүс тэр дундаа залуучууд оролцдоггүй. Тиймээс хүрч ажиллахад хүндрэлтэй бүлгийн жагсаалтыг гаргаж яагаад хүрч ажиллах боломжгүй байгаа, тэдэнтэй харилцахад ямар саад, бэрхшээл гараад байна гэдгийг тогтоох нь зүйтэй.

Зөвлөлдөх санал асуулгыг амжилттай зохион байгуулж явуулснаар шийдвэр гаргагч иргэдийн санаа бодлыг сонсох, мэдрэх, улмаар шийдвэр гаргахдаа тэдний нийтлэг ашиг сонирхлыг тусгах болон шийдвэр гаргах үйл явцад иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх боломжтой болно.

Нутгийн өөрөө удирдах бүх шатны байгууллага болон ОНХС-гийн үйл ажиллагааны эрх зүйн институциональ боломжийг судалж үзсэнээр хууль, дүрмээ баримтлан ажиллахад харшлах зүйлгүй болох нь тодорхой харагдаж байна.

Abstract

Article 3 of the Constitution of Mongolia states that the people shall participate in state affairs, and the the Law on Deliberative Polls is important to increase citizen participation in resolving certain issues.

Organize public opinion polls on the development of the capital city in accordance with the principles of deliberative democracy, implement in certain activities, such as adhering to the principles of local self-government and deliberative democracy, legal environment.

Ном зүй

- [1] Ганболд Ц. (2020). Монголын улс төр онол, номлол, нийтлэл. УБ., I боть. “МУИС-МОНГОЛ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН” х-358, 361
- [2] Ганболд Ц. (2020). Монголын улс төр уламжлал, шинэчлэл, тэмдэглэл. УБ., II боть. “МУИС-МОНГОЛ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН” х-302
- [3] Ганболд Ц. & Батболд Ц. (2018). Монголын Улсын нутгийн өөрөө удирдах байгууллагад зөвлөлдөх ардчиллыг ашиглах боломж, ач холбогдол //Ази дахь зөвлөлдөх ардчиллын туршлага” олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл / УБ., х-144-145
- [4] Жеймс С.Фишкин (2015). Хүмүүс үзэл бодлоо илэрхийлэхүй: Зөвлөлдөх ардчилал ба олон нийтийн зөвлөгөөн. /Орч. Г.Занданшатар/ УБ., “НЭПКО” хэвлэлийн газар.
- [5] Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль. УБ., 2017 он
- [6] МУ-ын ЗГХЭГ, МУИС. (2018). Ази дахь зөвлөлдөх ардчиллын туршлага” олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ., 10 сарын 11-12
- [7] МУИХТГ (2015). Үндсэн хууль ба зөвлөлдөх ардчилал: Онол практикийн бага хурлын эмхтгэл //Занданшатар Г. Үндсэн хууль ба зөвлөлдөх ардчилал: Илтгэл/ УБ., “СОЁМБО ПРИНТИНГ” ХХК. х-61
- [8] МУ-ын ерөнхийлөгчийн тамгын газар, МУ-ын ерөнхийлөгчийн дэргэдэх иргэний танхим (2012). Иргэдээ сонсож, иргэдтэйгээ зөвлөлдөж, хөгжлийг хамтдаа бүтээхүй. //Боловсруулсан: Ч.Сосормаа & Н.Баясгалан, Д.Оюунчимэг/. УБ., “КИТОН ПРИНТ” ХХК. 9-10
- [9] МУИС. (2018). Бурмаа Н. Иргэдийн оролцоо-Иргэний нийгэм. //Төрийн албан хаагчийн ширээний ном III. “МӨНХИЙН ҮСЭГ” ХХК. УБ., х-231
- [10] Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг дээшлүүлэх нь (2006). //Бямбачулуун Ц. НӨУБ-ын сонгууль/ Эрхэлсэн: Ц. Баасандорж, Баруун бүсийн

онол, практикийн бага хурлын эмхтгэл / УБ., “СОЁМБО ПРИНТИНГ” ХХК. х-301

- [11] НҮБХХ, УИХТГ. (2014). Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь төслийн хүрээнд //Хууль боловсруулах ажиллагаанд оролцоог хангах, иргэд байгууллага, олон нийтийн санал авах практикийн судалгаа. УБ., х-33-34
- [12] Төрийн байгуулал судлал сэтгүүл (2021). /Бямбачулуун Ц. Зөвлөлдөх ардчиллын онол, хандлага // . №3, х-34-43
- [13] Цэвэл Я. (1966). Монгол хэлний товч тайлбар толь. УБ., х-278

МОНГОЛ УЛСЫН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ ТОЙМ СУДАЛГАА

Д. Бумдарь

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар
Улс төр судлалын тэнхимийн профессор

Б. Хишигням

МУИС, Сэтгэл судлалын доктор, дэд профессор

Д. Бадамдаш,

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар
Улс төр судлалын тэнхимийн багш

Түлхүүр үг: цахим засаглал, цахим оролцоо, цахим монгол, цахим үндэстэн, цахим хөгжил

Агуулга:

- Хураангуй
- Цахим засаглалыг судлах хөгжлийн загварын зарим хандлага
- Монголын цахим засаглалын хөгжлийн хандлага
- Дүгнэлт

Хураангуй: 2003 онд зөвхөн 33 оронд цахим үйлчилгээг санал болгодог байсан бол өдгөө энэ тоо тав дахин нэмэгджээ. 2020 он гэхэд 193 орон дор хаяж нэг төрлийн цахим үйлчилгээг ашиглаж байна (Affairs, UN-E-Government-Survey-2020, 2020). Цахим засаглал ийнхүү өргөжсөн нь ашиглахад хялбар байдал, төрийн үйлчилгээг түргэн шуурхай явуулах, зардлыг багасган үр ашгийг ихэсгэсэн зэрэг давуу талуудаас үүдэлтэй юм.

Монгол улс нь “Цахим Монгол” үндэсний хөтөлбөр 2005-2012 он, Бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр 2008-2012 он, “Цахим засаг үндэсний хөтөлбөр”-ийг 2012-2016 онд тус тус хэрэгжүүлсэн ч мэдээлэл харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээг салгах үйл ажиллагаа амжилттай хийгдэж чадахгүй байна. Учир шалтгаан нь төр нь мэдээлэл харилцаа холбооны салбартай холбоотойгоор үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ бүх төрлийн мэдээллийн санг эзэмших, ашгийг зөвхөн төр хүртэх, эрх мэдлийг хэрэгжүүлэх үедээ ашиглах гэсэн өмнөх дэглэмийн соёл нөлөөлсөөр байгаа нь улстөрийн систем, засаглалын үр дүнгүй байдлаас дүгнэх боломжтой.

Нөгөө талаас сайн засаглалыг улам төгөлдөржүүлэхэд цахим засаглал хамгийн үр дүнтэй байгааг олон улсын сайн туршлагууд нотлосоор байна. Манай орны хувьд анх цахим засаглалыг төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэх зорилгоор үзэл санааг нэвтрүүлж эхлэж байсан бол өдгөө цахим засаглалын талаарх бодлого, үйл ажиллагааны чиглэлийг үндэсний хэмжээнд авчирах шаардлага нэгэнт үүссэн байна.

Тухайлбал “Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр мэдээллийн аюулгүй байдлын, цахим гарын үсгийн, мэдээллийн сангийн, хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын зэрэг цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардагдах хууль тогтоомжийг боловсруулж батлуулан, түүнтэй нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна хэмээн заасан байна. Мөн цар тахалтай холбоотой төрийн бүх үйлчилгээг цахимд шилжүүлэх, нээлттэй мэдээллийн өгөгдлийн хэрэглээг иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байлгах зэрэг олон асуудлууд шийдэгдэх шаардлагатай байна.

Энэхүү тойм судалгааны хүрээнд манай цахим засаглалын хөгжил хэрхэн явагдсан, гол тулгарч буй бэрхшээл юу болох талаар цахим засаглалын хөгжлийн загварын хандлагыг ашиглан судлан гаргахыг зорилоо.

Цахим засаглалыг судлах хөгжлийн загварын хандлага

Цахим засаглалыг ойлгохын тулд бүрэлдэхүүн хэсгүүдийг авч үзэх хэрэгтэй. Цахим засаглалыг дараах дөрвөн хэсэгт авч үзнэ (Dawes, 2002).

1. *Цахим үйлчилгээ* - төрийн үйлчилгээ, хөтөлбөр, мэдээллийг цахимаар хүргэх;
2. *Цахим ардчилал* - Олон нийтийн оролцоотой засгийн газрын үйл ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор цахим харилцаа холбоог ашиглах;
3. *Цахим худалдаа* - татвар, тээврийн хэрэгслийн бүртгэл, нийтийн үйлчилгээний төлбөр зэрэг бараа, үйлчилгээний төлбөрийг цахимаар хийх үйлчилгээ;
4. *Цахим менежмент* - мэдээлэл дамжуулах саад тотгорыг зайлуулан, төрийн ба төрийн бус байгууллагууд чөлөөтэй мэдээлэл солилцон, бүртгэл хөтөлж, мэдээллийн урсгалыг сайжруулах багтана.

Дээрх дөрвөн ойлголт иж бүрэн хэрэгжиж байж цахим засаглал хэрэгжинэ. Цахим засаглалын дөрвөн хүрээ хэрэгжиж байгаа эсэхийг цахим засаглалын хөгжлийн үе шатаар харьцуулан үзэж болдог.

Цахим засаглалын хөгжлийн үе шатын загваруудыг гаргасан судлаачдын онол, хандлагыг энэхүү судалгааны арга зүй болгож байна. Тухайлбал Richard Heeks (Heek, 2001) судлаач үзэхдээ хөгжиж буй улс орнууд цахим бэлэн байдлыг үүсгэх ёстой. Энэ нь цахим засаглалыг хөгжүүлэх үндэс болно гэж үзсэн байдаг. Үүний тулд “Дараах зургаан чиглэлийг хөгжүүлсэн байх ёстой. Институтчлагдсан байх, хууль эрх зүйн орчин бүрдсэн байх, улс төрийн манлайлал байх, амлалтаа биелүүлдэг байх, хүний нөөцийн чадвар сайн байх, технологи, мэдээллийн систем хангагдсан байх (The priority for an NeGI is therefore to build e-readiness in six areas: Institutions, Laws, Leadership and commitment, Human capacities, Technology, Data systems)” бүрдэл цогц байх ёстой. Энэхүү цогц байдал бий болохын тулд хөгжлийн 4 үе шатны загварыг санал болгосон байдаг.

Улмаар хөгжиж байгаа орнуудын цахим засаглалын загварыг судлаач Backus (M, 2001) гаргасан байдаг. Тэрээр цахим засаглал нь сайн засаглалыг дэмжих зорилготой, тиймээс нийгмийн олон тал оролцох ёстой гэж үзсэн байдаг.

Мөн судлаачид (Layne and Lee model: integration and technological and organizational complexity) буюу цахим засаглалын хөгжилд мэдээлэл харилцаа холбооны технологи (цаашид МХХТ) нь чухал болох загвар гаргасан.

Улмаар цахим засаглалын хөгжүүлж байхад төрийн чиг үүрэг тодорхой байх ёстой. Судлаач Палива, Шарма¹ нар үзэхдээ “төрийн байгууллага (g) нь иргэд (c), бизнес эрхлэгчид (b), бусад оролцогчид (e) нартай үргэлж харилцаж байдаг. Төрийн байгууллагууд нь салбарлан татвар хураан авч бусад үйлчилгээний байгууллагуудад хуваарилалт хийж байдаг. Энэ мэтчилэн төрийн бүх үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд МХХТ-ийг нэвтрүүлж цахимжих ёстой. Цахим засаглалыг үр дүнтэй байлгахын тулд (1) G2C—төр-иргэн, (2) G2G—төр-төрийн харьяа байгууллагууд, (3) G2E—төр-ажилтан, G2B—төр-бизнес эрхлэгчид гэсэн эргэх холбоо бүхий харилцааг үүсгэх ёстой” гэсэн байна.

Дээрх судалгааны ажлуудаас харахад цахим засаглал хөгжих нь системтэй, үе шаттай, олон талт байдлыг хангасан байх ёстой байна. Тодорхой цаг хугацааг туулах нь тодорхой бөгөөд хэрхэн үр дүнтэй байдлаар шилжилт хийх гэдэг нь хөгжлийн үе шатуудыг туулахаас гадна бодлогын болон эрх зүйн зохицуулалт зайлшгүй хэрэгцээтэй. Мөн цахим засаглал нь нийгмийн үйл ажиллагааг бүхэлд нь хамрах тул олон оролцогчыг хамруулах шаардлагатай болдог байна.

Иймд судалгааны ажлын хүрээнд цахим хөгжлийн загвараар нөхцөлүүд бүрдсэн эсэх, оролцогч талуудын харилцааг зохицуулсан эсэх, манайх хөгжлийн аль шатанд явааг тоймлон гаргахыг зорилоо.

Монголын цахим засаглалын хөгжлийн хандлага

Монгол улс 1990 онд ардчилсан шилжилт хийн төр, нийгмийн бүх харилцаа шинэ Үндсэн Хуулийн дагуу ардчиллын үнэт зүйлийг нэвтрүүлсэн байдаг. Гэвч ардчилсан төрд итгэх иргэдийн итгэл 30 жилийн турш тасралтгүй буурсаар ирсэн байна. Сант Марал судалгааны байгууллагын судалгааны үр дүнгээс харахад иргэдийн төрд итгэх үзүүлэлт 50 хувь хүрэхгүй байсаар ирсэн. Улмаар тус судалгаанд нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг эрэмблүүлэхэд эхний аравт авилга, хууль сахиулах байдал, засгийн газрын үйл ажиллагааны хүнд суртал тогтмол дурдагдаж ирсэн болно (foundation, 2020).

Ялангуяа төрийн үйлчилгээтэй холбоотой хүнд суртлыг шийдвэрлэх цорын ганц арга зам нь хээл хахууль өгөх гэсэн хариултыг судалгаанд ороцлогчдын 57.6% нь өгсөн удаа байдаг (Азийн сан, Сант марал судалгааны хүрээлэн, 2017). Олон улсын Worldwide Governance Indicators, 2021-д манай улсын Government Effectiveness (GE) нь 39.9 (Д. Кауфманн (Daniel Kaufmann), А. Краая (Aart Kraay), М. Маструцци (Massimo Mastruzzi), 2021) оноотой буюу хүнд суртал ихтэй, төрийн үйлчилгээ сул байсаар байгааг хэмжсэн байна.

Шинэ ардчилсан төрийн хувьд иргэдийн төрд итгэх итгэлийг сэргээж чадахгүй бол 20-30 жилийн дараа дарангуйллын тогтолцоо тогтох боломжтой судлаачдын таамаглал байдаг (М. Крозер (Michel Crozer), С. Хантингтон (Samuel P. Huntington), Ж.

¹Palvia & Sharma (2007) elaborate, a government agency (G) interacts with outside constituents including citizens (C), business (B), another governmental agency (G) or employees (E). Separate governmental agencies are held responsible for performing activities such as tax collection where such revenues are utilized to provide services similar to defense, security or health care. To perform all these activities governmental agencies deploy ICT, making this activity ‘electronic’ government or e-government. Thus, primary delivery models for e-government are: (1) G2C—Government-to-Citizen, (2) G2G—Government-to-Government, (3) G2E—Government-to-Employees and, G2B—Government-to-Business.

Ватануки (Joji Watanuki), 1975). Үүнээс сэргийлэхийн тулд төрийн үйлчилгээний ил тод байдал, иргэдийг мэдээлэлжүүлэх нь иргэдийн төрд итгэх итгэлийн түвшинг шууд нэмэгдүүлж чадахгүй ч төрд итгэх итгэл үнэмшлийг бататгах боломжтой юм. Товчхондоо төр, иргэн хоёрын харилцааг ойртуулах хэрэгцээ шаардлага үүссэн. Олон улсан энэхүү засаглалын сул байдлыг сайжруулахын тулд сайн засаглалын үзэл санааг дэлгэрүүлэх болсон. Сайн засаглалын суурь үнэт зүйл нь хариуцан тайлагнах (accountability), ил тод байдал (transparency), нээлттэй байдал (openness) гэж хэлж болно. Манай улсын хувьд 2004 оны сонгуулийн дараагаас сайн засаглалыг хөгжүүлэх үзэл санаа хүчтэй дэлгэрч эхлсэн байдаг.

НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрөөс иргэдийн өргөн оролцоог хангах, хууль дээдлэх ёсонд үндэслэн шийдвэр гаргах, засгийн газрын үйл ажиллагаа ил тод явагдах, иргэдийн хэрэгцээ, сонирхлыг мэдрэх, бүх иргэдэд тэгш хандах, төрийн сангийн эх үүсвэрийг үр ашигтай, үр нөлөөтэй зарцуулах, улстөрийн хариуцлагатай байх, хөгжлийн төлөвлөлтөд алсын хараатай хандах зэрэг шинжүүдээр сайн засаглалыг тодорхойлсон.

Улмаар технологийн ололтыг ашиглан цахим засаглалд шилжсэнээр сайн засаглалын үзэл санаа бодитой хэрэгжих боломжтой байж болно. Судлаач Контерас (Contreras, 2021) үзэхдээ сайн засаглал нь цахим засаглалын ёс зүй, хэм хэмжээний суурийг бүрдүүлж өгнө гэж үзсэн байдаг.

Манай улсын хувьд 1990 оноос цахим засаглалын хөгжлийн эх суурь тавигдсан гэж хэлж болно. Тодруулбал 1992 оны 2 дугаар сарын 14-ний өдөр “Засгийн газрын мэдээллийн автоматжуулсан системийн дотоод сүлжээ байгуулах тухай” Засгийн газрын 25 дугаар тогтоол гарсан. Цахим засаглалын хэрэгцээ шаардлагыг мэдрэн бодлогоор хөгжүүлж эхлэсэн нь 2005 оны “Цахим Монгол” үндэсний хөтөлбөрөөс эхлэлтэй юм. Улмаар дараах байдлаар бодлогын баримт бичгүүд батлагдсан байдаг. Үүнд:

- 2008 онд “Цахим Монгол” үндэсний хөтөлбөр
- 2012 онд “Цахим засаг” үндэсний хөтөлбөр
- 2019 онд “Цахим засаглал” үндэсний хөтөлбөрүүд багтана.

Эдгээр бодлогын баримт бичгүүдийн гол үзэл санаа, үр дүнг Хүснэгт.1-р үзүүлье.

Хүснэгт.1. Төрөөс цахим засаглалыг хэрэгжүүлэхээр батласан бодлого, хөтөлбөрүүд

I. “Цахим Монгол” үндэсний хөтөлбөр 2005-2012

Үзэл санаа	Хүлээгдсэн үр дүн	Хэрэгжсэн байдал	
МХХТ-д тулгуурласан удирдлагын шинэ загварыг бий болгож цахим засаглалыг хэрэгжүүлэх	• Цахим засаглалыг нэвтрүүлснээр төрөөс иргэд, байгууллагад үзүүлэх үйлчилгээг шинэ шатанд гаргах, иргэдийн зүгээс төр, засагт хандах мэдээллийн шинэ урсгалыг бий болгох • Зорилгын хүрээнд	2005 он 1. Монгол Улсын интернэтийн гадаад гарцын багтаамж 78Мбит/с 2. Интернэт хэрэглэгч 22,000 3. Өргөн зурвасын шилэн кабелийн	2012 он 1. Интернэтийн гадаад гарцын багтаамж 22Гбит/с 2. Интернэт хэрэглэгч 654,009 3. Өргөн зурвасын

зорилго тавьсан.	МХХТ-ийн хэрэгслийг төрийн удирдлагын тогтолцоонд нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах • Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна • Төрийн байгууллагын үйл ажиллагаа нээлттэй, ил тод, шуурхай, хүнд сурталгүй болно • Төрийн үйлчилгээ “иргэн” төвтэй зөв засаглалын тогтолцоо бүрдэх	урт 3251 км 4. Үүрэн холбооны хэрэглэгч 551,000	шилэн кабелийн урт 18123.8 км 4. Үүрэн холбооны хэрэглэгч 3,409.005
-------------------------	--	---	---

I. “Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр” 2008-2012

Үзэл санаа	Хүлээгдсэн үр дүн	Хэрэгжсэн байдал
<i>МХХТ-д тулгуурласан удирдлагын шинэ загварыг бий болгож цахим засаглалыг хэрэгжүүлэх зорилго тавьсан.</i>	• Төрийн байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн бодлого боловсруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлж, төрөөс үзүүлж байгаа үйлчилгээг хүртээмжтэй, чирэгдэлгүй болгож, цахим засгийн үйлчилгээг хөгжүүлж нэвтрүүлэх	• Үндэсний дата төвийг байгуулан иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийг төгөлдөржүүлж хөрөнгийн арилжаа солилцоог баталгаажуулан бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд хамрагдах төрийн байгууллагын бүртгэл, мэдээллийн сан, системийг шинэчилсэн • 2010 оны 7-р сарын 5-ны өдрөөс эхлэн орон даяар иргэний шинэчилсэн бүртгэлийг эхлүүлж, 21 аймгийн 331 сум, 9 дүүргийн 132 хороо, нийт 463 нэгжээр дамжуулан иргэдийг бүртгэлд хамруулан иргэдэд цахим иргэний үнэмлэх олгосон

II. “Цахим засаглал” үндэсний хөтөлбөр 2012-2019

Үзэл санаа	Хүлээгдсэн үр дүн	Хэрэгжсэн байдал
------------	-------------------	------------------

Цахим засаглалыг хөгжүүлэх нь “Төрийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, түүнд инновацийг нэвтрүүлэх арга замын нэг нь цахим засаглалыг хөгжүүлэх явдал юм”	• Энэхүү бодлогын баримт бичгийн хүрэх үр дүн нь 2005, 2012 оныхтой ижил агуулгатай • “Цахим засгийг хөгжүүлэх замаар төрийн албаны үйлчилгээг иргэндээ хандсан, үр нөлөөтэй, шуурхай, хэмнэлттэй болгоно”	• Цахим хэлбэрт шилжүүлэх боломжтой төрийн үйлчилгээг тодорхойлж 25 үйлчилгээг Төрийн үйлчилгээний цахим машинаар • Иргэдийн зүгээс хамгийн их хүндрэл, чирэгдэлтэй гэж үзсэн 18 үйлчилгээг цахим хэлбэрээр төрийн үйлчилгээний нэгдсэн портал болох www.ezasag.mn цахим хуудсаар хүргэсэн • ТҮЦ машины үйлчилгээг нэвтрүүлснээр давхардсан тоогоор 2018 онд 2,2 сая иргэн үйлчлүүлж, нэг үйлчилгээ авахад 1 цаг 40 минут хэмнэсэн
--	---	---

III. “E-Mongolia” цахим үндэстэн хөтөлбөр 2020

Үзэл санаа	Хүлээгдсэн үр дүн	Хэрэгжсэн байдал
“Алсын хараа 2050”, Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Цахим үндэстэн” болох	1. Төслийн эхний шатанд mgov.mn-д 34 байгууллагын 188 үйлчилгээг цахимаар үзүүлж байсан 2. 2020 онд Цахим үндэстэн хөтөлбөр нь Төрийн 23 байгууллагын 181 төрийн үйлчилгээг иргэдэд цахимаар хүргэх гар утасны аппликейшн татан авч хүссэн газраасаа мэдээлэл авах үйлчилгээ эхэлсэн	1. e-mongolia.mn болж өөрчлөгдсөн 2. 2021 онд Төрийн 50 байгууллагын 592 төрийн үйлчилгээг нэгтгэхээр бэлдээд байна

Эх сурвалж: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан <https://www.legalinfo.mn/>

Дээрх байдлаар ээлжит парламентын сонгуулийн дараа ялалт байгуулсан намын засгийн газар байгуулагдах бүрд цахим засаглалыг сайжруулах бодлогын баримт бичгүүд өөрчлөгдөн батлагдаж байсан байна.

Улмаар Хүснэгт.1-т дурдсан 2005 оноос хойш батлагдсан хөтөлбөрүүдийг бодит болгох үүднээс цахим засаглалын хөгжлийн эрх зүйн суурийг бүрдүүлэх, бодлогын чиглэл болсон 67 баримт бичгүүдийг УИХ болон Засгийн газрын тогтоолуудаар баталсан байна.

Гэвч олон улсын судалгааны байгууллагуудын индексжүүлэлтээр цахим засаглалын хөгжлийн байдал сул гарсаар байна. Тухайлбал United Nations Department of Economic and Social Affairs гаргадаг цахим засаглалын хөгжил буюу EGDI (E

government development index)-р манай улс 193 улсаас 92-т (Affairs, E-Government (EGDI) Index, 2020) бичигдэж байна. Энэхүү судалгааны хэмжигдэхүүн нь

- а. цахим үйлчилгээ- чанарын асуудал
- б. цахим технологи
- в. хүний нөөц дээр тулгуурлаж хийгддэг.

Энэхүү судалгааны үр дүнгээр манайх маш сул гэдгийг нотлон харуулж байна. Хамгийн гол нөлөөлсөн хүчийн зүйлийн нэг бол төрийн байгууллагын авилга, хүнд суртлын индекс тогтмол муу үзүүлэлттэй гарч байсантай холбоотой байж болно. Тухайлбал авилгын төсөөллийн индекс

Дотоодын төрийн байгууллагын хүнд суртлын талаарх судалгааны дүн харахад 2015 онд 62% нь хүнд суртал ихтэй гэж хариулж байсан бол 2018 онд 53% нь хүнд суртал ихтэй (МҮХАҮТ, 2021)гэдэг хариулт өгсөн байна. Судалгааны дундаж үзүүлэлтийн харахад Хүнд суртлын индекс 2-3 гэсэн үнэлгээ авсаар байна. Гол шалтгаан нь төрийн байгууллага хоорондын уялдаа холбоогүй ажлаас үүдэлтэй гэж судалгаанд оролцогчид хариулсан байна. Хариултаас харахад 2015 онд 62% нь муу, 20 % дунд гэж гэсэн бол 2018 онд 42% муу, 39% нь дунд гэсэн байна. Нийт хариултыг 70-80% орчим нь дунд, муу гэсэн үнэлгээтэй байгаа нь бодлогын баримт бичгүүд хэрэгжиж чадахгүй байна гэж үзэж болох талтай. Ялангуяа эрх зүйн орчин, технологийн хөгжил, хүний нөөцийн чадавх зэрэг нь бодлогын зорилготой уялдаж байсан эсэхийг харах шаардлагатай юм.

Тухайлбал байгууллага хоорондын уялдаа холбоо, нэгдсэн платформын асуудлыг хэрхэн шийдэж байсныг авч үзье. Манай улсын төрийн албаны үйлчилгээнд хэрэглэж байгаа технологи, системийн сайжруулалт, нээлттэй өгөгдлийг бий болгох ажлууд хийгдсээр ирсэн байна. Мэдээллийг нээлттэй болгох хандлага улам нэмэгдэж, хамтын ажиллагааг өргөжүүлж, засгийн газрын мэдээлэл хуваарилалтын нэгдсэн платформ-ыг бий болгохоор зорьсон байдаг.

Тухайлбал нээлттэй өгөгдлийн талаар “Олон Улсын Нээлттэй Засгийн түншлэлд” 2013 оноос оролцогч болсон байдаг. Тус санаачлагын хүрээнд манай улсад дараах үйл ажиллагаанууд хийгдсэн байна (Хүснэгт.2).

Хүснэгт.2. Нээлттэй өгөгдлийн санаачлага


Санаачилга	Эхэлсэн он	Хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаа
Нээлттэй Засгийн түншлэл	2013	- Төрийн үйлчилгээг сайжруулах - Төрийн институциудын ил тод байдлыг нэмэгдүүлэх - Шударга ёсыг бэхжүүлж, авилгыг бууруулах
Нээлттэй өгөгдөл	2014	2014 онд үзэл санаа нь манай улсад идэвхжсэн. Олон улсын төслүүд хэрэгжиж эхэлсэн. Нийтийн тээврийн унаанд ухаалаг карт уншигч суулгасан. Нийтийн тээврийн чиглэлийг зохицуулах зорилготой. НИТХ-ийн нээлттэй мэдээллийн санг бий болгосон.
Нээлттэй худалдан авалт	2012-2016	Тендэрийн цахим материал хүлээн авах, төсвийн ил тод байдлын талаарх техникийн дэмжлэг

ба төсөв

Эх сурвалж: Монгол улсын цахим өгөгдлийн зураглал ба үнэлгээ, 2017 он. Хуудас 22

Дээрх санаачлагын дагуу нээлттэй өгөгдөлийг нэгдсэн журмаар ашиглаж болох платформын бодит байдалд хэрхэн бүрэлдсэнг Бүдүүвч.1-р үзүүлье.


Бүдүүвч. 1. Үндэсний төвлөрсөн мэдээллийн санд төвлөрсөн байдал



Эх сурвалж: Монголын Үндэсний статистикийн хороо

Харин дараах Бүдүүвч.2-р үзүүлж байгаа сангууд Үндэсний төвлөрсөн мэдээллийн санд хараахан нэгдэж чадаагүй сангууд юм.

Бүдүүвч.2. Үндэсний төвлөрсөн мэдээллийн санд нэгдээгүй



Эх сурвалж: Монголын Үндэсний статистикийн хороо

Дээрх бүдүүвч 1,2-с харахад төрийн байгууллагын дотоод мэдээллийн сүлжээ, нээлттэй өгөгдлийн сангийн нэгдмэл бус байдал нь төрийн үйлчилгээнд сөргөөр нөлөөлж байгааг батлаж байгаа юм. Төрийн байгууллагын уялдаа холбооны талаарх судалгааны үр дүн үнэн байгааг илтгэж байна.

Ийнхүү бодлогын хэрэгжилт сул, системийн хувьд нэгдсэн бус байдал зэрэг нь цахим засаглалын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна хэмээн үзэн 2019 онд “Цахим засаглал” үндэсний хөтөлбөрийг батласан.

Тус үндэсний хөтөлбөрийн хүрээнд батлагдсан “Цахим үндэстэн” хөтөлбөрийг бодит болгох үүрэг нь Монголын Харилцаа, холбоо, Мэдээллийн Технологийн газарт ирсэн байдаг. Тус байгууллагын стратегийн зургаан зорилгын нэг нь энэхүү хөтөлбөр болсон байна. Тодруулбал Харилцаа Холбоо Мэдээлэл Технологийн Газар (ХХМТГ) нь

- дижитал дэд бүтэц;
- цахим засаглал;

- мэдээллийн аюулгүй байдал;
- тоон бичиг үсэгтэн-инновац;
- үйлдвэрлэл;
- үндэсний хөгжлийн хурдасгуур гэсэн 6 стратегийн зорилго тавин ажиллаж байгаа болно.

Тус агентлагаас дэвшүүлж байгаа стратегийн зорилгын хүрээнд Монгол улсын цахим засаглалыг хөгжүүлэх зураглалыг авч үзвэл Бүдүүвч.3-д үзүүлсэн байдлаар тодорхойлж болж байна.

Бүдүүвч.3. Цахим засаглалыг хөгжүүлэх бүрдэл хэсгүүд



Улмаар хамгийн сүүлд 2019 онд батлагдсан “Цахим засаглал” үндэсний хөтөлбөрт тусгагдсанаар цахим засаглалтай холбоотой 2 хуультай болно (хөтөлбөр, 2021) гэсэн зорилт тавьсан байна. Энэ нь эрхзүйн орчин бүрдээгүй байж гэсэн дүгнэлтийг шууд авч ирж байгаа болно.

Манай улсын цахим засаглалын эрхзүйн орчин одоогийн байдлаар хэрхэн бүрэлдсэн байгааг дараах хүснэгтээр харьцуулан үзүүлье (Хүснэгт.4. Эрхзүйн орчны харьцуулалт).

Хүснэгт.4. Эрхзүйн орчны харьцуулалт

№	Эстони улс (сайн туршлага)	БНСУ (азидаа тэргүүлэх)	Монгол улс
Цахим засаглалын харилцааг зохицуулах хууль эрх зүйн баримт бичиг			
1	Нийтийн мэдээллийн тухай хууль (Public Information Act)	Цахим засгийн тухай хууль (Digital)	Мэдээллийн ил тод байдал ба

- | | | |
|---|--|--|
| <ul style="list-style-type: none"> • Тоон гарын үсгийн тухай хууль (Digital Signatures Act) • Хүнамын бүртгэлийн тухай хууль (Population Register Act) • Архивын тухай хууль (Archives Act) • Үнэмлэх бичиг баримтын тухай хууль (Identity Documents Act) • Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль (Personal Data Protection Act) • Нийгмийн үйлчилгээний мэдээллийн тухай хууль (Information Society Services Act) • Цахилгаан харилцаа холбооны тухай хууль (Electronic Communications Act) • Нийтийн худалдан авах ажиллагааны тухай хууль (Public Procurement Act) • Төрийн нууц ба гадаадын нууц мэдээллийн тухай хууль (State Secrets and Foreign Classified Information Act) | <ul style="list-style-type: none"> government act) • Цахим гарын үсгийн тухай хууль (Digital signature act) • Үндэсний мэдээлэлжүүлэлтийн тухай хууль (The Framework act on National Information) • Цахим баримт бичиг, цахим шилжүүлгийн тухай хууль (the Framework Act on Electronic Documents and Transactions) | <ul style="list-style-type: none"> мэдээлэл авах эрхийн тухай • Цахим гарын үсгийн тухай |
|---|--|--|

Мэдээлэл солилцооны систем

<i>X-Road cистем-</i>	<i>-On-nara BPS-</i>	<i>E-mongolia</i>
• 2600 гаруй төрийн үйлчилгээ дамждаг ба гэр бүл болох ба салах, үл хөдлөх хөрөнгө зарах болон худалдан авахаас бусад иргэдэд зориулсан бүх төрлийн үйлчилгээг үзүүлдэг	• Төрийн үйлчилгээний 230 гаруй төв болон нутгийн захиргааны байгууллагын 850,000 хэрэглэгчтэй	• “Төрийн цахим мэдээлэл солилцох системийг ашиглан цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний жагсаалт”-ын дагуу төрийн 38 байгууллагын 592 үйлчилгээг үзүүлж байна
	-dBrain • Үндэсний санхүүгийн мэдээллийн систем-46 төрийн болон хувийн байгууллага харилцдаг	• Төрийн мэдээлэл

солилцооны
ХУР систем,
танилт
нэвтрэлтийн
ДАН систем,
төрийн
үйлчилгээний
нэгдсэн төвийг
нэвтрүүлж
иргэдэд
үйлчилж байна

Үр дүн

2019 оны байдлаар төрийн үйлчилгээний 99 хувь нь цахимаар хүрдэг, нийт Эстоничуудын 70 хувь нь ID карт тогтмол хэрэглэдэг.	31 төрлийн систем бүхий 19000 гаруй G2G болон G4C цахим үйлчилгээ үзүүлж байна.	Цахим албан бичиг солилцооны системээр Нийслэлд 1700 гаруй төрийн болон хувийн байгууллагуудыг хамрах болсон. Тоон гарын үсгийг 32000 хуулийн этгээдэд олгосон ба тендерт оролцох, албан бичиг солилцох, төрийн үйлчилгээ авахад ашиглаж байна.
--	---	---

3

Эх сурвалж: Парламентын судалгааны хүрээлэн “Цахим засаглал, бодлого болон тооны гарын үсэгтэй холбоотой эрхзүйн харьцуулсан судалгаа” 2021 он, хуудас 5

Хүснэгтээс харахад манай улсын цахим засаглалын эрхзүйн орчин сул байгааг харьцуулан харж болж байна.

Дүгнэлт

Монгол улсын нийт хүн амын 78.2% буюу 2,602,000 хэрэглэгч интернет болон нийгмийн сүлжээг ашигладаг. Энэ хувь нь насанд хүрсэн иргэдийн цахим хэрэглээ өндөр болохыг харуулж байна. Тодруулбал 14-64 насныхан хүн амын 64.4% эзлэдэг манай улсын хувьд интернет хэрэглэгчийн тоо өндөр байгаа юм. Монгол улсын цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний тоо 592 байна. Энэ нь нийт төрийн үйлчилгээний 20%-ийг эзлэдэг байна.

Тойм судалгааны явцад цахим засаг, цахим засаглал гэсэн нэр томъёог манай улс хэрхэн нэвтрүүлж, нэгдсэн ойлголттой болж чадсан эсэх нь сонирхол татаж байлаа.

Монгол Улсын хувьд цахим засаглалын бодлого хэрэгжүүлэхдээ зарим тохиолдолд “Цахим засаг” (E-Government), зарим үед “Цахим засаглал” (E-Governance) хэмээн орчуулсан байна. Ерөнхийлөгчийн тамгын газар, ШУА-ийн харьяа Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн судалгаанд “Цахим засаглал” гэх томъёолол нь англи хэлний E-Governance буюу “засаглалыг цахимжуулах” гэсэн утгаар, харин “Цахим засаг” гэх томъёолол нь “E-Government” буюу “төрийг цахимжуулах” утга илэрхийлнэ гэж тодорхойлж, энэ агуулгаар судалгаанд авч хэрэглэсэн гэжээ (Монгол улсын төрийн үйлчилгээг цахимжуулахтай холбоотой эрх зүйн орчны өнөөгийн байдал, 2014).

Энэ тодорхойлолтын агуулгаар 2004 оноос хойш (Electronic Government/ E-Gov) гэх үгний утгыг “Цахим Засаг” нэр үгээр төлөөлүүлж “төрийг цахимжуулах” гэсэн утгаар тодорхойлж хэрэглэжээ. Тиймээс төрийн үйлчилгээ цахим байвал цахим засаг манайд байна гэсэн хандлага нийтлэг байна. Үнэндээ цахим засаглалыг бүрэлдэхүүн хэсгүүд бүгд байж цахим засаглал манайд бүрэн хэрэгжих боломжтой юм. Манай улс одоогоор НҮБ-ын цахим засаглалын хөгжлийн тодорхойлолтоор цахим орчинг бүрдүүлэх, сайжруулах 2-р үе шатанд байна.

Мөн Палвиа, Шарма судлаачдын загвараар харахад (1) G2C—төр-иргэн, (2) G2G—төр-төрийн харьяа байгууллагууд, (3) G2E—төр-ажилтан, G2B—төр-бизнес эрхлэгчид гэсэн харилцааг үүссэн байгаа хэдий ч эдгээр оролцогчид хоорондоо мэдээлэл солилцох байдал бүрэн бэхжээгүй байна.

Цахим засаглал нь зүгээр нэг цахим хувьсгалын шинж тэмдэг биш бөгөөд засгийн газар, улс орон, иргэдэд бодит үр өгөөжийг бий болгодог. Тиймээс бид цахим засаглалыг хөгжлийг хэмжихдээ дараах үзүүлэлтийг тооцож үзэж байж хөгжлийн үе шатаа тодорхойлох боломжтой юм. Үүнд:

- *Иргэдэд хүртээмжтэй байдал нэмэгдсэн эсэх*
Үйлчилгээнд хамрагдах боломжгүй эсвэл нэвтрэх боломжгүй байсан иргэд төрийн үйлчилгээг авах хялбаршуулсан хэрэгсэлтэй болсон байх
- *Бүх талуудын үр ашгийг дээшлүүлсэн эсэх*
Илүү оновчтой үйл ажиллагааны журмуудыг хэрэгжүүлснээр зардлыг бууруулах, иргэд, төр ба хувийн хэвшлийн байгууллагууд, төрийн албаны үйлчилгээ авах аргачлалыг хялбаршуулсан байх
- *Үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлсэн эсэх*
Төрийн үйлчилгээг хэрэгцээтэй хүмүүс нь илүү сайн ашиглах боломжтойгоос гадна түншлэлийг бий болгох замаар илүү олон үйлчилгээг зах зээлд гаргаж, иргэдэд ашиглуулах боломжтой байх
- *Зардлыг багасгасан эсэх*
Ашиглахад хялбар, орон зайн хэрэгцээ багатай тул цахим засаглалын үйлчилгээ илүү хэмнэлттэй байдаг. Үүнээс гадна ашиглахад хялбар байдал нь иргэдийн төлбөрөө төлөлтийн байдлыг сайжруулсан байх
- *Залилан буурсан эсэх*
Мэдээлэл солилцох аргачлалыг сайжруулснаар ил тод байдал сайжирч, үе шат бүр дээр авилга гарах магадлал арилсан байх

Тойм судалгааны үр дүнд цахим засаглалыг хэрэгжүүлэх бодлогын бие даасан байдал сул агегтлагт харъяалагддаг. Нээлттэй өгөгдлийн хувьд ашиглах платформ нь хоорондоо холбоогүй байгаа нь төрийн үйлчилгээ авахад заавал цаасан баримтаар баталгаажуулах хүндрэл гардаг. Мөн иргэд нээлттэй өгөгдөл, цахим үйлчилгээ ашиглах чадвар сул байна. Хамгийн гол нь цахим засаглалын эрхзүйн орчин сайн бүрэлдээгүй байгаа нь гол анхаарах асуудал байна гэж харагдлаа.

Abstract

Although, Mongolia carried out “Digital Mongolia” national programme in 2005-2012, the National Programme to develop Integrated Registration System in 2008-2012, and the E-Governance National Programme in 2012-2016, the operation to separate information communication networks and services could not be successfully completed. The main reason is the inertia of mentality of the previous system to continue the state ownership of databases of all types, to monopolize of all profits for the government and to use for exercising power in implementing activities in information and communication sector resulting in ineffectiveness of political system and governance. In order to assess the digital governance issues and challenges of Mongolia, we intend to analyse policy documents, and conduct case research and make an inductive conclusion.

Ашигласан эх сурвалж

газар, М. У. (2014). *Монгол улсын төрийн үйлчилгээг цахимжуулахтай холбоотой эрх зүйн орчны өнөөгийн байдал*. Улаанбаатар хот: Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар.

Dawes, S. S. (2002). The Future of E-Government. *An Examination of New York City's E-Government Initiatives* (хууд. 3). New York City: New York City Council Select Committee.

Affairs, D. o. (2020). UN-E-Government-Survey-2020. (хууд. 34). New York: United Nations.

Heek, R. (2001). *Building e-Governance for Development: A Framework for National and Donor Action*. Manchester: The University of Manchester.

M, B. (2001). *E-Governance and Developing Countries, Introduction and examples*.

foundation, S. M. (2020). *Politbarometer*. Ulaanbaatar: Sant maral.

Азийн сан, Сант марал судалгааны хүрээлэн. (2017). *Авилгын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа*. Улаанбаатар хот: https://asiafoundation.org/wp-content/uploads/2017/09/MG-SPEAK2017_MNG.pdf.

Michel Crozer, Samuel P. Huntington, Joji Watanuki. (1975). *A Report on Governability of Democracies to the Trilateral Commission: The Crisis of Democracy*. New York: New York University Press.

Contreras, E. (2021 оны 7 20). *Foundations of E-Government: An Emerging Model-of-Use for Developing Countries*. http://learnlink.aed.org/Publications/Sourcebook/chapter6/Foundations_egov_modelofuse.pdf-ээс Гаргасан

Affairs, D. o. (2020 оны 11 10). *E-Government (EGDI) Index*. <https://publicadministration.un.org/egovkb/en-us/Data/Country-Information/id/113-Mongolia>-ээс Гаргасан

МҮХАЙТ. (2021 оны 11 10). *Хүнд суртлын индекс 2018*. https://resource4.sodonsolution.org/mongolchamber/File/2019/10/17/kgmdw7wnaabkz9hk/2_Sudalganii%20tailan_final_V20181224_web.pdf-ээс Гаргасан

хөтөлбөр, “ . з. (2021 оны 11 20). *Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт*. <https://www.legalinfo.mn/annex/details/9503?lawid=14177>:
<https://www.legalinfo.mn/annex/details/9503?lawid=14177>-ээс Гаргасан

Д. Кауфманн (Daniel Kaufmann), А. Краая (Aart Kraay), М. Маструцци (Massimo Mastruzzi). (2021). *Worldwide Governance Indicators*. World Bank.

УЛС ТӨРИЙН СОЦИОЛОГИД БЛОКЧЕЙН ТЕХНОЛОГИЙГ ХЭРЭГЛЭХ БОЛОМЖ

Т.Есүхэй

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,
Улс төр судлалын тэнхимийн дадлагажигч багш

Б.Болор-Эрдэнэ

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн магистрант

Хураангуй: Технологийн хурдацтай хөгжил хүн төрөлхтний өдөр тутмын амьдралын хэв маягаас эхлээд шинжлэх ухаануудын ирээдүйн чиг хандлагад хүчтэй нөлөө үзүүлсээр ирсэн. Энэхүү өгүүллээр орчин үеийн технологийн нэгэн дэвшил болох блокчейний нийгмийн шинжлэх ухаанд, тэр дундаа улс төрийн социологид хэрхэн ашиглагдаж болох талаар шинжилгээ хийхийг зорилоо. Блокчейн технологийн хэрэглээ маш олон салбарт хурдацтайгаар өсөн нэмэгдэхийн сацуу салбар бүрт томоохон өөрчлөлтүүдийг авчирж байна.

Түлхүүр үгс: Блокчейн, улс төрийн социологи, дата, нууцлал

Блокчейн нь дижитал, төвлөрсөн бус бүртгэлийн систем болохынхоо хувьд шинэ технологи юм. Бизнес, хууль зүй, эдийн засаг, компьютерийн шинжлэх ухааны хүрээнд шинжлэх ухааны судалгаа ихээр хийгдэж байгаа ч нийгмийн шинжлэх ухааны үүднээс судалсан судалгаа хомс байна. Блокчейн нь шинжлэх ухааны салбар бүрт төлбөрийн хэрэгсэл, хөрөнгө, хэрэглэгдэхүүн, нийгмийн хөдөлгөөн, улс төрийн асуудал болохын хувьд олон талаас нь судлах боломжтой. Блокчейн технологийн мэдээллийг хэрхэн хянаж байгаа, хэрхэн дамжуулж байгаа нь нийгмийн шинжлэх ухаан, тэр дундаа улс төрийн шинжлэх ухаанд хамаарч болох аюулгүй байдал, засаглал, удирдлага, түүнд итгэх итгэл, хувийн нууц, халдашгүй байдал зэрэг ойлголтууд шинэ тутам нөхцөл байдлыг бий болгох өргөн боломжтой ажээ.


Судлаачид блокчейн технологийг зөвхөн мөнгөн гүйлгээнээс гадна өөр ямар хэлбэрээр ашиглаж болох талаар олон янзын санал, таамаглал дэвшүүлж байгаагийн нэг нь нийгмийн шинжлэх ухаанд дата өгөгдлийг цуглуулах, нэгтгэх, бүртгэх, боловсруулахад ашиглах боломжтой хэмээн үзэж эхэлжээ.

Блокчейний талаар судалж, хөгжүүлж буй судлаачид уг технологийг тодорхойлохдоо тухайн агшин дахь хэрэглэгчид өөрсдөд тулгамдаж буй асуудлаа ардчилсан байдлаар шийдвэр гаргах, түүндээ бодитоор оролцох боломжийг олгодог, зарим комплекс асуудлыг шийдвэрлэхэд олон нийтийн санаа бодлыг цуглуулахад ашиглах боломжтой гэж үзжээ. Мөн эдийн засгийн шинжлэх ухааны үүднээс аж үйлдвэрийн дараагийн хувьсгал, капитализмын дараахь нийгмийг бүтээх эхлэл гэх зэргээр тодорхойлж иржээ. (Beaumont 2018; Wetherill 2018; Schwab 2016) Бид уг технологийн талаар Биткойн хэмээх банк болон бусад сонгодог институтээр дамжуулалгүйгээр хэрэглэгч хооронд төлбөр тооцоо, мөнгөн гүйлгээ хийх боломж бүхий цахим мөнгөн тэмдэгтээр анхлан таньж мэдсэн билээ. Блокчейн нь гагцхүү

цахим бөгөөд санхүүгийн ач холбогдолтой зүйлсийн бүртгэлээс гадна бодит биет зүйлсийг ч бүртгэх боломжтой бөгөөд уг бүртгэлээ хэрэглэгч хоорондын (peer-to-peer) сүлжээг ашиглан баталгаажуулж, аюулгүй байдлыг хангадаг.

Блокчейний бүтэц

Блокчейн нь өгөгдлийг нарийвчлан бүртгэж авсан блокуудын нэгдэл бөгөөд уг блокууд нь өөр өөрийн хэш код (hash code)-оор нэрлэгдсэн байна. Блок бүр жагсаалтад буй өмнөх блокынхоо хэш кодыг өөртөө давхар бүртгэж гинжин хэлхээг үүсгэдэг. Ингэснээр уг блокууд дээрх дата, бүртгэлийн аюулгүй байдлыг өндөр түвшинд хангадаг.




Хэлэлцээний алгоритм

Нөүд (nodes) буюу тухайн сүлжээний хэрэглэгчид блокчейн сүлжээн дээр бүртгэгдэж буй бүртгэл, датаг бусад хэрэглэгчид давхар өөртөө хуулбарлан авч баталгаажуулснаар уг технологийн гол онцлог болох тухайн гүйлгээ, бүртгэлийг гуравдагч институтээр биш нийт хэрэглэгчдийн оролцоотойгоор хянаж, баталгаажуулах үйл явц хэрэгждэг.

Зураг 2. Төвлөрсөн бус тогтолцооны зураглал

Decentralized Ledger



Нууцлалын тогтолцоо

Блокчейний хэрэглэгчид SHA256 алгоритмын тусламжтайгаар үүсгэсэн хэш код бүхий бүртгэлтэй бөгөөд уг хэш кодоор тухайн хэрэглэгч өөрийгөө танигдахгүй байх нөхцлийг бүрдүүлдэг. Үүний тусламжтайгаар блокчейн нь хэрэглэгчдийн хувийн нууц болон ил тод байдлыг хамтад нь хангаж чаддаг. Хэрэв блокуудын мэдээлэлд зориудаар өөрчлөлт оруулж, зарим нөүдэд халдлаа гэхэд блокуудад бүртгэгдсэн хэш кодууд зөрөх учир бусад нөүдүүдийн тусламжтайгаар уг халдлагыг таньж, буцаан үндсэн өгөгдлийг сэргээх боломжтой. Тухайн блокчейний нийт нөүдийн 51 хувьд халдаж тухайн өөрчлөлтөө хийж чадвал тухайн датаг бодит гэж итгүүлэх боломжтой ч

одоогийн технологийн хөгжил, нөөц бололцоог үзвэл ийм боломж хомс байна. Мөн тухайн блокчейнийг хэдий олон хүн хэрэглэнэ, төдий чинээ нууцлал, хамгаалалт сайжрах юм.

Судлаачдад блокчейн хэрэгтэй юу?

Зарим шинжлэх ухааны судалгаанд мэдээллийг явцууруулан ашиглаж, явцуу эрх ашигт нийцүүлэн тайлбарлах тохиолдлууд гардаг бөгөөд ийм тохиолдол түгээмэл байж болзошгүй хэмээх хардлага нэмэгдэж, хүмүүсийн шинжлэх ухааны судалгаанд итгэж үнэмших нь багасч эхэлсэнтэй дэлхий улс орнууд тэмцэж эхэлжээ. Жишээлбэл Данийн шинжлэх ухааны шударга бус байдлыг зохицуулах хороо (DCSD) нь 1993 онд, Их Британийн Хэвлэлийн ёс зүйн хороо (COPE) нь судалгаа, судалгааны өгүүллүүдийн ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх зорилгоор 1997 онд тус тус байгуулагдаж байв. Мөн АНУ-ын засгийн газар 1989 онд Шинжлэх ухааны шударга байдлын газар (OSI) болон Шинжлэх ухааны шударга байдлын хяналтын албыг (OSIR) үүсгэн байгуулжээ. Гэсэн хэдий ч мэдээлэл боловсруулах, хуурамчаар үйлдэх, эсвэл бусад хэлбэрийн шинжлэх ухааны зохисгүй үйлдэл, зөрчил зэргийг эрдэмтэд ямар давтамжтайгаар гаргадаг нь маргаантай хэвээр байна. Энэ сэдвээр хийсэн тооцооллууд нь бодит байдлаас зөрүүтэй байх нь элбэг ажээ.

Хэдийгээр блокчейн нь одоо байгаа төвлөрсөн системүүдийн сул талыг арилгах хувьсгалт технологи боловч аль ч салбарт блокчейн системд шилжихийн өмнө хийж судалгаанд блокчейн шаардлагатай эсэхийг тооцож үзэх хэрэгтэй бөгөөд тохиромжтой блокчейний загвар бүтцийг тодорхойлох нь зүйтэй. Тодорхойлохдоо дараахь алхамуудаар өөрийн судалгааны ажлыг үнэлж үзнэ.

Нэгдүгээрт, судалгааны ажилдаа блокчейнийг хэрэглэх боломжтой эсэхийг тодорхойлохдоо нэгдүгээрт, өгөгдлийн сангийн уламжлалт буюу төвлөрсөн технологи таны хэрэгцээг хангаж чадаж байна уу?

Хоёрдугаарт, судалгааны датаг тань олон хүмүүс шинэчлэх, засварлах шаардлагатай юу? Ихэнх тохиолдолд судалгаанд оролцсон респондент, мэдээллийг нэгтгэж буй судлаач гэсэн хоёр төрлийн хэрэглэгч дата сан руу ханддаг билээ.

Гуравдугаарт, судалгаанд оролцогч, судлаач хооронд итгэлцэл бий юу? Учир нь уламжлалт төвлөрсөн тогтолцоонд итгэлцлийг бүрэн хангах боломжгүй байдаг.


Дөрөвдүгээрт, судалгаанд оролцогч, судлаач нар судалгааны явцад харилцах гуравдагч талд (судалгааны систем нийлүүлэгч, төрийн дата төв, хяналтын байгууллагууд г.м) итгэдэг үү? Дээр дурьдсанчлан DCSD, COPE, OSI зэрэг байгууллагууд шинжлэх ухааны нийтлэл бүтээлүүд дэхь дата мэдээллийг урвуулан ашиглах, засах, өөрчлөхтэй тэмцэж буй хэдий ч дэлхий нийтээр дөнгөж мөсөн уулын оройтой тэмцэж эхэлж буй билээ. Тиймээс оролцогч талууд бүрэн итгэлцэх, судалгааны үр дүнгээ бүрэн баталгаажуулах боломжтой технологийг ашиглах боломжтой.

Тавдугаарт, судалгааны датаг нууцлах шаардлагатай юу? Судалгаанд оролцогч нь судлаачаас болон бусад хүмүүсээс овог нэр, байршил зэрэг судалгаанд шаардлагагүй хувийн мэдээллийг нууцлах, судалгааны хариултыг яг хэн гэж хүн хариулсан нь танигдахгүй байх нөхцлийг бүрдүүлэх, мөн нэгтгэгдсэн датаг эрх бүхий хэрэглэгч, институт л нэвтэрч үзэж, ашиглах эрхээр хангах зэрэг олон боломжит үйлдлүүдийг блокчейн технологи олгодог.

Дээрх таван шаардлага таны судалгааны ажилд шаардагдаж байгаа, аль эсвэл дээрх давуу талуудыг ашиглаж судалгааны ажлын үр дүнгээ илүү бодитой болгож, үр дүнд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхийг хүсвэл та судалгааны ажилдаа блокчейнийг ашиглах боломжтой.

Улс төрийн социологийн судалгааны блокчейн систем ажиллах зарчим

Зураг 3. Улс төрийн социологийн судалгааны блокчейн систем ажиллах зарчим



Блокчейнийг улс төрийн социологийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэхдээ судлаачдад дата өгөгдлийг бүрэн ашиглахаар, респондентуудад зөвхөн судалгааг бөглөхөөр, зарим хэрэглэгчдэд судалгааны үр дүнг үзэх боломжтой зэргээр системд хандах хэрэглэгчдийн эрхүүдийг тусгайлан тохируулах бүрэн боломжтой. Их, дээд сургуулиуд болон судалгааны институтиуд өөрийн серверт цугласан датаг хадгалж, баталгаажуулж, хэвлэн нийтлэх байдлаар оролцно. Судлаачид судалгааны анкет үүсгэхдээ их, дээд сургуулийнхаа академийг бүртгэлийг ашигласнаар, эрдэм шинжилгээний бус зорилгоор үүсгэсэн судалгааны асуултуудаас ялгарах, итгэлцлийг нэмэгдүүлэх боломжтой. Судлаач судалгааны респондентуудын нас, хүйс, боловсрол, амьдран сууж буй газар орон нутаг, ажил албан тушаал зэрэг мэдээллийг тухайн хүмүүсийн хувийн нууцад халдахгүй байдлаар цуглуулж судалгааны үр дүнгээ илүү нарийвчилж гаргах боломжийг бий болгох үүднээс E-Mongolia зэрэг төрийн дата системүүдтэй уялдуулах боломжтой. Мөн ингэснээр хуучин технологи ашигладаг судалгаанд тулгарч ирсэн, хуурамч хаягаас олон тооны хандалт ирэх зэргээр судалгааны ажилд саад учруулах эрсдлээс хамгаалж, цаашлаад судалгааны үр дүнг бодит иргэдээс цуглуулсан баталгаатай мэдээлэл болохыг баталгаажуулах давуу талтай.

Дүгнэлт

Өнөө үед судлаачид социологийн судалгаа авахдаа интернэт, гар утас, биеэр уулзах уулзалт зэрэг аргуудаас гадна олон янзын технологи, аппликейшн, вебсайтуудыг өргөн ашигладаг болж хөгжиж ирсэн ч цуглуулсан датаг нэг цэгт төвлөрүүлж нэгтгээд, төвлөрсөн сангаа ашиглан дүгнэж боловсруулаад олон нийтэд хүргэдэг уламжлалт шинж хадгалагдсаар байгаа нь дата мэдээллийн аюулгүй байдлаас эхлээд судалгааны үр дүнд итгэх итгэл бага зэрэг эрсдэлт хүчин зүйлсийг бий болгосоор байна.

Блокчейн улс төрийн социологийн судалгаанд оролцогчид ямар хариулт илгээснийг нээлттэйгээр харах боломжтой ч хэн хариулсныг нууцлах боломжийг хамтад нь олгож байгаа нь томоохон дэвшил ажээ. Ингэснээр, бүхий л дата их, дээд сургууль, судалгааны институтиудын баталгаатай сервер дээр хадгалагдахаас гадна нөүд(node)-үүдийн тусламжтайгаар уг датаг засах, устгах, халдах боломжгүй болгон аюулгүй байдлыг хангана. Мөн цаашлаад олон институтиуд дундын дата санг үүсгэж чадвал аль хэдийн цугласан датануудыг өөр нэгэн судлаач өөрийн судалгаа, арга зүйд нийцүүлэн хэрэглэх боломжийг ч ирээдүйд үүсгэж, төсөв хөрөнгө, цаг хугацааг хэмнэх томоохон ололт болох юм.

Abstract

The rapid development of technology has had a profound effect on the future direction of the sciences, starting with the daily life of mankind. This article aims to analyze how blockchain, one of the advances in modern technology, can be used in the social sciences, especially in political sociology. The use of blockchain technology is growing rapidly in many industries, and is making a big difference in every industry.

Ашигласан ном, материал

- Ahmad, M. and Salah, K. (2018) “IoT security: Review , blockchain solutions , and open challenges,” *Future Generation Computer Systems*, 82, pp. 395–411. doi:10.1016/j.future.2017.11.022.
- Aitzhan, N.Z. and Svetinovic, D. (2018) “Security and Privacy in Decentralized Energy Trading Through MultiSignatures , Blockchain and Anonymous Messaging Streams,” 15(5), pp. 840–852.
- Decker, C. and Wattenhofert, R. (2013) “Information Propagation in the Bitcoin Network.”
- Eyal, I. and Emin, G. (2013) “Majority is not Enough : Bitcoin Mining is Vulnerable *.”
- Liang, X. et al. (2017) “ProvChain : A Blockchain-based Data Provenance Architecture in Cloud Environment with Enhanced Privacy and Availability,” pp. 468–477. doi:10.1109/CCGRID.2017.8.
- Luu, L. et al. (2016) “Making smart contracts smarter,” *Proceedings of the ACM Conference on Computer and Communications Security*, 24-28-Octo, pp. 254–269. doi:10.1145/2976749.2978309.
- Mackey, T.K., Nayyar, G. and Mackey, T.K. (2017a) “Expert Opinion on Drug Safety A review of existing and emerging digital technologies to combat the global trade in fake medicines in fake medicines,” *Expert Opinion on Drug Safety*, 16(5), pp. 587–602. doi:10.1080/14740338.2017.1313227.
- Salah, K., Member, S. and Rehman, M.H.U.R. (2019) “Blockchain for AI : Review and Open Research Challenges,” *IEEE Access*, 7, pp. 10127–10149. doi:10.1109/ACCESS.2018.2890507.
- Sharma, P.K. et al. (2017) “DistBlockNet : A Distributed Blockchains-Based Secure SDN Architecture for IoT Networks,” (September), pp. 78–85.
- Sharma, P.K., Chen, M. and Park, J.H. (2018) “A Software Defined Fog Node Based Distributed Blockchain Cloud Architecture for IoT,” *IEEE Access*, 6, pp. 115–124. doi:10.1109/ACCESS.2017.2757955.

- Sharples, M. and Domingue, J. (2016) “The Blockchain and Kudos : A Distributed System for Educational Record , Reputation and Reward,” 2, pp. 490–496. doi:10.1007/978-3-319-45153-4.
- Sun, J. and Yan, J. (2016) “Blockchain-based sharing services : What blockchain technology can contribute to smart cities.” doi:10.1186/s40854-016-0040-y

**МОНГОЛ ДАХЬ ЕВРОП СУДЛАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА ТУЛГАМДАЖ
БУЙ АСУУДЛЫН СУДАЛГАА**

Г.Золзаяа

ОТИС, Олон улсын харилцаа, Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч

Б.Одгэрэл

Доктор, профессор

ОТИС-ийн Эрдэм шинжилгээ, Судалгаа эрхэлсэн дэд захирал,

Б.Галиндэв

Доктор, Профессор, ОТИС-ийн багш

С.Одхүү

Доктор, Профессор, ОТИС-ийн багш,

Н.Хосбаяр

Доктор, ОТИС-ийн Гадаад харилцааны албаны дарга,

Keywords: *European Union, International politics, European Study, Program, Curriculum*

Монгол Улс газарзүйн өвөрмөц, геополитикийн чухал байрлалтай болохынхоо хувьд Европын Холбооны анхаарал, ашиг сонирхлыг татаж байдаг төдийгүй ардчиллын үзэл санаа, үнэт зүйлсийг баримталдаг тул Европын Холбоо нь Монгол Улстай харилцаагаа эерэгээр бодитой идэвхжүүлэх хандлагатай байдаг. (Ц.Лхам, 2020) 2011 онд батлагдсан “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”-д АНУ, Япон, Европын Холбоо гэх мэт өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхээр анх удаа бодлогын түвшинд заажээ. 2017 оны хоёрдугаар сарын 15-нд “Европын холбоо, гишүүн орнууд, Монгол Улсын хооронд Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг дүгнэж Европын Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг үндэслэн Европын Парламент тогтоолын төслийг баталсан юм. Энэ чухал баримт бичигт : Монгол Улс Европын Холбооны хувьд Ази дахь “үнэ цэнэтэй түнш” мөн бөгөөд геополитикийн давтагдашгүй байршилтай хэмээн онцлон тэмдэглэсэн нь ойлголцол, итгэлцэлийг улам нэмэгдүүлэн болно. Мөн “Европын холбоо, АНУ, Япон, БНСУ, Энэтхэг улсыг оролцуулсан Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого, Орос, Хятадтай тогтоосон стратегийн түншлэл, Монгол, Орос, Хятад болон Монгол, Япон, АНУ-ын хооронд гурван талт байнгын өндөр түвшний уулзалтыг анхааралдаа авч...”, тогтоолын “Бүс нутаг, дэлхий нийтийн сорилт ба хамтын ажиллагаа” гэсэн хэсгийн 50 дугаар зүйлд: “Европын холбоог оролцуулсан Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын үзэл баримтлал, нөлөө бүхий стратегийн түнш, шууд хөрш Орос, Хятадтай тогтоосон бүтээлч, үр дүнтэй тэнцвэртэй харилцааг онцлон тэмдэглэж байна” гэжээ. (Д.Уламбаяр, 2019)

Монгол Улс Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /ЕАБХАБ/-д 2012 онд элссэн, 2006 онд Хельсинкид болсон Ази, Европын дээд түвшний уулзалт буюу АСЕМ-ын төр, засгийн тэргүүн нарын бага хурлын үеэр манай улс АСЕМ-ын гишүүн болсон гэх мэт харилцаа, хамтын ажиллагааны хувьд талууд ач холбогдол өгдөг. Европын Холбооны Ази дахь бодлого тогтмол өөрчлөгддөг боловч үйл ажиллагааны гол үнэт зүйлсийн нэг болох ардчилал, хүний эрхийг дээдлэх

зарчмын хүрээнд манай улс Ази дахь хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжтой улсуудын нэг юм. Нөгөө талаар Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал дахь Гуравдагч хөршийн бодлогын хүрээнд Европын Холбоо нь тодорхой байр суурь эзэлдэг.

Нэг. Хэдийгээр өөр тивд байдаг ч Монгол Улсын түнш Европын холбоотой харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх нь монголчуудын хувьд чухал гэж үзнэ. Монгол Улс газарзүйн өвөрмөц, геополитикийн чухал байрлалтай болохынхоо хувьд Европын Холбооны анхаарал, ашиг сонирхлыг татаж байдаг төдийгүй ардчиллын үзэл санаа, үнэт зүйлсийг баримталдаг тул Европын Холбоо нь Монгол Улстай харилцаа, хамтын ажиллагаагаа боломжтой бүх салбар, хүрээ, чиглэлээр өргөжүүлэх хандлагатай болохыг Олон улсын харилцаа, Олон улсын эрх зүйн чиглэлээр суралцаж буй бакалаврын түвшний оюутнуудын ойлголт, төсөөлөл, судлаач эрдэмтдийн үзэлд тулгуурлан тодруулахыг хичээсэн болно.

Монгол дахь Европ судлалын өнөөгийн байдал хийгээд Европын холбооны олон талт бодлого, үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудлыг харьцуулан судалж, санал гаргах, дүгнэлт өгөх зорилгын хүрээнд манай баг дараах судалгааг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Монгол Улсад хэрэгжүүлж буй Олон улсын харилцааны хөтөлбөрүүд дэх Европ судлалын хичээлийн агуулгад хийсэн дүн шинжилгээ,
2. Монгол улсад Улс төр судлал, Олон улсын харилцаа, Олон улсын эрх зүйгээр суралцаж буй бакалаврын түвшний оюутнуудын Европ судлалын хичээлийн талаарх ойлголт, төсөөлөлийг тодруулах анкет судалгаа,
3. Европ судлалын чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтэн, судлаач, багш, экспертүүдээс ганцаарчилсан ярилцлага авах, Европын Холбоо, түүний бодлого, үйл ажиллагааны талаар судлаачдын үзэл бодол, байр суурийг харьцуулан дүгнэх чанарын судалгаа зэрэг болно.

Европын Холбоо, түүний бодлого, үйл ажиллагааны талаар судлаачдын үзэл бодол, байр суурийг харьцуулан дүгнэх чанарын судалгааны хүрээнд энэ чиглэлийн судлаачидтай ганцаарчилсан ярилцлага хийсэн бөгөөд тус холбооны бодлого, үйл ажиллагаа, өнөөгийн байдал, учирч буй хүндрэл бэрхшээл, хөгжлийн цаашдын хандлагын талаар судлаачидын үзэл бодол, байр суурийг тодруулахыг зорьсон болно.

Европын холбооноос Ази руу чиглэсэн зорилго, бодлогын чиг хандлага юу вэ?, Цаашид ямар бодлого голлох төлөвтэй байна вэ? асуултын хүрээнд судлаачдын дийлэнх нь боловсрол, шинжлэх ухаан, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлогыг уг холбооноос Азийн улс орнууд руу явуулж байгаа талаар байр суурь нэгтэй байв. Хэдийгээр Ази нь өргөн уудам газар нутаг томоохон зах зээл, улс төрийн өөр өөр тогтолцоо, дэглэмтэй улс орнууд оршдог боловч эдийн засгийн хамтын ажиллагааны хувьд Европын сонирхол, анхаарлыг татаж байна гэж дүгнэж байв.

Монгол улс руу чиглэсэн тус холбооны бодлогын хувьд судлаачид Монгол Улс руу чиглэсэн бодлогыг 1992 оноос Европын Холбоотой дипломат харилцаа тогтоож, 1994 онд “TACIS”¹ хөтөлбөрт манай улс анх хамрагдсанаар Европтой өргөн хэмжээнд харилцах эхлэл тавигдсан гэж үзэж болно. Учир нь эдгээр хөтөлбөрүүдийн гол утга санаа бол ардчилал, хүний эрхийг дээдлэх үзэл санаа, үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэхэд оршдог. Энэ утгаараа Монгол Улсыг Европын Холбооныхон өндрөөр үнэлдэг. “ТАСИС” хөтөлбөрийн хүрээнд хүний нөөц, байгууллагын чадавхийг

¹ ТТУХН-т Үзүүлэх Техникийн Тусалцааны Хөтөлбөр

бэхжүүлэх, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэх, шилжилтийн үеийн нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж байсан талаар экспертүүд онцолж байв.

“...Европын Холбооны Шинэ Азийн бодлогын үзэл баримтлал Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн хөгжилд идэвхитэй хариу өгөх шаардлага байгааг тодорхой харуулж байгаа юм. Зүүн Хойд, Зүүн Өмнөд, Төв Ази гэсэн бүтэцтэй Европын Холбооны Азийн бодлого нь дурьдсан бүс нутгийн хөгжлийн үйл явцтай нийцэж байхын зэрэгцээ тодорхой улс орон, тухайн нөхцөл байдал бүрийн шаардлагад тохирч харилцан адилгүйгээр тодорхойлогдоно гээд Европын интеграцчилалын хүрээнд Атлантын болон Их 8-ын түншүүдтэйгээ нэгдсэн байр суурь баримтлана гэжээ. “Зүүн Хойд Азийн Япон, БНСУ, Монгол нь ардчилсан улсууд бөгөөд Орос, Хятадын дунд геополитикийн “онцгой”, чухал байрлалтай ардчилсан Монгол Улсын бие даасан гадаад бодлого явуулахад нь дэмжлэг үзүүлнэ” гэж онцлон зааж байсан

Монголын тал ЕХ-той харилцахдаа ямар чиг баримжаанд тулгуурлан хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар судалгаанд оролцсон экспертүүд тус Холбооны гол үнэт зүйл, тогтсон зарчим болох ардчилал, хүний эрхийг онцолж байв. Учир нь манай улс нь Ази тив дэх цөөн ардчилсан засаглалтай улсуудын нэг юм. Нөгөөтэйгүүр Евро стандарт буюу Холбооноос хамтын ажиллагааны аль ч салбарт стандартыг нэмэгдүүлэх, тогтвортой бодлого баримтлах нь чухал болох талаар дурдсан. Монгол Улс, ЕХ аль салбарт хамтран ажиллах нь харилцан ашигтай байх талаар зарим судлаачид өмнө дурдсан үнэт зүйлс хийгээд соёлын хамтын ажиллагааг онцолж байсан бол тодорхой судлаачид хөнгөн үйлдвэрлэл, худалдаа болон боловсролын салбарыг дурдаж байв.

Боловсрол, Шинжлэх Ухааны салбар дахь харилцаа, хамтын ажиллагаа хэр далайцтай байгаа талаар судлаачид өөр өөрсдийн байр суурийг илэрхийлж байсан бөгөөд Монголын зүгээс шаардлагатай алхамуудыг хийх талаар онцолж байв. Тухайлбал судалгаанд оролцогчид “TACIS-ын TEMPUS-ийн дээд боловсролын салбарын өөрчлөлт, шинэчлэлтийн чиглэлээр 20-иод төсөлд тусламж дэмжлэг үзүүлж амжилттай хэрэгжсэн.

Европын Холбооны боловсролын тогтолцоонд ИДС-ууд аналитик шинжилгээ хийх асуудал оюутнуудад тулхүү орж байгаа юм. Тэр нь нэг талаараа юуг илэрхийлээд байна гэвэл аливаа зүйлд үнэн дүгнэлт хийдэг. Тэрнийхээ үр өгөөжийг улс орныхоо хөгжил дэвшил ба тухайн улс орныхоо нийгмийн амьдралд оруулах хөрөнгө оруулалт гэдэг үүднээсээ авч үздэг юм байна лээ. Дээрээс нь өндөр чанартай, нарийн стандарт мөрдсөн боловсрол эзэмшсэн хүмүүс аливаа үйл ажиллагаа, ажлын байран дээр эсвэл ажиллаж байгаа бусад нөхцөл байдалдаа тэр соёл, стандартыг төлөвшүүлээд байгаа юм.

Эдгээр төсөл нь боловсролын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах, ЕХ-ны дээд боловсролын байгууллагуудыг Монгол Улс дахь түншүүдтэй харилцаа, хамтын ажиллагаа өрнүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. 2002-2006 оны Ерөнхий хөтөлбөр нь ялангуяа эрдэм шинжилгээний тогтвортой байдал, зохистой шийдэлд хүрэх үүднээс боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин зэрэг судалгааны хоёр талын ашиг сонирхлыг тодорхойлох асуудлыг хамарч байсан зэрэг асуудлыг онцолж бидний зүгээс идэвхи санаачилгаа дээшлүүлэхийг анхааруулсан санааг тэмдэглэж байв

Мэдээж, худалдаа, хөрөнгө оруулалт, албан ёсны хөгжлийн тусламж хамгийн гол чиглэл болов уу. Монголын тал ЕХ-ноос бидэнд олгосон GSP+ийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байна. МҮХАҮТ энэ чиглэлийн үйл ажиллагаа учир дутагдалтай байна гэж хэлж болохоор байдаг. GSP+ийн чиглэлд гурвалсан болон дөрвөлсөн бизнесийн шинэ моделийг угсрах явдал байгаа болов уу. Европын стандартыг нутагшуулах төслийн хүрээнд 6 мянга гаруй стандарт батлагдсан. Үүнийг цаашид үргэлжсүүлэх шаардлагатай.

ЕХ-нд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийн талаар ерөнхийлөн дүгнэвэл нэгдүгээрт улс төрийн зарим байр суурийн асуудал, хоёрдугаарт дүрвэгсдийн асуудал болж байна. Европын холбооны хууль тогтоогчид, үүсгэн байгуулагчид, шинжээч судлаачид нь интеграцчилалын чиг хандлага зорилгыг ерөнхийд нь тогтоосон ч хүндрэл бэрхшээлүүд тулгарсаар байна. Интеграцчилал олон асуудалтай тулгарч холбооны гишүүд улсуудын зүгээс ч Европын холбоог татан буулгах талаар санал гарч байна. Дэлхийн улс төр, олон улсын харилцаанд олон янзын үзэл санаа оршиж байгаа нэгдэн нийлж, хүндрэл бэрхшээлүүдийг даван гарч буй энэхүү онцлог бүс нутгийг бид анхаарч авч үзэх шаардлагатайг судалгааны үр дүн тодруулж байна.

Хоёр. Эдүгээ манай улсад Олон улсын харилцааны хөтөлбөр хэрэгжүүлж буй арав гаруй их, дээд сургууль байгаагаас бид МУИС, ОУСДС, МПУ, ХУИС, Отгонтэнгэр Их Сургуулийн сургалтын хөтөлбөрийг харьцуулж, зорилго, агуулга, судлах цаг, Европ судлалын хичээл тусгагдсан байдлыг судалсан болно. Ингэхдээ Европын холбоо, улс төр, олон улсын хамтын ажиллагааны хүрээг тухайн хичээлийн агуулгад чухалчилсан болно.

ОУХ-ны хөтөлбөр хэрэгжүүлэгч их, дээд сургуулиудын албан ёсны сайтаас тухайн хөтөлбөрийн зорилгыг харьцуулан авч үзэхэд дараах нийтлэг болон ойролцоо байдал ажиглагдаж байна. Үүнд: 1. Олон улсын бодлого, улс төр, эдийн засгийн үйл явцыг ойлгох, дүн шинжилгээ хийх чадвартай, 2. Гадаад хэлний өндөр мэдлэгтэй, 3. Шинжлэх ухааны судалгааны арга зүйг эзэмшсэн, Дипломат алба, олон улсын бодлого, үйл ажиллагаанд шаардлагатай мэдлэг, стандартыг эзэмшсэн чадварлаг, мэргэшсэн боловсон хүчин бэлтгэхэд тус хөтөлбөрүүдийн зорилго чиглэгдэж байна.

Хүснэгт №1

Европ судлалын хичээл хөтөлбөрүүдэд тусгагдсан байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч сургууль	Европ судлалын хичээл тусгагдсан байдал	
	/Европын холбоо, улс төр, олон улсын хамтын ажиллагааны хүрээ/	Кредит
МУИС	Байхгүй	-
ХУИС	Байхгүй	-
Отгонтэнгэр Их Сургууль	Байхгүй	-
МПУ	Байхгүй	-
ОУСДС	Герман судлал	2 кр

Дээрх таван их, дээд сургуулиас ОУСДС-ийн Олон улсын харилцааны хөтөлбөрт Европын тухайлсан нэг улсаар буюу “Герман судлал” гэсэн хичээл байна. Бусад сургуулийн хувьд энэ чиглэлийн агуулгыг Бүс нутаг судлалын хичээлийн хүрээнд ойлголт өгдөг байна. Сүүлийн жилүүдэд Ази судлал, ялангуяа тус хөтөлбөрт Зүүн хойд Ази судлалын хичээлүүд нэмэгдэж байгаа боловч олон улсын харилцааны гол тоглогч улсуудын бүс нутаг болох Европын холбоо, тэдгээрийн гадаад бодлого, улс төрийн үйл явцын хичээлүүд хумигдаж, уг мэргэжлээр төгсөгчид Европ судлал, Европын холбооны талаар ойлголт төсөөлөл, мэргэжлийн мэдлэг багатай байна. Энэ талаар ахмад дипломатчид, экспертүүдтэй ганцаарчилсан ярилцлага хийхэд Монгол Улсад Европын холбооны байнгын Элчин сайдын яамыг байгуулахад онцгой үүрэг гүйцэтгэсэн Тэргүүн шадар, ахмад дипломатч, Доктор ScD, профессор Г.Төмөрчулуун “... Гадаад харилцааны яамны Европын газрын мэргэжилтнүүд Европ судлал, Европын холбооны талаар гүнзгий мэдлэгтэй байх ёстой. Манай улс дотооддоо олон улсын харилцааны мэргэжилтнүүдээ бэлтгэдэг байх нь олон давуу талтай ч мэргэшүүлэх чиглэлд энэ салбар орхигдож байна” гэдгийг онцолж байв. Иймд Гадаад харилцааны яамны Европын газар, Европ-Монголын харилцааны албанд ажиллах хүсэл сонирхолтой уг хөтөлбөрөөр суралцан төгсөгч нь Европын орнуудыг сонгон гүнзгийрүүлэн судлах, Европын Холбоотой харилцан ойголцох, хамтран ажиллах мэргэжлийн хүмүүс бэлтгэх хэрэгцээ, шаардлага байсаар байна.

Гурав. Олон улсын харилцааны мэргэжилд европ судлал /Европын холбоо, улс төр, олон улсын хамтын ажиллагааны хүрээ/, европын улс орнуудын харилцааны хичээл нь хөтөлбөрийн хүрээнд заавал судлагдвал зохих хичээлийн нэг мөн билээ. Орчин үеийн олон улсын харилцааны түүх, улс төр, эдийн засгийн харилцааны гол судлагдахуун төдийгүй олон улсын харилцаанд бодлого тодорхойлохуйц томоохон улс орнуудаас гадна өөрийн тоглолтын хүрээнд үүрэг гүйцэтгэдэг улс орнууд энэ бүс нутагт оршдог. Олон улсын харилцааны чиглэлээр мэргэжил эзэмшүүлдэг гадаадын их сургуулиудын хөтөлбөрийн түүвэрлэсэн судалгаанд Солонгос, Япон, Хятад, Пакистан, Азербайжан, Турк, Австрали, Испани, Португали, Их Британийн их сургуулиуд дахь тус мэргэжлийн хүрээн дэх хөтөлбөрт шинжилгээ хийв.

Хүснэгт №4. ИДС-иудад Европ судлал чиглэлийн хичээлүүд хөтөлбөр оруулсан байдал

Их сургууль	Хичээлийн нэр	Хичээлийн кредит	Хичээлийн төлөв
Ёнсей Их Сургууль	Европын улс төр	3 кр	Заавал судлах
Кёотогийн Их Сургууль	Европын улс төр	2 кр	Сонгон судлах
Шаньдун Их Сургууль	Европын улс төр, олон улсын харилцаа	2 кр	Заавал судлах
Пакистаны Их Сургуулиуд	Бүсчилэн оруулсан	2 кр	Сонгон судлах
Азербайжаны Их Сургууль	Европ судлал	1,5 кр	Сонгон судлах
Австралийн Их Сургууль	- Орчин үеийн Европ, - Европын холбоо:Түүх, улс	3 кр 2 кр	Сонгон судлах

	төр, Харьцуулсан Европын улс төр		Сонгон судлах
IE (Instituto de Empresa) Их Сургууль	Европын Холбоо	3 кр	Заавал судлах
			Заавал судлах
		6 кр	
	- Европын байгууллагууд		Заавал судлах
	- Европын холбооны улс төрийн систем	4 кр	
Коймбрагийн Их Сургууль	- Европын эдийн засаг		Сонгон судлах
	- Европын нийгмийн бодлого	6 кр	
	- Дэлхийн бодлого зүй дахь Европын байр суурь	6 кр	Сонгон судлах
		4 кр	Сонгон судлах
	- Европын холбооны бодлого, улс төр	2 кр	Заавал судлах
Лийдсийн Их Сургууль	- Дэлхийн бодлого ба Европын холбоо	2 кр	Сонгон судлах
	- Европ болон Ази судлал	3 кр	Заавал судлах
Москвагийн Их Сургууль	- ОХУ, Европын Холбооны харилцаа	2 кр	Сонгон судлах

Үүнээс үзэхэд Солонгосын Ёнсей их сургуульд Олон улсын харилцааны бакалаврын сургалтын хүрээнд “Европын улс төр” хичээлийг 3 кредит мэргэжлийн сонгох хичээлийн хөтөлбөрөөр хэрэгжүүлдэг ² байхад Японы Киотогийн Их сургуулийн нээлттэй сургалтын хөтөлбөрт “европын улс төр” ³ хичээлийг 2 кредит цагийн хүрээнд европын улс орнуудын бодлогыг төр болон нийгмийн харилцаанд үндэслэн харьцуулан судлах, европын улсуудын эргэн тойрон дахь улс төрийн харилцааны өөрчлөлт хэрхэн явагдаж буйг судлах зорилготойгоор заадаг байна. Харин Хятадын Шаньдун их сургуулийн Олон улсын улс төр, нийтийн удирдлагын сургуулийн Олон улсын харилцааны бакалаврын хөтөлбөрт “Европын улс төр олон

² http://politics.yonsei.ac.kr/pagegenerater.asp?catalogid=politics&language=en&pagecode=en_gradu01
(Ёнсей Их Сургуулийн Олон улсын харилцааны бакалаврын хөтөлбөр)

³ https://ocw.kyoto-u.ac.jp/en/syllabus/?act=detail&syllabus_id=g_gov_1255&year=2021
(Киотогийн Их Сургуулийн Олон улсын харилцааны бакалаврын хөтөлбөр)

улсын харилцаа” хичээлийг заавал сонгон үзэх хичээлд багтаан судлан үздэг байна. Түүнчлэн Пакистан улсын дээд боловсролын хорооноос 2018 онд Олон улсын харилцааны чиглэлээр зэрэг дээшлүүлэх болон мэргэжил эзэмшүүлэх их дээд сургуулиудын нэгдсэн хөтөлбөрийг баталжээ. Үүнд үндсэн хөтөлбөрийн заавал сонгон судлах болон мэргэжлийн сонгох хичээлд европ судлал, европын улс төр болон харилцааны хичээл тусгагдаагүй боловч сонгох боломжит 3 кредитийн хичээлд бүс нутаг судлалын хүрээнд европ судлалыг 3 бүсчлэн багтаажээ⁴.

Мөн Азербайжаны Аялал жуулчлал, менежментийн их сургуулийн Олон улсын харилцааны хөтөлбөр нь Европ судлал хичээлийг 1.5 кредит цагаар европын улс орнуудын улс төр, засаглал, түүх, соёл болон олон улсын дахь европын эдийн засгийн байр суурийг судлан таниулах зорилготойгоор хөтөлбөрт тусгасан байна. Дээрх сургуулиудын хөтөлбөрт европ судлал, европын улс төр хичээл тусгагдсан байдлаас үзэхэд Хятад, Солонгос, Японы сонгон авсан их сургуулиудад европ судлал нь мэргэжлийн болон заавал сонгон судлах хичээлд багтаан үздэг байхад Пакистан болон Азербайжанаас бидний сонгосон их сургуулиудад европ судлалын хөтөлбөрийг бага кредитээр болон сонгож боломжит хичээлд багтаан судалдаг байна. Австралийн Үндэсний Их Сургуулийн Олон улсын харилцааны бакалаврын хөтөлбөрийн сонгон судлах хичээлүүдэд Орчин үеийн Европ, Европын холбоо:Түүх, улс төр, Харьцуулсан Европын улс төр⁵ зэрэг хичээлийг энэ чиглэлээр мэргэших, ирээдүйд Европ судлалаар ажиллах хүсэлтэй оюутнууд сонгон судлах боломжтой байна. Испанийн IE (Instituto de Empresa) Их Сургуулийн Олон улсын харилцаагаар⁶ суралцагч оюутнууд Европын холбоо 3 кр хичээлийг заавал судалдаг бол Португалийн Гадаад харилцааны тэргүүлэх их сургуулийн нэг болох Коймбрагийн их сургуулийн⁷ оюутнууд европын холбоо, улс төр, гадаад бодлогын талаар 24 кредит заавал болон сонгон байдлаар судлах боломжтой байна. Харин Их Британы Лийдсийн Их Сургуулийн Олон улсын харилцааны хөтөлбөрт Европын холбооны бодлого, улс төр хичээлийг заавал судлахаас гадна Дэлхийн бодлого ба Европын холбоо хичээлийг сонгон судлах боломжтой.⁸ МГИМО буюу Москвагийн Олон улсын харилцааны дээд сургуулийн тус хөтөлбөрөөр суралцагч “Европ болон Ази судлал” 3 кредит, “ОХУ, Европын Холбооны харилцаа” 2 кредитийн хичээлийг үздэг байна. Түүврийн аргаар гадаадын 10 их сургуулиудын олон улсын харилцааны бакалаврын хөтөлбөр⁹ дахь Европ судлалын хичээл тусгагдсан эсэхийг судлахад сургуулиуд бүгд хөтөлбөртөө уг агуулгыг тусгай хичээл болгон заадаг байна. Энэ нь олон улсын харилцааны гол тоглогчдын нэг Европын холбоо, Европ судлалын агуулгыг чухалчлах нь эдгээр мэргэжлийн түгээмэл зорилго болж байгааг илэрхийлж байна.

Дөрөв. Европ судлал хичээлийн талаар ИДС-ын оюутнуудаас авсан анкетын судалгааны дүн

⁴<https://www.hec.gov.pk/english/services/universities/RevisedCurricula/Documents/2017-2018/CURRICULUM%20OF%20INTERANTIONAL%20RELATION.pdf>

(Пакистаны Их Сургуулиудын Олон улсын харилцааны бакалаврын хөтөлбөр)

⁵ <https://programsandcourses.anu.edu.au/program/bir> (Австралийн Их Сургуулийн Олон улсын бакалаврын хөтөлбөр)

⁶ <https://www.ie.edu/university/studies/academic-programs/bachelor-international-relations/courses/#program-menu> (IE Их сургуулийн Олон улсын харилцааны бакалаврын хөтөлбөр)

⁷ https://apps.uc.pt/courses/EN/programme/846/2021-2022?id_branch=12211#branch-12211

(Коймбрагийн Их Сургуулийн Олон улсын харилцааны бакалаврын хөтөлбөр)

⁸ <https://www.bachelorstudies.com/BA-International-Relations/United-Kingdom/University-of-Leeds-Faculty-of-Social-Sciences/> (Лийдсийн Их Сургуулийн Олон улсын харилцааны хөтөлбөр)

⁹ <https://sgia.mgimo.ru/programs/BA-MGIMO/Curriculum-BA-MGIMO> (Москвагийн Олон улсын харилцааны дээд сургуулийн Олон улсын харилцааны бакалаврын хөтөлбөр)

Судалгаанд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн 8 ИДС-ийн Олон улсын харилцаа, Улс төр судлал, Олон улсын эрх зүй чиглэлээр суралцаж буй 300 оюутныг хамруулсан болно. Тус судалгааг Монгол улсад Улс төр судлал, Олон улсын харилцаа, Олон улсын эрх зүйгээр суралцаж буй бакалаврын түвшний оюутнуудын Европ судлалын хичээлийн талаарх ойлголт, төсөөлөлийг тодруулах зорилгоор явуулсан бөгөөд судалгаанд оюутнуудыг хамруулахдаа хүйс болон суралцдаг курсийн тэнцвэртэй төлөөлөх байдлыг хангахыг зорьсон бөгөөд бакалаврын өдрийн ангийн 19-21 насны оюутнууд хамрагдсан болно. Судалгааны хамрагдсан оюутнуудын 53.2 хувь нь эмэгтэй, 46,8 хувь нь эрэгтэй байв. Нийт оролцогчдын 45.2 хувь нь 1-2 курс/түвшний, 54.8 хувь нь 3-4 түвшний оюутнууд байв. Судалгааг монгол улсад олон улсын харилцаа чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулж буй их дээд сургуулийн оюутнуудыг хамруулсан болно. Үүнээс МУИС 33.22%-г эзэлж байгаа бол 16.94% нь Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн оюутнууд байв. Бусад их сургуулийн оролцогчид 7-8% эзэлж байгаа нь хөтөлбөрөөр суралцагчидтай харьцуулбал зохистой түүвэр болсон гэж үзэж байна.

График №1. Судалгаанд оролцсон ИДС-ийн эзлэх хувийн жин






График №2. “Та Европын холбоо, Европын холбооны улс төр, гадаад бодлогын талаарх мэдлэгээ үнэлнэ үү”



“Та Европын холбоо, Европын холбооны улс төр, гадаад бодлогын талаарх мэдлэгээ үнэлнэ үү” гэсэн асуулгад нийт судалгаанд хамрагдагсдын 4.9% нь “Маш сайн”, 20,2% нь “Сайн” гэсэн үнэлгээ өгсөн нь нийлээд 1\4%-ийг эзэлж байна. Харин тэн хагас-50.1% буюу 151 оролцогч “Дунд”, үлдсэн 24.5% нь “Муу”, “Огт мэдэхгүй” гэсэн хариултыг өгсөн нь анхаарал, сонирхол татсан болно. Үүнээс харахад Европын холбоо болоод Европын холбооны улс төр, гадаад бодлогын талаарх хичээлийн цагийг нэмж, оюутнуудын мэдлэгийг сайжруулах шаардлагатай гэж дүгнэж болох юм. Оролцогчдын суралцаж мэргэжлээр авч үзвэл олон улсын харилцаа хөтөлбөрийн 41 оюутан буюу 22.1% нь “маш сайн” болон “сайн” үнэлгээ, 50.8% буюу 94 оюутан “дунд”, 27% буюу 50 оюутан “муу” гэсэн хариултыг өгсөн бол улс төр судлал хөтөлбөрөөр суралцдаг судалгаанд оролцсон 75 оюутны 24% буюу 18 оюутан “маш сайн” болон “сайн” гэж дүгнэсэн, 56% буюу 42 оюутан “дунд”, 20% нь оюутан энэ талаарх мэдлэг муу гэсэн хариултыг өгчээ. Олон улсын эрх зүй хөтөлбөрөөр суралцагч 41 оюутны 41.4% нь “маш сайн” болон “сайн” үнэлгээ, 36% оюутан “дунд”, уг хөтөлбөрийн судалгаанд оролцогчдын 20% нь “муу” хэмээн өөрсдийн мэдлэгийг тус тус үнэлжээ.

“Та Европын холбоо, түүнтэй адилтгах хичээлийг судалж байсан уу?” гэсэн асуулгад нийт судалгаанд хамрагдагсдын 29.53% буюу 88 оролцогч “цөөн” гэсэн хариултыг өгсөн бол 22.48% буюу 67 оролцогч “огт судалж байгаагүй” гэсэн хариулт өгчээ. Үүнээс дүгнэвэл Европын холбоо, түүнтэй адилтгах мэдлэгийг нэг хичээл болон тухайлсан хичээлүүдээр хүргэж байгаа нь Европ судлалаар мэргэшин төгсөх боломж хумигдмал байгааг харуулж байна.

График №5. “Таны мэргэшиж буй чиглэл, төгсөөд сонирхож буй ажлын байр юу вэ?”



“Таны мэргэшиж буй чиглэл, төгсөөд сонирхож буй ажлын байр юу вэ?” гэсэн асуулгад 30.82% буюу 86 оролцогч ГХЯ-нд мэргэжилтэн болно гэсэн хариултыг өгсөн бол 29.03% буюу 81 оролцогч хувийн хэвшилд гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн гэсэн хариулт өгчээ. Мөн ТББ-д гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн гэсэн сонголтыг 15.77%, Олон улсын байгууллагад мэргэжилтэн 16.85%, Бусад гэдэгт 7.53% саналаа өгчээ. Олон улсын байгууллагад мэргэжилтэн болно гэдэг итгэл үнэмшилтэй оюутан 1\5 хүрэхгүй байгаа нь бас анхаарахгүй байж болохгүй дүр зураг ажиглагдав.

“Хэрвээ Европын холбооны тухай, холбогдолтой хичээл танд санал болговол та сонирхон судлах уу?” гэсэн асуулгад 41.53% буюу 125 оролцогч сонирхож судална гэсэн бол 28.90% буюу 87 оролцогч шаардлагатай бол судална гэсэн хариулт өгчээ. Үлдсэн 11.63% мэдэхгүй, сонирхдоггүй тул судлахгүй 4.98%, маш сонирхож судална 12.92% байна. Үүнээс дүгнэж үзвэл Европын холбооны тухай болон

үүнтэй холбогдолтой хичээлийг оюутнуудыг судлах сонирхол их байгааг харгалзан сургалтын хөтөлбөрт энэ чиглэлийн хичээлүүдийг нэмж тусгах шаардлагатай нь харагдаж байна.

“Монгол улс ба Европын холбооны улсуудын хамтын ажиллагааны ач холбогдлыг та хэрхэн үнэлдэг вэ?” гэсэн асуулгад 36.88% буюу 111 оролцогч дунд гэсэн үнэлгээг өгсөн бол маш бага 7.31%, маш их 6.31% гэсэн үнэлгээг тус тус өгчээ. Үүнээс дүгнэж үзвэл Монгол улс ба Европын холбооны харилцаа, хамтын ажиллагааны тухай мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээх, сурталчлах, сургалт явуулах шаардлагатай байна.

“Таны бодлоор Европын холбооны улс төр, гадаад бодлого, эдийн засгийн талаар ойлголт, мэдлэгтэй байхын ач холбогдол юу вэ?, Мөн Таны суралцаж буй мэргэжилд ЕХ-ны улсуудын улс төр, хамтын ажиллагааны тухай мэдлэг тодорхой хичээл шаардлагатай гэж үзэж байна уу?” гэсэн асуулгад тухайн суралцаж буй мэргэжилд нь маш чухал шаардлагатай болон шаардлагатай гэж үзсэн оролцогчид Европын холбооны улс төр, гадаад бодлого, эдийн засгийн талаар ойлголт, мэдлэгтэй байхын ач холбогдлыг өндрөөр үнэлсэн байгаа бол суралцаж буй мэргэжилтэй холбоотойгоор “Мэдэхгүй”, “Шаардлагагүй” гэсэн хариулт өгсөн оролцогчид Европын холбооны улс төр, гадаад бодлого, эдийн засгийн талаар ойлголт, мэдлэгтэй байхын ач холбогдлыг дунд болон багаар үнэлсэн байна. Улс орнуудын хөгжил, харилцаа, хамтын ажиллагаа бие биеэс ихээхэн хамааралтай болсон даяаршсан ертөнцөд амьдарч буй залуу үе ингэж явцуурч, ялгавартай хандаж болохгүй гэсэн гаргалгаа хийхэд хүргэж байна.

“Европын холбооноос хамгийн сайн мэддэг, нөлөө бүхий улс төрч хэн бэ?” гэсэн асуулгад “Мэдэхгүй” болон хоосон үлдээсэн хэсэг асуулгын хуудсанд багагүй ажиглагдаж байна. Оюутнуудын хувьд Ангела Меркель, Жейн Касбекс, Урсула, Маргарет Тэтчер зэрэг улс төрчдийг онцолж бичсэн байв. Эндээс улс төрд хувь хүний ялангуяа лидер, удирдагчийн оролцоо, байр суурь, нэр хүнд, нөлөө, ач холбогдол өндөр болохыг оюутнуудад заах, ойлгуулахад анхаарах учиртай нь харагдлаа.

Анкетын судалгааны үр дүн ОУХ, Улс төр судлал, Олон улсын эрх зүйн мэргэжлээр суралцаж буй оюутнуудын хувьд Европ судлал, Европын холбооны үйл ажиллагаа, тус бүс нутгийн улс төр, олон улсын хамтын ажиллагааны талаар хөтөлбөрөөр олгож буй ойлголт мэдлэг хангалтгүй байгааг нотолж байна.

Дүгнэлт

Монголд Европ судлал хангалттай түвшинд хөгжиж чадахгүй байна. Шалтгаан нь харилцаа өргөн түвшинд хөгжихгүй байгаа, нөгөө талаар олон улсын харилцаа, улс төр судлал чиглэлээр мэргэжилтэн, хүний нөөц бэлтгэж буй ИДС-иудад энэ чиглэлийн хичээл байхгүй. Энэ агуулгад зөвхөн хэл, соёл талаас заахыг чухалчлан, улс төр, олон улсын хамтын ажиллагаа, гадаад бодлогын шинжилгээ хийх чадвартай судлаач бэлтгэхэд анхаарах асуудлыг орхидуулжээ.

Чанар судалгааны үр дүн Европ судлал, ялангуяа Европын холбоо, Европын улс төр, олон улсын харилцааны асуудал манай улсын хувьд чухал ач холбогдолтой болохыг, Европын холбоо, түүний гишүүн орнуудтай манай улсын хамтын ажиллагааны ач холбогдолын цар хүрээ өргөжиж байгааг тодорхой харуулж байна.

Олон улсын харилцаа, Улс төр судлал, Олон улсын эрх зүй хөтөлбөр хэрэгжүүлж буй их, дээд сургуулиуд бакалаврын хөтөлбөрүүддээ Европ судлалын

хичээл тусгаагүй. Зарим их, дээд сургуулиудын хувьд Европ судлалын агуулгыг Бүс нутаг судлал хичээлээр суурь шинжтэй ойлголтыг олгох зэргээр хязгаарлагдаж байна. Хөтөлбөрөөр суралцагчдын хувьд энэхүү агуулгаар мэдээлэл бүрэн авч чадахгүй, энэ чиглэлийн ойлголт мэдлэг дутмаг байдгаас үргэлжлүүлэн судлах, судалгааны сэдвийг гүнзгийрүүлэхэд хүндрэл учирдаг байна. Иймд дотоодын их, дээд сургуулиуд Европ судлалын хичээлийн агуулгыг өргөжүүлэх, цагийг нэмэх, сонгон судлах хичээлийг төрөлжүүлэх, ингэхдээ шаардлагатай, мэргэшүүлэх хичээлүүдийг түлхүү оруулах замаар Европ судлал, ялангуяа Европын холбоо, Европын улс төр, олон улсын харилцааны мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх нь Европыг холбоо болон гишүүд орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэхэд манай улсад чухал ач холбогдолтой юм.

Abstract

This study aims to determine the level of knowledge on the European Union, a region of major players in international relations, world politics and diplomacy, its multifaceted activities in the world, the current situation, the challenges it faces and the real trends in development of undergraduate students study Political Science, International Relations and International Law, to compare the views and positions of European scholars, researchers and researchers, and to analyze and comment on the content of the European Studies curriculum in the International Relations programs implemented in Mongolia.

Ном зүй

Т.Ариунсанаа (2013) Олон улсын харилцаа, дэлхийн бодлого зүйн удиртгал УБ.,

Б.Жаргалсайхан. (2004). *Хувь тавилангийн эрхшээл*. УБ.

Д.Уламбаяр. (2019 оны 8 1). Европын Холбоо Монгол улсын чухал түнш. *Зууны мэдээ*, 152, 2.

К.Дэмбэрэл. (2018). *Олон улсын хаарилцааны онол, үйл ажиллагаа*. УБ.

Ц.Лхам. (2020). Европын Холбооны стратегийн бие даасан байдал ба Монгол улс. *Олон улс судлал*, 1 (110), 66.

Г.Төмөрчулуун (2020) Монгол геополитикийн мандан бууралт ба сэргэлт УБ.,

Их дээд сургуулиудын “Олон улсын харилцаа” хөтөлбөрүүд:

http://politics.yonsei.ac.kr/pagegenerater.asp?catalogid=politics&language=en&pagecode=en_gradu01 (Ёнсэй Их Сургуулийн Олон улсын харилцааны бакалаврын хөтөлбөр)

https://ocw.kyoto-u.ac.jp/en/syllabus/?act=detail&syllabus_id=g_gov_1255&year=2021 (Кёотогийн Их Сургуулийн Олон улсын харилцааны бакалаврын хөтөлбөр)

<https://www.hec.gov.pk/english/services/universities/RevisedCurricula/Documents/2017-2018/CURRICULUM%20OF%20INTERANTIONAL%20RELATION.pdf> (Пакистаны Их Сургуулиудын Олон улсын харилцааны бакалаврын хөтөлбөр)

<https://programsandcourses.anu.edu.au/program/bir> (Австралийн Их Сургуулийн Олон улсын бакалаврын хөтөлбөр)

https://apps.uc.pt/courses/EN/programme/846/2021-2022?id_branch=12211#branch-12211 (Коймбрагийн Их Сургуулийн Олон улсын харилцааны бакалаврын хөтөлбөр)

<https://www.bachelorstudies.com/BA-International-Relations/United-Kingdom/University-of-Leeds-Faculty-of-Social-Sciences/> (Лийдсийн Их Сургуулийн Олон улсын харилцааны хөтөлбөр)

<https://www.ie.edu/university/studies/academic-programs/bachelor-international-relations/courses/#program-menu> (IE Их сургуулийн Олон улсын харилцааны бакалаврын хөтөлбөр)

AZERBAIJAN TOURISM AND MANAGEMENT UNIVERSITY, SYLLABUS ON DISCIPLINE OF EUROPEAN STUDIES, Page 3

<https://sgia.mgimo.ru/programs/BA-MGIMO/Curriculum-BA-MGIMO> (Москвагийн Олон улсын харилцааны дээд сургуулийн Олон улсын харилцааны бакалаврын хөтөлбөр)

ИРГЭНШЛИЙН МӨРГӨЛДӨӨН: ЕВРОПЫГ ЧИГЛЭСЭН ИСЛАМЫН УРСГАЛ ДАХЬ АФГАНИСТАН

Д.Түмэнжаргал

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар
Улс төр судлалын тэнхимийн ахлах багш, доктор

Б.Эрдэнэбат

БХЭШХ-гийн захирал, доктор (Ph.D), профессор

Хураангуй: АНУ-ын түүхэн дэх хамгийн урт, удаан үргэлжилсэн дайн гэгдэх Афганистаны дайн дуусгавар болж, АНУ-ын цэрэг Афганистаны нутгийг орхин гарснаар афганистан үндэстний урсгал Европ руу чиглэсэн “Исламын ертөнцийн сандаачигдсан үерийн урсгал”-д хүч нэмэн нийллээ.

Ойрх дорнод, Африк болон Ази тивд хэдэн мянган жил суурин оршсон соёл иргэншлүүд улс төр, дайн, энгийн хүмүүс хүлцээд байж боломгүй гаслан зовлонгоос үүдэн хүчтэй динамик урсгалд орж Европ руу чиглээд хэдэн жилийн нүүрийг үзэж байна.

Исламын эсрэг үзэл газар авсан барууны ертөнцөд ислам шашинтай үй олон дүрвэгсэд эргэж буцахгүйгээр орж байгаа нь соёл иргэншлийн хоёр том ертөнцийг нэг дор учраа ололцох түүхэн процессыг бий болгож, үүнийг соёл иргэншлийн мөргөлдөөн гэж томъёолохоос өөр аргагүйд хүрчээ.

Түлхүүр үг: Соёл иргэншил, Исламын шашин, Афганистан, зэвсэгт мөргөлдөөн, тогтворгүй байдал

Оршил:

Соёл иргэншлийн мөргөлдөөний тухай үзэл санааг АНУ-ын нэрт улс төр судлаач Самуэл Хантингтон анх 1992 онд хэлэлцүүлсэн илтгэлийнхээ үеэр дурдаж, 1993 онд Foreign Affairs сэтгүүлд “Иргэншил хоорондын мөргөлдөөн үү?” хэмээх өгүүлэл нийтлүүлж байв. Улмаар 1996 онд түүний “Иргэншил хоорондын мөргөлдөөн: Шинэчлэгдэж буй дэлхийн дэг журам” нэг сэдэвт бүтээл хэвлэгдсэнээр энэхүү үзэл санаа улам бүр түгж байв. Үүгээр хүйтэн дайны дараах үед зөрчил, сөргөлдөөн улс үндэстнүүдийн хооронд бус соёл иргэншлүүдийн хооронд өрнөх, улс гүрнүүд соёл, иргэншлээр хуваагдан талцал үүсгэх тухай санааг Хантингтон дэвшүүлсэн.

Хантингтоны дэвшүүлсэн санаа 2001 оны 9 сарын 11-ний халдлага, түүний дараагаар барууны зарим орнуудын Исламын шашинт орнуудын эсрэг өрнүүлсэн дайн, тухайн үед дэлхийн улс орнуудын баримталж байсан бодлого зэргээр улам батлагдаж, бусад нөлөө бүхий судлаач шинжээч нар ч барууны орнууд болон Исламын шашинтай орнуудын сөргөлдөөнийг иргэншил хоорондын мөргөлдөөний үзэл санаагаар тайлбарлахыг оролдож эхлэв.

Хэлэлцүүлэг:

Делигийн Их сургуулийн Улс төрийн шинжлэх ухааны профессор Дийпшиха Шахи “9 сарын 11-ний үйл явдлаас хойших Афганистаныг ойлгох нь: Хантингтоны иргэншлийн талаарх хандлагад шүүмжлэлт өнцгөөс хандах нь” сэдэвт өгүүлэл, АНУ-ын Флорида мужийн дээд сургуулийн Улс төрийн шинжлэх ухааны профессор Дэбидатта Махапатра “Иргэншил хоорондын мөргөлдөөн Афганистанд илэрч буй нь” сэдэвт өгүүлийг тус тус хэвлүүлжээ.

Барууны орнууд болон исламын харилцаа 15 жилийн өмнө дэгдсэн “Шог зургийн шуугиан”-аас үүдэн хурцадмал байдалд орж байсныг хэн бүхэн санаж байгаа (Amayreh, 2006). Энэ үед аж үйлдвэржсэн хөгжингүй гүрнүүд тооны хувьд христийн шашны бүх урсгалыг нийлүүлсэнтэй дүйхүйц Ислам шашинтнуудад өөрсдийн дүрэм, ёсыг тулгаж байлаа. Иймэрхүү үйлдлүүд нь исламын тэрс үзэлтнүүдийн идэвхийг нэмэхээс гадна шинэ террорист хандлага газар авах үндэс нь болж байв. Зөрчил, мөргөлдөөний үр дүнд нь үрэгдэж байсан энгийн номхон иргэд үнэндээ амбицтай хэсэг бүлэг лидерүүдийн буруу бодлогын золиос нь болж байна гэхэд хилсдэхгүй нөхцөл үүссэн. Өөрөөр хэлбэл, энэ хямрал барууныхны зүгээс хөгжлөөр хоцрогдсон ислам шашинтнуудад юуг, яаж хийхийг нь зааж, “Үнэний зам мөр”-өө хүчээр тулгахыг оролдсоноос үүдэлтэй.

ЗХУ 1991 онд задран унасны дараахан гол дайснаа алдсан барууны гүрнүүд цэргийн үйлдвэрлэлийн цогцолбороо хуучин төвшинд нь яаж барьж байхаа мэдэхгүй болж, НАТО оршин тогтнох бодит шалтгаан нь үгүй болж эхэлсэн. Ийм нөхцөлд барууны гүрнүүд маш хурдан “Шинэ дайсан”-аа олох шаардлага үүсэж НАТО-ийн ерөнхий нарийн бичгийн дарга өөрөө цэргийн эвслийнхээ гол дайсныг Ислам шашинтнууд гэж тодорхойлсноор барахгүй, ислам бол терроризмыг эх үндэс болсон, цэрэгжсэн шашин гэдгийг баталсан олон ном, өгүүлэл нийтлэгдэж байлаа (Moseley, 1995). Энэ цаг үе америкийн улс төр судлаач Самуэль П. Хантингтоны “Соёл иргэншлийн мөргөлдөөн”-ий үндсэн зарчим өргөн тархаж (П.Хантингтон, 1996) байсантай давхацдаг.

Хүний дүр төрхийг дүрслэх нь хориотой исламын шашинд, тэдний онгон шүтээн зөнч Мухаммедыг элдвээр, ямар ч цензургүй шоглон гутаах нь исламын шашин шүтэгч энгийн хүмүүст эмзэг тусах нь ойлгомжтой. Эмиратын нэртэй сэтгүүлч Ибрагима Шукралла «Галф Ньюс» сонины 2020 оны 10 дугаар сарын 27-ны дугаарт “Исламыг эсрэг үзэл” (исламофобия) дээд цэгтээ хүргэхэд хэсэг улсын засаг төр идэвхтэй оролцож байгааг дурдаад, “Хэрэв та эмэгтэй хүнийг доромжилж байгаа бол та эхнэрээ үзэн ядагч, хэрэв та хар арьстныг доромжилж байгаа бол та арьс өнгөөр ялгаварлан гадуурхагч, хэрэв та еврейчүүдийг доромжилж байгаа бол та антисемист, хэрэв та ислам шашинтныг доромжилж байгаа бол үг хэлэх эрх чөлөөгөө эдэлж байгаа нь тэр” гэсэн тэдний тайлбараар жишээ татжээ (Shukralla, 2020).

Үг хэлэх эрх чөлөөгөөр халхлан шашин шүтэгчдийг эмзэг сэдвээр нь доромжлох янз бүрийн өдөөн хатгалтууд эргээд “тэрс үзэлтнүүд”-ийн тэсвэрлэшгүй байдал, хүчирхийллээ зөвтгөх шалтгаан болсноор юунд хүргэдгийг бид олон үйл явдлаас харж болохоор байна.

Афганистаны “2 тодорхойлолт”

Үнэндээ Афганистан эртнээсээ олон улсын жихадист бүлэглэлүүдийн үйл ажиллагааны талбар байлаа.. Зөвлөлтийн цэрэг 1979 оны сүүлчээр цөмрөн орсны дараа “Зөвлөлтийн эсрэг олон улсын жихадистууд”-ын үйл ажиллагааны гол цэг нь

Афганистан байлаа. Энд Саудын Араб, Египет, Ойрхи дорнодын бусад улсуудаас үзэл суртлынхаа төлөө үхэхээс ч буцахгүй идэвхтэй төлөөллүүд цугларч, Афганистантай хиллэдэг Пакистаны бүс нутгуудад олон улсын дайчдыг цэргийн болон шашны боловсролд сургаж байсан. Статистикийн мэдээгээр 1982-1992 онуудад Пакистаны шашны сургуулиудад ойролцоогоор 35 000 афган дайчид тулалдааны бэлтгэлд хамрагдсан байна (Solomon, 2001). Эдгээр хүмүүс шаардлагатай цэргийн дадал дүйд суралцаад зогсоогүй маш том үндэстэн дамнасан сүлжээ бий болгожээ. Зөвлөлтийн цэрэг Афганистанаас гарсны дараа джихадистуудын зарим нь иргэний дайнд үргэлжлүүлэн оролцож, бусад нь Дэлхийн халуун цэгүүдэд (Босни Герцеговин, Чечень, Косово) байлдахаар тарсан бол Афганистаны дайнд америкийн цэргүүд ялагдаад ирэнгүүт эдгээр үндэстэн дамнасан террорист бүлэглэлүүдийн үйл ажиллагаа эргэн сэргэж байна.

АНУ болон түүний холбоотнууд “Талибгүй ардчиллыг байгуулах” амлалт өгч дайнаа эхэлж байсан бол 20 жилийн дараа ялагдал хүлээсэн АНУ Афганистанд байсан зорилгоо зөвхөн терроризмтой тэмцэх тэмцэл байлаа хэмээн тайлбарлав. Талибууд Кабулд орсон үйл явдал Афганистан улс дах АНУ болон түүний холбоотнуудын 20-н жилийн дайн эзлэн түрэмгийлэл байсныг гэрчлээд зогсоогүй, бусад орнуудад барууны “ардчилал”-ын загварын эрин үе дууссаныг баталсан үйл явдал байлаа. Америк Европчууд афганчуудыг “Ардчилсан өөрчлөлт”-ийнхөө багаж хэрэгсэл болгон ашиглаж байсан ч Афганистанд шинээр бий болгосон асуудлууд нь шийдэгдээгүйгээр үл барам тус бүс нутагт шинэ чичиргээг эхлүүлж байна.

Шанхайн Нийгмийн шинжлэх ухааны академийн Эрдэм шинжилгээний төвийн захирал Пан Гуан (潘光 : 塔利班可能跟20多年前有所不同, 但本质并没有变) «Гуанча» порталд өгсөн ярилцлагадаа, “Засаглалыг авсан талибууд 20 жилийн өмнөхөөсөө ялгарах магадлалтай ч мусульманы суннит урсгалыг баригч тэдний хэтэрхий туйлширсан үзэл санаа нь хэзээ ч өөрчлөгдөхгүйд гол аюул оршино” гэжээ.

Талибын засгийн одоо авч явуулж байгаа зарим аядуу арга хэмжээнүүд зөвхөн цаг зуурын үзэгдэл бөгөөд олон улсын хамтын нийгэмлэгүүдийн дэмжлэг аваагүй цагт Афганистаны хөгжих боломж нь хомс байх нь эргэлзээгүй. Энэ байдлаас дүгнэлт хийхэд дайн тэнд дуусаагүй, харин ч хил дамнасан дайн болон үргэлжлэх өндөр магадлалтай байна.

Афганистаныг орхисон АНУ-ын 2 шалтгаан, түүнд хийх дүгнэлт

Афганистаныг тойрсон улс төрийн үйл явдлууд бүх дэлхийг цочроогоод барахгүй, “Ардчиллын архитектор” гэгдэх Америкчуудын тэнд туурвисан ээлжит “Бантан”-г олон улсын нийгэмлэгүүд зохицуулах гэж мунгинаж байна. Энэ үед Афганистаныг хорин жил эзлэн түрэмгийлсэн АНУ-ын амжилтгүй, үр дүнгүй төгсгөлийн учир шалтгаан улс төр судлаачид, цэргийн шинжээчдийн судалгааны том объект байх нь аргагүй.

АНУ Афганистаныг яагаад орхихоор шийдэв гэсэн асуултад улс төрчид, шинжээчид хариулахдаа – энэ бол Америкийн геополитикийн уналт (декаданс) байлаа гэж баталж байгаа ч миний хувьд Вашингтон энэ удаа олон улсын харилцааны салбарын тэргүүлэх эрдэмтэн Роберт Гиллиний боловсруулсан “Тогтвортой байдал дах ноёрхлын онол” (Hegemonic Stability Theory)-ын онцгой стратегийг улс төрийн бодит жишээн дээр хэрэгжүүлжээ гэж харж байна. Түүний онолоор том улс төр тогтвортой байдлын ноёрхолд суурилах ч эсрэгээрээ ноёрхогч гүрэн өөрийн эзлэн түрэмгийллээс

татгалзаж, цэргийн хүчээ гэнэт гаргах нь бүх бүс нутгийг хамарсан тогтворгүй байдлыг “тухайн ноёрхогч оронд” ашигтайгаар эргэдэг байна (Gilpin, 1988).

Өнөөдөр АНУ Афганистаныг тойрсон хүндрэлтэй нөхцөл байдлыг албаар үүсгэж, үүнд нь ч барууны олон нийтийн либераль мэдээллийн хэрэгслүүд “Талибын хөдөлгөөн”-ий талаар дэгс мэдээ тараах, Америкийн бодлогод нэмэр болж байна. Америкийн эзлэн түрэмгийллийн үед Афганистаны дотоод улс төр тийм ч сайн байгаагүй, сайжраагүй. Үнэн хэрэгтээ зовлон, гасланд унасан афганы энгийн олон ястан иргэдээс өөр ямар ч шинэ юм тэнд бий болоогүй.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд болон шинжээчид өнөөдөр талибуудад орхисон америкийн зэвсэг техникийн тоо, тэдгээрийн тэнгэр тулсан үнийг тооцож байна. Мэдээж хэрэг, “Талибууд америкийн өндөр технологийн зэвсэг, техникийг (жишээ нь: Дональд Трампын их санаа зовж байсан Black Hawk нислэг тэргүүд) яаж ашиглах вэ?” гэсэн асуулт зовлонгүй тавигдана. Монголчууд “Хоосон буу хорин жилд нэг дуугарна” гэж ярьдаг. Хэрэв буу хананд зүүлтэй байгаа бол дараагийн удаад тэр буунаас болж юу болохыг хүлээх л үлдэж. Ингээд харахаар америкийн хэрэгжүүлж байгаа стратегийн бодит алхмууд дорхноо гараад ирнэ.

Харин одоохондоо америкийн засгийн газар Афганистаны төв банкны 9,5 тэрбум долларын активыг царцааж, бэлэн мөнгөний гүйлгээг хаалаа. Ямар ч орны эдийн засгийн тогтвортой байдалд саад учруулдаг, тухайн оронд дарамт шахалт үзүүлэх гол багаж нь болдог энэ аргад Америкууд их дуртай.

Америкууд Афганистанаас гэнэт гарсан шийдвэр стратегийн алдаа байв уу, эсрэгээрээ алсыг харсан тооцоотой үйлдэл байв уу гэдгийг цаг хугацаа удахгүй харуулна.

Цэргийн шинжээчийн “2 жишээ” дүгнэлт

Америк холбоотнуудтайгаа хамтран Афганистаны газар нутагт хийсэн хорин жилийн дайндаа ичгэвтэртэйгээр ялагдаж, Афганистан эзэнт гүрнүүдийг булшлах оршуулгын газар гэдгээ ээлжит удаагаа баталлаа

Америкчууд зөвлөлтийн армийн алдааг дахин давтаж, үйл явдлаас урган гарч байгаа нөхцөл байдалд улс төрийн тодорхой дүгнэлт хийж, түүндээ тулгуурлан бодлого боловсруулахгүйгээр энэ хэдэн жилүүд өнгөрчээ.

Вашигтоны улс төрчид цэргийнхнээсээ ямар хугацаанд, ямар үр дүн хүлээх ёстойгоо ч шаардлагатай түвшинд ойлгоогүй гэхэд болно. Үүнийг цэрэг армийнхны шоглон хэлдгээр “Тэр улсыг хөндлөн дайрч өнгөрөх тушаалын дагуу дайраад өнгөрлөө, эргээд эхний цэг дээрээ ирэх тушаалын дагуу дахиад л хөндлөн туушиндлаа, Дараа нь яах вэ?” гэдэг шиг л юм болоод өнгөрлөө. Хамгийн гол алдаа нь улс төрийн шийдэлдээ байсан ч цэргийнхний урагшгүй байдал их байсныг энд дурдсуу.

Шугамын ангийн дарга, захирагч нарын алба хаах хугацаа зургаан удаа солигдсон энэ 30 жилийн хугацаанд НАТО сансраас удирдах удирдлагын систем, хамгийн дэвшилтэт технологитой зэвсгээр зэвсэглэсэн хэдий ч Пентагонд төвтэй даяарчлагдсан удирдлагад бүх итгэл найдвараа атгуулсан НАТО-гийн цэргийн дарга нар байлдааны ажиллагаанд бие даан шийдвэр гаргаж чадахаа больжээ. Энэ нь ч Афганистан дах тэдний ялагдлын гол шалтгаан гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Бусад салбарын монополууд шиг “Цэргийн монопол НАТО”-д дайснаа бодитой харахгүйгээр дутуу үнэлэх, зэвсэглэлийн хөгжлийн бодлогоор халхлагдсан батлан

хамгаалах төсвийн асар их мөнгөнөөс өөр юм бодож чадахаа болих, цэрэг-улс төрийн нөхцөл байдлаа буруу тодорхойлох зэрэг олон асуудал нүүрлэжээ. Энэ мэт дутуу үнэлгээнүүдээс болоод илүү зардал гарах, батлагдсан төлөвлөгөөнүүдэд засвар их орох, захирагч дарга нарын шийдвэрт өөрчлөлтүүд байн байн гарах, цэргийн амь эрсдэл ихсэх, цэргийн ажиллагаанд тооцоологдоогүй их хохирол амсах зэрэг хүсээгүй зүйлд үргэлж хүргэдэг.

Зөвхөн 2010 оны туршид америк болон түүний холбоотнууд руу буудлагын зэвсэг, РПГ бусад удирдлагагүй тийрэлтэт сум ашигласан 18057 удаагийн зэвсэг дайралт болсныг 2011 оны 1 дүгээр сард Кабулд болсон хэвлэлийн бага хуралд Пентагоны төлөөлөгч албан ёсоор мэдээлж байсан. Тэд үнэндээ ядмагхан зэвсэглэсэн, энгийн тактиктэй, маш өндөр сэтгэл зүйн бэлтгэлтэй, “Харийнханд тайван байх нөхцөлийг олгохгүй” гэсэн гол даалгавар партизануудтай л тулалдаж байлаа. Партизанууд гранат шидэгч, гар аргын токарь дээр зорсон тийрэлтэт сумаар жил болгоны 18000 халдлагаа амжилттай биелүүлж ирсэн юм.

Афганистаны Засгийн газрын арми гэж юу вэ? Энэ нь талибанчуудын эсрэг 2007 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулсан хэдий ч бие даан байлдааны ажиллагаа явуулах туршлагагүй Зэвсэгт хүчин. Үргэлж холбоотнуудынхаа нөмөргөн дор гэрийн тэжээвэр амьтад шиг болсон Афганы арми эзэндээ найдаж явсаар, эзэн нь орхиод зайлах үед хямралд шууд өртөж байгааг бид харлаа. (Turan, 2021) Энэ бол бидэнд нэгийг бодуулах том сургамж.

Энэ дүр зураг анх удаагаа болж байгаа биш, давтагдсаар бараг зүй тогтол болсон үзэгдэл. Шулуухан хэлэхэд Ирак, Сири, Ливид болсон “Тулалдаануудад” НАТО-гийн цэргүүд дайснаа амьдаар нь нэг ч хараагүй зорилгодоо хүрсэн шүү дээ. Учир нь тэдгээр улсын засгийн газрын цэргүүд ухрахдаа ямар ч замыг миньжүүлээгүй, ямар ч гүүрийг дэлбэлээгүй, ямар ч мэргэн буудагчгүй, холбоогүй тохиолдолд бие даан эх орныхоо төлөө үүрэг гүйцэтгэх чадваргүй ийм л нэр төдий арми байлаа. Жишээ нь: Багдад дахь “Цөлийн шуурга”-наар хоёр “Абрамс” танк гүүр даван орж ирээд, хотын тэг дунд хүрч хоёр цаг гаруй Америкийн телевизийн камерт зургаа татуулан, залхуутайгаар хэд хэдэн буудлага явуулсан. “Танкын байлдааны дүрэм”-ийг ноцтой зөрчсөн энэ тохиолдол дайсан тэнд байхгүйг л харуулж байлаа. Саддамын цэргүүдэд орчин үеийн танк эсэргүүцэх зэвсэг байсан хэдий ч тэд бүгдээрээ тулаан болохоос өмнө амь зулбан зугтсан байжээ.

Иракт зөвлөлтийн зөвлөгчдийн төлөвлөгөөгөөр хотын районы хамгаалалтыг бэлдэх, америкийн холбоог барих сүлжээг урьдчилаад тоноглох, цэргийн ангиудаа орон нутгийн суурин, тосгоны байдалтай өнгөлөн далдлах, хаа сайгүй гранат шидэгчдийг бэлдэх ажлууд хийгдсэн бол уу? Тийм юмны үнэр ч тэнд байсангүй. Дарангуйлагч Саддам өөртөө зориулж төв талбайгаар сүртэй марш хийхэд л бэлтгэгдсэн, хий хоосон дулдуйдагчдаар армиа босгосон нь энэ. Афганистан дах Ганигийн засгийн газрын арми талибуудын өмнө яг дээрх дүр зургийг давтан харууллаа. Бас л бидэнд нэгийг бодуулах сургамж.

Улс төр судлаачийн “2 жишээ” дүгнэлт

Талибууд засаглаж байгаа Афганистан нь улс төрийн хувьд тусгаарлагдмал, кланы системтэй, хаалттай, олон улсын хамтын нийгэмлэгүүдийн зүгээс бүрэн эрхт тусгаар улс оронд тооцогдохгүй байх магадлалтай. Талибаны удирдлагууд хуурамч аядуу зан гаргаж байгаа боловч үнэн хэрэг дээрээ цаг хугацаа өнгөрөхийн хирээр яалт ч үгүй шариатын хатуу дэг жаяг руугаа гулсан орно. Энэ нөхцөл байдал одоогийн болон ирээдүйн Афганистаны тогтвортой байдалд нуугдмал аюулыг бий болгож байна.

Америк болон түүний холбоотнуудад Афганистаны дайн хамгийн удаан үргэлжилсэн дайн байлаа. Афганистан дах цэргийн эзлэн түрэмгийлэлд үрсэн америкийн төсөв хэдэн их наяд доллар (тодорхой тоог ухахгүйгээр) байлаа ч “Сэм ах”-ын Афганистан дах сонирхлын төлөө өргөсөн америкийн болон холбоотнуудын хэдэн зуун цэргийн амь, ирээдүйд итгэх итгэлээ алдсан олон сая афганчууд, Афганистаны улс төрийн системийн болон нийгэм – эдийн засгийн доройтол сүйрэл, бүх дэлхийг хамарсан хар тамхины сүлжээ, америкийн түрэмгийллийн эсрэг Афганистанд явагдсан хэдэн зуун террорист үйлдлүүдийн хор хохирлыг “хэдэн ч доллар”-аар хэмжишгүй.

Сүүлийн 30 жил америкаар толгойлуулсан европын хэдэн гүрэн Ойрх Дорнодод асар их хохирол авчирсны тод жишээ нь Ирак, Сири, Ливи болон бусад улсууд. Үүнээс үүдээд, сандаачигдсан хувь тавилантай, энэ зовлонгийнхоо төлөөсөнд өшөө авах хүсэлтэй хэдэн арван сая хүн бий болжээ. Өөрөөр хэлбэл, барууны улс гүрнүүдийн тавьсан энэ суурь тоогоор цөөн тэрс үзэлтнүүдийн шашны үзэл суртлаа дэлгэрүүлэх, шинэ гишүүдийг өөрийн талдаа төвөггүй элсүүлэх хөрс болж байна.

Хойд Африк, Ойрх Дорнодоос Европыг бүрхэн урсах дүрвэгчдийн холимог, тэсрэмтгий урсгалд нэмэгдэж Афганистанчууд түрэн орж ирлээ. Энэ фон дээр дүрвэгчдийг хүлээн авах квотоо нэмэх асуудлаар европын улсууд ярилцаж, нөгөө л бүгдэд танил “Үйл ажиллагааны тавилтууд” явагдаад эхлэв. Өөрөөр хэлбэл, америкийн геополитикийн шийдвэрээс гарсан “үр жимс”-ийг Европчууд өөрсдийн мөнгөө төлж хүртэх зовлонд дахин уналаа.

Америкийн улс төр судлаач Самуэль П. Хантингтоны “Иргэншил хоорондын мөргөлдөөн”-ий үндсэн зарчмаар шинэчлэгдэж буй дэлхийн дэг журам дах хүчний харьцаа өөрчлөгдөж, Европын газар нутаг дээр явагдаж байгаа соёл иргэншлийн тулгаралтад исламын шашинтнууд тоогоор давамгайлж эхэллээ.

Ашигласан ном, зохиол

Amayreh, K. (2006, 3 4). *Islam and West: Conflict or cohesion?* . Retrieved from aljazeera: <https://www.aljazeera.com/news/2006/3/4/islam-and-west-conflict-or-cohesion>

Gilpin, R. (1988). The Theory of Hegemonic War. *The Journal of Interdisciplinary History* . , 591.

Moseley, R. (1995, 2 12). *ISLAM IS NOT THE THREAT NATO MAKES IT OUT TO BE*. Retrieved from Chicago Tribune: <https://www.chicagotribune.com/news/ct-xpm-1995-02-12-9502120298-story.html>

Shukralla, I. (2020, 10 27). Islamophobia: Why Macron is wrong on the freedom of expression debate.

Solomon, J. (2001, 9 13). *Osama Bin Laden: How the U.S. helped midwife a terrorist*. Retrieved from The Center for Public Integrity : <https://publicintegrity.org/accountability/osama-bin-laden-how-the-u-s-helped-midwife-a-terrorist/>

Turan, R. I. (2021, 8 17). *Why the US-trained Afghan army failed to fend off Taliban*. Retrieved from <https://www.aa.com.tr/en/world/why-the-us-trained-afghan-army-failed-to-fend-off-taliban/2337959#:~:text=Reiterating%20that%20a%20lack%20of,dependent%20on%20this%20air%20support%2C>

П.Хантингтон, С. (1996). *Соёл иргэнийн мөргөлдөөн: Өөрчлөгдөж буй дэлхийн дэг журам*.

**МОНГОЛ УЛС ШАНХАЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГЫН
ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ ЭСЭХ АСУУДЛЫГ ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ АСПЕКТААР ШИНЖЛЭХ НЬ**

Д.Ундрах

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн дэд профессор

Д.Ууганжаргал

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар,
Улс төр судлалын магистрант

Хураангуй: Зүүн хойд Ази болон Төв Азийн бүс нутагт орших Монгол улс Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага (ШХАБ)-д 2004 оноос эхлэн ажиглагчийн статустай яриа хэлцэлд идэвхитэй оролцсоор ирсэн. Тус байгууллага нь аюулгүй байдал, цэргийн хамтын ажиллагаа чиглэлд илүү хөгжих төлөвтэй, улс төрийн яриа хэлцэл давамгайлсан бүсийн нутгийн байгууллага болж төлөвших хандлагатай. Монгол улс ШХАБ-д элссэн тохиолдолд худалдаа, хөрөнгө оруулалт, тарифын хөнгөлөлт, тусгайлсан төсөл хөтөлбөрийн хувьд эдийн засгийн ямар үр өгөөжтэй байх нь тодорхойгүй хэвээр байна. Энэхүү судалгааны ажлын дүнд Монгол улс нь ШХАБ-д элсэхгүйгээр ажиглагчийн статусаа хэвээр хадгалах нь тохиромжтой хэмээн үзсэн болно.

Түлхүүр үг: *Эдийн засгийн хамтын ажиллагаа, Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага, худалдаа, хөрөнгө оруулалт, тарифын хөнгөлөлт;*

Удиртгал

ШХАБ-д Монгол улс ажиглагчийн статустай үйл ажиллагаанд нь оролцож даруй 18 жил өнгөрчээ. Хятад улсын санаачилагаар байгуулагдсан Евроазийн бүс нутаг дахь бүс нутгийн шинжтэй нөлөө бүхий томоохон байгууллага болон төлөвшиж буй тус байгууллагад Монгол улс нэгдэх нь нийгэм, улс төр, геополитик, эдийн засгийн ямар үр өгөөж өгөх талаар судлан тодруулах нь практик ач холбогдолтой юм. Энэхүү судалгаагаар Монгол улс ШХАБ-д элссэнээр бий болох эдийн засгийн хамтын ажиллагааны ашиг тусыг тодруулж, холбогдох үр дүнг тайлбарлах оролдлого хийлээ.

ШХАБ-ын үүсэл хөгжлийн түүхэн тойм

1990 онд дэлхийн социалист систем нуран унаж, түүний тэргүүлэгч улс Зөвлөлт Холбоот улс задарснаар Бүгд Найрамдах Хятад Ард Улс (цаашид Хятад гэх) нь Оросын Холбооны Улс (цаашид ОХУ гэх) болон Төв Азийн шинэ тулгар улсуудтай хилийн итгэлцлийг бэхжүүлэх, цэрэг зэвсгийн тоог хорогдуулах, хүч хэрэглэхгүй байх зэрэг асуудлаар ойлголцож, хамтран ажиллах шаардлага үүссэн.

1996 онд ОХУ-ын ерөнхийлөгч Борис Ельцин Хятадад төрийн айлчлал хийж, Хятад-Оросын харилцан ойлголцлын тунхаглалд гарын үсэг зурсан. Түүний айлчлалын үеэр Хятадын санаачлагаар Казахстан, Киргизстан, Тажикстан улсын төрийн

тэргүүнийг Шанхай хотноо урьж, Орос, Хятадын төрийн тэргүүн оролцон 1996 оны 4 дүгээр сарын

26-ны өдөр Хилийн бүст цэргийн салбарт итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээний тухай хэлэлцээрийг баталжээ. Эдгээр улсууд нь “Шанхайн тав” хэмээн нэрлэгдэх болж, 1997 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Москва хотноо удирдагчид уулзаж, Хилийн бүст зэвсэгт хүчнээ хорогдуулах хэлэлцээрийг зөвшилцсөн байна. Хэлэлцээрээр цэргийн тоо, хилийн ойролцоох зэвсэглэлийг доод түвшинд бууруулж, зөвхөн хориглон хамгаалах түвшинд хүрэхээр тохиролцсон. Мөн хүч үл хэрэглэх, цэргийн давамгайлал тогтоохгүй байх чиглэлээр үүрэг хүлээжээ.

2001 онд “Шанхайн тав+Узбекистан” гэсэн томъёоллоор ШХАБ хэмээх бүс нутгийн нэгдэл бий болжээ.¹ 2005 оноос Терроризм, экстримизм, сепаратизм зэргийг тэргүүлэн хянах асуудал хэмээн үзсэн байна. 2017 оны Астана хотноо зохион байгуулагдсан дээд хэмжээний уулзалтаар ШХАБ-д Пакистан, Энэтхэг хоёр улс элссэнээр албан ёсны гишүүнчлэлтэй улсын тоо 8 болж, Афганистан, Беларусь, Иран, Монгол улсууд ажиглагчийн статустай, Армени, Азербайжан, Камбож, Непал, Шри-Ланка, Турк улсууд яриа хэлэлцээний түншийн түвшиний оролцоотой болов.² Монгол улс 2004 оны Ташкентын уулзалтаар ажиглагчийн статустай болжээ.

Зураг 1.ШХАБ-ын үйл ажиллагааны орнуудын газрын зураг



Онолын үндэслэл

Улс орнуудын хооронд эдийн засгийн интеграцид орох үйл явц идэвхитэй явагдаж байна. Эдийн засгийн нэгдлийг бий болгож буй улс орнууд чөлөөт худалдааг дэмжих, тарифын хөнгөлөлт үзүүлэх, харилцан ашигтай хөрөнгө оруулалт, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зэрэг интеграцичлалын арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнууд олон талт хамтын ажиллагааг өрнүүлэхдээ тодорхой зорилгын дор нэгддэг.

Оролцогч улсуудын хувьд:

- Эдийн засгийн хөгжил харьцангуй ижил түвшинд байх
- Орон зайн хувьд ойр дөт орших
- Шийдвэрлэвэл зохих асуудал нь ижил байх
- Шинэчлэл, инновацийн үйл явц жигд байх нь эдийн засгийн интеграцийн урьдчилсан нөхцөл болдог.

¹ Alyson J. et al, “The Shanghai Cooperation Organization” SIPRI Policy Paper, No. 17(May 2007)., 167-169.

² Баярхүү.Д, ШХАБ & <<Нэг бүс-Нэг зам>> (Улаанбаатар: Удам соёл ХХК, 2018)., 11-13.

Эдийн засгийн интеграцичлалын үндсэн зорилго нь: Тухайн үйл явцад нэгдэн орсон орнуудын үйлдвэрлэх хүчний салбарыг хөгжүүлэх, оролцогч эдийн засгуудын хөгжлийн түвшинг ойртуулах, улмаар нийтэд нь түргэтгэх, үйл ажиллагааг нь олон улсын түвшинд уялдуулан зохицуулах нэгдсэн бодлого, үйл ажиллагаагаар дэмжихэд оршдог.³

Олон улсын харилцаанд оролцогчид аль нэг эдийн засгийн хамтын ажиллагаа, түүнтэй холбогдох интеграцид нэгдэхдээ олонх тохиолдолд өөрийн улсын хүртэх эдийн үр ашиг, өгөөж талаа чухалчилж үздэг онцлогтой. Энэ нь оролцогч орнууд таваар, үйлчилгээ, капитал, ажиллах хүч, чөлөөтэй шилжүүлэх бололцоо олгодог гаалийн холбоо болон эдийн засгийн олон улс дамнасан холбоодыг байгуулахад хүргэдэг. Түүнчлэн улс төрийн засаглалын үндсэн дээр байгуулагддаг улс төрийн холбоод ч чухал үүрэгтэй.⁴

Улс төрийн холбоо нэгдэл нь хамтын ажиллагааны эерэг харилцааг бүрдүүлж улмаар эдийн засгийн харилцан өгөөжтэй хоёр талт болон олон талт харилцааг хөгжүүлэхэд суурь болж өгдөг.

Олон улсын худалдааны бодлого нь хүчин зүйлсийн үр ашигтай хуваарилалт, эдийн засгийн өсөлт, сангийн бодлого, валютын ханшны бодлого улмаар худалдааны тэнцэлтэй холбоотой чухал ойлголт юм. Олон улсын худалдаа чөлөөтэй нэвтрэлцэх онолын үндсийг Английн сонгодог эдийн засагч А.Смит “Туйлын давуу талын онол”-оор тайлбарласан бол, эдийн засгийн онолын дараах томоохон төлөөлөгч Д.Рикардо олон улсын худалдаанаас ашиг олох асуудлыг хөнджээ. Худалдаанд протекционист болон тарифыг хөнгөлөх замаар татварын бодлогын хөшүүргээр олон улсын байгууллагын гишүүн орнуудын худалдааны нэвтрэлтийг нэмэгдүүлж, эсвэл бууруулдаг.⁵ Иймд эдийн засгийн хамтын ажиллагаа өрнүүлэхэд улс хоорондын худалдааны эргэлт, түүний тэнцэл ихээхэн чухал үүрэгтэй.

Эдийн засгийн хамтын ажиллагаатай улс орнуудын харилцааны чухал хэрэгсэл нь шууд хөрөнгө оруулалт юм. Хөрөнгө оруулагчаас тодорхой оронд түүхий эд олборлох, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зэргээр хөрөнгөө байршуулан машин, техник, технологи, мэдлэгийн үйлдвэрлэлийг нийлүүлдэг. “Засгийн газрууд гадаадын хөрөнгө оруулалт татах зорилгоор өөрийн нутгийн тодорхой хэсэгт чөлөөт худалдаа, үйлдвэрлэлийн бүсийг байгуулах, гадаадын хөрөнгө оруулалтыг тодорхой салбар, чиглэлд урамшуулах, зах зээлийг тэлэх үүднээс бүс нутгийн хэмжээнд чөлөөт худалдааны бүс байгуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.”⁶ Улс орнууд эдийн засгийн бүтцийн суурь өөрчлөлтөө олон улсын хамтын ажиллагааны байгуулагаар дамжуулан харилцан ашигтайгаар эдийн засгийг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах, ажлын байрыг нэмэгдүүлэхэд маш чухал хөшүүрэг болгон ашиглаж байна.

Сэдвийн судлагдсан байдал

Судлаач Алисон, Байлес нарын “Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага” бүтээл нь тус байгууллагын үүсэл, хөгжлийн түүх, ОХУ-ын баримтлах бодлого, Хятадын дэвшүүлж буй бодлогууд зэрэг үндсэн гурван бүлгээс бүрджээ. Судлаачид уг бүтээлийн нэгдүгээр бүлэгт ШХАБ байгуулагдсанаас хойш өнөөг хүртэлх үйл явц, гишүүн болон бусад оролцогч улсуудын байр суурийг дэлгэрэнгүй тайлбарлажээ. Хоёрдугаар бүлэгт ОХУ-ын баримтлах бодлогыг түлхүү авч үзэж, аюулгүй байдал, геополитикийн ганцаардлыг хэрхэн даван туулах, холбоотны эрэлд гарсан зэрэг улс

³ Баасанхүү.Г, Оюунсүрэн.Д, Баттогтох.Ж, Энхцэцэг.С, Оюунсүрэн.С, Баясгалан.С, *Олон улсын харилцааны үндэс ба даяаршил*, (Улаанбаатар: МУИС пресс хэвлэлийн газар, 2019), 267.

⁴ Цэдэндагва.Г, *Эдийн засгийн онол*, (Улаанбаатар: Статистик ХХК, 2001), 309.

⁵ Алтанцэцэг.Б, Отгонтөгс.Б, *Макро эдийн засаг*, (Улаанбаатар: МУИС хэвлэх үйлдвэр, 2000), 271-272.

⁶ Санжмятав.Б, *Дэлхийн эдийн засаг*, (Улаанбаатар: МУИС хэвлэх үйлдвэр, 2014), 121-122.

төрийн бодлогын асуудлыг илүү хөндсөн. Эдийн засаг, худалдааны асуудлын хувьд ОХУ-аас Хятад руу түүхий эд экспортлох, хийн хоолой тавих, эрчим хүч нийлүүлэх асуудлуудаас өөр хоёр талын эдийн засгийг хөгжүүлэх томоохон төсөл хөтөлбөр бага байгааг тодотгожээ. Гуравдугаар бүлэгт Хятад улсын зүгээс явуулах бодлогын хүрээнд аюулгүй байдлыг тогтворжуулахын зэрэгцээ эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх сонирхол байгааг дэлгэрэнгүй тайлбарласан байна.⁷

Ричард Ху “Хятад ба Төв Ази дах ШХАБ-ын үүрэг” бүтээлд “Хятад дотоодын тулгамдаж буй аюулгүй байдлын асуудал буюу Шинжааны өсөн нэмэгдэж буй салан тусгаарлах хандлагыг бууруулах, террорист, экстремист бүлэглэлүүдийг Афганистан болон бусад лалын улс орнуудаас үсэрхийлж орж ирэхээс сэргийлэх асуудлыг судалжээ. Харин Төв Азийн улсуудын ШХАБ дах өсөн нэмэгдэж буй оролцоог онцолж, цаашид тулгарах асуудлуудыг” тодруулсан байна.⁸

Е.В.Бойков “ШХАБ-ын гишүүн орнуудын хүмүүнлэгийн хамтын ажиллагааны асуудлууд” өгүүлэлд Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын тэргүүлэх нэг чиглэл нь хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагаа болохыг дурджээ. ШХАБ байгуулагдснаас хойш гишүүн орнууд соёл, боловсрол, байгаль орчин, залуучуудын бодлого, спорт, аялал жуулчлал, хэвлэл мэдээлэл зэрэг салбарт нилээд практик үр дүнтэй хамтын ажиллагааг бий болгож чаджээ. ШХАБ-ын орнууд хүмүүнлэгийн хамтын ажиллагааны зарим салбарт тодорхой амжилт гаргасан байна. “Боловсролын байгууллага хооронд суралцагч болон шинжлэх ухаан, сурган хүмүүжүүлэхийн салбарын ажилтнуудын солилцоо явагдаж, шууд холбоо тогтоож, боловсролын салбарт ШХАБ-ын гишүүн орнуудын хэл, түүх, соёл, уран зохиолыг судлах зэрэг ажлууд хэрэгжиж байна. Олон талт механизм бүрэлдсэний дотор ШХАБ-ын гишүүн-орнуудын боловсролын сайд нарын зөвөлгөөн, түүнчлэн тухайн салбар дахь хамтын ажиллагааг зохицуулах зорилготой байнгын ажиллагаатай ШХАБ-ын гишүүн орнуудын хүмүүнлэгийн хамтын ажиллагааны асуудлаар шинжээчдийн бүлэг байгуулагдсан нь хамтын ажиллагааны хүчин чармайлтыг бэхжүүлж байна.”⁹ зэрэг асуудлыг хөнджээ.

Судлаач Б.Төгсбилгүүн “ШХАБ цэргийн эвсэл мөн үү” эрдэм шинжилгээний өгүүлэлдээ цэргийн эвслийн онолд тулгуурлан ШХАБ-ыг цэргийн эвсэл мөн эсэхийг судласан байна. ШХАБ-ын голлох хоёр орон ОХУ, Хятадын хоорондын үл ойлголцол их, Дундад Азийн орнуудын зөрчил, маргаанаас үүдэлтэйгээр цэргийн эвсэл болж чадахгүй хэмээн дүгнэжээ.

Судлаач Д.Баярхүү “ШХАБ ба “Нэг бүс-нэг зам” нэг сэдэвт бүтээлдээ “ШХАБ-ын үүсэл хөгжил, гишүүн, оролцогч орнуудын байр суурь, ашиг сонирхол, Монгол улсын ажиглагчийн статус, оролцоо, элсэх эсэх асуудал, болгоомжлох тал, Хятадын дэвшүүлж буй төслийн явц, цаашдын ШХАБ-ын хөгжлийн хандлага зэргийг дэлгэрэнгүй тайлбарлажээ. Түүнчлэн ШХАБ нь төлөвшлийнхөө шатанд явж буй бөгөөд гишүүн орнуудад маргаантай асуудал олон байгааг жишээгээр нотолж, хэрэв Монгол улс гишүүнээр элсвэл гуравдагч хөршийн бодлогод хор хөнөөлтэй, эдийн засгийн хамтын ажиллагаа сул зэрэг нь одоогийн ажиглагчийн статусыг хадгалах үндэслэл гэдгийг онцолсон байна. Харин Хятадын дэвшүүлж буй Нэг бүс-нэг зам

⁷ Alyson J. K. Bailes, Pál Dunay, Pan Guang, Mikhail Troitskiy, “The Shanghai Cooperation Organization,” SIPRI Policy Paper, No. 17(May 2007): 185-199.

⁸ Richard Hu, “China and central asia: The role of the shanghai cooperation organization (sco),” The Mongolian Journal of International Affairs, Number 11(2004) 132-136.

⁹ Бойков Е.В. “ШХАБ-ын гишүүн орнуудын хүмүүнлэгийн хамтын ажиллагааны асуудлууд”, Олон Улс Судлал, №1(2018): 18-19, DOI: <https://doi.org/10.5564/jis.v0i1.1119>.

хөтөлбөрт Монгол улс идэвхи, санаачлагатай оролцох нь чухал байгааг цохон тэмдэглэжээ.”¹⁰

Судалгааны ажлын энэ хэсэгт ШХАБ-ын хамтын ажиллагаанд худалдаа, хөрөнгө оруулалт, тарифын хөнгөлөлт, валютын нэгдсэн тогтолцоо, гишүүн болон оролцогч орнуудад зориулсан тусгай эдийн засгийн хөтөлбөр бий эсэх, тэдгээр нь үр өгөөжтэй эсэх, Монгол улс элсэхэд эдийн засгийн эерэг нөлөө буй эсэхийг тодруулах юм.

ШХАБ-ын гишүүн орнуудын засгийн газрын тэргүүн нарын 2003 оны 9 дүгээр сард болсон уулзалтаас “*Гишүүн орнуудын худалдаа, эдийн засгийн олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх хөтөлбөр*”-ийг баталж, бүс нутгийн худалдаа, эдийн засгийн олон талт хамтын ажиллагааны ойрын, дунд (2010 он хүртэл) болон урт (2020 он хүртэл) хугацааны хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэхэд чиглэсэн 100 орчим төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам, шалгуурыг тооцож хэлэлцжээ. “Худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, нефть, байгалийн хийн орд газрыг эзэмших, газрын тос, байгалийн хий тээвэрлэх хоолойг барьж байгуулах, усны эрчим хүчийг ашиглах, химийн аж үйлдвэр, хөдөө аж ахуй үйлдвэрийн цогцолбор, хүнсний үйлдвэрийг хөгжүүлэх, тээвэр, байгаль хамгаалах, хүмүүнлэг, соёлын зэрэг салбарт хамтын ажиллагааг түлхүү хөгжүүлэх чиглэл өгсөн байна. Энэ шалгуурын дагуу даруй хэрэгжих бололцоотой, шууд үр дүнгээ өгөх арга хэмжээг тэргүүн ээлжинд сонгох үүрэгтэй”¹¹ хэмээжээ.

2003 оны уулзалтаар БНХАУ-ын Ерөнхий сайд Вэнь Зябао ШХАБ-д чөлөөт худалдааны бүс байгуулах урт хугацааны зорилт дэвшүүлж, бусад бүс нутаг дахь барааны урсгалыг сайжруулахын тулд яаралтай арга хэмжээ авахаа мэдэгдэж дараах эдийн засгийн хамтын ажиллагааны бүтцийг бий болгохыг цохон тэмдэглэсэн. Үүнд:

- Эдийн засгийн чиглэлээр
- Эрчим хүчний клуб
- Банк санхүүгийн нэгдэл
- Хамтын ажиллагааны форумуудыг хөгжүүлэн ажиллуулах болсон байна.

2005 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн ШХАБ-ын Москвагийн дээд хэмжээний уулзалтын үеэр тус байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга хэлэхдээ “...ШХАБ эрчим хүчний хамтарсан төслүүдэд тэргүүлэх ач холбогдол өгөх болно; тэр дундаа газрын тос, байгалийн хийн салбарт нүүрс, устөрөгчийн шинэ нөөц хайх, усны нөөцийг хамтран ашиглах чиглэлийг зорихоо мэдэгдэж”, ирээдүйн хамтарсан төслийг санхүүжүүлэх зорилгоор ШХАБ-ын банк хоорондын консорциум байгуулах асуудлыг дээд хэмжээний уулзалтаар тохиролцсон. ШХАБ-ын Банк хоорондын холбооны анхны хурал 2006 оны 2 дугаар сард Бээжинд хотноо болж банк санхүүгийн нэгдлийн механизмыг төлөвшүүлэх асуудлыг эдийн засгийн хамтын ажиллагааны чухал чиглэл хэмээн үзжээ.

2006 оны 11 дүгээр сард Алматы хотод болсон “ШХАБ: Үр дүн ба хэтийн төлөв” олон улсын бага хурлын үеэр ОХУ-ын ГХЯ-ны төлөөлөгч “Орос улс ШХАБ-ын “Эрчим хүчний клуб”-ийн төлөвлөгөөг боловсруулж байгаа”-г зарласан. 2007 оны 11 дүгээр сард болсон ШХАБ-ын дээд хэмжээний уулзалтын үеэр Москва дахин “Эрчим хүчний клуб”-ыг тогтворжуулах санаачилгыг илэрхийлсэн. Гэвч ШХАБ-ын бусад гишүүн орнууд энэ санаачлагыг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэггүй байна.

2007 онд болсон ШХАБ-ын дээд хэмжээний уулзалтын үеэр Ираны дэд ерөнхийлөгч Парвиз Давуди “Шанхайн хамтын ажиллагааны байгууллага бол олон

¹⁰ Баярхүү.Д, *ШХАБ & <<Нэг бүс-Нэг зам>>* (Улаанбаатар: Удам соёл ХХК, 2018), 100-130.

¹¹ Санжмятав.Б, *Дэлхийн эдийн засаг*, (Улаанбаатар: МУИС хэвлэх үйлдвэр, 2014), 177.

улсаас хараат бус банкны шинэ системийг бий болгоход тохиромжтой газар” хэмээн мэдэгдсэн нь банк санхүүгийн нэгдлийг дэмжихээ илэрхийлсэн хэрэг болжээ. 2009 оны 6 дугаар сард Екатеринбургийн дээд хэмжээний уулзалтын үеэр Хятад улс дэлхийн санхүүгийн хямралын үед ШХАБ-ын бусад гишүүн орнуудад 10 тэрбум ам.долларын зээл олгохоор төлөвлөж байгаагаа зарласан явдал нь нийгэмлэгийн хүрээнд хөрөнгө оруулалтын боломжийг бий болгох томоохон санаачилга болсон байна.

Хятадын засгийн газраас бусад гишүүн орнуудтай худалдаагаа өргөжүүлэн хөгжүүлэхэд зориулан 1 тэрбум ам.долларын хөрөнгө гаргаж санхүүжүүлсэн. ОХУ-Хятадын хооронд эрчим хүч, байгалийн хий худалдан авах, алт, алмаз олборлох, мод бэлгэн гаргах салбарт хамтын ажиллагаа өрнөж олон тэрбум долларын худалдаа хийгдэж байна.

Зураг 2. Хятадын Нэг бүс-Нэг зам төсөл

China's One Belt, One Road initiative



Эх сурвалж: БНХАУ-ын Гадаад Харилцааны яам

2013 оны 11 дүгээр сард Ташкентад болсон гишүүн орнуудын ерөнхий сайд нарын уулзалтын үеэр Хятадын санаачлагаар Хятадын зүүн хэсэг болон Европыг холбон олон улсын тээврийн хонгилогч буюу авто болон төмөр замыг байгуулснаар Торгоны замын эдийн засгийн бүслүүр (Silk Road Economic Belt)-ийг бий болгох, улс орнуудын хооронд худалдаа, хөрөнгө оруулалтыг өргөтгөх санаачлага дэвшүүлж, амжилттай хэрэгжүүлж байгаар цохон тэмдэглэжээ.”¹²

2019 оны 6 дугаар сард болсон Бишкекийн дээд хэмжээний уулзалтын үеэр Пакистаны Ерөнхий сайд Имран Хан ШХАБ-ын гишүүн орнуудын дунд ам.долларын оронд үндэсний мөнгөн тэмдэгтийн зах зээл байгуулах тухай мэдэгдэл хийсэн зэрэг эдийн засгийн хамтын ажиллагааг өрнүүлэх санал, санаачилга, бодит ажлууд хийгджээ.

ШХАБ-ын өмнө тулгарч буй сорилт ба зөрчил

Шанхайн Хамтын ажиллагааны байгууллага нь цаашид ямар байдлаар хэлбэршин тогтнох нь эргэлзээтэй хэвээр байна. Аюулгүй байдлын байгууллага уу? Эдийн засаг, соёл хүмүүнлэгийн оролцоо нэмэгдэх үү? Хэн нэгэн цөөн улсын явцуу эрх ашгийг гүйцэлдүүлэгч болох уу? Эсвэл Ази-Номхон далайн яриа хэлцлийн

¹² Мөн тэнд.

томоохон механизм болох уу? зэрэг олон асуултыг эрэлхийлэх шаардлага үүсч байна. Гишүүн болон оролцогч улсуудын ашиг сонирхол хол зөрүүтэй байгаа нь ШХАБ-ын гол асуудал болоод байгаа тухай судлаачид тэмдэглэх болов.¹³ Асуудлыг тодруулвал,

ОХУ-Зөвлөлт Холбоот улс задарсаны дараа НАТО болон барууны орнуудад стратегийн хувьд ялагдан, орон зай нь хумигдсан. 2014 оны Крымийн хэрэг явдлаас хойш АНУ, Европын холбооны хүчтэй хориг санкцад орж геополитикийн ганцаардалд орсноор үргэлжийн холбоотны эрэлд гарах болсон. Ази, Ойрхи дорнодын хүн ам олонтой томоохон улсуудыг ШХАБ-д элсүүлэх сонирхолтой бол Хятад эсрэгээрээ Монголоос бусад улсыг элсүүлэхийг сайшаахгүй байна. Төв Азийн улсуудад ОХУ хяналтаа алдсаар байхад Хятад улс эдийн засгийн нөлөөллөө тус бүсэд бэхжүүлж байна. Мөн Хойд манжуур, Казахстаны зүүн хэсгээрх Алтайн нуруу, Өвөр Байгаль зэрэг газар нутгийг 300 жилийн өмнөх манай түүхэн нутаг хэмээн Хятадын олон нийтийн сүлжээнд үе үе хэлэлцдэг нь ОХУ-ын судлаачдын эгдүүг хүргэдэг. Нэг үгээр хэлбэл энэ хоёр улс сайн итгэлцэж өгөхгүй байна.

Хятад-ШХАБ-ыг илүү эдийн засгийн чиглэлээр хөгжүүлэх сонирхолтой. Гэхдээ өөрийн шинэ зах зээл, түүхий эдийн хавсрага маягаар хандаж буй нь үнэн юм. Эдийн засгийн хамтын ажиллагаа гэсэн атал “Нэг бүс-Нэг зам” төсөлд ОХУ-ыг “их гүрэн” гээд төмөр зам барьж өгөхгүй хэмээн ялгасан. Хятадаас өөр улс хөрөнгө оруулалт хийхгүй байгаа нь эдийн засгийн холбоо болоход хол байгааг илтгэнэ. ШХАБ-д элсэхээр хүсэлтээ өгсөн Иран, Афганистанаас исламын терроризмын аюул байсаар байгаа нь Хятадын Шинжаан-Уйгарын асуудалд таагүй нөлөөтэй.

Энэтхэг-Төв Ази дах Хятадын нөлөөг багасгах зорилготой ОХУ нь Энэтхэгийг ШХАБ-д элсүүлсэн бол Хятад зөрүүлээд өөрийн холбоотон Пакистаныг элсүүлсэн. Магадгүй ШХАБ-ын үйл ажиллагааг хянахад АНУ-ын тавиул улс ч гэж Энэтхэгийг хардаж байна.

Лалын улсуудын ирээдүйн давамгайлал-Афганистан, Иранаас гадна Ирак, Турк цаашлаад Саудын Араб ШХАБ-д элсэх сонирхолтойгоо илэрхийлдэг. Хэрэв ирээдүйд энэ бүх улсууд элсчихвэл хүн амын хувьд исламын улсууд олонх болох тооцоо байна. Хэрэв тийм зүйл тохиовол исламын шашинт улсуудын эцэс төгсгөлгүй хэрүүлийн талбар болж хувирах юм. Түүнчлэн Казахстаны АНУ-тай харилцах сонирхолтой ганцаарчилсан тоглолт, Афганистан, Иран, Азербайжаны явцуу ашиг сонирхлууд гэх зэрэг асуудал олон бий. Үүнээс үзэхэд ШХАБ-ын гишүүн орнуудад улс төрийн нэгдлийн хувьд хол зөрүүтэй байр суурь бүхий ашиг сонирхол оршиж байгаа нь олон улсын байгууллага болж төлөвших асуудалд нь эргэлзээ төрүүлж байна.

2022 оны 1 дүгээр сард Казахстан улсад нефть, хийн түлшний үнийн өсөлтөөс үүдэлтэй бослого, үймээний үеэр тус улсын эрх баригчид ШХАБ-ын хүчирхэг орнуудын тусламжаас илүүтэйгээр Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага (ХАБГБ)-аас цэргийн тусламж хүсэмжилж, улмаар цэрэг оруулан дотоодын хурцадмал байдлыг намжаасан явдал нь ШХАБ-ын хамтын аюулгүй байдлын механизмд эргэлзэх эргэлзээг төрүүлж мэдэхээр байна.

Монголын ШХАБ-д элсэх эсэх тухай асуудал

2004 оноос хойш Монгол улс ШХАБ-д ажиглагчийн статустай байгаа нь ШХАБ -ыг олон ашиг сонирхлын цуглуулга хэвээр байгаагаас шалгаалж байх талтай. Түүнчлэн Монгол улс тус байгууллагад элссэн тохиолдолд гурав дах хөршийн бодлогод чамгүй хор уршигтай зүйл болно. Монгол нь НАТО-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцогч, мөн АНУ-ын Мянганы сорилтын корпорациас олон зуун сая долларын зээл,

¹³ Баярхүү.Д, *ШХАБ & <<Нэг бүс-Нэг зам>>* (Улаанбаатар: Удам соёл ХХК, 2018), 60-110.


тусламж авдаг болон нийгмийн бүхий л салбарт АНУ, Европын холбооны улсуудтай өргөн харилцаатай бөгөөд энэ бүхэн зогсоход хүрнэ гэсэн үг. ОХУ-Хятад хоёр хийн хоолойн төсөл хэрэгжүүлж, Монголыг тойруулаад барьж дуусч буй энэ нөхцөлд ажиглагчаар байхыг хөрш орнууд ойлгоно. Түүнчлэн Монгол улсын Ерөнхийлөгч 2018 оны уулзалтын үеэр ШХАБ-д элсэх асуудлыг судалж байгаа хэмээн илэрхийлсэн нь дотоодын зарим дидломатууд, улс төрчдийн элсэх шаардлагагүй хэмээсэн байр суурийн баталгаа юм.

ШХАБ-ын Монгол улстай өрнүүлж буй эдийн засгийн хамтын ажиллагааны орчин

ШХАБ нь эдийн засгийн хамтын ажиллагааны механизм бүрдүүлэх оролдлогыг хийж байгаа ч тодорхой хөтөлбөрүүдийг тууштай хэрэгжүүлэх, гишүүн улсууд төсөл хөтөлбөрт хөрөнгө оруулалт хийх тал дээр оролцоо хангалтгүй байна. Хятадын “Нэг бүс-Нэг зам” төслийн амбиц, дэд бүтцийн томоохон төсөл хөтөлбөрүүд нь ШХАБ-ын бүтцээс гадуур хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд өрнөж байна.

Монгол улсын хувьд гишүүнээр элсэхэд эдийн засгийн ямар үр өгөөж хүртэх, ямар төсөл хөтөлбөр ШХАБ-ын хүрээнд хамтран хэрэгжүүлэх асуудал тодорхой бус, хийж буй гадаад арга хэмжээ хоёр хөршийг эс тооцвол сүүлийн жилүүдэд төдийлөн өсөхгүй байна. Тус байгууллагын гишүүн орнуудтай хийж буй худалдаа, хөрөнгө оруулалтыг төлөвийг шинжлэхэд ОХУ, БНХАУ-тай хийсэн хоёр талт эдийн засгийн харилцаа л давамгайлж байна.


Зураг 3. Монгол улсын ШХАБ-ын гишүүн улс оронтой хийж буй экспорт, (мянган ам доллар)



Эх сурвалж: Статистикийн Ерөнхий хороо

2020 оны байдлаар Монгол улсын экспортын бүтцийг улсаар нь ангилан харахад ШХАБ-ын гишүүн орнуудтай хийж буй экспортын хэмжээ өндөр боловч БНХАУ-тай хийж буй хоёр талын харилцаанд суурилсан экспорт (Ковид-19 вирусийн тархалттай холбоотой хилийн дэглэмээс шалтгаалан БНХАУ-аас бусад улс руу хийгдсэн экспортын хэмжээ буурсан) 97 орчим хувийг (ОХУ 3 орчим хувь) бүрдүүлж байна. Казахстан, Киргизстан, Пакистан, Тажикстан, Узбекистан, Энэтхэг зэрэг ШХАБ-ын бусад гишүүн орнууд Монгол улстай хийх экспортын идэвх байхгүй байна.

Зураг 4. Монгол улс ШХАБ-ын гишүүн орнуудтай хийсэн импорт. (мянган ам доллар)




Эх сурвалж: Статистикийн Ерөнхий хороо

2020 оны байдлаар Монгол улсын импортын бүтцэд ОХУ, БНХАУ, Казахстанас бусад ШХАБ-ын гишүүн орнуудаас импортын бараа эргэлт хийгдээгүй байна. Эндээс төв болон өмнөд Азийн ШХАБ-ын гишүүн орнуудаас Монгол улстай хийх гадаад худалдааны идэвхи харьцангуй сул байгаа нь харагдана.

Монгол улс руу чиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хувьд ШХАБ-ын гишүүн орнууд 4/1 хувийг бүрдүүлж байна. Энэ нь ОХУ, БНХАУ-тай хийж буй хоёр талт эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд л хийгдэж буй хөрөнгө оруулалт гэдгийг онцлох нь зүйтэй.

Зураг 5. Гадаадын шууд хөрөнгө оруулалт улсаар (сая ам доллар)



Эх сурвалж: Статистикийн Ерөнхий хороо

ШХАБ-аас гаалийн тарифын хөнгөлөлт, валютын нэгдсэн тогтолцоо, гишүүн болон оролцогч орнуудад зориулсан тусгай эдийн засгийн хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг асуудлууд тодорхой бус байгаа нь Монгол улс тус чиглэлд ямар эдийн засгийн үр өгөөж хүртэхийг тооцоолоход хүндрэл учруулж байна. Тус байгууллагад чөлөөт худалдаа тэгш байдлаар хөгжөөгүй Хятадын бараа бүтээгдэхүүний зах зээл байдалтай байна. Эдийн засгийн хамтын ажиллагааг 2003 оноос хойш өрнүүлж эхэлсэн боловч зөвхөн Хятад улс 1-1.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн нь үнэндээ хангалтгүй юм. Хятадын хөрөнгө оруулалтад дургүйцсэн хандлага ч гишүүн болон ажиглагч улсуудын дунд нэмэгдэх болсон. Гаалийн тарифын хөнгөлтийн тогтолцоо төлөвшөөгүй, тухайлсан төсөл хөтөлбөрүүдээс хөрөнгө оруулалт авах боломж хомс байгаа нь ШХАБ-ыг эдийн засгийн үр өгөөжийн хувьд одоогоор Монгол улсад төдийлөн ашиг өгөхөөргүй болохыг илтгэж байна.

Дүгнэлт:

ШХАБ нь одоогоор төлөвшлийн шатанд хөгжиж буй бөгөөд гишүүн орнуудын байр суурь ихээхэн зөрчилдөөнтэй байна. Судалгаанаас үзэхэд ШХАБ нь цэргийн эвсэл, эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын аль нь ч биш, яриа хэлэлцлийн томоохон талбар болон хөгжиж буй байгууллага болох нь харагдаж байна.

Тус байгууллагад Монгол улс элсэхэд эдийн засгийн ямар үр өгөөж хүртэхийг худалдаа, хөрөнгө оруулалт, тарифийн хөнгөлөлт, тухайлсан төсөл хөтөлбөрүүд зэрэг эдийн засгийн хамтын ажиллагааны үүднээс дүгнэж үзэхэд төдийлөн үр өгөөж ажиглагдахгүй байна. Иймд гадаад бодлогын хувьд эрсдэлтэй, эдийн засгийн хувьд өгөөж нь тодорхойгүй байгаа ШХАБ-д элсэхгүйгээр ажиглагчийн статусаа хэвээр хадгалах замаар тус байгууллагын үйл ажиллагаанд оролцох нь зохимжтой хэмээн үзэж байна.

Ашигласан эх сурвалж

1. Bailes.Alyson J. K, Pál Dunay, Pan Guang, Mikhail Troitskiy. “The Shanghai Cooperation Organization.” SIPRI Policy Paper, No. 17(May 2007)., 1-66.
2. Hu. Richard. “China and central asia: The role of the shanghai cooperation organization (sco).” The Mongolian Journal of International Affairs, Number 11(2004)., 129-151.
3. Ts.Tugsbolguun. “Does the Shanghai Cooperation Represent an Example of a Military Alliance?.” The Mongolian Journal of International Affairs, (2009)., 54-102.
4. Б,Алтанцэцэг, Б.Отгонтөгс. *Макро эдийн засаг*. Улаанбаатар: МУИС хэвлэх үйлдвэр., 2000.
5. Г.Баасанхүү, Д.Оюунсүрэн, Ж.Баттогтох, С.Энхцэцэг, С.Оюунсүрэн, С.Баясгалан. *Олон улсын харилцааны үндэс ба даяаришил*. Улаанбаатар: МУИС пресс хэвлэлийн газар., 2019.
6. Д.Баярхүү, *ШХАБ & <<Нэг бүс-Нэг зам>>*. Улаанбаатар: Удам соёл ХХК., 2018.
7. Е.В.Бойков. “ШХАБ-ын гишүүн орнуудын хүмүүнлэгийн хамтын ажиллагааны асуудлууд.” Олон Улс Судлал, №1(2018). 13-26., DOI: <https://doi.org/10.5564/jis.v0i1.1119>.
8. Г.Цэдэндагва, *Эдийн засгийн онол*. Улаанбаатар: Статистик ХХК., 2001.
9. О.Билэгбат, *Төв Азийн аюулгүй байдал ба Монгол улс*. Улаанбаатар: МУИС-ОУХС-Олон улсын харилцааны тэнхим., 2003
10. Э.Энхсоёмбо, *Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын хүрээн дэх БНХАУ-ын ашиг сонирхол*. Улаанбаатар: МУИС-ОУХС-Олон улсын харилцааны тэнхим., 2009
11. Х.Нурсауле, *Казахстаны гадаад бодлого ба ШХАБ дахь оролцоо*. Улаанбаатар: МУИС-ОУХС-Олон улсын харилцааны тэнхим., 2011
12. Б.Санжмятав, *Дэлхийн эдийн засаг*. Улаанбаатар: МУИС хэвлэх үйлдвэр., 2014.
13. В.Ариунчимэг, *Монгол , ШХАБ-ын хамтын ажиллагааны хэтийн төлөв*. Улаанбаатар: МУИС-ОУХС-Олон улсын харилцааны тэнхим., 2016
14. *Globalization and modern Eurasia: History, trends, challenges for change*. Улаанбаатар: Слав-Еврази судлалын зүүн азийн IX бага хурал. Удам соёл., 2018
15. *ШХАБ-20 жил бүрэн зураглал*. Улаанбаатар: Урангар пресс.,, 2021.

ЯПОНЫ ӨСӨЛТИЙГ ДЭМЖСЭН “ЯПОН МАЯГИЙН МЕНЕЖМЕНТ” МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ МЭДЛЭГ¹

КАТАНОДА Томоки
МУИС, ОУХНУС

Олон улсын харилцааны тэнхимийн докторант

Хураангуй: Монгол Улс “Япон лугаа адил хөгжье” гэсэн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Японы эдийн засгийн хөгжлийг дэмжсэн “Япон маягийн менежмент”-ийн гурван тулгуурыг тайлбарлах болно. Мөн Монголын өнөөгийн нөхцөл байдалд харилцан үзгээд, Монголын эдийн засгийг хөгжүүлэхийн тулд дагах ёстой талуудын дүн шинжилгээ хийнэ.

Түлхүүр үг: Keiretsu, Япон лугаа адил хөгжье, Насан туршийн хөдөлмөр эрхлэлт, Ахмадын албан тушаал ахих тогтолцоо, ХК, МЕТІ

1. Судалгааны зорилго, танилцуулга

2021 онд УИХ-ын дарга Г. Занданшатар “Япон лугаа адил хөгжье²” гэсэн зорилтын дагуу Монгол улс нь Японы эдийн засгийн хөгжлийн туршлагаас улам бүр судлаж, суралцаж байна. Японы хөгжлийг загварчлан, амжилтад хүрсэн улсын нэг жишээ бол Малайзын холбооны улс юм. Тус улс 1981 онд “Дорныг харах бодлого” буюу “Look East policy” -ыг гаргаж, Японы амжилт, хөгжлийн нууцаас суралцахыг зорьж байсан. Үүнд Япончуудын хөдөлмөрийн ёс зүй, суралцах ажиллах урам зориг, ёс суртахуун, удирдах чадвар зэрэгт суралцаж, Малайзын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, аж үйлдвэрийн баазыг бий болгоход хувь нэмрээ оруулах бодлогыг баримталж байгаа юм³. Тодруулбал, Малайзаас олон оюутан, мэргэжилтнүүдийг Япон руу явуулан суралцуулж, сурсан мэдлэгээ ашиглан төрөл бүрийн шинэчлэлүүдийг хийсэн⁴. Үүний үр дүнд 1986 онд Хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль батлагдаж, гадаадын хөрөнгө оруулалтыг эрчимтэй нэвтрүүлснээр иргэдийн ажилгүйдлийн түвшин буурч, орлого нэмэгдсэн⁵. Энэ үед Япон улс нь 1954-1973 он хүртэл үргэлжилсэн эдийн засгийн өндөр өсөлт буюу “Japanese economic miracle” -ийн дараах үедээ байсан бөгөөд Малайз нь Япон улсын энэхүү амжилтыг харан суралцсан байна.

Энэхүү нийтлэлд Америкийн бизнес судлаач Жеймс Абэгглен (James Christian Abegglen, 1926-2007) -ий “*The Japanese Factory*” буюу “Японы менежмент” (1958) номонд эдгээр япон хүмүүсийн хөдөлмөрийн ёс зүй, суралцах ажиллах хүсэл эрмэлзэл, ёс суртахуун, удирдах чадвар гэх мэтийг товч өгүүлсэн бөгөөд энэ нь өнөөг хүртэл үргэлжилсээр байна. Энэхүү өгүүлэлд дээрх зүйлд тулгуурлан “Япон маягийн менежмент”-ийг өнөөгийн Монголын эдийн засагт хэрхэн хэрэгжүүлэх боломжтой талаар авч үзэх болно.

¹ Энэхүү баримт бичгийн үзэл бодол нь хувийн үзэл бодол бөгөөд Японы Засгийн газар, ЭСЯ-ны албан ёсны үзэл бодол бус.

² <https://ikon.mn/n/255x>

³ Yamamoto(2013)44

⁴ <https://www.my.emb-japan.go.jp/Japanese/JIS/LEP/LEP.htm>

⁵ Oda(1997)271

2. Япон маягийн менежмент

Японы менежментийн арга нь онцлог шинж чанартай бөгөөд энэ шинж чанар нь Японы эдийн засгийн гол тулгуур болж өгдөг. Гэвч япон хүмүүс өөрсдөө үүнийгээ анзаардаггүй ба АНУ-ын бизнес судлаач, Японы София их сургуулийн профессор Жеймс Абэгтлен үүнийг олж мэдсэн байна. Энэхүү Япон маягийн менежмент дээр тулгуурласан Японы эдийн засгийн онцлогийг АНУ-ын олон эрдэмтэдийн зүгээс онцолж байсан бөгөөд 1985 оны Плаза Аккордын дараа иенийн ханш өссөн үед ч АНУ-тай хийх худалдаанд өөрчлөлт ороогүй юм⁶.

Япон маягийн менежментэд гурван онцлог шинж чанар байдаг гэж Абегтлен онцлон тэмдэглэсэн байдаг: (1) Насан туршийн хөдөлмөр эрхлэлт, (2) Ахмадын албан тушаал ахих тогтолцоо, (3) Компанид зориулсан үйлдвэрчний эвлэлийн холбоо. Эдгээрийг "гурван төрлийн ариун эрдэнэ"⁷ гэж нэрлэсэн⁸ ба хожим олон эрдэмтэд Япон маягийн менежментийг судлаж, янз бүрийн онолууд гаргаж ирсэн байдаг. Гэсэн хэдий ч Япон улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тайланд эдгээр олон онолыг (1) компаниудын дотоод зохион байгуулалт, (2) компанийн засаглалын тогтолцоо, (3) компаниудын хооронд урт хугацааны бизнесийн харилцаа тогтоох гэсэн гурван үндсэн шинж чанар болгон дурджээ⁹. Энд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тодорхойлолтын дагуу япон маягийн менежментийн онцлогийг тайлбарлах болно.

2.1. Компаниудын дотоод зохион байгуулалт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тайланд япон маягийн менежментийн эхний онцлог шинж чанар бол насан туршийн хөдөлмөр эрхлэлт болон ахмадын цалингийн тогтолцооны гол төлөөлөл болох компаниудын дотоод зохион байгуулалт хэмээн дурджээ. Энэ нь урт хугацааны ажлын байрыг баталгаажуулж, ажлын хүчийг гаднаас авахыг хязгаарлаж, нас, ажилласан жил, амжилтад тулгуурлан албан тушаал ахих тогтолцоогоор дамжуулан дотоод ажилчдад компанийн онцлог, мэдлэг, ур чадвар хуримтлуулах хөшүүрэг болгож, байгууллагын доторх хамтын ажиллагааг нэмэгдүүлэх үр дүнтэй юм. Түүнчлэн ийм дотоод зохион байгуулалтын хүрээнд байгууллагын доторх янз бүрийн хэлтэс, шатлалуудын дунд мэдээлэл солилцож, байгууллагын шатлалд найдахгүйгээр хэвтээ байдлаар шийдвэр гаргах зохицуулалтыг хийдэг. Энэ нь доороос дээш шийдвэр гаргадаг гэгддэг Японы компаниудын онцлогтой хамаатай бөгөөд газар дээр нь ажиллаж байгаа ажилтнууддаа шийдвэр гаргах өргөн эрх мэдлийг өгснөөр нөхцөл байдлаас шалтгаалан уян хатан хариу үйлдэл үзүүлэх боломжтой болдог байна¹⁰.

Эдгээрийг дэмжих механизм нь (1) ажилд авах, (2) боловсрол / сургалт, (3) албан тушаал ахих / цалин хөлс, (4) шаардлагагүй хөдөлмөрийг арилгах явдал гэдгийг Катсубэ онцолж байна. Юуны өмнө, элсэлт гэдэг нь 3-р сард ЕБС, их сургуулиа дөнгөж төгссөн, 4-р сард нэг дор ажилд орсон шинэ төгсөгчдийг ажилд авах тогтолцоо юм. Үүнээс үүдэн шинэ төгсөгчдөд ажилд орох боломж нь ганцхан байдаг ба дараа нь ажлын байраа солих тохиолдолд хүлээлгийн орон тоонд ордог байна. Энэхүү тогтолцооны гол суурь нь насан туршийн хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоо бөгөөд компани болон ажилчид хоорондын харилцаа нь Европ, АНУ-ынх шиг гэрээн дээр бус харин тухайн байгууллагын харьяалал дээр тогтдог. Түүнчлэн сургалт дадлагын тухайд

⁶ Konomi(1998)52

⁷ Энэ нь эзэн хаан сэнтийд залрах үед өмнөх эзэн хаанаас өвлөгдөх ёстой "толь, магатама (Чулуун баримал), сэлэм" бөгөөд Японд гурван чухал зүйлийг "гурван төрлийн ариун эрдэнэ" гэж дүрсэлсэн байдаг.

⁸ Katsube(2019)24

⁹ <https://www5.cao.go.jp/j-j/wp/wp-je06/06-00202.html>

¹⁰ <https://www5.cao.go.jp/j-j/wp/wp-je06/06-00202.html>

бол зөвхөн тухайн компанид удаан хугацаагаар ажиллах ажилчдад зориулж ОJT болон сургалтын бааз дахь групп сургалтыг хэрэгжүүлэн, ажилтнаа бэлддэг байна. Ингэснээр ажилчид дээд албан тушаалын зааварлагч ажилтан болон групп сургалтад хамрагдсан хамт олонтойгоо харилцаа холбоогоо гүнзгийрүүлж, компанидаа үнэнч байх нь нэмэгдэнэ. Албан тушаал ахих, цалин хөлсний хувьд эдгээр үйл явцыг туулан, компанидаа үнэнч байж, бүрэн эрхт болсон ажилчид эхэндээ бага цалинтай, тушаал дэвших нь ч удаан байдаг. Үүний үр дүнд ажилчид нэг компанид удаан ажиллахын давуу тал болон ажлаа эрт солихын сөрөг талыг ойлгодог байна. Гэсэн хэдий ч шаардлагагүй хөдөлмөрийг арилгах тогтолцоо байдаг тул ажилчид насан туршийн ажил эсвэл ахмадын цалингийн тогтолцооноос болж ажилдаа залхуурах нь бага болох юм. Энэ нь үндсэндээ Японы компаниуд орон тооны бус ажилчдынхаа тоог цөөлөх замаар эдийн засгийн давалгаатай уялдуулан ажиллах хүчээ тохируулдаг ч хугацаанд нь хийж чадахгүй байгаа эсвэл шаардлагагүй ажиллах хүч гэж үзвэл энэхүү тогтолцоог хэрэгжүүлдэг. Үүнд (1) өөр албан тушаалд шилжүүлэх, (2) охин компани руу түр хугацаанд томилох, (3) охин компани руу шилжүүлэх, (4) сайн дураараа тэтгэвэрт гарах, (5) тэтгэвэрт гаргах, (6) ажлаас халах хэмээх дараалал бүхий тогтолцоо юм.¹¹

Дээр дурдсанчлан Япон маягийн менежментийн нэг онцлог болсон компани доторх байгууллага нь насан туршийн хөдөлмөр эрхлэлт дээр тулгуурласан дотоод сургалтын систем, мөн компанидаа үнэнч байх, шаардлагагүй хөдөлмөрийг арилгах тогтолцоо байдгийг мэдэж авлаа.

2.2. Компанийн засаглалын тогтолцоо

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тайланд дурдсанаар Япон маягийн менежментийн хоёр дахь онцлог шинж чанар бол компани дотроос дэвшсэн менежер болон банкинд төвлөрсөн компанийн засаглалын тогтолцоо буюу компанийн үр ашигтай үйл ажиллагааг хангах хяналт болон сахилга батын тогтолцоо юм. Японд компанийн гол оролцогчдыг ажилчид гэж үздэгийг онцолсон. Ийм учраас Японы компаниудын ТУЗ-ын гишүүдийн дийлэнхи хувь нь ажилчид дотроосоо томилогддог заншилтай. Түүнчлэн Японд компани хоорондоо хувь нийлүүлэх тохиолдол байдаг ба гол харилцагч банк нь томоохон зээлдүүлэгч төдийгүй өөрөө хувьцаа эзэмшигч байдаг тул давхар хяналтын үүргийг ч гүйцэтгэдэг байна. Дотоод ажилчдаас бүрдсэн ТУЗ нь бизнесийн гүйцэтгэл, хяналтыг салгаж, улмаар ажилчдад ашигтай, харин хувьцаа эзэмшигчдэд ашиггүй хөрөнгө оруулалтын төслүүдийг сонгох боломжийг бий болгодог. Гэхдээ өрийн дарамт болон гол харилцагч банкны нөлөө нь эдгээр ёс суртахууны аюулыг хязгаарлаж байдаг.¹²

Компани дотроос дэвшсэн ТУЗ-ын гишүүд олон байгаа нь 2.1-д заасантай ч холбоотой. Японы компаниудын дийлэнхи нь удирдлагын ажилтнуудаас эхлээд жирийн ажилтан хүртлээ ихэнхи ажилчид нь төгсөөл шууд ажилд орсон ажилчид байдаг. Эдгээр ажилчид нь компанидаа үнэнч байхын зэрэгцээ тус компанийг Японы уламжлалт “гэр”-тэй адилтган, өөрийн мэт дээдэлдэг байна.¹³ Түүнчлэн Дэлхийн 2-р дайны дараа Холбоот хүчин конгломератыг татан буулгасны улмаас ажилчид компаний хувьцааг давуу эрхтэйгээр худалдан авч энэ нь улмаар үйл ажиллагаа, эзэмшил, компанийн засаглалыг нэгтгэсэн юм.¹⁴

¹¹ Katsube(2019)25-26

¹² <https://www5.cao.go.jp/j-j/wp/wp-je06/06-00202.html>

¹³ Katsube(2019)24-27

¹⁴ <https://www5.cao.go.jp/j-j/wp/wp-je06/06-00202.html>

2.3. Компани хоорондын урт хугацааны бизнесийн харилцаа

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тайланд “系列” Keiretsu буюу корпорацийн групп зэрэг компаниудын хооронд урт хугацааны бизнесийн харилцаа тогтоох нь Япон маягийн менежментийн гурав дахь онцлог шинж чанар гэж дурдсан байдаг. Томоохон аж ахуйн нэгжүүд охин болон хараат компаниудынхаа засаглалд томоохон үүрэг гүйцэтгэдэг, Японы эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон эд анги үйлдвэрлэгчдийн хамтын ажиллагааны харилцаа нь Японы компаниудын өрсөлдөх чадварыг дээшлүүлж байгаа хэмээн үнэлэх нь ч байдаг¹⁵.

Бодит байдал дээр томоохон компаниуд харилцан ашигтай ашиг сонирхлын үүднээс холбогддог бол, Keiretsu компаниуд нь эцэг эх, хүүхдийн харилцаа шиг урт хугацааны тогтвортой харилцааг эрэлхийлдэг. Түүнчлэн банкууд Keiretsu компаниудад зээлийг идэвхтэй олгож, гол харилцагч банк гэгдэх хамаарал бүхий компаниудын “манаач” болсон. Нэмж дурдахад, Японы бүх санхүүгийн байгууллагууд ижил үүрэг гүйцэтгэхийн тулд Сангийн яам, МЕТІ буюу Олон улсын худалдаа, аж үйлдвэрийн яам зэрэг зохицуулалтын байгууллагууд захиргааны удирдамж гэх Японд зориулсан тусгай зохицуулалтыг хэрэгжүүлсэн¹⁶.

Доорх хүснэгтээс харахад Японы томоохон компаниудад хараат олон компани, үндсэн ажилчид байсаар байгааг харж болно.

Олон хамаарал бүхий 11 компани(2018 оны байдлаар)¹⁷

№	Компанийн нэр	Нэгдсэн охин компаниудын тоо	Байнгын ажилчдын тоо	Борлуулалт (100 сая иен)
1	Sony Corporation	1292	128,400	76,033
2	Nomura Holdings, Inc.	1285	28,186	17,155
3	Nippon Telegraph and Telephone Corporation (NTT)	944	274,844	113,910
4	Hitachi, Ltd.	864	303,887	91,623
5	ORIX Corporation	850	34,835	26,787
6	Dentsu Inc.	844	55,843	8,384
7	Mitsubishi Corporation	834	77,164	64,258
8	SoftBank Group Corp.	763	68,402	89,010
9	Toyota Tsusho Corporation	731	57,988	57,974
10	Sumitomo Corporation	664	70,900	39,970
11	Toyota Motor Corporation	597	364,445	275,972

¹⁵ <https://www5.cao.go.jp/j-j/wp/wp-je06/06-00202.html>

¹⁶ Katsube(2019)27

¹⁷ <https://toyokeizai.net/articles/-/204910?page=2>

Дээр дурдсанчлан keiretsu компаниудын охин компаниуд эх компанитай тогтоосон харилцааг ашиглаж тогтвортой худалдаа болон банкнаас санхүүжилт авдаг ч эх компаниас шилжин ирсэн ажилчдаа хүлээн авах үүргийг даалгасан байна. Мөн гол харилцагч банк нь keiretsu компанид зээл олгох зэрэгцээ тухайн банкнаас ТУЗ-ийн гйшүүнийг гаргаж удирдлагын хариуцлагын үүрэг гүйцэтгэдэг. Сангийн яам, Олон улсын худалдаа, аж үйлдвэрийн яам олон тооны ажилтан бөхий бөгөөд Японы эдийн засгийг дэмжин ажилладаг эдгээр компаниудыг дэмжихийн тулд банкууд тогтвортой санхүүжилтээр хангахыг албадан бус хэлбэрээр уриалж байна.

3. Монгол улсын эдийн засагт хэрэглэх

Монгол Улс Япон шиг хөгжихийн тулд юуны өмнө Монголын менежмент ямархуу түүхтэй, ямар төвшинтэй вэ, ямар цэгүүдийг сайжруулах шаардлагатай вэ гэдгийг ойлгох хэрэгтэй. Энд "Япон маягийн менежмент"-ийн дээр дурдсан гурван шинж чанарын дагуу Монгол улсын менежментийг шинжлэн судаллаа.

3.1. Компаниудын дотоод зохион байгуулалт

Монголд социализмын үеийн бодлогыг өвлөн авсан хөдөлмөрийн хууль үйлчилж байгаа бөгөөд хэд хэдэн удаа шинэчлэгдсэн ч ажилчдын хамгаалал Японтой харьцуулахад илүү хүчтэй байдаг.

Тухайлбал, Японд Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дүрэмд ажлаас халахдаа (1) боловсон хүчнийг цомхотгох зайлшгүй шаардлага, (2) ажлаас халахаас зайлсхийх, (3) боловсон хүчнийг оновчтой сонгох, (4) ажлаас халахад шударга ёстой байдал гэдэг дөрвөн шаардлагыг тавьдаг¹⁸. Нөгөөтэйгүүр, 2021 онд шинэчлэгдсэн, 2022 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхлэх Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлд ажил олгогчийн тэргүүлсэн хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгох нөхцөлийг дараах байдлаар нарийвчлан заасан байдаг.

80 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ажил олгогчийн санаачилгаар цуцлах
80.1. Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дараах үндэслэлээр ажил олгогчийн санаачилгаар цуцалж болно:

80.1.1. аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, нэгж татан буугдсан, ажлын байр хасагдсан, орон тоо цөөрсөн;

80.1.2. ажилтан мэргэжил, мэргэшлийн түвшин, ур чадвар, ажлын гүйцэтгэлийн хувьд гүйцэтгэж байгаа ажил үүрэгтээ тэнцэхгүй болох нь тогтоогдсон. Энэ тухай ажилтанд өмнө нь анхааруулж, мэргэжил, мэргэшлийн түвшин, ур чадвар, ажлын гүйцэтгэлээ сайжруулах боломжит хугацаа олгосон байвал зохино;

80.1.4. ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан /хоёр ба түүнээс дээш/ гаргасан, эсхүл хөдөлмөр эрхлэлтийн харилцааг шууд цуцлахаар хөдөлмөрийн гэрээнд тусгайлан заасан ноцтой зөрчил гаргасан;


80.2. Аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, нэгж татан буугдсанаас бусад тохиолдолд ажлын байр нь хэвээр хадгалагдаж байгаа ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр ажил олгогчийн санаачилгаар цуцлахыг хориглоно.¹⁹

Иймд Монгол Улсын хөдөлмөрийн хуулинд бүрэн чадамжгүй ажилтны ажлын гүйцэтгэлийг сайжруулахад хангалттай хугацаа олгох, ноцтой зөрчил гаргасан ч нэг дор ажлаас халах боломжгүй, ажилчдын эрх маш сайн хамгаалагдсан байдаг.

¹⁸https://www.mhlw.go.jp/seisakunitsuite/bunya/koyou_roudou/roudouseisaku/chushoukigyoku/keiyakushuryo_rule.html

¹⁹ <https://old.legalinfo.mn/law/details/16817>

Монголын ажилласан жилээр ажилчдын эзлэх хувь(2020 оны байдлаар)



Нөгөөтэйгүүр ажиллах хүч багаучраас урт хугацаанд хүний нөөцийн хөгжилд хүрч чадахгүй байгаа асуудал Монголд бий. Японд ажилласан хугацаа дунджаар 11 жил байдаг бол Монголын нийт иргэдийн 44 хувь нь 3 жилийн дотор ажлаасаа халагдана²⁰. Ажилласан жил 13.6 болтлоо хөдөлмөрийн бүтээмж нэмэгдсээр байгаа нь судалгаанаас харагдаж байгаа²¹ тул богино хугацаанд дахин ажлын байр солигдвол хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэхгүй байх асуудал бий.

Дээрхээс харахад Монгол Улс ажилчдыг хамгаалах талаар эрх зүйн зохицуулалт, хуулийн заалт багагүй боловч олон ажилчид мэргэжил эзэмшилгүй богино хугацаанд ажлаасаа гарах, улмаар энэ нь хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэхэд сөргөөр нөлөөлөх зэрэг эрсдэлтэй асуудлууд ч цөөнгүй байна.

3.2. Компанийн засаглалын тогтолцоо

Дараа нь компанийн засаглалын механизмд дүн шинжилгээ хийнэ. Японы томоохон компаниудын ихэнх нь хувыцаат компани бөгөөд хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй байдаг. ХХК-ийн онцлог нь бүх хөрөнгө оруулагчид нь аж ахуйн нэгжийг төлөөлөн ажилладаг ажилчид боловч хувыцаа эзэмшигчдийн нэгдсэн хурал, төлөөлөн удирдах зөвлөл байгуулах үүрэг байхгүй, албан тушаалтнуудын бүрэн эрхийн хугацаа хязгааргүй, санхүүгийн тайланг нийтлэх үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, өмчлөл, менежмент нь адилхан. Төрөл бүрийн хөрөнгө оруулалтын өмчлөлийн харьцаа тогтмол боловч эдгээр нь бүгд хувийнх юм²².

Доорх хүснэгтэд Монгол, Японы хамгийн том 10 компанийн корпорацын хэлбэрийг харьцуулж үзүүлэв. Томоохон компаниудыг Монгол Улс ба Японд янз бүрээр тодорхойлон авч үзэж байна. Монгол Улсад Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ) -аас зарласан ТОП 100 ААН байдаг ч Японд үүнтэй төстэй зүйл байхгүй тул төлсөн татварын хэмжээгээр хамгийн том компанийг авч үзлээ.

Монголын ТОП 10 шилдэг 10 татвар төлөгч (2021он)²³

	Компанийн нэр	Компанийн хэлбэр
1	Эрдэнэт үйлдвэр	ТӨҮГ
2	Эрдэнэс-Таван толгол	ХК
3	Оюутолгой	ХХК

²⁰ “Монгол Улсын Ажлын Байрны Нөхцөлийн Түүвэр Судалгаа 2020.” 14
https://mlsp.gov.mn/uploads/files/Ajliin_bair_nukhtsul_sudalgaa_tailan_2020.pdf

²¹ <https://www5.cao.go.jp/j/wp/wp-je06/06-00202.html>

²² <https://news.zindaa.mn/ro>

²³ <https://www.mongolchamber.mn/a/664>

	Компанийн нэр	Компанийн хэлбэр
4	Энержи Ресурс	ХХК
5	ХИК	ХХК
6	АПУ	ХК
7	Шунхлай	ХХК
8	Голомт Банк	ХХК
9	Лекс-Ойл	ХХК
10	Ти Ти Жи Ви Си Өү	ХХК

Шилдэг 10 татвар төлөгч (2018 оны 11-р сараас 2019 оны 10-р сар)²⁴

	Компанийн нэр	Татварын төлбөрийн хэмжээ (100 сая иен)	Борлуулалты н хэмжээ (100 сая иен)	Компанийн хэлбэр
1	Toyota Motor Corp.	6599	302256	ХК /1st section of the TSE/
2	Nippon Telegraph and Telephone (NTT) Corp.	5332	118798	ХК /1st section of the TSE/
3	INPEX Corp.	3973	9713	ХК /1st section of the TSE/
4	NTT DOCOMO, Inc.	3378	48408	100% NTT Corp.
5	Sumitomo Mitsui Financial Group, Inc.	3314	57353	ХК /1st section of the TSE/
6	KDDI Corp.	3091	50803	ХК /1st section of the TSE/
7	Honda Motor Co., Ltd.	3031	158886	ХК /1st section of the TSE/
8	SoftBank Group Corp.	2367	96022	ХК /1st section of the TSE/
9	Mitsubishi Corp.	2060	161037	ХК /1st section of the TSE/
10	SoftBank Corp.	2059	37473	ХК /1st section of the TSE/

TSE: Tokyo Stock Exchange, Inc.

Дээрх хүснэгтээс харахад Монголын олон компани ХХК-ийн хэлбэртэй байгааг харж болно. Монголын топ 100 аж ахуйн нэгжийн 87 нь ХХК, 2 нь ТӨХК, 2 нь ТӨК, ХК нь ердөө 9 компани байна²⁵. Ийм учраас Монголын олон компани Япон шиг

²⁴ <https://toyokeizai.net/articles/-/328202?page=2>

²⁵ <https://www.mongolchamber.mn/a/664>

хувьцаа эзэмшигчдийнхээ мэдээллийг хянаж, ил болгох үүрэг хүлээдэггүй нь Монголын компаниуд болон Японы компаниудын хоорондох томоохон ялгаа юм.

Компанийн засаглалын тогтолцооны энэхүү ялгаа нь улсын эдийн засаг дахь компаниудын гүйцэтгэх үүрэг, оруулах хувь нэмэрт ч бас тодорхой хэмжээгээр нөлөөлдөг гэж болно.

3.3. Компани хоорондын урт хугацааны бизнесийн харилцаа

Тус өгүүллийн 2.3-т keiretsu компаниудын дэмжлэгтэй компаниудын хооронд урт хугацааны бизнесийн харилцааг бий болгосноор Японд тогтвортой менежмент бий болсон гэж дурдсан. Нөгөөтэйгүүр Монгол Улс цөөн хүн амтай учраас keiretsu компанийг үүсгэх зах зээл хараахан бий болоогүй байна. Тийм учраас Монголын аж ахуйн нэгжүүд Японы компаниудаас илүүтэй гадаадын компаниудтай байнга хамтран ажиллахыг шаарддаг байж болох юм. Харамсалтай нь Японы компаниудын хөгжил удаашралтай, Монгол Улсад Японы 428 компани бүртгүүлсэн (2020 он) ч үүнд идэвхигүй компаниуд ч багтаж байгаа бөгөөд Монголд ердөө Японы 447 иргэн Монгол Улсад оршин суудаг байгаа(2020 он) нь бодит байдлыг илэрхийлдэг. Нэмж дурдахад Монгол Улс Япон Улсаас 36.4 тэрбум иений бараа бүтээгдэхүүн импортлож байгаа ч Япон руу экспортолж буй хэмжээ ердөө 1.55 тэрбум иен(2020 он) байна²⁶.

Япон улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам МОНЦАМЭ агентлагтай хамтран Японы компаниудтай хамтран амжилттай ажиллаж буй Монголын компаниудын тухай тусгай нийтлэл дээрх нөхцөл байдлыг сайжруулах зөвлөмж болно. Эдгээр онцлох нийтлэлд бүх бизнес эрхлэгчид бизнесийн түншүүд болон хамтран ажилладаг компаниудтай "итгэлцлийн харилцаа"-г онцолж байна. Мөн Элчин сайд Х. Кобаяши

“先ずは、当たり前ですが、約束は厳格に守るということを実践して欲しいと望んでいます。契約の支払い期限を超過する、当事者間の合意なく一方的に契約の内容が反故にされるという事例が散見されます。少くも遅れても支払うのだから問題ないだろうという大らかかつ柔軟な考えがモンゴルにはあるのかもしれませんが、これは是非改めて欲しいと願っています。-Юуны өмнө энэ бол мэдээжийн хэрэг, гэхдээ амласан амлалтаа чандлан дадлагажуулаасай гэж хүсч байна. Хугацаа хэтрүүлсэн гэрээний төлбөрийг талууд тохиролцоогүй, нэг талт байдлаар хийх Гэрээний агуулгыг зөрчих тохиолдол бий. Бага зэрэг хоцорсон ч төлнө гээд асуудалгүй гэсэн уян хатан санаа Монголд байж магадгүй, гэхдээ энэ өөрчлөгдөнө гэж хүсч байна.” гэжээ²⁷.

4. Дүгнэлт, Санал

Япон маягийн менежментийг тайлбарласны дараа Монголын компаниудын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн. Монголын компани бүтэц хэлбэрээ өөрчилж, Японых шиг keiretsu хэлбэрийн компани байгуулахад эдийн засгийн бүтцэд эрс шинэчлэл хийх шаардлагатай учраас цаг хугацааны хувьд хүндрэлтэйгээс гадна хүний нөөцийг хөгжүүлэх тогтолцоо, бизнесийн түнш, хамтын ажиллагааг бий болгоход хүндрэлтэй байдаг бөгөөд компанитай итгэлцлийн харилцааг компани дангаар нь хийж болно.

Тодруулбал, шинэ ажилчдыг сургах сургалтыг нэмэгдүүлэх, тус компанид нэгэн зэрэг орсон ажилчдын эв нэгдлийн мэдрэмжийг нэмэгдүүлэх, ажилдаа ашигласан

²⁶ <https://www.mofa.go.jp/mofaj/area/mongolia/data.html#section6>

²⁷ <https://www.montsame.mn/mn/read/221418>

<https://www.montsame.mn/en/read/274991>

<https://montsame.mn/jp/read/282761>

ур чадвараа дээшлүүлэхэд урамшуулал олгох замаар ажилчдыг нэг компанид тууштай ажиллуулах механизм бий болгох асуудлыг онцлож болно. Түүнчлэн бизнесийн түншүүдтэйгээ итгэлцлийн харилцааг бий болгохын тулд Японы компаниудтай урт хугацааны бизнесийн харилцаатай байсаар ирсэн Монголын компаниудын туршлагагаас судлаж, харилцан тохиролцсон гэрээ, амласан амлалтыг нэг бүрчлэн дагаж мөрдсөний үндсэн дээр компани хоорондын итгэлцлийг бий болгох үйл ажиллагааг тууштай хэрэгжүүлэх нь зохистой гэж дүгнэж байна.

Монголын эдийн засаг гадаад орнуудтай хамтран ажиллаж, хөгжихийн тулд эдгээр яаралтай арга хэмжээнүүдээс эхлэх ёстой гэж дүгнэж болно.

Abstract: In order to realize Mongolia's goal of "Let's develop like Japan," this paper explained the three pillars of "Japanese-style management" that supported Japan's economic development, applied them to the current situation in Mongolia, and analyzed them in the future. Also, We will analyze what kind of points should be followed to develop the Mongolian economy.

Keywords: Keiretsu, Let's develop like Japan, lifetime employment, the seniority system, Stock company, METI

4. Ашигласан материал

A. Эрдэм шинжилгээний өгүүлэл

- H. Yamamoto. 2013. “ルックイースト政策(東方政策)の30年と今後の展望 : ディスカバリージャパン・セカンドウェーブに向けて(30 Years of Look East Policy and Future Prospects: Towards Discovery Japan Second Wave).” *Kyoto University Research Information Repository AMS Discussion Paper*, 2: 44-53
- N. Katsube. 2019. “The Present of Japanese Style Management.” *Senshu University, Senshu business review Vol.14 No.1*: 23-34
- T. Oda. 1997. “Development politics of Malaysia and its economic growth.” *Kobe University Repository: Kernel, Bulletin of the Faculty of Human Development*, 5(1): 263-286
- Y. Konomi. 1998. “Limitations of Japanese Management.” *Keio University, Macro review, Vol.11, No.1*: 51-59

Б. Мэдээ, сэтгүүлийн нийтлэл

- Bolormaa.B. 2021. “SANKOU TECH MONGOLIA社長ツェンデーフー氏: 夢は社員と共に成長めざし、世界に高品質製品を輸出すること(SANKOU TECH MONGOLIA President Ms. Tsedenkhuu: My dream is to grow with our employees and export high quality products to the world.).” *Монцамэ news*. Accessed December 3, 2021. <https://montsame.mn/jp/read/282761>
- H. Tanaka. 2018 “最新！連結子会社数が多い500社ランキング(latest! Ranking of 500 companies with the largest number of consolidated subsidiaries).” *Toyokeizai news*. Accessed November 7, 2021. <https://toyokeizai.net/articles/-/204910?page=2>
- T. Utsunomiya. 2020 “「税金を多く納めている」TOP100社ランキング(Top 100 companies that "pay a lot of taxes" ranking).” *Toyokeizai news*. Accessed November 30, 2021. <https://toyokeizai.net/articles/-/328202?page=2>

Zindaa news. 2011 “ХК ба ХХК-ийн ялгаа.” Accessed November 30, 2021. <https://news.zindaa.mn/ro>

Наранмандухай.Т. 2021. “Б.Хос-Эрдэнэ: Дэлхийн хэмжээний компани болохоор зорьж байна.” Монцамэ news. Accessed November 30, 2021. <https://www.montsame.mn/mn/read/221418>

Наранмандухай.Т. 2021. “Ц. Ууганцэцэг: Өнөөг хүртэлх хугацаанд компанийнхаа ажилчдаас хоёр том зүйлийг сурсан.” Монцамэ news. Accessed November 30, 2021. <https://www.montsame.mn/en/read/274991>

Төгөлдөр. А. 2021. “МАН-ын 100 жил, Эх орончдын өдрийн мэндчилгээ.” iKon news. Accessed December 15, 2021. <https://ikon.mn/n/255x>

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам. 2020. “Монгол Улсын Ажлын Байрны Нөхцөлийн Түүвэр Судалгаа 2020.”

В. Цахим сайтууд (Website content)

Cabinet Office. 2006. “Annual Report on the Japanese Economy and Public Finance.” Accessed November 7, 2021. <https://www5.cao.go.jp/j-j/wp/wp-je06/06-00202.html>

Embassy of Japan in Malaysia. 2008. “東方政策の概要(Overview of Look East Policy).” Accessed November 6, 2021. <https://www.my.emb-japan.go.jp/Japanese/JIS/LEP/LEP.htm>

Ministry of Foreign Affairs of Japan. 2021. “モンゴル国(Mongolia).” Accessed November 30, 2021. <https://www.mofa.go.jp/mofaj/area/mongolia/data.html#section6>

Ministry of Health, Labour and Welfare of Japan. n.d. “労働契約の終了に関するルール(Rules for termination of employment contract).” Accessed November 30, 2021. https://www.mhlw.go.jp/seisakunitsuite/bunya/koyou_roudou/roudouseisaku/chushoukigyou/keiyakushuryo_rule.html

Эрх Зүйн Мэдээллийн Нэгдсэн Систем. 2021. “ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ.” Accessed November 30, 2021. <https://old.legalinfo.mn/law/details/16817>

МҮХАҮТ. 2021. “Монгол Улсын 2020 оны ТОП 100 ААН тодорлоо.” Accessed November 30, 2021. <https://www.mongolchamber.mn/a/664>

ЗОХИОГЧИД

Зохиогчийн нэр	Албан тушаал	E-mail
Ж.Төртогтох	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, профессор, Ардчилал судлалын төвийн захирал	turtogtokh@num.edu.mn
Д.Уртнасан	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн докторант, Ардчилал судлалын төвийн судлаач	Toto_bear@yahoo.com
Ц.Батболд	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн дэд профессор	Batbold_ts@num.edu.mn
О.Мөнхжаргал	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн багш	Munkhjargal.o@num.edu.mn
Я.Төгөлдөр	ШУТИС, Нийгмийн ухааны салбарын эрхлэгч, дэд профессор	tugul@must.edu.mn
Д.Бумдарь	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын профессор	bumdari@num.edu.mn
М.Мөнхзул	ХААИС-ЭЗБС-ХААХЭЗТ	munkhzul@mul.edu.mn
Г.Уянга	ХААИС-ЭЗБС-ХААХЭЗТ	uyanga@mul.edu.mn
Б.Сарантуяа	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн магистрант	sarantuyabtr@gmail.com
Б.Эрдэнэдалай	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн ахлах багш	erdenedalai@num.edu.mn
Г.Цэнд-Аюуш	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн багш, доктор	Tsendayush_g@num.edu.mn
Д.Түмэнжаргал	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн ахлах багш	tumeed@num.edu.mn
Г.Эрдэнэбаяр	МУИС, ШУС, Хүмүүнлэгийн ухааны салбар, Философи, шашин судлалын тэнхимийн дэд профессор	erdenebayar.g@num.edu.mn
Б.Сүхболд	Улаанбаатар эрдэм их сургуулийн сургалт эрхэлсэн дэд захирал	sukheemodun@yahoo.com
Н.Батжаргал	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн докторант	nbatjargal81@gmail.com
Д.Ундрах	МУИС, ШУС, Нийгмийн ухааны	Poli_und@num.edu.mn

	салбар, Улс төр судлалын тэнхимийн дэд профессор	
Г.Ануцэцэн	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн магистрант	ganu01216@gmail.com
Ц.Бямбачулуун	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн докторант	byambachuluuntseden@gmail.com
Б.Хишигням	МУИС, Элсэлт бүртгэлийн хэлтсийн дарга, дэд профессор	khishignyam@num.edu.mn
Д.Бадамдаш	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн багш	badamdash@num.edu.mn
Т.Есүхэй	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн дадлагажигч багш	tyesukhei@num.edu.mn
Б.Болор-Эрдэнэ	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн магистрант	Bayart.oyun@gmail.com
Г.Золзаяа	ОТИС, Олон улсын харилцаа, Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч	zolzaya@otgontenger.edu.mn
Б.Одгэрэл	ОТИС-ийн Эрдэм шинжилгээ, судалгаа эрхэлсэн дэд захирал, доктор, профессор	odgerel@otgontenger.edu.mn
Б.Галиндэв	ОТИС-ийн доктор, профессор	galindev@otgontenger.edu.mn
С.Одхүү	ОТИС-ийн доктор, профессор	odkhuu@otgontenger.edu.mn
Н.Хосбаяр	ОТИС-ийн Гадаад харилцааны албаны дарга, доктор	khosbayar@otgontenger.edu.mn
Б.Эрдэнэбат	БХЭШХ-гийн захирал, доктор, профессор, хурандаа	erdenebatb@must.edu.mn
Д.Ууганжаргал	МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн магистрант	Uuganjargal127@gmail.com
Катанода Томоки	МУИС, ОУХНУС-ийн докторант	20D1NUM0180@stud.num.edu.mn